

Пристийн Зэргийн Үүрэг
ба Адислалууд



Пристийн Зэрэгтнүүдийн Үндсэн Гарын Авлага, А Хэсэг

Пристийн Зэргийн Үүрэг ба Адислалууд

Пристийн Зэрэгтнүүдийн Үндсэн Гарын Авлага, А Хэсэг

Исүс Христийн

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс Хэвлэн гаргав.

Солт Лэйк Сити, Юта

1998. Intellectual Reserve, Inc. Исүс Христийн Хожмын Үеийн

Бүх Эрхийг Эдэлнэ.

Англи эхийн зөвшөөрөл: 1996–9.

Орчуулгын зөвшөөрөл: 1996–9.

Duties and Blessings of the Priesthood:

Basic Manual for Priesthood Holders, Part A -ийн орчуулга

Агуулга

Оршил	v
Тахир Дутуу Гишүүдийг Хамруулах нь.....	vii

Пристийн Зэргийн Байгууллага Ба Түүх

1. Пристийн Зэрэг.....	1
2. Адамаас Дахин Сэргээлтийн үе хүртэлх Пристийн Зэрэг.....	8
3. Пристийн Зэргийн Дахин Сэргээлт	15
4. Пристийн Зэргийн Чуулга	23
5. Диконы Үүрэг	31
6. Багшийн Үүрэг.....	40
7. Пристийн Үүрэг.....	48
8. Бишоп ба Салбарын Ерөнхийлөгчийн Үүрэг	57
9. Ахлагч ба Дээд Пристийн үүрэг	63
10. Патриархууд ба Патриархын Адислалууд	69
11. Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн Хэрэгцээ	77

Хувийн ба Гэр Бүлийн Хариуцлага

12. Гэр Бүлийнхээ Сайн Сайхны Төлөө Хүлээх Эцгийн Хариуцлага	85
13. Гэр Бүлийнхэнтэйгээ Зөвлөх	92
14. Гэр Бүлийн Залбирлыг Удирдах	100
15. Эрх Гэр: Ариун Сургаалаас Суралцах Төв	106
16. Заахад Бэлтгэх	113
17. Судраас Заах.....	123
18. Ариун Сүнсний Хүчээр Заах нь.....	131
19. Эрх Гэр дэх Даруу Төлөв Байдал	137
20. Гэр Бүлийн Асуудлуудыг Эвээр Шийдвэрлэх	144
21. Гэр Бүлийн Төсвөө Зохицуулах.....	151
22. Гэрийн Үйлдвэрлэл ба Хадгалалт	158
23. Ажиллах Чадвараа Хөгжүүлэх.....	166
24. Эрүүл Мэндээ Хамгаалах	175
25. Нэгдэл, Улс Гүрэндээ Үйлчлэх	183

Ариун Сургаалын Зарчмууд ба Номлолууд

26. Исүс Христийн Ариун Сургаалын Гэрчлэл	191
27. Исүс Христэд Итгэх.....	196
28. Наманчлал.....	206

29. Усан Баталгаа, Үргэлжлэх Гэрээ	214
30. Ариун Сүнсний Бэлэг	223
31. Залбирал ба Мацаг Барилт	230
32. Бишрэл	237
33. Хайр Хүндэтгэл, Үйлчилгээ.....	243
34. Зан Суртахууны Цэвэр байдал.....	250
35. Мөнхийн Гэр бүл	256
Ашигласан Материал	265
Индекс	266
Ариун Сүмүүд ба Барилга Байгууламжууд.....	276

Оршил

Хичээлийн Зохион Байгуулалт

Пристийн Зэргийн эдгээр хичээлүүдийг Аароны болон Мэлкизэдэк Пристийн Зэрэгтнүүд ашиглаж болохуйцаар зохиосон болно. Цөөн тооны пристийн зэрэгтнүүд бүхий бага хэмжээний салбарт гишүүд нэг ангид уулзаж болно. Пристийн Зэрэгтний тоо нь харьцангуйгаар хангалттай мөн байр талбай хүрэлцээтэй газруудад багш насанд нь тохируулан хэрэгцээг нь хангахыг харгалзан үзэж, гишүүдийг насны ангиллаар нь хувааж болох юм.

Бие Даан Суралцах нь

Эдгээр хичээлүүдийг үндсэндээ бие даан суралцахад зориулав. Тиймээс пристийн зэрэгтэн бүр долоо хоногийн турш гарын авлагаасаа суралцан, ярилцах бэлтгэлтэйгээр хичээлд ирэхдээ гарын авлага ба судраа авчрах нь зүйтэй. Энэхүү бэлтгэлийг урамшуулах зүйтэй арга нь багш хэдэн гишүүдийг урьдчилан хичээлийг уншин бусадтайгаа ярилцах бэлтгэлтэй ирэхийг хүсэхэд оршино. Хичээлд хүн бүр судраа авчрах нь чухал бөгөөд хүн бүхэн судраа авчрах зуршилтай болох хүртэл багш чуулгынханд үргэлж сануулж байх хэрэгтэй.

Багшид Туслах нь

Багшид өгөх тусламж нь гарын авлаганд орсон бөгөөд хичээл бүрт жижиг шрифтээр бичин хавсаргасан болно. Эдгээр тусламжууд нь багшийн зүгээс асууж болохуйц асуултууд, хичээлд оролцоход зориулсан зөвлөмжүүд болон зураг, хүснэгтүүдийг ашиглах заавруудыг багтаасан. Ярилцлагын асуултууд болон зөвлөсөн аргуудад нэмэлт болгон гарын авлагыг ашиглаж байгаа багш үр дүнтэй гэж үзсэн бусад арга хэлбэр, хичээлийн төрлийг хэрэглэж болно. Бараг бүх хичээлд самбар, шохой хэрэглэх тул хичээл бүрийн турш ангид тэдгээр зүйлс байх талаар багш урьдаас анхаарах нь чухал. (Хүснэгт хэлбэрээр ашиглах үзүүлэн таниулах ихэнхи материалуудыг самбарт бичсэн байж болно.)

Хичээлийн Тоо Хэмжээ

Удирдагчдад пристийн зэргийн хэсгүүдэд ярилцах шаардлагатай гэж үзсэн санал бодол болон тулгамдсан асуудлуудаа хэлэлцэх хангалттай цаг үлдээхээр энэ гарын авлаганд гучин таван хичээл

бэлтгэсэн. Энэхүү нэмэлт цагуудыг дараах байдлаар ашиглаж болно–

1. Хэсэг, салбарын үйл ажиллагааг төлөвлөх, ярилцах болон пристийн зэргийн удирдлагаас өгсөн онцгой сэдвүүдийг таниулах.
2. Олон улсын сэтгүүлүүд болон Утышпт-д хэвлэгдсэн ерөнхий чуулган дээр үг хэлсэн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн хэлсэн үгийг ярилцах.
3. Бататган суралцах хэрэгтэй гэж үзсэн сэдвүүд дээр нэгээс илүү долоо хоногийг зарцуулах.
4. Пристийн зэрэгтнүүдийн тусын тулд Их Эзэний Сүнсээр удирдуулан цагаа ашиглах.

Тахир Дутуу Гишүүдийг Хамруулах нь

Мөнх бус амьдралынхаа үйлчлэлийн үед Исүс Галил нуурын дэргэдэх уул өөд гарчээ.

Олон түмэн Аврагчийн өмнө цугларч, доголон, сохор, хэлгүй, зэрэмдэг болон бусдыг Исүсийн хөлд ирүүлэхэд Тэрээр тэднийг анагаалаа. Хэлгүй нэгэн ярьж, зэрэмдэг нэгэн эдгэрч доголон нэгэн алхаж, сохор нэгэн харахыг түмэн олон гайхан ширтэж, бүгдээр Бурханыг алдаршуулав. (Матай 15:30–31 -ийг үз).

Дутагдал гачигдалтай хүмүүст нинжин сэтгэлээр хандахыг Аврагч маань бидэнд жишээ болон сургасан. Дахин амилалтынхаа дараа Нефайчуудад айлчлахдаа Тэрээр сэтгэл нь хүмүүст хандах нинжин сэтгэлээр дүүрсэн болохыг хэлжээ. Тэрээр өвчтэй, доголон, сохор, эрэмдэг зэрэмдэг, уяман, хэлгүй, дүлий болон ямар нэгэн байдлаар шаналсан хүмүүс тэдний дунд байгаа эсэхийг асуулаа. Тэднийг энэрч байсны учир тэд бүгдийг Түүний өмнө авчирч эдгээлгэхийг Тэр хүссэн; Түүний дотор сэтгэл нигүүлсэнгүй ажгуу. (3 Нефай 17:6–7 -г үз).

Сүмийн багш нь тахир татуу гишүүддээ нинжин сэтгэлээр хандах онцгой албанд байгаа юм. Тэрээр тэднийг ойлгож, хичээлийн үеэр хийх үйл ажиллагаануудад тэдгээр гишүүдийг оролцуулах эрмэлзлэлтэй байх хэрэгтэй. Ямар нэгэн чадавхи султай бүх л гишүүд хичээлийн үед онцгой анхаарал шаарддаг. Онцгойлон анхаарал тавих хэрэгтэй гишүүдэд хандахад нь дараах зөвлөмжүүд багшид туслаж болох юм.

- Гишүүн бүрийн хэрэгцээ болон чадавхийг мэд.
- Тэднийг хичээлийн үеэр дуудан унших, залбирах болон бусад хэлбэрээр хичээлд оролцуулахын тулд тахир дутуу гишүүдтэйгээ урьдчилан ярилц. “Хичээл дээр унших талаар ямар бодолтой байна даа?”, “Олон нийтийн өмнө та залбирал хэлэхийг хүсэж байна уу?” гэх мэт асуултуудыг тавь.
- Тэдний онцгой хэрэгцээг тодорхойлохын тулд пристийн зэргийн удирдагчидтай гэр бүлийн гишүүдтэй нь боломжтой үед өөрсөдтэй нь ярилц.
- Чадавхи султай гишүүдийн оролцоо болон суралцах зүйлийг нэмэгдүүлж сайжруулахыг чармай.
- Ангийн гишүүн бүр бусдыгаа хүндэлж ойлгож байх учиртайг анхаар.

-
- Энгийн, нөхөрсөг, дотно бай. Тахир дутуу эсэхээсээ үл хамааран Бурханы хүүхэд бүр хайр хүндэтгэл хүртэж бусдад өөрийгөө ойлгуулах ердийн хэрэгцээтэй байдаг.

Гишүүн бүр биеийн, оюуны, сэтгэлийн болон нийгмийн чадвараасаа үл хамааран өргөмжлөл тийш хөгжих чадавхитай байдгийг Сүмийн багш нар санаж байх ёстой. Хүн бүр сурах боломжтой бүх зүйлийг сурч байгаа эсэхийг багш хянах ёстой. Аврагчийн үгийг сана:

“Ахан дүүсийн минь хамгийн нэгэнд нь өчүүхэн ч бол түүнийг үйлдсэнээр та түүнийгээ надад үйлдсэн хэрэг болой.” (Матай 25:40).

Энэ хичээлийн зорилго бол пристийн зэрэг гэж юу вэ мөн пристийн зэргийн дуудлагаа хэрхэн хичээнгүйлэн биелүүлэх талаар ойлгоход бидэнд туслах явдал юм.

Оршил

Пристийн зэргийг хүлээн авсан цагаа сана. Пристийн зэрэгтнүүд толгой дээр тань гараа тавин тодорхой үгсийг хэлэх тэр мөчид Их Эзэний Сүнс тэнд байсан нь дамжиггүй. Ийн гүйцэтгэх эрх мэдэл бүхий эрчүүд танд пристийн зэргийг олгосон. Тэрхүү үйл явдлыг эргэцүүлэн бодохдоо та өөрөөсөө ийн асуу:

- Тэр өдөр надад чухам юу тохиолдсон бэ?
- Пристийн зэргийг хүлээн авсныхаа дараа би өөр хүн болсон уу?
- Пристийн зэрэгтэйн учир өнөөдөр би өөр хүн үү?
- Пристийн зэргээрээ дамжуулан би бусдад үйлчлэх боломжтой байв уу?
- Пристийн зэргээ ашигладаг байдлыг минь Тэнгэрлэг Эцэг маань таалан үздэг үү?

Пристийн Зэрэг бол Бурханы Хүч Чадал Мөн

“Пристийн зэрэгтнүүд бид Их Эзэний нэрээр үйлдэхдээ Тэнгэрлэг Эцэгийн нэрээр болон нэрийнх нь өмнөөс хийж байгаа хэрэг болой. Пристийн зэрэг нь Тэнгэрлэг Эцэг эрчүүдээр дамжуулан ажиллуулдаг хүч чадал болой.” (Харолд Б. Ли, “Сүмийн Удирдлагыг Дага”, *Ensign*, 1973 оны 7-р сар, х. 98.)

Пристийн зэрэг нь Бурханы хүч чадал юм. Өөртөө байдаг пристийн зэргээр Бурхан ажлаа гүйцэтгэдэг. тэр бүх л зүйлийг энэхүү хүчээр бүтээсэн мөн тэрээр түүгээр л тэнгэр газрыг захирдаг. Пристийн зэрэг нь Бурханы хүч чадал тул энэ нь мөнх юм. Эхлэлд байсан тэр л пристийн зэрэг нь ертөнцийн төгсгөлд ч байх болно гэдгийг бид Агуу Их Үнэт Сувдаас уншдаг. (Мозэс 6:7 -г үз).

Бурхан, Исүс Христ хоёр, мөнх бус байдал, мөнхийн амьдралыг хүртэхэд нь тусламж болгон хүнд пристийн зэргийн хүчийг олгосон (Мозэс 1:39 -ийг үз). Тиймээс пристийн зэрэг нь Бурханы эрх мэдэл бөгөөд хүн төрөлхтний авралд зориулж бүхнийг хийлгэхээр хүнд өгөгдсөн юм.

Пристийн зэргийг атгагч бид Бурханы нэрээр үйлдэх эрх мэдэлтэй. Их Эзэний бошиглогч, Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит бүх пристийн зэрэгтнүүдэд хандан хэлэхдээ: “Бид Их Эзэний төлөөний хүмүүс; бид түүнийг төлөөлдөг; тэрээр бидэнд өөрсдийгөө болон ертөнц дээрх түүний бусад хүүхдүүдийг аварч, өргөмжлөхөд шаардлагатай бүхнийг хийхэд биднийг хүчирхэгжүүлдэг эрх мэдлийг өгсөн.

“Бид Их Эзэн Исүс Христийн элч нар. Бидний даалгавар бол Түүнийг төлөөлөх явдал юм. Бид . . . тэр энд биеэрээ байсан бол чухам юу хийх байсан, түүнийг л хийхээр тушаал авсан.” (“Our Responsibilities as Priesthood Holders,” *Ensign*, June 1971, p.49).

Пристийн Зэргийн Эрх Мэдлийн Шугам

Пристийн Зэрэгтэн бүрийн “эрх мэдлийн шугам”-ыг мөрдөж үзэхэд Исүс Христэд хүрэх учиртай. Энэ нь тухайн хүн хэнээр пристийн зэрэгт батлуулснаа, тэр хүний нь хэн баталсныг мэдэх учиртайг хэлж байгаа юм. Тухайн хүн энэ ёслолуудыг Исүс Христээс пристийн зэргийг хүлээн авцгаасан Пэтэр, Жэймс, Жон нараар томилогдсон Жозеф Смитийг хүртэл ухарааж хүн бүрийг мэдэх учиртай. Энэ нь бидний “эрх мэдлийн шугам” гэж нэрлэгддэг. Хэрэв тухайн хүнд эрх мэдлийн шугамын хувь байхгүй бол түүнийг пристийн зэрэгт томилогдсон хүнээс олж авах боломжтой.

Урьдчилан даалгасан пристийн зэрэгтнээр гишүүдэд эрх мэдэл нь Исүс Христээс ирснийг харуулсан “эрх мэдлийн шугамын” хуудсыг үзүүлэхийг хүс.

Пристийн Зэргийн Хүч Чадал Зөв Шударга Амьдралаар Ирдэг

“Пристийн зэргийг атгадаг бүх л хүмүүс Их Эзэний төлөө үйлдэх эрх мэдэлтэй. Гэвч тэрхүү эрх мэдлийн үр дүн нь буюу тэр эрх мэдлээр дамжуулан ирдэг хүч нь бидний амьдралын хэв загвар дээр тулгуурлан; бидний зөв шударга байдлаас хамаардаг.” (Х. Бүркэ Питэрсон, *Ensign*, 1976 он, 5-р сар, х. 33).

Бид эрх мэдэлтэй төдийгүй, пристийн зэргийн хүч чадалтай байхын тулд зөв шударгаар амьдрах учиртайг Их Эзэн судруудад тодорхой өгүүлсэн байдаг. Олон олон хүмүүс дуудагдсан хэдий ч цөөн нь сонгогдсон болохыг тэр хэлсэн. Учир нь, тэдний зүрх сэтгэл нь ертөнцийн юмс, хүмүүний нэр алдарт төвлөрч, тэд нэг чухал сургаал: пристийн зэргийн эрх нь тэнгэрийн хүчтэй салшгүйгээр холбогдсон бөгөөд тэнгэрийн хүч нь зөвхөн зөв шударга ёсны зарчмаар л хянагдаж, удирдагддаг гэдгийг үл сурснаас ажгуу. Пристийн зэргийн эрх бидэнд олгогдсон байж болох хэдий ч, бид нүглээ халхалж, бардамнаж, хий хоосон санаархаж хүмүүний үрсийг зөв шударга бусаар хянахыг бодолхийлэх аваас, тэнгэр алсалж Их Эзэний Сүнс гашуудах болой. Их Эзэний Сүнс холдоход, тухайн хүн пристийн зэрэг болон эрх мэдлээ алдах болно (С ба Г 121:34–37 -г үз).

Ягаад эдгээр юмс биднийг пристийн зэргийн хүч чадалтай байхаас хол байлгадаг вэ?

Пристийн зэргийн хүч чадлын эх булаг нь Ариун Сүнсээр дамжуулан ажилладаг Бурхан болой. Пристийн зэргээ хэрэглэх Ариун Сүнсний удирдамжийг авахын тулд бид зарлигуудыг дагаж, зохистой амьдрах ёстой. “Эрх мэдлийн шугам” нь бидний өмнөх хүмүүсээр дамжин Исүс Христэд хүрдэг хэдий ч, пристийн зэргийн хүч нь зөвхөн Тэнгэрлэг Эцэгээс Ариун Сүнсээр дамжин ирдэг юм. Пристийн зэргийн хүчтэй бол бид Их Эзэний ажлыг хийж чадна; харин тэр хүчийг эс агуулах аваас боломжгүй юм.

1-а үзүүлэнг таниул, “Эрт цагт Христ гүйцэтгэж байсны адилаар пристийн зэрэгтнүүд өвчтөнийг адислаж байна.”

“Бид хичээн амьдарвал бид Тэнгэрлэг Эцэгээс өгсөн хүчийг агуулж зовлонд учирсан айл өрхөд амар амгаланг авчрах болно. Бидний хүч бага хүүхдүүдийг үдшийн бүрийгээр нулимстай нүдтэйгээ унтахад нь адислан, тэтгэх болно. Бидний хүч гэр бүлийн цуглаанд аз жаргал авчрах, ядарсан эхнэрийн уймарсан сэтгэлийг тайвшруулах хүч болой. Биднийх, эргэлзэж тээнэгэлзсэн, эмзэг сэтгэлтэй өсвөр насныхны замыг нь заах хүч юм. Биднийх, анхныхаа болзоонд эсвэл ариун сүмийн гэрлэлтэндээ явах гэж буй охиныг; номлолын ажилдаа, эсвэл их сургуулийн эрдмийн аянд явах гэж буй хүүг адислах хүч болно. Залуу ахан дүүс минь, бидний хүч, зүй бус харилцаанд нэгдсэн хөвгүүдийн нүгэлт бодол санааг зогсоох чадалтай болой. Биднийх өвчтэйг анагааж, ганцаардсаныг тайтгаруулах хүч байж чадна. Эдгээр нь пристийн зэргийн зарим чухал зорилгууд юм.” (Х. Бүркэ Питэрсон, “Priesthood–Authority and Power,” *Ensign*, 1976 он, 5-р сар, х. 33).

Урьдаас товлосон пристийн зэрэгтнээс, амьдралд нь тохиолдсон, пристийн зэргийн хүч чадлыг мэдрүүлсэн үйл явдлаас хуваалцахыг хүс.

Пристийн Зэргийн Хүчийг Хөгжүүлэх нь

Пристийн Зэргийн хүчийг хөгжүүлэхийн тулд бид хэд хэдэн зүйлсийг хийх боломжтой.

ХҮСЭЛ

Юуны өмнө бид пристийн зэргийн хүчээ хөгжүүлэх эрмэлзэлтэй байх учиртай. Судрууд бидэнд эрчүүд Их Эзэнээс эрмэлзлэлийнхээ дагуу хүлээн авдаг хэмээн сургадаг (Алма 29:4, С ба Г 4:3, С ба Г 6:8, С ба Г 7:1–3 -ыг үз).

ЗӨВ ШУДАРГААР АМЬДАР

Бид Тэнгэрлэг Эцэгийнхээ бүх л зарлигуудыг сахихаар чармайх нь зүйтэй. Зөв шударгаар амьдарснаар бид Ариун Сүнсийг үргэлжийн хамтрагчаа болгох бөгөөд тэрээр биднийг хийх ёстой зүйлд маань хөтлөн залах болно (2 Нефай 32:5 -ыг үз).



ДАРУУ БАЙ

Өөрийгөө даруу байлгаж, нүглээ наманчилж, эцсээ хүртэл тэвчсэн хүн адислагдсантай адил юм. . . . (Алма 32:15 -ыг үз). Пристийн зэргийн удирдагчдынхаа өгсөн даалгаврыг хүлээн авч зөвлөмжийг нь даган, биелүүлэх хүсэл зоригтой, бусдын сайн сайхны төлөө хэрэгцээтэй бүхнийг хийх, Сүнсний зөвлөмжийг сонсож дагах хүсэлтэй байх хэрэгтэй.

СУРАЛЦ

Бид судраас эрэлхийлж эргэцүүлэн бодох ёстой. Зөвхөн судраас биечлэн суралцсанаар л бид Бурханы хүсэл зоригийг мэдэх бөгөөд Бурханы хүсэл зоригийг мэдэхгүйгээр бид ариун сургаалаар амьдарч чадахгүй. Ийм зорилгоор пристийн зэрэгтнийхээ үүргийг мэдэхийн тулд бид пристийн зэргийн гарын авлагаас суралцах хэрэгтэй.

ЗАЛБИР

Тэнгэрлэг Эцгээсээ биднээр юу хийлгэх хүсэлтэй байгааг нь бид асуух ёстой. Бид Пристийн зэргээ зөвөөр ашиглах удирдамж хүсэн тогтмол залбирах учиртай. Сатаны бидэнд өвлүүлэхээр эрмэлздэг уруу таталтанд өртөхгүй байхын тулд бид үргэлж залбирах ёстойг Исүс хэлжээ (3 Нефай 18:18 -ыг үз).

БУСДЫГ ХАЙРЛА

Биднийг бүх л хүмүүсийг хайрлаг хэмээн пристийн зэргийн хүч нь хайран дээр түшиглэдэг болохыг Исүс Христ бидэнд сургадаг (С ба Г 121:41–42, 45–46 -г үз). Хайр хүндэтгэл өрх гэрээс эхэлдэг. Бид эхнэр хүүхдүүдээ хайрлаж, тэдний сайн сайхны төлөө санаа тавих учиртай. Хайр хүндэтгэлээ гэр бүлийнхэндээ үзүүлэх нэг арга бол бид пристийн зэргээ хэрэглэн тэднийхээ амьдралыг залж адислах явдал юм.

ПРИСТИЙН ЗЭРГЭЭ АШИГЛА

Пристийн зэргээ ашиглахдаа бид бусад пристийн зэрэгтнүүд болон ертөнц дахинд, ялангуяа гэр бүлийнхэндээ үлгэр жишээ үзүүлдэг. Гэр бүлийнхэн маань биднийг пристийн зэргээ ашиглаж байгааг харахдаа, бид Их Эзэний үйлчлэгчид гэдгийг мэдэх бөгөөд тусламж хэрэгтэй үедээ тэд бидэнд хандах болно. Эцэг, хөвгүүд нь пристийн зэргээ гэр бүлийнхээ тусын тулд хэрэглэснээр ирдэг адислалуудыг огт амсах боломжгүй зарим гэр бүлүүд байдаг нь харамсалтай.

1-а, Эрт цагт Христ гүйцэтгэж байсны адилаар пристийн зэрэгтнүүд өвчтөнийг адислаж байна.

Карл Блохын, Христ хараагүй нэгнийг эдгээж байгаа нь. Эх зураг нь Данийн Фрэдиксбүрг шилтгээний сүмийн Хааны Залбирал суудал дээр буй. Фрэдиксбүргийн Үндэсний Түүхийн Музейн зөвшөөрлөөр ашиглав.

Пристийн зэрэг бидний өрх гэрт өөрчлөлт гаргах боломжтой. Ерөнхийлөгч Дэвид О. МакКэй хэлэхдээ: “Эр хүн пристийн зэргийг агуулж, алдаршуулж байдгийн учир өрх гэр өөрчлөгддөг” гэжээ (“Priesthood,” *Instructor*, 1968 он, 10-р сар, х. 378).

Пристийн зэргийг агуулдаг бид зөв шударга амьд арвал дараах зүйлсийг хийх болно:

- Хэдийгээр өөрийн тань эрмэлзлэлтэй нийцэхгүй байвч гэр бүлийнхнийхээ зөв шударга эрмэлзлэлийг шударгаар бодолц.
- Хамгийн бага хүүхдийг боловч сонс.
- Гэр бүлийнхээ сайн сайхан байдлыг өөрийнхөө тайван байдлаас илүүд тавь.
- Өөрийгөө хянаж сур.
- Үргэлж бусдад хандах хайр хүндэтгэлээ үзүүлсэн тийм дуу хоолойгоор ярь.

Пристийн зэргээ дээдлэх өөр ямар арга замууд байж болох вэ?

Дүгнэлт

“Бурханы пристийн зэргээс хүчтэй зүйл энэ ертөнцөд үгүй гэдгийг бид ухамсарлах учиртай” (Н. Элдон Таннэр, “Are You Taking your Priesthood for Granted?” *Ensign*, 1976 он, 5-р сар, х. 41).

Ерөнхийлөгч Н. Элдон Таннэр пристийн зэргийг хүлээн авахад зохистой байхын ач холбогдлын талаар дараах түүхийг ярьсан юм.

“Намайг бишоп байхад манай хэсэгт ахлагчаар томилогдох насанд хүрсэн зургаан хөвгүүн байлаа. Би зөвхөн тавд нь л зөвшөөрөл өгч чадсан бөгөөд зургаа дахь нь бэлэн биш байсан. Бид энэ талаар хэд хэдэн удаа ярилцахад тэрээр надад ‘Би зохисгүй’ гэж хэлсэн. Тэр энэ талаараа сэтгэл ихэд зовинож байсан хэдий ч зөвшөөрөгдөх боломжтой гэж бодоогүй. . . . Авга ах нь ирээд, ‘Та ямар ч л байсан тэр хүүг нөхөдөөс нь хоцроож үлдээх учиргүй. Хэрэв зөвшөөрөхгүй бол та түүнийг Сүмээс хөндийрүүлж байгаа хэрэг’ гэж намайг зөвшөөрөхийг хүссэн юм.

“Би түүнд, ‘Пристийн зэрэг бол тэр хүүд өгч болох хамгийн чухал зүйл. Бид пристийн зэргийг зүгээр тараадаггүй. . . . Хүү бид хоёр бие биенээ ойлгож байна. Тэр ахлагчаар томилогдоход бэлэн биш байна’ хэмээн тайлбарлалаа. Тэрээр түүнд зөвшөөрөл олгоогүй.

“Хэдэн жилийн дараа ерөнхий чуулганд оролцож байхад минь, . . . нэгэн залуу эр дөхөж ирээд, ‘Ерөнхийлөгч Таннэр, та намайг санахгүй л болов уу. Би таны нөгөө ахлагчаар томилогдохыг зөвшөөрөөгүй хүү байна.’ Тэрээр гараа сунган ‘Би үүнд тань танд баярласнаа илэрхийлэх гэсэн юм. Би одоо Калифорнид бишоп болсон. Хэрэв тэр үед та зохисгүй байхад минь надад зөвшөөрөл олгосон бол магад,

пристийн зэрэг гэж юу болохыг хүндэтгэн үзэж, надад чухам ямар хариуцлага оногдохыг мэдэхгүй бөгөөд өнөөдөр бишоп хэмээн дуудагдахгүй байсан нь тодорхой биз ээ' гэж хэлэв" ("Priesthood Responsibilities," *Утгышлт*, 1973 он, 7-р сар, х. 94).

Пристийн зэргийг үр дүнтэй хэрэглэхийн тулд бид бүгдээрээ энэхүү чухал зарчмыг суралцах ёстой. Пристийн зэргийн эрх нь тэнгэрийн хүчтэй салшгүй холбоотой бөгөөд тэнгэрийн хүч нь зөвхөн зөв шударга зарчмыг баримталснаар л хянагдаж удирдагдаж болно гэдгийг бид ухаарах учиртай. (С ба Г 121:36 -г үз). Бурханаас хүчийг хүлээн авахын тулд бид зохистой болох ёстой.

Бид Бурханы эрх мэдэл хүчийг атгаж байгаа бөгөөд бид түүнийг төлөөлдөг гэдгээ үргэлж санаж байх хэрэгтэй. Пристийн зэргээ хэрэглэхдээ бид, "Энэ тохиолдолд Исүс Христ надаар юу хийлгэх бол? Түүний хүссэнээр нь би үйлдэж байна уу?" гэж өөрсдөөсөө асуух нь зүйтэй.

Уриалга

1. Пристийн зэргийн гарын авлагын заавруудыг анхааралтай судалж хичээл бүрт өгөгдсөн сорилтуудыг хүлээн зөвшөөр. Тэдгээр сорилтуудыг гүйцэтгэсэнээр, та пристийн зэргийнхээ хүчийг нэмэгдүүлж, Тэнгэрлэг Эцэгтээ ойртож, бусдад илүүтэйгээр үйлчлэх болно.
2. Пристийн зэргийн эрх мэдлийнхээ тэмдэглэлийг хөтөл. Та өөрийн пристийн зэргээ ухарааж хөөсөөр Исүс Христэд хүрэх учиртай.
3. Пристийн зэргийн эрх мэдлээ цаасан дээр бичиж пристийн зэрэгт томилсон хүмүүстээ өг.

Нэмэлт Судар

С ба Г 107:1–14 (Мэлкизэдэк ба Аароны пристийн зэргийн ялгаа)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас "The priesthood," 13 ба "Priesthood Organization," 14-р бүлгүүдийг судал.
2. С ба Г 121:34–46 -г судал.
3. Пристийн зэрэгтэн гишүүнээс пристийн зэрэг нь Исүс Христээс эхэлсэнийг харуулсан "эрх мэдлийн шугам" -аа хичээлийн үеэр үзүүлэхийг хүс.
4. Бас нэг пристийн зэрэгтнээс, пристийн зэргийн хүчийг илэрхийлсэн өөрт нь тохиолдсон нэг үйл явдлаас хуваалцахыг хүс.
5. Пристийн зэрэгтэн бүрийг долоо хоног бүр пристийн зэргийн цуглаанд ирэхдээ, судраа авчирч, хичээл бүрт хэрэглэх онцгой шүлгүүдийг уншиж бэлтгэлтэй байхыг хүс.
6. Хичээлд хэрэглэх түүх ба судруудыг бусад гишүүд хэлж болохыг анхаар.

Адамаас Дахин Сэргээлтийн Үе Хүртэлх Пристийн Зэрэг

Энэ хичээлийн зорилго нь бидний хүлээн авсан пристийн зэрэг нь он жилүүдийн туршид Адамд ба бусад зөв шударга эрэгтэйчүүдэд өгөгдсөн пристийн зэрэгтэй адил болохыг ойлгоход туслах явдал болно.

Оршил

Адам бол патриархын пристийн зэргийг атгасан анхны хүн байсан. Энэ нь Бурхан түүнд гэр бүлээ удирдахад болон Түүний өмнө буцаж очиход хэрэгтэй ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдлийг олгосон хэрэг юм. Тэрээр бас ерөнхийлөгчийн зөвлөлийн түлхүүрүүд буюу Бурханы сүмийг дэлхий дээр удирдах эрх мэдлийг атгасан анхны бошиглогч байсан. Энэ эрх мэдлээр тэр олон эрчүүдэд пристийн зэргийг олгосон бөгөөд хэрхэн хэрэглэхийг нь заасан. Адамаас хойших бүх л Сүмийн Ерөнхийлөгч нар энэхүү ижил эрх мэдлийг атгасаар ирсэн билээ.

Сүмийн олон алба үүрэгт томилогдсон бүх л пристийн зэрэгтнүүдийг удирдах эрх мэдэл нь нэг үед, нэг л хүнд–Сүмийн Ерөнхийлөгчид– олгогддог (С ба Г 81:1–2, С ба Г 132:7 -г үз). Өнөөдөр цорын ганц хүн пристийн зэргийн энэхүү эрх мэдлийг атгадаг хэдий ч, олон хүн пристийн зэрэгтэй бөгөөд энэ нь Адамын анх хүртсэнээс нь хойш олон олон бошиглогчдын хүртсэнтэй адил пристийн зэрэг юм (Пристийн зэргийн түлхүүрийн талаар нэмэлт мэдээллийг энэ гарын авлагын 11-р хичээлээс үз).

Адам Пристийн Зэргийг Хүлээн Авсан



Адам, Ив хоёрыг Эдэний Цэцэрлэгээс хөөгдсөний дараа Бурханы элч тэдний өмнө гарч ирэн, ариун сургаалыг заажээ (Мозэс 5:4–9 -ийг үз). Сүм байгуулагдаж, өнөөдөр бид усаар батлахаар өгөгдсөн журамтай адил Адам усаар батлуулсан (Мозэс 6:64–65 -ыг үз). Тэрээр ариун сургаалын бүх л ёслолуудыг гэр бүлийнхээ төлөө гүйцэтгэхийн тулд Адамд пристийн зэргийн эрх мэдлийг өгсөн. Энэ эрх мэдлээр тэрээр гэр бүлийнхнээ усаар баталсан төдийгүй зөв шударга хөвгүүддээ пристийн зэргийг олгосон.

2-а, Пристийн Зэрэг бүх Үе Удамд

“Пристийн зэргийг хүлээн авагсад намайг хүлээн авдаг гэж Их Эзэн айлдсан” (С ба Г 84:35.)

Пристийн Зэрэг бүх Үе Удамд

Эрин үе бүрийн бошиглогчид дээд пристийн зэргийг аггаж байсан (С ба Г 84:17-г үз).

МЭӨ 4000 орчим.	Адамын Эрин Үе	Урвалт	(С ба Г 107:40, 41)	Цаг Хугацааны Бүрдлийн Эрин Үе	МЭ 1880	Цаг Хугацааны Бүрдлийн Эрин Үе	Мянган Жил Дахин Сэргээгдсэн Сүм (С ба Г 20:1) Дахин Сэргээгдсэн Пристийн Зэрэг (С ба Г 13; С ба Г 278, 12, 13)			Жозеф Смит
МЭӨ 3765 орчим.	Инокийн Эрин Үе	Урвалт	(С ба Г 107:48, 58)	Лихайн Эрин Үе	МЭӨ 600 орчим.	Лихайн Эрин Үе				Лихай
МЭӨ 3000 орчим.	Ноагийн Эрин Үе	Урвалт	Үер (С ба Г 107:52, 53)	Мозэсийн Эрин Үе	МЭӨ 1500 орчим.	Мозэсийн Эрин Үе				Мозэс
МЭӨ 2000 орчим.	Абрахамын Эрин Үе	Урвалт	(С ба Г 84:14, Абрахам 1:16, 18)	Урвалт	МЭӨ 600 орчим.	Урвалт				Лихай
МЭӨ 400 орчим.	Цаг Хугацааны Дундажийн Эрин Үе	Томохон Урвалт	(Еврей, 5:9–10 Матай 16:19; 3 Нэфай 11:21, 22:12:1)	Христ, Төлөөлөгчид, Шавь нар Америкт	МЭӨ 400 орчим.	Цаг Хугацааны Дундажийн Эрин Үе				Жозеф Смит

Эрин Үе. Ариун Сургаал ба пристийн зэргийн эрх мэдэлийг онцгой тулхууруудийн хамтаар Их Эзэнээс сонгогдсон хүмүүст дэлхий дээр амьдарч буй Бурханы хүүхдүүдэд сургаж тэднийг удирдахын тулд өгөгдсөнийг хэлнэ.

2-а үзүүлэнг таниул, “ Пристийн Зэрэг бүх Үе Удамд”. Хүснэгт эрин үеүд гэж нэрлэгдэх цаг хугацааны найман үед хуваагдсан болохыг тайлбарла. Хүснэгтийн доод хэсэгт байгаа эрин үеийн тодорхойлолтыг унш. Ариун сургаал чухам хэдэн эрин үе дамжсаныг бид мэдэхгүй бөгөөд энэ найм нь зарим ерөнхий үеүдийг төлөөлж байгаа болохыг тайлбарла. Эрин үе бүрийг дурдахдаа тохирох зургийг таниулж зураг бүртэй хамт өгөгдсөн судрыг унш. Эдгээр зургууд нь бошиглогч бүр Мэлкизэдэк Пристийн зэргийг атгаж байсныг заадаг.

Патриархын Эрин Үе

Адам хүүхдүүд, ач нартаа ариун сургаалыг зааж, тэд пристийн зэргийн шаардлагатай ёслолуудыг хүлээн авч, патриархын журам ёсоор Сүмийг зохион байгуулахад нь анхаарал тавьсан. Пристийн зэргийн патриархын журам гэдэг нь Сүмийн байгууллага нь гэр бүлд төвлөрдөг бөгөөд пристийн зэрэг нь эцгээс хүүд шилждэг болохыг хэлж байгаа юм. Патриархын эрин үед амьдарч байсан агуу патриархуудын тоонд Сэф, Инос, Каинан, Махалалиэл, Жарэд, Инок нар ордог (С ба Г 107:40–52 -ыг үз).

2-а үзүүлэн, “ Пристийн Зэрэг бүх Үе Удамд.” Адамын эрин үеийн зургийг зааж, үзүүлэнгийн С ба Г 107: 40–41-ийг унш.

Анхны Томоохон Урвалт

Хүн өөрийн сонголт буюу сонгох эрх чөлөөтэй. Энэ сонголтоор Адамын зарим хүүхдүүд нь зарлигуудыг зөрчихөөр сонгосон. Олон олноор энэ сонголтыг хийж, үнэнээс нүүр буруулснаар, тэд ертөнцийн юмсад татагдан муу ёрын болон хувирсан (Мозэс 5:12–13 -ыг үз). Үнэнээс ийнхүү тасран унах явдал тохиох нь урвалт хэмээгддэг болно.

Адам болон бусад зарлигуудыг дагагсад тэдгээр хүмүүст номлон тэднийг наманчлалд дуудахыг оролдсон. Ихэнх хүмүүс наманчлаагүй, гэхдээ Инок бошиглогчтой нэгдэгсэд нь Заин гэж нэрлэгдэх болсон. Судрууд бидэнд Инок болон тэдний бүх хүмүүс Бурхантай цуг алхаж байсныг, Бурхан тэднийг өөртөө татан авсны учир Заин энэ дэлхий дээр үгүй болсныг хэлдэг (Мозэс 7:69 -ийг үз). Хүснэгт дээрх Инокийн эрин үеийн зургийг зааж, С ба Г 107:48–53 -ыг унш.

Инок болон Заины хүмүүсийг дэлхийгээс татаж авсны дараа нүгэлтэй хүмүүсийн тоо давамгайлж эхэлсэн. Их Эзэн хүмүүсийг наманчлалд дуудан анхааруулахаар бошиглогч Ноаг илгээсэн. Хэрэв тэд эс наманчлах бөгөөс, их үерт автан дэлхийгээс арчигдах болно хэмээн Ноа тэдгээр хэрцгий хүмүүст хэлсэн. Гэвч, Ноагийн гэр бүлийнхэн нь л түүнийг сонсож зарлигуудыг дагасан. Ноагийн анхааруулсны дагуу үер болж Ноа болон гэр бүлийнхэн нь л аврагдсан байна.

Хүснэгтэн дэх Ноагийн эрин үеийн зургийг зааж, Мозэс 8:19–20-г унш.

Үерийн дараах Пристийн Зэрэг

Үерийн дараа Ноа зөв шударга үр ач нартаа пристийн зэргийг олгосон. Ноагийн дараа амьдарч Пристийн зэргийг хүлээн авсан зөв шударга нэгэн эр бол Мэлкизэдэк юм. Мэлкизэдэк туйлын зөв шударга байсны улмаас пристийн зэрэг түүний нэрээр нэрлэгдсэн (С ба Г 107:2–4-ийг үз). Мэлкизэдэк Абрахамыг, Абрахам бусад олон хүнийг пристийн зэрэгт томилсон. Тиймээс ч, Мэлкизэдэк Пристийн Зэрэг нь Мозэсийн үеийг хүртэл үргэлжилсэн.

Хүснэгтэн дэх Абрахамын эрин үеийн зурагт хандаж С ба Г 84:14 -ийг унш.

Израилчуудаас Мэлкизэдэк Пристийн Зэрэгийг авсан нь

Судрууд бидэнд хэлсэнчлэн Абрахам хүү Исаакдаа, Исаак өөрийн хүү Жакобт пристийн зэргийг олгожээ. Жакобын нэр Израил болон өөрчлөгдсөн тул Жакобын удам Израилийн үрс гэж нэрлэгдэх болжээ.

Мозэсийн өдрүүдэд Тэрээр Израилийн үрсийг Египетээс гаргасны дараа Их Эзэн Израилийн үрсэд ариун сургаалыг бүрнээр нь хүртээжээ. Гэвч тэд татгалзсаны улмаас Их Эзэн тэднээс Мэлкизэдэк пристийн зэрэг болон ариун сургаалын дээд ёслолуудыг буцаан авсан. Тэд зөвхөн ариун сургаалын бага ёслолуудтай л үлдсэн (золиослолын хууль гэх мэт) бөгөөд тэдгээр нь Мозэсийн ах Аароны нэрээр нэрлэгдсэн бага пристийн зэргээр гүйцэтгэгддэг байв.

Их Эзэн тэдэнд ариун сургаалын ёс суртахууны болон шударга журмын зарчмуудыг үлдээсэн. Эдгээр сүнслэг хуулиудаас гадна хүмүүсийн бие махбодын болон түр зуурын бусад үйл ажиллагааг удирдах хуулиуд байсан. Эдгээр хуулиудын ихэнх нь Дүрвэлт, Ливитикүс болон Дэтүрономид агуулагддаг. Тэдгээр нь ариун сургаалыг орлох бус, сүүлийн өдрүүдэд израилийн хүүхдүүдийг бүрэн ариун сургаалаар амьдрахад нь бэлтгэх арга зам болж ариун сургаалд нэмэлт болдог.

Мэлкизэдэк Пристийн Зэргийг Израил үндэстнээс авсан хэдий ч дэлхий дээрээс аваагүй юм. Мозэсийн цаг үеэс Исүс Христийн ирэх хүртэл, хэд хэдэн бошиглогчид Мэлкизэдэк Пристийн Зэргийг атгаж байсан. Тэдгээр бошиглогчид нь Илайжа, Аизаяа, Лихай, Даниэл болон Изикиэл байжээ.

Хүснэгтэн дэх Мозэсийн эрин үеийн зурагийг зааж, С ба Г 84:6, 19–27 -г унш.

Мормоны Номын Үеийн Пристийн Зэрэг

Лихай болон гэр бүлийнхэн нь Иерусалимийг орхин Америк тийш аялахад тэдэнд пристийн зэрэг байсан. Тиймээс ч, Мормоны Номын түүхийн турш зөв шударга хүмүүст пристийн зэргийн ёслолуудыг

гүйцэтгэж байжээ. Мормоны Номын үед пристийн зэргийн талаар ярьсан хоёр хүн бол Бинжамин Хаан болон Алма юм.

Хүснэгтийг зааж, Мозаяа 6:3 ба Алма 13:1–2, 8–9-ийг унш.

Исүсийн Өдрүүд дэх Пристийн Зэрэг

Исүс энэ дэлхий дээр ирэхдээ ариун сургаалыг бүрдэлээр нь дахин сэргээсэн. Тэрээр пристийн зэргийн түлхүүрүүдийг буюу бүрэн эрх мэдлийг атгаж байсан бөгөөд Төлөөлөгчдийг (Матай 10:1–4) болон Далыг (Лүк 10:1) томилжээ. Тэрээр дагалдагчдынхаа дунд Сүмийг байгуулж эцэст нь тэр дэлхийг орхин одоход Төлөөлөгчдөд бусдыг пристийн зэргийн олон олон албанд томилох эрх мэдэл өгөгдсөн байжээ (Үйлс 14:23 -ыг үз). Ийм байдлаар пристийн зэрэг дамжин Исүс Христийн Сүмийн үндэс суурь болсон юм.

Хүснэгт, Матай 16:19, Еврейчүүд 5:5–10 ба 3 Нефай 11:19–22, 12:1-ийг унш.

Томоохон Урвалт

Исүс тэнгэрт хальснаас хойш хэсэг хугацааны турш Сүм үнэнийг зааж, мянга мянган хүмүүс олон хотуудаас Сүмд нэгдсэн байна. Гэвч энэ үед түүх давтагджээ. Сүмд нэгдэгсдийн зарим нь хуулиудыг дуулгавартай дагахаас татгалзаж ариун сургаалын ёслолуудыг өөрсдийнхөө бодол санаанд нийцүүлэн өөрчилжээ. Тэр үед, Төлөөлөгчид болон пристийн зэргийн удирдагчдын хамт олон гишүүд хэлмэгдэж амиа алджээ. Эдгээр эрсийг устгаж бусад нь үнэнээс няцасны дараа Сүм пристийн зэргийн эрх мэдлээ алдсан байна. Пристийн зэрэг Сүмд үл хадгалагдах цаг иржээ.

Олон зууны турш сүнслэг харанхуйлал дэлхийд ноёлжээ. Томоохон урвалтын үед байгуулагдсан сүмүүдэд пристийн зэрэг байсангүй. Үр дүнд нь, тэд Бурханы удирдамжийг хүлээн авч, авралд шаардлагатай ёслолуудыг гүйцэтгэж чадахгүй болжээ. Аизаяагийн хэлсэнчлэн, тэд хуулийг гуйвуулж, ёслолуудыг өөрчлөн, үүрдийн гэрээг зөрчсөн (Аизаяа 29:13 -ыг үз).

2–6 үзүүлэнг таниул, “Бурханы эрх мэдэлтний гарыг толгой дээрээ тавиулан, эрчүүд пристийн зэргийг хүртдэг.”

Пристийн Зэргийн Дахин Сэргээлт

Энэхүү томоохон урвалт 1820 оны хаврын тэр өдөр залуу хөвгүүн Бурханд хандан аль сүмд нэгдэхээ асуун залбирах тэр өдрийг хүртэл дэлхий дээр үргэлжилжээ. Залбирлынх нь хариуд Бурхан Эцэг Түүний Хүү Исүс нар түүний өмнө бууж ирсэн. Эдгээр сүмүүдийн алинд ч үл нэгдэхийг Исүс түүнд хэлжээ, “тэд үг

2-6, “Бурханы эрх мэдэл өгөгдсөн хүн эрэгтэйчүүдэд гараа толгой дээр нь тавьж пристийн зэргийг хүртээдэг.”



хэлээрээ ойрхон байдагч зүрх сэтгэл нь алсад оршдог, тэд хүчийг нь агуулаагүй хэдий ч, бурханлаг шинжийг агуулан хүмүүсийн үгийг сургаал болгон заадаг” (Жозеф Смит—Түүх 1:19).

Жозеф Смитээр дамжуулан Их Эзэн энэ дэлхий дээр өөрийн үнэний Сүмээ авчирч, ариун сургаалын шаардлагатай бүхий л зарчмууд, ёслолуудыг дахин сэргээсэн. Үүнийг хийхийн тулд Их Эзэн Жозеф Смитэд он жилүүдийн туршид Адам болон бусад зөв шударга эрсийн атгаж байсан ариун пристийн зэргийг олгосон. Өнөөдөр бид тэрхүү пристийн зэргийг хадгалж байдаг бөгөөд энэ эрин үед—цаг хугацааны бүрдлийн энэ эрин үед, пристийн зэрэгийг дахин дэлхийгээс буцааж авахгүй болохыг Их Эзэн бидэнд амласан. Энэ нь Христийг дэлхий дээр эргэж ирэхэд энд байх болно.

Хүснэгтэн дэх цаг хугацааны бүрдлийн эрин үеийн зургийг зааж С ба Г 20:1, С ба Г 13, С ба Г 27:8, 12–13 ба С ба Г 86:10-ыг унш.

Дүгнэлт

Өнөөдөр бидний атгаж буй пристийн зэрэг нь Адамд өгөгдсөнтэй адил пристийн зэрэг бөгөөд Исүсийн атгадаг пристийн зэрэгтэй нэгэн адил юм. Адам болон бусад бошиглогчдын адил бид энэ дэлхий дээрх Их Эзний төлөөний хүмүүс. Түүний төлөөний хүмүүс тул бид өөрсдөдөө, гэр бүлдээ болон Сүмдээ Бурханы өмнө дахин очиход нь туслах хүчийг агуулдаг. Бишоп буюу салбарын ерөнхийлөгчийн зөвшөөрөл өгөгдсөний дараа бид үр хүүхдүүдээ усаар баталж, тэдэнд Ариун Сүнсний бэлгийг өгч, хөвгүүдээ пристийн зэрэгт томилж чадна. Ийм болон бусад олон замаар пристийн зэрэг бидний ба бусдын амьдралд баяр баясгалан авчирдаг.

Уриалга

1. Пристийн зэргийн талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилц. Та хөвгүүддээ Пристийн зэргийг хүлээн авахад зохистой байхад нь туслаж чадах замуудыг хөгжүүл.
2. Зохих цагт нь, тийн гүйцэтгэх эрх мэдэл олгогдсоны дараа хүүхдүүдээ усаар баталж, баталгаа хийн хөвгүүдээ пристийн зэргийн албанд томил.

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Priesthood Organization,” 14-р бүлэгийг судла.
2. Пристийн зэрэгтэн бүрийг пристийн зэргийн цуглаандаа судраа авчрахыг сануул.
3. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Пристийн Зэргийн Дахин Сэргээлт

Хичээл 3

Энэ хичээлийн зорилго бол Христийн үеийн дараагаар дэлхийгээс буцааж авсан ариун пристийн зэргийн дахин сэргээлтийг ойлгоход бидэнд туслах явдал юм.

Оршил

Пристийн зэрэгтнүүдийн хувьд бид өнгөрсөн үед Бурхан өөрийн үйлчлэгчиддээ өгсөнтэй адил эрх мэдлийг атгадаг.

3-а үзүүлэнг таниул, “Христ арван хоёр Төлөөлөгчдөө томилж тэдэнд пристийн зэргийн түлхүүрүүдийг өгсөн.”

Пристийн зэрэгтэйгээр бидний гүйцэтгэж болох зарим ёслолуудыг дор дурьдсан болно:

- Жон Баптист болон Нефайчууд гүйцэтгэсний адилаар усаар батлах (Матай 3:15–17; 3 Нефай 11:19–26 -г үз).
- Исүсийн адилаар ариун ёслолыг гүйцэтгэх (Лүк 22:19–20 -ийг үз).
- Паул болон Нефайчуудын адилаар Ариун Сүнснийг өгөх (Үйлс 19:5–6 ба 3 Нефай 18:37-г үз).
- Пэтрийн адилаар өвчтэйг анагаах (Үйлс 3:1–8 -ыг үз).

Эдгээр пристийн зэргийн ёслолуудыг эрт цагаас олон итгэлт пристийн зэрэгтнүүд гүйцэтгэж байсан.

Пристийн зэргийн эдгээр үүргүүдийг өнөөдөр бид яагаад гүйцэтгэх боломжтой вэ?

Бурханы пристийн зэрэг өнөөдөр дэлхий дээр байгаа тул бид пристийн зэргийн ажлыг гүйцэтгэж чадна. Эрт цагийн үйлчлэгч нарын барьж байсан пристийн зэрэг нь өнөөдөр Түүний Сүмд зохистой эрчүүдэд олгогдсон тул Бурхан пристийн зэргээр гүйцэтгэгдсэн ажлыг хүлээн зөвшөөрдөг.

Томоохон Урвалт ба Дахин Сэргээлт

Бид хоёрдугаар хичээлд Христийн үеийн дараагаар томоохон урвалт газар авсан тухай ярилцсан. Энэ нь хүмүүсийн нүгэлт байдлын уршгаар пристийн зэрэг болон Исүс Христийн үнэн сургаалын ихэнх нь өөрчлөгдөж устсан тухай юм. Олон агуу бошиглогчид хүмүүсийг үнэнээс холдохыг урьдчилан мэдсэн. Ийм нэгэн бошиглогч бол Аизаяа байжээ. Тэрээр Урвалтийн талаар өгүүлэхдээ хүмүүс хууль хөсөрдүүлж ёслолуудыг өөрчлөн үүрдийн гэрээг зөрчсөн болохыг хэлжээ (Аизаяа 24:5 -ыг үз) . Аизаяагийн бошиг биеллээ олсон. Гэм нүглээс болоод Христийн үеийн дараа



пристийн зэргийн жинхэнэ хүчийг дэлхийгээс буцааж авахад хүрсэн. Мормоны Номын хүмүүс хэсэг хугацааны туршид пристийн зэргийн адислалуудаар бялхах цорын ганц хүмүүс байсан хэдий ч эцэст нь тэд ч үнэнээс гажсан. Урвалтын уршгаар дэлхийн хүмүүс жинхэнэ ариун сургаалыг сонсож, пристийн зэргийн авралын ёслолуудыг хүлээн авч чадахгүй болжээ.

Гэвч, Тэнгэрлэг Эцэг бүх хүүхдүүдээ Түүнд буцаж очихыг хүсдэг юм. Тиймээс ч, биднийг Түүнд буцаж очихын тулд пристийн зэрэг болон ёслолуудыг нь бусад үнэний хамтаар дахин сэргээх нь Түүнд зайлшгүй шаардлагатай байсан.

Олон бошиглогчид энэ цагийг хүлээж байсан. Жишээ нь, Аизаяа Их Эзэн хүмүүсийн дунд гайхамшигийг бүтээн, гайхалтай ажлыг гүйцэтгэх тэр цагийг зөгнөн номлосон (Аизаяа 29:13–14 -ийг үз). Түүнчлэн Пэтр “бүх л зүйлийн сэргээн босголт” (Үйлс 3:19–21) явагдах тэр цагийг урьдаас хэлдэг. Сэргээн босголт нь татан буугдсан болон алдагдсан зүйлийг буцааж авчрахыг хэлж байгаа юм. Пристийн зэрэг ба ариун сургаал дахин сэргээгдэх хэрэгтэй байсан ба эс бөгөөс хүн төрөлхтөн устах байсан ажээ. 1820 онд Бурхан Эцэг ба Их Эзэн Исүс Христ нар өөрсдийгөө Жозеф Смитэд илчилснээр дахин сэргээлт эхэлсэн юм.

Жозеф Смит болон Пристийн Зэргийн Дахин Сэргээлт

Жозеф Смит бол Тэнгэрлэг Эцэгийн “шудрага агуу” сүнслэг үрсийн нэг байсан юм. Абрахамын нэгэн адил тэрээр дэлхийд ирэхээсээ өмнө чухал үүрэгт сонгогдсон байжээ (Абрахам 3:22–23-ыг үз). Үр дүнд нь, Жозеф Смитийн үүрэгийг эртний олон бошиглогч нар мэдэж байжээ. Жакобын хүү Египетийн Жозеф болон Мормоны Номын бошиглогч Лихай нар Жозеф Смитийн болон түүний үүргийн талаар мэдэж байсан. Лихай өөрийн хүү Жозефт Египетийн Жозефийн хэлсэн Жозеф хэмээн нэрлэгдэх хожмын үеийн бошиглогчийн тухай номлолыг өгүүлжээ.

2 Нефай 3:6–15 -ыг унш.

Жозеф Смит балчир наснаасаа үнэнийг хайх эрлээ эхэлжээ . Дөнгөж арван дөрвөн настай байхдаа тэрээр ойн төгөлд очиж аль сүмд нэгдэх ёстойгоо Бурханаас асуув. Залбирлынх нь үр дүнд Бурхан Исүс Христийн хамтаар бие махбод бүхий жинхэнэ дүрээрээ түүний өмнө заларчээ. Гурван жилийн дараа, 1823 онд, тэнгэрийн элч Моронай Жозеф Смит дээр айлчлан ирж, түүнд Мормоны Номын тухай өгүүлжээ. Моронай Америкийн эртний оршин суугчдын тэрхүү нандин бичээсийг Жозеф Смитэд өгсөн байна.

3-а. Христ арван хоёр Төлөөлөгчөө баталж, тэдэнд пристийн зэргийн түлхүүрүүдийг өгөв.

Бурханы тусламжтайгаар Жозеф тэрхүү бичээсийг орчуулах боломжтой байсан. Жозеф Смитэд өгөгдсөн Мормоны Ном болон илчлэлүүд нь Урвалтын үед алдагдсан олон үнэнийг дахин сэргээсэн.

Гэвч, Бурханы тухай үнэн болон Түүний сургаалуудын дахин сэргээлт нь хангалттай биш байв. Пристийн зэрэг дэлхий дээр байхгүй байх тэр үед Жозеф Смит мэндэлжээ. Тэр үүргээ пристийн зэрэггүйгээр биелүүлэх боломжгүй байсны улмаас түлхүүрүүдийг атгасан буюу түүнийг томилох эрх мэдэлтэн хүмүүсээр түүнд пристийн зэрэг өгөгдөн дахин сэргээгдэх нь зайлшгүй чухал болсон. 1838 онд Жозеф Смит, Оливэр Коудригийн хамтаар Аароны Пристийн Зэргийг хэрхэн хүлээн авсан тухай ийнхүү тэмдэглэсэн байдаг.

3-6 үзүүлэнг таниул, “Жон Баптист Жозеф Смит ба Оливэр Коудри нарт Аароны Пристийн Зэргийг олгов.”

Жозеф, Оливэр нар орчуулгаа үргэлжлүүлсээр, 1829 оны 5 сарын 15-нд тэд Их Эзэнд хандан ялтсанд дурдагдсан нүглийг наминчлах усан баталгааны талаар асуун залбирахаар ойд очив. Их Эзнийг дуудаж байх үед нь гэрэлт үүл хөлөглөсөн элч тэнгэрээс бууж ирж тэдний толгой дээр гараа тавин тэднийг Аароны Пристийн Зэрэгт томилсон. Тэрхүү элч нь Жон Баптист байлаа. Тэрээр удахгүй тэдэнд олгогдох Мэлкизэдэк Пристийн Зэргийн түлхүүрүүдийг атгадаг Пэтр, Жэймс, Жон нарын удирдлаган дор ажилладаг болхоо мэдэгдэв. Жозеф, Оливэр нар энэ өдөр усаар батлуулжээ (Жозеф Смит–Түүх 1:68–72-ыг үз).

Хожим нь тэр жилдээ, 1829 онд, Жозеф Смит ба Оливэр Коудри нарт Мэлкизэдэк Пристийн Зэрэг олгогдсон байна. Исүсийн эртний Төлөөлөгчид Пэтр, Жэймс, Жон нар тэдний өмнө залран, толгой дээр нь гараа тавин тэднийг томилжээ (С ба Г 27:12 -ыг үз). Ийн, Жозеф Смит Аароны ба Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авсан. Эрт цагт хүмүүсийн барьж байсан Бурханы хүч чадлыг энэ дэлхийд буцааж авчиран Пристийн эрх мэдлийг дахин сэргээсэн.

Аароны Пристийн Зэрэг

Аароны Пристийн Зэрэг нь Мэлкизэдэк Пристийн Зэргийн нэгэн хэсэг бөгөөд үүний удирдлаган дор ажилладаг. Аароны пристийн зэргийг Жозеф Смит ба Оливэр Коудри нарт олгохдоо, Жон Баптист тэдэнд энэ пристийн зэргийг тэдэнд олгохыг Мэлкизэдэк Пристийн Зэргийн түлхүүрүүдийг атгадаг Пэтр, Жэймс, Жон нар түүнд зааварласан болохыг өгүүлжээ.

3-6. Жон Баптист, Жозеф Смит ба Оливэр Коудри нарт Аароны Пристийн Зэргийг олгов.



Аароны Пристийн Зэрэг нь Мозэсийн ах Аароны нэрээр нэрлэгдсэн байна. Аарон, Мозэсийн заавраар Бурханы ажлыг гүйцэтгэдэг байв. Үүний адилаар Аароны Пристийн Зэрэгтнүүд нь Мэлкизэдэк Пристийн Зэрэгтнүүдээс бага эрх мэдэлтэй. Энэ шалтгааны улмаас, энэ нь агуу пристийн зэрэг болох Мэлкизэдэк Пристийн Зэрэгт хамааралтайн учир Аароны Пристийн Зэрэг нь зарим тохиолдолд бага пристийн зэрэг хэмээгддэг (С ба Г 107:14-ийг үз). Энэ нь уг пристийн зэрэг жижиг, чухал бус болохыг хэлж байгаа хэрэг биш юм. Аароны Пристийн Зэргийн тусламжтайгаар хөгшин залуу ялгаагүй эрэгтэйчүүд агуу ажлыг гүйцэлдүүлдэг.

Аароны Пристийн Зэргийн хүч болон үүргүүд нь—

- Бурханы элчүүдийн үйлчлэлийн түлхүүрүүдийг атгах. Энэ нь Бурханы ажлыг гүйцэтгэхдээ бид Бурханы элчүүдийн тусламжийг авах эрхтэй болохыг хэлнэ.
- Бусдад Аароны Пристийн Зэргийг олгох.
- Наманчлалыг номлон, усаар батлах.
- Ариун ёслолын нандин ёслолыг гүйцэтгэх.
- Ариун сургаалыг зааж, Сүмийн гишүүдийн гэрчлэлийг бэхжүүлэх.
- Сүмд өргөл цуглуулах.
- Ариун сүм, сүмийн барилга ба бусад байгууламжуудыг барихад туслах.
- Ядуу, бэлэвсэн, өнчинийг харж хандах.
- Бишоп ба чуулгын ерөнхийлөгчийн зааврын дагуу Сүмийн цаг зуурын үйлчилгээнд оролцох (сүмийн барилга цэвэрлэх гэх мэт)

Аароны Пристийн Зэргийн дикон, багш, пристийн үүрэг нь хоорондоо ялгаатай юм. Эдгээр үүргүүдийг С ба Г 20:46–59 -т тодорхойлсон.

С ба Г 20:46–59 -ийг унш.

Аароны Пристийн Зэргийг бас бэлтгэл үеийн пристийн зэрэг гэж тодорхойлж болно. Энэ нь Мэлкизэдэк Пристийн Зэргийн адислалуудыг гүйцэтгэгчэд арга замыг нь бэлтгэдэг мөн Аароны Пристийн Зэрэгтнүүдэд Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авахад нь хэрэгтэй туршлагыг олгодог.

Аароны Пристийн Зэргийн хүч чадал, эрх мэдэл гэж юу вэ?

Мэлкизэдэк Пристийн Зэрэг

Мэлкизэдэк Пристийн Зэрэг нь Хуучин Гэрээний бошиглогч Абрахамын үед амьдарч байсан Мэлкизэдэкийн нэрээр нэрлэгдсэн. Ийн нэрлэхээс өмнө, энэ нь Ариун Пристийн Зэрэг хэмээн Бурханы Хүүгийн алдараар нэрлэгдэж байжээ. Гэвч, Бурханы нэрийг

олонтаа давтахаас зайлсхийхийн үүднээс эртний Сүм пристийн зэргийг Мэлкизэдэкийн нэрээр нэрлэхээр заасан ба “учир нь, Мэлкизэдэк бол гайхамшигт дээд прист байсан ажгуу” (С ба Г 107:1–6).

Мэлкизэдэк Пристийн Зэрэг нь Сүмийн бүх л албыг тэргүүлэх эрхийг атгадаг болохыг Сургаал ба Гэрээнүүд илчилдэг. Энэ нь Сүмийн бүх л алба нь Мэлкизэдэк Пристийн Зэргийн нэгэн хэсэг болох хэрэг болой. Үүнээс илүүтэй эрх мэдэл эсвэл пристийн зэрэг гэж үгүй. Нэмж хэлэхэд, энэ пристийн зэрэг нь биднийг Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиход зайлшгүй бүх л сүнслэг ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэлтэй юм (С ба Г 107:8–19 -ийг үз).

Мэлкизэдэк Пристийн Зэргийн хүч болон үүргүүд нь—

- Ариун Сүнсний бэлгийг хүртээх.
- Зохистой эрчүүдийг Мэлкизэдэк Пристийн Зэрэгт томилох.
- Ариун сүмийн гэрлэлтийг гүйцэтгэх.
- Амьд болон нас нөгчөгсдөд зориулан ариун сүмийн ажлыг гүйцэтгэх.
- Өвчтөнийг адислах
- Бүх хүний сэтгэлийн болон цаг зуурын сайн сайханд дэм үзүүлэх.
- Сүмийн төлөө Бурханаас мэдлэгийг хүлээн авах.

Ахлагч, дээд прист, патриарх, Дал, Төлөөлөгчийн албууд нь онцгой хариуцлагынхаа улмаас ялгаатай байдаг. Мэлкизэдэк Пристийн Зэрэгтнүүд Аароны Пристийн Зэрэгтний бүхий л үүргийг гүйцэтгэж болно; учир нь Аароны Пристийн Зэргийн үүргүүд нь Мэлкизэдэк Пристийн Зэргийн үүргүүдийн нэг хэсэг юм. Мэлкизэдэк Пристийн Зэргээр бид өөрсдийгөө болон бусдыг нэгэн өдөр тэнгэрийн хаант улсад ороход нь бэлтгэдэг.

Урьдаас товлосон пристийн зэрэгтнээс Үйлс 19:1–6 -д өгүүлэгдсэн, Паул зарим шавь нарыг дахин усаар баталсан тухай явдлыг уншихыг хүс. Эдгээр хүмүүс юуны учир дахин усаар батлуулах хэрэгтэй байсан бэ?

Дүгнэлт

Пристийн зэрэг дэлхий дээр байгаагүй бол бид Бурханы ажлыг хийж чадахгүй бөгөөд үнэний сүм оршин тогтнох боломжгүй байх юм. Хэн ч мөнхийн амьдралыг олохгүй байсан нь дамжиггүй. Мөнхийн амьдрал нь зөвхөн зарчмууд болон ариун сургаалын ёслолуудыг сахигсдад ирэх бөгөөд ариун сургаалын ёслолууд нь пристийн зэрэггүйгээр гүйцэтгэгдэх нь үгүй юм. Пристийн зэрэг нь хүний бус Бурханы хүч учир хүн өөртөө пристийн зэргийг өгч чадахгүй. Хүн зохих эрх мэдлийн дагуу үл хүртсэн бол бусдад ч үүнийг олгож чадахгүй (С ба Г 42:11 -ийг үз). Эдгээр шалтгааны

учир пристийн зэрэг тэнгэрийн элчүүдээр дамжин Жозеф Смитэд дахин сэргээгдсэн юм. Өнөөдөр бүх хүн төрөлхтөний тусын тулд Их Эзэний ажлыг гүйцэлдүүлэхээр дахин сэргээгдсэн Исүс Христийн үнэний сүмд пристийн зэрэг агуулагддаг (С ба Г 84:17 -г үз).

Бурханы пристийн зэргийг хүлээн авсан Сүмийн эрэгтэй гишүүн бүр өөртөө болон гэр бүлийнхэндээ, эргэн тойрныхоо бүх л хүмүүст мөнхийн амьдралын адислалуудыг мэдрэн баясахад нь туслах өндөр хариуцлагыг хүлээдэг.

Уриалга

1. Пристийн зэргийнхээ боломж болон үүргийг судла. Үүнийг та судраа уншиж, мацаг барин залбирч, пристийн зэргийн гарын авлагаа судлаж пристийн зэргийн удирдагчдаасаа заавар авснаар хийж болох юм.
2. Пристийн зэргийн үүргээ бүхий л чадвараа дайчлан гүйцэтгэж, үйлчлэлээ нэмэгдүүлэхээр үргэлж чармай.
3. Эрх мэдлээр давуу нэгнийг дэмжин, өөрт тань өгөгдөөгүй хүч болон эрх мэдлийг байгаа хэмээн буруу сэтгэхээс зайлсхий.

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. Пристийн зэргийн тухай ойлголттой болохын тулд С ба Г 13; 20; 84; 107; 121 ба 124 -р бүлгүүдийг унш.
2. *Gospel Principles* гарын авлагаас “The Priesthood Organization,” 14 ба “The Church of Jesus Christ Today,” 17-р бүлгүүдийг судал.
3. Энэ хичээл дэх түүх ба судраас уншиж танилцуулахыг гишүүдэд даалга.

Энэ хичээлийн зорилго бол пристийн зэргийн чуулга хувь хүн, гэр бүл, болон Сүмд хэрхэн тусалдаг арга замуудыг ойлгоход бидэнд туслах явдал болно.

Оршил

Пристийн зэрэгтнүүд бид Сүмийн удирдлагаар хэлүүлэлгүйгээр олон зүйлийг өөрсдөө хийх эрх чөлөө болон хариуцлагыг хүлээдэг (С ба Г 58:26–29 -ийг үз). Бид ажлаа хийж; гэр бүлийнхэндээ анхаарал тавин; дуулгавартай байж; өөрсөддөө, гэр бүлийнхэндээ болон бусдад олон сайн үйлсийг хийж болно. Гэвч, заримдаа бидэнд хэн нэгний тусламж хэрэг болно гэдгийг бид ойлгох учиртай. Бид шаварт гацаж, тусламж гуйх хүчгүй болтлоо өвдөж, хүүхдийн дуулгаваргүй байдалд зүрхээ эмтэлж, эсвэл хэн ч танд анхаарал тавихгүй байгаа юм шиг санагдаж болох юм.

Нэг өдөр хадланч саравчиндаа өвсөө нуруулдаж байхдаа ширүүн бороо орох гэж байгааг анзаарчээ. Хэрэв борооноос өмнө нуруулдаж дуусахгүй бол өвс нь сүйрч магадгүй тул түүнд нэн даруй тусламж хэрэгтэй байлаа. Тэр хөршүүдээсээ тусламж хүсэн, тэд ч түүнд борооноос өмнө өвсөө нуруулдахад нь туслав. Тэдний тусламжтайгаар тэрээр хадлангаа аврах боломжтой байсан юм.

Ийм байдлаар бидэнд ганцаар шийдэж чадамгүй хувийн болон гэр бүлийн асуудал тулгарахад бид бусдаас тусламж гуйхаас эмээхгүй байх нь зүйтэй.

Хэн бидэнд туслах вэ? Бид хаанаас тусламж хайх вэ?

Пристийн Зэргийн Чуулгуудын Зорилго

Пристийн зэргийг өсгөж бусдад үйлчлэхийн тулд хамтран ажиллаж Сүмээ байгуулахын тулд пристийн зэрэгтнүүдэд туслахаар Тэнгэрлэг Эцэг пристийн зэргийн чуулгуудыг байгуулжээ. Тэдгээр нь түүнчлэн хэрэгцээтэй үед бие биендээ туслахад нь гишүүдийг дэмжихээр бүтээгдсэн.

Пристийн зэргийн чуулга нь пристийн зэргийн ижил албыг хүлээсэн эрчүүдийн бүлэг юм. Цөөн тооны пристийн зэрэгтэн эрчүүдтэй Сүмийн зарим нэгдлүүдэд бүх пристийн зэрэгтнүүд ямар алба хүлээснээсээ үл хамааран нэг бүлэг болон зохион байгуулагддаг.

Пристийн зэрэгтэн олон эрчүүдтэй Сүмийн нэгдлүүдэд дээд пристийн, ахлагч нарын, пристийн, багш нарын, диконы чуулгууд тус тусдаа зохион байгуулагдана. Пристийн чуулгаас бусад чуулга бүрийг ерөнхийлөгч болон хоёр зөвлөхүүд нь тэргүүлдэг. Хэсгийн пристийн чуулга нь бишоп болон хоёр пристийг туслах болгон тэргүүлдэг. Гадасны ерөнхийлөгч, түүний зөвлөхүүд нь гадасны бүх дээд пристүүдэд зориулсан дээд пристийн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл болдог.

Нэг нэгэндээ туслан, бие биендээ хүлээсэн хариуцлагыг нь заах үүргээ биелүүлэхэд нь чуулгын гишүүдэд туслахын тулд чуулгын цуглаан Ням гариг бүрт явагддаг. Эдгээр цуглаануудад, чуулгын дотоод үйл ажиллагаа зохицуулагдаж, пристийн зэргийн даалгавруудыг оноож, ариун сургаалыг зааж, гэрчлэлүүд батжиж, гишүүн бүрийн сүнслэг байдал нэмэгддэг.

Пристийн зэргийн үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлэх талаар судруудад хэлсэн байдаг.

С ба Г 107:99–100-г унш.

Чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл болон бүлгийн удирдагчид нь бидэнд пристийн зэргийн үүргийг маань заах болон эдгээр үүргүүдийг гүйцэтгэх явцдаа суралцах боломжуудыг олгох учиртай. Бид үүргээ мэдсэний дараа пристийн зэргийн томилогдсон албандаа хичээнгүйлэн ажиллах нь бидний хариуцлага болно. Бид пристийн зэргийн дуудлагаа бусдад үйлчлэх болон чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлөөс даалгавар хүлээн авах замаар хичээнгүйлэн биелүүлснээр өөрсдийн үйлчлэх ойлголт болон чадавхиа дээшлүүлдэг.

Сурч, гүйцэтгэсэн пристийн зэргийн үүргүүдээсээ ярилцахыг гишүүдээс хүс.

Пристийн Зэргийн Чуулгууд Хэрхэн Үйл Ажиллагаагаа Явуулдаг Болох нь

Бошиглогчдоороо дамжуулан Их Эзэний бидэнд илчилсэн ариун сургаалын бүх л зарчмуудыг пристийн зэргийн чуулгууд хүлээн зөвшөөрч хэрэглэдэг. Зарим чухал зарчмууд нь зөв шударга ёс, эв нэгдэл, дэмжлэг болон нөхөрлөл болно.

ШУДАРГА ЕС

Пристийн зэргийн эрх нь тэнгэрийн хүчтэй салшгүй холбоотой бөгөөд тэнгэрийн хүч нь зөвхөн зөв шударга ёсны зарчмуудыг хэрэглэснээр л хянагдаж, үйлдэгддэг болохыг Их Эзэн бидэнд хэлдэг (С ба Г 121:36 -г үз). Пристийн зэргийн чуулгын хүч гишүүдийнх нь хүчээс хамаарна. Илүү зөв шударга болох бүрдээ Их Эзэнээс бид илүү хүч, удирдамжийг хүлээн авна.

ЭВ НЭГДЭЛ

“Чуулга нь бид нэг нэгэндээ сүнслэг төдийгүй материаллаг хэлбэрээр, мөн өөр олон аргаар тус дэм болж чадахуйц хэмжээнд эв нэгдэлтэй байх учиртай. Эв нэгдлийн сүнсийг чуулгадаа агуулж чадсан тэр үед л бид Сүмийн пристийн зэргийн байгууллагын бүрэн утгыг ойлгож эхэлнэ.” (Дэвид О.МакКэй, “The Fundamental Basis for Home Teaching,” *Improvement Era*, 1963, 7 сар, х. 615).

ДЭМЖЛЭГ

“Пристийн зэргийн бүх л чуулгууд . . . өөрсдийгөө цэгцлэх, Пристийн зэргийн хүчний сүнсэн дор сэтгэлийн дарамтанд байгаа хүн бүр чуулгынхаа дэмжлэгээр биеэ даах чадвартай болж байгаа эсэхийг тодотгохоор Их Эзэнээс ‘зарлиг хүлээсэн’ болно” (Харолд Б. Ли, “The Place of the Priesthood Quorum in the Church Security Program,” *Improvement Era*, 1937 он, 10 сар, х. 634).

НӨХӨРЛӨЛ

Сүмийн эхний өдрүүдэд эрчүүд чуулгадаа “өөрсдийнхөө чин сэтгэлийн шударга зүтгэлийг зориулж байжээ. . . . Пристийн зэргийн тэдгээр чуулгуудад бүрэлдсэн нөхөрлөлийн бүрэн хүч чадал, гайхамшигийг бид мэдэж чадашгүй. Номлолын ажилд алс одсон үед нь эрчүүд бие биенийхээ гэр бүлийг харж хандаж байсан. Бэрхшээл гунигаа хуваалцан, шударга журам бүрэлджээ. . . . Эрчүүд халуун амиа ч нэг нэгэндээ зориулахад бэлэн байсан

“Нэгэнтээ оршиж асан бие махбодын аюул бидэнд тулгараагүй нь үнэн хэдий ч, өвөг дээдэст маань тулгарч байснаас илүү аймшигт үр уршигтай байж болзошгүй хэмээн айдсыг минь төрүүлж буй тоолшгүй олон аюул бидэнд нүүрлээд байна. Эдгээр нөхцөл байдалтай учирахад бидэнд нөхөд хэрэгтэй юу? Тийм ээ!” (Стэфэн Л. Ричардс, “The Priesthood Quorum: A Three-fold Definition,” *Improvement Era*, 1939он, 5-р сар, х. 294).

Ариун сургаалын талаарх хандлагаа бэхжүүлэх хэрэгтэй болох аваас, чуулгын бүх л итгэлт ахан дүүс бидэнд анхааруулахаар, биднийг сүнслэг байдлаар тэтгэхээр, үйл ажиллагаанд буцаж орох замаа олоход туслахаар нэгдэх болно гэдгийг мэдэх нь бидэнд тайтгарлын ундарга болдог. Ахлагч Боид И. Пакэр хэлэхдээ: “Идэвхгүй болсон хүн чуулгын гишүүний байдлаа алддаггүй. Тэрээр чуулгын талаар сонирхлоо алдаж болох хэдий ч, чуулга хэзээ ч гишүүнийхээ талаар сонирхолоо гээх учиргүй. Чуулга нь үргэлж, цаг ямагт гишүүн бүрийнхээ төлөө хариуцлага хүлээдэг. Идэвхгүй гишүүнээ эс хэрэгсэн сонирхлоо бууруулж түүнтэй үл харилцах нь пристийн зэргийг атгаж байгаагийнх нь хувьд өөрийнхөө эрхийг

үгүйсгэж буй хэрэг болно.” (A *Royal Priesthood* [Melchizedek Priesthood study guide, 1975], х. 134).

Бүгдээр хамтдаа нэгдэж, бүрэлдэхүүн төгсөөр хадгалагдахын учир, Сүмд гишүүн бүр нь хэрэгтэй (С ба Г 84:110 -ыг үз). Сүмийн байгууллага өнөөгийн дэлхийд хамгийн төгс нь бөгөөд пристийн зэргийн чуулгууд нь энэ байгууллагын амин чухал хэсэг нь болно. Пристийн зэргийн чуулга хариуцлагаа тодорхойлохдоо чуулгын бүх гишүүдийн талаар бодолцсон байх ёстой. Ахлагч Пакэр ийнхүү хэлжээ: “Пристийн зэргийн чуулга нь зохих ёсоор үйл ажиллагаагаа явуулж байвал чуулгынхаа ах нараар дэмжүүлсэн тухайн хүн амьдралын ямар ч хариуцлага тулгарсан үед доголдох нь бараг үгүй.” (A *Royal Priesthood* [Melchizedek Priesthood Study Guide, 1975], х. 134).

Чуулгын гишүүн бүр өөрийн үүргээ биелүүлэх үед чуулгын үйл ажиллагаа зохих ёсоор явагдана. Жишээ дурдахад, гэрийн багшаар үйлчилснээр пристийн зэрэгтнүүд чуулгын ерөнхийлөгч болон чуулгад хамрагдах бүх гэр бүлийн хооронд холбоос нь болдог. Гэрийн багш нар асуудлыг тодорхойлж, хэрэгцээ шаардлагыг илтгэснээр, чуулга үйл ажиллагаанд шилжиж чадна. Эдгээр мэдээллийг ашиглан пристийн зэргийн чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлаган дор чуулга нь чуулгынхаа гишүүдэд тусламж хэрэгтэй үед нь дэмжлэг үзүүлэх боломжтой болно.

Гэр бүлийн дараагаар, чуулга нь тусламжийн анхдагч эх сурвалж болдог. Иймээс чуулгын гишүүд туслалцаа шаардлагатай чуулгын гишүүдэд хариу өгөх ёстой.

Пристийн зэрэгт ахан дүүсийн ёсоор пристийн зэргийн чуулгын гишүүд бие биендээ үйлчлэх ямар онцгой арга замууд байж болох вэ?

Пристийн Зэргийн Чуулгын Гишүүдийн Ёсоор Өөрсдийн Үүргийг Гүйцэтгэх нь

С ба Г 108:7 -г уншихыг гишүүдээс хүс. Бие биендээ урам зориг нэмэрлэхийн тулд бид юу хийж болохыг энэ судар бидэнд хэлж байна вэ?

Сударт дурдсан арга замуудыг самбарт бич.

Бусад олон зүйлсийн сацуу пристийн зэрэгтэн ахан дүүстээ юу хэлж, юу зааснаараа тэднийг зоригжуулж чаддагийг Их Эзэн цохон хэлсэн байдаг. Ерөнхийлөгч Ж. Рүбэн Кларк Жр. чуулга нь чуулгын гишүүн бүрийн бие биенээ хайрлах хайр хүндэтгэлтэй түвшинд бат бэх байдгийг хэлжээ.

“Чухал хэрэгцээ, асуудал тулгарсан үед нь тусламж хэрэгтэй ах нарт чуулга: байшин барих, худалдаа арилжаа эхлэх, гар урлаач бол

багаж хэрэгсэл худалдаж авах, тариаланч бол үр тариаг нь цуглуулах, ургацаа суулгаж, хурааж авах, тулгамдсан хэрэгцээ гарахад нь хувцас, сууц, хоол хүнс, эмнэлгийн тусламж, хүүхдүүдэд нь хичээлийн хэрэгсэл, бусад олон төрлийн зүйлээр хангаж дэмжлэг үзүүлдэг.” (“Church Welfare Plan,” a discussion by President J. Reuben Clark before the First Citizens’ Conference on Government Management at Estes Park, Colorado, 1939, 6-p cap, x. 20).

Хэрэв бид бие биенээ чин сэтгэлээсээ хайрлан хүндэтгэвэл бидний чуулга ямар байх вэ?

Пристийн зэргийн чуулгын зорилго нь пристийн зэрэгтэн бүрт пристийн зэргээ чуулгын бусад гишүүддээ хэрэгцээтэй цагт туслахын тулд хэрхэн хэрэглэхэд сурахад нь дэмжлэг үзүүлэх явдал юм. Энэ зорилго нь зөвхөн гишүүн бүр туслах эрмэлзэлтэй байж мөн чуулгын гишүүдийн хэрэгцээ тодорхойлогдсон үед л биеллээ олно. Энэ шалтгааны улмаас бид гачигдалтай нөхдийнхөө талаар чуулгын удирдагчиддаа мэдээлэх болон өөрсдөө шаардлагатай үедээ тусламж гуйх учиртай. Бусдын хэрэгцээг мэдтэлээ чуулгын гишүүд бусаддаа туслаж чадахгүй юм. Хүн бүр өөрсдийн асуудлаа шийдвэрлэхээр хичээх нь зүйтэй хэдий ч, бидэнд чуулгын тусламж хэрэгтэй цаг тохиолдох нь дамжиггүй. Бусад маань үйлчлэх боломжоор хангагдахын учир, бид тусламж гуйхаасаа эмзэг хэрэггүй.

Дараах түүх чуулга нэгэн гишүүндээ хэрхэн тусалсныг илэрхийлнэ.

“1918 оны намар, Дэлхийн Нэгдүгээр Дайны үеийн аймшигт нөхцөлд 14 сая гаруй хүн нас нөгчсөн юм. Өвөл эрт болж . . . хөрсөндөө байсан чихрийн манжингийн ихэнхийг хөлдөөлөө. Аав, Францис ах хоёр өдөр бүр хөлдүү хөрснөөс нэг тэрэг чихрийн манжин ухан гаргаж, нэг нэгээр нь оройг нь таслан, чихрийн манжингийн том улаан тэргэнд ачин чихрийн үйлдвэр тийш зөөдөгсөн. Флоид ах бид хоёр цэрэгт байсан тул энэ нь хөрс хөлдсөний дараа туслах хүчээр дутмаг хэцүү ажил байсан. . . .

“Тэд гэр бүлдээ мөнгө олох ганц зүйл болох ургацын ажилд өдрийн ганц хоолтойгоор зүтгэж байхад нь Чарлэс ахын есөн настай хүү Кэннэф хурц хатгаа хүрч хэдхэн цаг хүнд өвдсөнийхөө дараа эцгийнхээ гар дээр амьсгаа хураасан тухай том ах Жорж Албэрт муу мэдээ дуулгаж, аавыг Огдэнд ирж, хүүг гэр бүлийнх нь булш, Лихайн оршуулгын Газарт хүргэхийг хүсэн утсаар ярьжээ.

“Жижигхэн ачийнхаа цогцсыг оршуулахаар гэртээ авчрах гэж аав минь Огдэний Таван Цэгийг чиглэжээ. Гэрт нь хүрэхдээ, тэрээр Чарл халуундаа шатан, нас барсан хүүгээ тэврээд сульдан хэвтэж байхыг нь олсон байна.

“Үхэлтэй тулгарсан залуу эцэг, ‘хүүг минь аваад яв, гэр бүлийн булшинд аваачиж тавьчихаад миний хойноос маргааш ирээрэй’ гэж бувтнажээ.

“Аав Кэннэфийг гэртээ авчирч, мужааны өрөөндөө авс хийж, ээж эгч нарын маань хамт даавууг нь бэлдэн, дараа нь аав, Франц хоёр, хоёр найрсаг хөршийнхөө хамтаар булшны нүх ухахаар явжээ. Олон олноор үрэгдэж байсан тул гэр бүлүүд нь өөрсдөө нүх ухдаг байлаа. Оршуулгын товчхон залбирал л тэр үед хийгдэж байсан ганц ёслол юм.

“Тэднийг оршуулгын газраас дөнгөж ирснийх нь дараа утас дуугарч, Жорж Албэрт бас нэгэн зүрх зүсэм мэдээ сонсгожээ: Чарл нас барсан бөгөөд 7 настай Вэста, 5 настай Илаин гэх хоёр охин нь хүнд өвдсөн, мөн 4-тэй Рэлдон, 3-тай Полинь хэмээх хоёр нялх нь үхэх сэхэхийн даваан дээр байлаа.

“Бидний хэдэн сайн үеэлүүд . . . Чарлд авс бэлдэж, түүнийг төмөр замын ачааны машинаар гэр лүү явуулсан юм. Аав залуу Францын хамт биеийг нь төмөр замын зогсоолоос авчирав. . . .

“Дараагийн өдөр нь ядарч туйлдсан настай аав маань – энэ удаа тас хар үстэй, цэнхэр нүдтэй, инээмсэглэлээр дүүрэн байдаг Вэстаг авчрах гашуудалт үүрэгт дуудагджээ.

“Тэнд очихдоо аав маань цэнхэр нүдтэй алтан үстэй бяцхан Бурханы элч болсон Илаиний өлгийнх нь хажууд сөгдөн суугаа гашуудалд сөхөрсөн залуу эх Жулиетийг олжээ. Жулиет сэтгэл эмтрэмээр уйлан, залбирч байв. . . .

“Аавыг Вэстагийн цогцсыг гэртээ авчрахынх нь өмнө гашуудлын үг дахин иржээ. Илаин, аав, Кэннэф ах, Вэста эгчтэйгээ нэгдэхээр одсон байлаа. Энэ нь аавын минь нэг долоо хоногийн дотор гэр бүлийнхээ дөрөв дэх гишүүнийг авчран нутаглуулахаар хийсэн зүрх зүсэм бас нэгэн аялал байлаа.

“Илаинийг оршуулсан тэр үдэш ч, маргааш өглөө нь ч үхлийн гамшигт мэдээ дуулгахаар утас дахин дуугарсангүй. . . .

“Өглөөний хоолны дараа аав Францад хандан, ‘Хүү минь, бид талбайд очиж, улам илүү хөлдөхөөс нь өмнө ахин нэг тэрэг чихрийн манжин ухаж гаргахыг бодъё. Морьдоо хөллө, замдаа гаръя.’ гэжээ.

“Францис дөрвөн морь хөллөсөн тэргээ замд оруулахад аав хажуунаас авиран гарчээ. Тэднийг Саратога замаар явж байхад нь хөрш тариаланчдынх нь жолоодсон, чихрийн манжин овоолсон тэрэгнүүд ар араасаа цуван зөрж өнгөрлөө. Хажуугаар нь өнгөрөхдөө хүн бүр нэгийг хэлнэ: ‘Сайн байна уу, Жорж ахаа,’ Бид

гүн эмгэнэж байна, ‘Жоржоо’ Танд олон нөхөд бий шүү’ гэх зэргээр даллан мэндчилж байв.

“Сүүлчийн тэргэнд Жаспэр Ролф явлаа. Тэр сэтгэл өндөр мэндлэн, ‘Энэ эцсийнх нь, Жорж ахаа,’ гэж хэлэв.

‘Аав маань Францис ахад хандан, ‘Энэ бүгд манайх байсан ч болоосой,’ гэжээ.

‘Талбайдаа ирээд Францис чихрийн манжингийн том улаан тэрэгнээсээ үсрэн бууж талбайнхаа хаалгыг дэлгэн орлоо. Тэрээр бүгдийг зогсоон, хэдэн хором зүүн-баруун, урагш-хойш талбайг гүйлгэн харав–бүх л талбайд нэг ч чихрийн манжин байсангүй. Тэр үед л, Жаспэр Ролфийн ‘Энэ эцсийнх нь, Жорж ахаа,’ гэж хэлсний учрыг тэрээр ухаарчээ.

“Аав маань тэрэгнээс бууж, өөрийнхөө үргэлж биширдэг тэрхүү шим тэжээлт бор хөрснөөс атган авч, дараа нь эрхий хуруугүй зүүн гараараа чихрийн манжингийн таслагдсан оройг өргөж хөдөлмөрийнхөө бэлэг тэмдэг нь болсон бүхэл тийш нүдэндээ итгэхгүй байгаа мэтээр ширтэв.

“Аав–зургаа хоногийн дотор хайрлан хүндэтгэдэг гэр бүлийнхээ дотно дөрвийг оршуулахаар авчирсан: авс хийж, булшний нүх ухан; тэр ч бүү хэл оршуулгын хувцас бэлдэлцсэн-энэ эр, тарчлал авчирсан энэ бүх л мөчүүдийн туршид бүдэрч, няцан ухарч, эргэлзэн тээнэгэлзээгүй энэ гайхамшигт эр–чихрийн манжингийн оройг таслан хураасан овоон дээр суун баярлаж талархсандаа хүүхэд шиг цурхиран уйлжээ.

“Тэрээр өндийж том улаан алчуураараа нүдээ арчин, тэнгэр өөд ширтээд, ‘Эцэг минь, хэсгийнхээ ахлагч нарын төлөө тандаа баярлалаа’ гэж хэлсэн.” (Les Goates, as quoted by Vaughn J. Featherstone, “Now Abideth Faith, Hope and Charity,” *Ensign*, July 1973, pp. 36–37.)

Дүгнэлт

Сүмийн бүх л чуулгууд Их Эзэний зорилгыг хэрэгжүүлэхээр байгуулагддаг. Пристийн зэргийг атгадгын хувьд бид өөрсөддөө оногдсон хариуцлагыг биелүүлэх учиртай.

Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит ийнхүү бичжээ: “Сүмийн түүхэнд пристийн зэрэгт өгөгдсөн хариуцлагын биелэлт урьд хэзээ ч өнөөдрийнхөөс илүү чухал байсангүй. Урьд өмнө бид хэзээ ч, Их Эзэнд үйлчлэх, зарлигуудыг нь сахих, өгөгдсөн дуудлагаа хичээнгүйлэн биелүүлэх үүнээс илүү хариуцлага хүлээж байсангүй. (Doctrines of Salvation, 3:117.)

Уриалга

1. Өөртөө оногдсон даалгавруудыг биелүүл.
2. Чуулгын бусад гишүүдийнхээ хэрэгцээ шаардлагыг мэд.
3. Тусламж хэрэгтэй үедээ пристийн зэргийн чуулгадаа ханд.

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. С ба Г 107:21–26, 58–66, 85–100 -г унш.
2. Самбар, шохой бэлтгэ. Эдгээр нь ихэнх хичээлд хэрэглэгдэх тул долоо хоног бүр ангидаа бэлэн байлгах нь зүйтэй.
3. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг ангийн гишүүдэд даалга.

Энэ хичээлийн зорилго бол диконы үүргийг ойлгоход бидэнд туслах явдал болно.

Оршил

Сүмийн Ерөнхийлөн Удирдах Бишоп Сүмийн диконуудад хандан дараах зөвлөмжийг өгч байна:

“Бүх хүн Бурханы хүүхдүүд хэдий ч, та нар нэгэн илүү зүйлийг агуулдаг. Та нарт Түүний нэрээр үйлдэх эрх мэдэл байна. Энэ нь та нарыг бүх л ертөнцөөс онцгойлон тусгаарладаг. Энэ нь та нарыг шууд л бусдаас илүү болгохгүй ч, бусдаас илүү сайн амьдрах хариуцлагыг оногдуулдаг.

“Та нар Бурханы хүүхэд, мөн Түүний пристийн зэргийг атгадаг гэдгээ мэддэг учраас адислалыг агуулдаггүй бусадтай харьцуулахад та нараас илүү ихийг шаарддаг юм.” (Виктор Л. Браун, “The Aaronic Priesthood—A Sure Foundation,” *Ensign*, 1972, 7-р сар, х. 90.)

Диконы Үүрэг

Диконууд бид Их Эзний үйлчилгээнд байгаа (С ба Г 64:29 -ийг үз). Их Эзэний ажил бол бидний ажил. Үүргээ биелүүлэн пристийн зэргээ алдаршуулахдаа бид Аврагчаа алдаршуулдаг. Тиймээс ч, Аврагчдаа хайр хүндэтгэлээ үзүүлэх хамгийн сайн арга замуудын нэг бол диконы хувьд бид үүргээ биелүүлэх явдал юм. Эдгээр үүргүүд нь Сүмдээ анхаарал тавин ариун ёслолыг түгээх болно.

“Сүмдээ анхаарал тавих” ба “Ариун Ёслолыг Түгээх” хэмээн самбарт бич.

Сүмдээ анхаарал тавих гэдэг нь бусад олон зүйлүүдийн хажуугаар цаг зуурын хэрэгцээнд нь гишүүдэд туслах явдал болно. Идэх хоолтой, орох оронтой, өмсөх хувцастай байх нь цаг зуурын хэрэгцээ юм. Мацгийн өргөлийг цуглуулж, тэтгэлтийн хөтөлбөрт ажиллан, гачигдалтай хүмүүст үйлчилгээ үзүүлэх замаар Сүмийн цаг зуурын хэрэгцээнд анхаарлаа хандуулан диконууд бишопт тусалдаг.

Мацгийн өргөл цуглуулах тухай дараах түүх залуу дикон энэ хариуцлагын чухлыг хэрхэн ойлгосон болохыг харуулна. Энэ явдал олон жилийн тэртээ гишүүд гачигдалтай нэгэнд туслах мацгийн өргөл болгон хоол, хувцас, болон шатахуун тос өгдөг байсан үед болжээ.

“Би дикон байсан тул гудамжныхаа хүмүүсээс мацгийн өргөл цуглуулах ёстой байлаа. Сахалтай, нас тогтсон, Питэр Рэид ах биднийг удирддаг байсан бөгөөд мацгийн өргөл цугларч хэрэгцээтэй нэгэнд хүргэгдсэн эсэхийг тодорхойлох нь түүний үүрэг байлаа.

“Би гудамжныхаа бүх сүмийн гишүүн айлд очин, . . . гачигдалтай нэгэнд ямар нэгэн юм өгөх боломжийг тэдэнд олгох учиртай байв. Нэг нь уут дүүрэн нүүрс өгөхөд, нөгөө нь түлшний мод, бас нэг нь гурил, сав жимс, аяга элсэн чихэр, талх, гэх мэтийг өгдөгсөн. . . .

“Нэгэн Бямба гаригт манай хөл бөмбөгийн баг тоглохоор төлөвлөж, би ч тэсэн ядан хүлээж байлаа. Мацгийн өргөл цуглуулах нь миний үүрэг бөгөөд үүргээ умартах учиргүй гэдгээ мэдэж байсан боловч би тоглохыг юунаас ч илүү хүсч байв. Үүргээс илүү хүсэл маань давамгайлж, би хөл бөмбөг тоглов. . . .

Дараах өглөө нь Рэид ах манай арын хаалгыг тогшин, намайг асуулаа. Би буруу хэрэг хийсэндээ гэмшин–хаашаа ч хамаагүй нуугдахыг хүссэн–гэвч би толгой бөхийн түүнтэй уулзав. Тэрээр зөвхөн, ‘Уиллард, надтай хамт бага зэрэг алхах хэдэн минут чамд байна уу?’ гэж асуулаа.

“Намрын тэр өдөр сэрүүн байв.

“Би түүний хамтаар эхлээд, Нэгдүгээр хойд ба Гуравдугаар баруун гудамжнуудын уулзвар буланд орших жижиг модон байшингуудтай талбайд очлоо. Тэрээр нэгэн хаалгыг тогшиход, ядруу туранхай эмэгтэй хаалга тайлав.

“Тэр эмэгтэй ийн хэлсэн юм: ‘Рэид ах аа, бид өчигдөр хоол аваагүй, энэ байшинд идэх юм юу ч алга даа.’

“Рэид ах хариуд нь: ‘Эгч минь, уучлаарай, гэхдээ өнөөдрийн энэ өдөрт багтаад бид танд ямар нэг юм өгнө.’

“Дараа нь, тэр талбайн дээд эцэст байрлах нэгэн хаалгыг бид чиглэсэн. Тогшсоны хариу болгон нэгэн дуу биднийг орохыг урив.

“Бид ороод настай эрэгтэй эхнэрийнхээ хамт орондоо хэвтэж байхыг харлаа. Тэр эрэгтэй ‘Рэид ах аа, бид нүүрсгүй болсон, дулаацахын тулд орондоо л байх хэрэгтэй байна,’ гэв.

“Талбайн нөгөө хэсэгт бид олон хүүхэдтэй жижигхэн ээжтэй мэндэллээ. Нялх хүүхэд нь уйлагнан, бусдынх нь нүдэнд нулимс цийлэгнэнэ.

“Энэ надад хангалттай байсан! . . .

“Би хайнга байдлаар үүргээ умартсандаа харамсан уйлах дөхлөө. . . . Тэдгээр хүмүүсийг хоол, нүүрсээр үдээс өмнө хангаж би маш чухал



нэгэн сургамжийг авсан юм.” (“Program Outline for Teaching Observance of the Law of the Fast,” 1965, x. 19–20).

Гэвч, мацгийн өргөл цуглуулах нь Сүмд анхаарал тавих ганц арга юм Өөр арга нь бэлэвсэн эмэгтэйд цэцэрлэгийн ажилд нь тариалах, услах, тордох замаар тусалж болох юм. Ургац хураалтын үед, бид үүнд хүнсээ цуглуулж хадгалахад нь тусалж болно. Эдгээр зүйлийг хийснээр бид түүний цаг зуурын хэрэгцээнд нь тусална.

Үзүүлэнгүүдийг таниул, 5-а, “Диконы үүргүүдийн нэг нь мацгийн өргөл цуглуулах болно,” 5-б, “Тэтгэлгийн хөтөлбөрт чуулга болж ажиллах нь диконуудын Сүмд анхаарал тавих нэг арга болно.”

Сүмд анхаарал тавина гэдэг нь түүнчлэн, зарлигуудыг сахихад нь гишүүдэд туслах явдал болно.

Зарлигуудыг сахихад нь гишүүдэд бид хэрхэн туслаж чадах вэ? (Өөрсдийнхөө үг, үйлсээр ариун сургаалыг тэдэнд зааснаар бид үүнийг хийж чадна)

С ба Г 20:58–59 -ийг уншихыг гишүүдээс хүс. Бусдыг Христ рүү ирэхэд нь зааж, анхааруулж урих ямар аргууд байж болох вэ?

Анхааруулж, урьж, зааснаараа бид Сүмийн гишүүдийн сүнслэг хэрэгцээг хангаж байгаа хэрэг юм. Ийн хэрэгжүүлэх нэгэн арга нь бид Сүмд үг хэлэх явдал болно. Залбиралтайгаар яриагаа бэлтгэснээр Ариун Сүнс гишүүдэд бидний үгийн үнэнийг гэрчлэх болно. Энэ үүргээ биелүүлэх өөр арга замууд нь цуглаан уулзалтуудын талаар гишүүдэд сануулах, дуудлага хүлээн авсан үедээ гэрийн багшийн ажлыг гүйцэтгэх гэх мэт байж болно.

Ариун ёслолыг түгээх нь гишүүдийн сүнслэг хэрэгцээг хангах хамгийн нандин арга замуудын нэг болно. Ийн гүйцэтгэснээр бид Их Эзэний Сүнс болон энэхүү ёслолын ач холбогдлыг мэдрэх ёстой. Ариун ёслолыг Их Эзэний нэрээр гэгээнтнүүдэд түгээж байгаа учир бид Түүнийг төлөөлөхдөө зохистой байх учиртай.

Бид Түүний хүссэнээр үйлдэж, хувцаслах ёстой.

Нэгэн Ерөнхий Эрх Мэдэлтэн дикон байх үеийнхээ үйлчилгээг ийн дурссан юм: “Ариун ёслол гэгдэх энэ нандин үйлчилгээнд оролцохыгоо би алдар хүндтэйгээр авч үздэг байснаа сайн санаж байна. Эцэг эх маань энэ ёслолд оролцохын тулд зохистой байж гар болон зүрх маань цэвэр ариун байх учиртайг заасныг би санадаг.” (Виктор Л. Браун, “The Aaronic Priesthood—A Sure Foundation,” *Ensign*, 1972, 7-р сар, х. 89–90.)

Зохих ёсоор ариун ёслолыг тарааснаар бид диконы хувьд үүргээ биелүүлдэг. Энэ үүрэг бол бид бие биенээ дэмжих явдал юм (С ба Г 107:85 -ыг үз). Энэ үүрэгт хандах бидний зүтгэлийг мэдсэнээр гишүүд дэмжлэг олж, өөрсдийн үүргээ биелүүлэх гүнзгий эрмэлзлэлтэй болно.

5-б, “Тэтгэлгийн хөтөлбөрт чуулга болж ажиллах нь диконуудын Сүмд анхаарал тавих нэг арга болно.”



5-в үзүүлэнг таниул, “ Ариун ёслолыг түгээх нь нандин хариуцлага мөн.”

Дикон дуудлагаа биелүүлэхийн тулд ямар онцгой зүйлүүдийг хийж болохыг бид дурдсан бэ? Хариултуудыг самбарт жагсаа. (Эдгээр нь “Багшийн Бэлтгэл”-д хавсаргасан санаануудыг агуулах учиртай.)

Диконууд Үүргээ Хэрхэн Суралцах нь

Диконууд бидэнд үүргээ судлах нилээд хэдэн аргууд, бас газрууд байж болох юм. Ийн суралцах нэгэн арга нь өөрөө судлах болон залбирах явдал юм. Ингэхийн тулд бидэнд ганцаараа байж, сударт зааснаар үүргээ судлан, тэдгээрийг ойлгохдоо тусламж хүсэн залбирах цаг, газар хэрэгтэй болж болно.

Түүнчлэн бид үүргээ гэртээ эцэг эх, ах нараасаа суралцдаг. Эдгээр үүргүүдийг гэр бүлийн цуглааны үеэр зааж болно. Ням гаригт пристийн зэргийн цуглааны үеэр диконы чуулгын ерөнхийлөгч мөн заах боломжтой. Их Эзэн диконы чуулгын ерөнхийлөгч нь чуулгынхаа диконуудыг тэргүүлж, тэдэнд үүргийг нь заах зарлигийг буулгасан байдаг (С ба Г 107:85 -ыг үз). Тэрээр үүргээ ухамсарлаж, диконы албандаа хэрхэн зүтгэхийг ойлгоход бидэнд тусална.

Пристийн зэргийн зөвлөгч, бишопын зөвлөлийн гишүүн, эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнээр заалгасныхаа хувьд бидэнд үүргийг маань ойлгуулахад тусалж чадна. (Аароны Пристийн Зэргийн чуулгагүй газруудад бишопын зөвлөл, салбарын ерөнхийлөгчийн зөвлөл, эсвэл ерөнхийлөн удирдах пристийн зэргийн албан хаагч Аароны Пристийн Зэргийг тэргүүлж, Аароны Пристийн Зэргийн чуулгын ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэдэг.)

Үүргээ суралцах хамгийн сайн аргуудын нэг нь тэдгээрийг биелүүлэх явдал болно. Үүргээ гүйцэтгэхдээ бид түүнийгээ илүү ойлгож, Их Эзнээ баярлуулдаг. Их Эзэн бидэнд баярлахдаа олон зүйлийг Ариун Сүнсээрээ дамжуулан илчилдэг. Диконууд бид Ариун Сүнсийг өөрсөдтэйгээ хамт байлгахын тулд үргэлж зохистой амьдрах учиртай.

Диконы Чуулга Диконууддаа Хэрхэн Туслах нь

Чуулгын гишүүд нэг нэгэндээ олон аргаар туслаж болно. Чуулгын цуглаанаар уулзаснаар бид нөхөрлөлөө бэхжүүлдэг. Түүнчлэн бид үүргээ суралцаж, түүнийгээ гүйцэтгэхэд тустай үйлийг төлөвлөхөд бие биендээ дэмжлэг үзүүлж чадна. Эдгээр үүргүүд нь гишүүдэд цаг зуурын хэрэгцээгээ хангахад нь туслах, номлогчийн ажилд бэлтгэх болон үйлчлэх, ургийн бичгээ хөтлөх, нас барагсдын төлөө усаар батлуулах, чуулгын насны залуу хөвгүүдийг идэвхжүүлэх, ариун сургаалыг суралцах зэрэг болно. Чуулга үүргээ биелүүлэхээр хамтран ажиллах боломжийг бидэнд олгодог. Үүргээ биелүүлснээр бид Бурханы хаант улсыг байгуулахад тусална.

5-в, “ Ариун ёслолыг түгээх нь нандин хариуцлага мөн.”



Чуулгын үйлчилгээгээр дамжуулан бид ариун сургаалд хандах хувийн өсөлтөө мэдэрнэ. Ариун сургаалыг суралцаж, үүргээ биелүүлснээр мэдлэгээ дээшлүүлж, чуулгын албанд үйлчилснээр удирдлагын чадвараа нэмэгдүүлдэг.

С ба Г 107:60–62, 85 -ыг уншихыг гишүүдээс хүс. Диконы чуулгыг хэн тэргүүлдэг вэ? Тэр ямар үүрэг хүлээдэг вэ?

Эрх мэдэлтнүүд чуулгын ерөнхийлөгчийг сонгож, түүнийг үйлчилгээнд дууддаг. Тэдгээр эрх мэдэлтнүүдээр батлагдан дуудагдах учиртай хоёр зөвлөхөө ерөнхийлөгч сонгоно. Чуулгын зөвлөгч албан хаагчдыг үүрэгт нь дадлагажуулдаг. Тэрээр мөн чуулгын цуглаанд ариун сургаалын хичээл заадаг. Чуулгын албан хаагчид чуулгын гишүүдийг пристийн зэргийн үүргээ биелүүлэхэд нь зааварладаг. Эдгээр болон бусад адил төстэй аргуудаар чуулгын гишүүд Сүмд анхаарал тавьж сурдаг.

Диконы Чуулга маань бас нийтэч харьцаа, нөхөрлөл, тусламжийг олж болох газраар биднийг хангадаг. Хэрэв сэтгэлээр унаж эсвэл үнэнд эргэлзэн тээнэгэлзвэл, бид урамшуулал болон тулгарсан асуудлынхаа хариу чуулгаас хүлээн авч болно. Дараах түүх бие биендээ тулгарсан асуудалд анхаарал тавьдгаа үзүүлснээр бид хэрхэн нэгнийгээ урмаар тэтгэж болохыг илэрхийлдэг. Энэ жишээнд чуулгын идэвх султай гишүүний асуудлыг харуулна.

Нэгэн дикон Сүмдээ идэвх султай буюу пристийн зэргийн болон Сүмийн цуглаандаа хэзээ ч оролцдоггүй байлаа. Ням гаригуудад тэр голдуу гэрийн ажил хийж өнгөрөөнө. Тэрээр олонтаа пристийн зэргийн цуглааны талаар мэдэхийг хүсэх бөгөөд нөхөрлөлөөр дутаж байгаага мэдэрч байв. Гэвч, хэн ч түүнд пристийн зэргийн цуглаанд оролцох урилга өгөөгүй учраас тэр хэзээ ч тэнд өөрийгөө хэрэгтэй гэж мэдэрдэггүй байв. Нэгэн ням гаригт байшингийнхаа нэг өрөөг будаж байхад нь диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл түүнтэй уулзахаар ирлээ. Тэд түүнийг дараагийн ням гаригт пристийн зэргийн цуглаанд оролцохыг хүсэв. Тэр үгүй гэдгээ хэлэв. Түүний хариулт тэднийг сэтгэлээр унагааж болох байсан хэдий ч, тэд шантарсангүй. Тэдний гурав нь ням гариг бүрт нөгөөх л саналаа тавин ирдэг боллоо.

Идэвх султай энэ хүү дикон байхдаа сүмд хэзээ ч очоогүй хэдий ч, чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийнхний хайр, санаа тавьсан байдал нь түүнийг урамшуулж, түүнд гүнзгий сэтгэгдэл төрүүлжээ. Хожим, Сүмийг эрэлхийлэхэд нь тэрхүү санаа тавьсан байдал түүнд нөлөөлжээ. Өнөөдөр тэрээр Сүмдээ идэвхтэй, пристийн зэргийн үүргээ гүйцэтгэгч нэгэн болсон.

Дүгнэлт

Үүргээ суралцаж, диконы ёсоор пристийн зэргээ хичээнгүйлэн биелүүлэхдээ бид өөрсдийгөө хөгжүүлэн, бусдад нэгэн адил гүйцэтгэхэд нь тусладаг. Энэ нь “сүмд анхаарал тавьж, сүмийн байнгын гүйцэтгэгч байх явдал болно” (С ба Г 84:111).

Уриалга

1. Ариун сургаалаар амьдарч, пристийн зэрэгтний хувьд бусдад сайн жишээ үзүүл.
2. Диконы үүргийг заасан судруудыг залбиралтайгаар судла
3. Хүсэлт гарсан үед мацгийн өргөлийг цуглуул.
4. Ариун ёслолын үйлчлэлийг хүндэтгэж ариун ёслол түгээхдээ Аврагчийн төлөөний хүн хэрхэн үйлдэж хувцаслах ёстой, тэр байдлаар гүйцэтгэ.

Нэмэлт Судрууд

1 Тимоти 3:8–10 (Диконы шинж чанарууд)

С ба Г 84:30–32 (диконы алба нь бага пристийн зэргийн хавсралт болдог)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. С ба Г 20:38–60; С ба Г 107 -г унш.
2. Дараах диконы үүргүүдийг хичээлийн ярилцлагын үеэр самбарт бичихэд бэлтгэ. Самбар хэрэглэх боломжгүй бол үзүүлэн бэлтгэ.

Диконы Үүргүүд

1. Сүмд анхаарал тавих
2. Ариун ёслолыг түгээх

Үүргээ Биелүүлэх Арга Замууд

1. Ариун сургаалыг үгээрээ болон үйлсээрээ заах.
2. Цуглааны талаар гишүүдэд мэдэгдэх
3. Цаг зуурын гачигдалтай гишүүдэд дараах байдлаар туслах:
 - А. Мацгийн өргөл цуглуулах
 - Б. Тэтгэлгийн хөтөлбөрт ажиллах
4. Ариун ёслол түгээх даалгаврыг хүлээн авах

Энэ хичээлийн зорилго бол багшийн үүргийг ойлгоход бидэнд туслах явдал болно.

Багшийн Үүрэг

Багшийн үүрэг диконы бүх үүргийг агуулдаг. Пристийн зэргийн ямар алба хашдагаасаа үл хамааран, бид үргэлж диконы эрх мэдэл хариуцлагыг хүлээх болно. Үүнтэй адилаар, бид прист болон томилогдоход бидний үүрэг диконных болон багшийнхийг мөн агуулах болно. Зарим маань багш, зарим нь удахгүй болох учир, бид энэ албын үүргийг сурах нь зүйтэй.

С ба Г 20:53 -ыг уншихыг гишүүдээс хүс. Багшийн ямар ямар үүргүүд байдаг вэ? Хариултыг самбарт жагсаа. (Тэдгээр нь хичээлийн төгсгөлд “Багшийн Бэлтгэл” гарчгийн дор жагсаасан байх учиртай.)

Гишүүдтэй цуг байж, тэднийг бэхжүүлнэ гэдэг нь тэднийг мэдэж, тэдэнтэй хамт сүмийн үйл ажиллагаануудад оролцон, хэрэгцээгээ хангахад нь болон бусдад үйлчлэхэд нь тэдэнд туслахыг хэлж байгаа болно.

С ба Г 20:54–55 -ыг уншихыг гишүүдээс хүс. Багшийн өөр ямар ямар үүргүүд байдаг вэ? Хариултыг самбарт жагсаа.

54 -р шүлэгт Багш нар Сүмийн гишүүдийн дундах хайр ба эв нэгдлийг дэмжих ёстой гэж хэлдэг. Бид үүнийг тэдэнд ялгаатай талаа тогтооход нь туслаж нэг нэгэндээ үйлчлэхийг нь дэмжсэнээр хийж чадна. 55-р шүлэгт багш нар гишүүдэд үүргээ биелүүлэхэд нь туслах ёстой гэж заадаг.

Багш Үүргээ Хэрхэн Биелүүлэх вэ?

Багшийн хувьд үүргээ биелүүлэх олон арга зам бий. Тэрээр, сайн гэрийн багш байж, сүмийн гишүүдтэй мэндчилэн, ариун ёслолыг бэлтгэж, гэр орондоо туслан, энх амгаланг зохицуулагч байснаар бусдад зохих үлгэр жишээ үзүүлж чадна.

ЗОХИСТОЙ ҮЛГЭР ЖИШЭЭ ҮЗҮҮЛ

Гишүүдийг бэхжүүлэх нэг арга зам бол үлгэр жишээ үзүүлэх явдал болдог. Алма хүү Кориантонтайгаа ярьж байхдаа, хэрэв Зорамайчууд түүний нүгэлт удирдлагыг харвал тэд Алмагийн үгэнд итгэхгүй болохыг хэлсэн байдаг (Алма 39:11 -ийг үз). Кориантоныхтай адилаар, бид хаана байгаа, юу хийж байгаагаас

үл хамааран бидний амьдрал ч бусдад нөлөөлөх болно. Бид хэзээ ч хаана ч зөв шударга байдлын сайн жишээ байх нь чухал юм.

САЙН ГЭРИЙН БАГШ БАЙ

6-а үзүүлэнг таниул, “Гэрийн багшлалт нь багшийн нэгэн чухал үүрэг болно.”

Бусдад зааж, гишүүдийг бэхжүүлэх дуудлагаа бид гэрийн багшлалтаар хичээнгүйлэн биелүүлж чадна. Энэ үүргийг гүйцэтгэхдээ Их Эзэний урам зоригоор эрх олгогдсон гэдгээ бид санах учиртай. Ариун сургаалыг номлохоор томилогдсон бүх хүмүүс үнэнийг сургахаар илгээгдсэн Тайтгаруулагч Сүнсээр дамжуулан үүргээ гүйцэтгэдэг болохыг Их Эзэн хэлсэн байдаг (С ба Г 50:13–14-ийг үз).

Заахаар томилогдсон айлдаа чухам юу заах учиртайгаа бид хэрхэн мэддэг вэ?

Бошиглогч Жозеф Смит болон түүний гэр бүлийнхэнд заадаг байсан нэгэн гэрийн багш гэрээр багшилж байгаа хүмүүстээ зориулж юу хийх нь зүйтэйг дараах түүхээр үзүүлсэн юм.

“Бошиглогч болон гэр бүлийнхэнд нь багшийн хувьд айлчлан очих даалгавраа бодохоос би зүрхшээж байлаа. Өөрийн үүрэгтээ би багадаж байгаа юм шиг санагдаж байлаа. Эцэст нь би түүний хаалгыг нь очиж тогшиход Бошиглогч өөрөө үүдэн дээрээ гарч ирэв. Би тэнд сандран зогсохдоо түүнд ийн хэллээ:

“ ‘Жозеф ах аа, хэрэв боломжтой бол, би танд багшийн хувьд айлчлахаар ирлээ.’

“Тэрээр, ‘Уиллиам ах аа, ор ор, ирсэнд тань баярлалаа; тэр сандал дээр суу, би яваад гэрийнхнээ дуудаад ирье’ хэмээн хэлэв.

“Тэд удалгүй орж ирж суудлаа эзэлцгээв. Тэрээр дараа нь: ‘Уиллиам ах аа, өөрийгөө би гэр бүлийнхнийхээ хамтаар танд танилцуулж байна’ гээд тэрээр суудлаа эзлэн: ‘Уиллиам ах аа, та хэрэгтэй гэж үзсэн бүхий л асуултаа асууж болно’ гэв.

“Энэ үед зүрхшээж байсан сэтгэл минь тайвширч, би ийн хэлсэн: ‘Жозеф ах аа, та шашин шүтлэгээ дагаж амьдрахыг чармайдаг уу?’

Тэрээр “Тийм “ гэлээ

“Тэгэхэд нь би: ‘та гэр бүлийнхэнтэйгээ цуг залбирдаг уу?’ гэхэд,

“Тэрээр мөн л ‘Тийм’ гэж хариуллаа.

“ ‘Та гэр бүлийнхэндээ ариун сургаалын зарчмуудыг заадаг уу?’

“ ‘Тийм, би хичээдэг’ гэж тэр хариулав.

“ ‘Та хоолондоо адислал хүсдэг үү?’

“ ‘Тийм’ гэж тэр хариулсан.

“ ‘Та гэр бүлийнхэнтэйгээ амар амгалан, эв нэгдэлтэй амьдрахыг хичээдэг үү?’



Тийм болохоо тэрээр батлан хэллээ.

“Дараа нь түүний гэргий Эмма эгчид хандан, ‘Эмма эгч ээ, та шашин шүтлэгээ дагаж амьдрахыг чармайдаг уу? Та үр хүүхдүүддээ эцэг эхийнхээ үгийг дуулгавартай дагахыг сургадаг уу? Та тэдэнд залбирахыг сургахыг хичээдэг үү?’ хэмээн асуулаа.

“Эдгээр бүх асуултанд тэрээр, ‘Тийм, би хичээдэг’ гэж хариулсан.

“Тэгээд би Жозефт хандан, ‘Би багшийн ёсоор асуух бүх зүйлээ дууслаа. Одоо хэрэв танд хэлэх зүйл байвал би дуртайяа сонсох болно’ гэхэд,

“ ‘Бурхан таныг адислаг, Уиллиам ах аа. Даруу, итгэлтэй байх аваас, та багшийн хувьд танд учрах бүхий л саад бэрхшээлийг даван туулах хүч чадалтай байх болно’ гэж хэлэв.

“Багшийн ёсоор тэдэнд салахын өмнөх адислалаа үлдээгээд би тэндээс гарсан.” (William Farrington Cahoon, “Recollections of the Prophet Joseph Smith,” *Juvenile Instructor*, 1896, 8сар 15, х. 492–93.)

Энэ гэрийн багшийн адилаар бид ч бас гэр бүлүүдтэй хамт залбирч, гэр бүлдээ хүлээсэн хариуцлагаа гүйцэтгэхэд нь тэднийг урамшуулж, ариун сургаалаар амьдрахад нь туслах замаар гэрийн багшийн үүргээ бататгаж чадна. Бидний заадаг гэр бүлд тусламж хэрэгтэй бол бид тэдний хэрэгцээг пристийн зэргийн эрх мэдэлтнүүдэд мэдээлэх учиртай.

Бид томилогдсон айлдаа айлчлан очихдоо өрхийн тэргүүнийх нь зөвшөөрлийг авсан байх ёстой. Тэд гэр бүлийнхнээ төлөөлөн Их Эзэний өмнө хариуцлага хүлээдгийн учир бид гэр бүлд нь тэдний заавраар сургах учиртай. Сургахдаа зөвхөн тэдний зааврыг дагаснаар л бид багшийн хувьд үүргээ биелүүлдэг.

Их Эзэний хүссэнээр гэрийн багшлалтаа хийснээр бид Сүмд хайр хүндэтгэл, эв нэгдлийг бүтээдэг. Бид багшийн дуудлагаа нухацтай авч үзсэнээр ямар үр дүнд хүрч болохын нэгэн сайн жишээг доорх түүх харуулна.

“Саяхавтар. . . нэгэн эрэгтэй багшлах насны хүүтэйгээ манайд гэрийн багшаар томилогдсон байлаа. Эцгийнх нь ариун сургаалд өөрийгөө зориулсныг бид мэдэж байсан, хүүгийнх нь гадаад үзэмж байр байдал эцгийнхтэйгээ адил байсан хэдий ч, хүүгээс бид чухам юу хүлээхээ мэдэхгүй байв. Анхных нь айлчлалаар, би залуу хүүд анхаарлаа төвлөрүүлээ. Дуу цөөтэй боловч түүний хэлсэн бүхэн нь пристийн зэрэгтээ бишрэлтэйг нь илтгэсэн. Удалгүй тэд манай залуу хүү насан өөд болоод жил болж байгаа бөгөөд бид удахгүй хүүхэдтэй болохыг маань мэдэв. Тэр мөчөөс эхлээд тэд бидний

төлөө залбирч биднийг урамшуулсныхаа хувьд бидэнд онцгой хүмүүс болсон. Айлчлалынх нь төгсгөлд би залуу хүүгээс нь залбирал хэлэхийг хүслээ. Залбиралдаа тэрээр хүүгээ алдсанд минь биднийг тайтгаруулан нэгтгэж, удахгүй төрөх үрийг маань адислахыг Их Эзэнээс хүсэв. Тэрээр эхнэрийг маань төрөхдөө хүндрэлгүй байхыг онцгойлон гүйн залбирлаа. Эхнэр бид хоёр тэр залуу багшийн чин сэтгэл, мэдрэмтгий оюунд тун их талархалтай байсан. Дараах өдрүүдэд нь тэдгээр ах нар бидний талаар олонтаа санаа тавих болсон (сард нэгээс илүүтэй). Хүүхэд маань мэндэлсний дараа залуу хүү эцгийнхээ хамт бэлэг авчирлаа. Бид залбирахаар өвдөг сөгдөхөд, багш маань Их Эзэнд хүүхдийг маань аюулгүй төрүүлсэнд талархснаа илэрхийллээ.” (Х. Бүркэ Питэрсоны “The Role of the Teacher”-д дахин өгүүлснээр, *New Era*, 1974, 5-р сар, х. 10–11.)

Та илүү сайн гэрийн багш байхын тулд юу хийж чадах вэ?

СҮМД МЭНДЧИЛ

Бид сайн жишээ үзүүлэх дуудлагаа гишүүдийг цуглааны байранд ирэхэд нь мэндчилэх замаар хичээнгүйлэн биелүүлж чадна. Бид тэдэнтэй гар барин мэндчилж мэндийг нь асууж болно. Бид хаалган дээр дулаан, нөхөрсөг мэдрэмжээр мэндчилэн зогсохдоо гишүүдийн дунд орших хайр эв нэгдлийг нэмэгдүүлдэг.

АРИУН ЁСЛОЛЫГ БЭЛТГЭ

Хариу шагнал хүлээлгүйгээр ямар нэгэн сайн үйлс бүтээх нь жинхэнэ үйлчилгээ болдгийг Аврагч бидэнд сургадаг. Ариун ёслолыг бэлтгэх нь энэ зарчмын нэгэн илрэл болно. Үүнийг хэн бэлтгэсэн нь ихэвчлэн дурдагдалгүй өнгөрдгийн улмаас ариун ёслолыг багш нар бэлтгэдэг болохыг гишүүд ихэнхдээ анзаардаггүй. Гэсэн хэдий ч, жинхэнэ үйлчилгээ болох энэ үйлчилгээ гүйцэтгэгдэж, Их Эзэний таашаалд өртдөг.

Ариун ёслолыг бэлтгэхээр өөрсдийгөө бие махбод болон сүнслэг чанарын хувьд бэлтгэхийн тулд бид юу хийж болох вэ? (Бие махбодын хувьд цэвэр байх санааг гарга.)

ГЭРТЭЭ ТУСАЛ

Багшийн хувьд бид гэр бүлийнхэндээ бас тусалж чадна. Гэр орноо цэвэрлэж, засаж сэлбэн, цэцэрлэгээ арчилж, талбайд ажиллахад туслах нь чухал. Үүнээс гадна, пристийн зэрэгтний хувьд гэр бүлийнхэндээ ариун сургаалаар амьдрахад нь бид тусалж чадна.

6-б үзүүлэнг таниул, “Пристийн зэргийн дуудлагаа хичээнгүйлэн биелүүлдэг багш гэр бүлээ бэхжүүлэхэд тусалдаг.”

6-б, “Пристийн зэргийн дуудлагаа хичээнгүйлэн биелүүлдэг багш гэр бүлээ бэхжүүлэхэд тусалдаг.”



Энэ түүх нь тамхи татдаг, мөн эхнэр болон өсвөр насны хүүтэйгээ ариун сүмд батлуулаагүй зэрэг зайлшгүй зүйлсийг гүйцэлдүүлээгүй, идэвх султай нэгэн пристийн зэрэгтний тухай болно. Нэгэн өглөө пристийн зэргийн цуглаан дээр ариун сүмийн гэрлэлтийн тухай сонсоод хүү нь мөнхийн гэр бүлийн эв нэгдлийг ихэд сонирхжээ. Тэр хичээл, уг сэдвээр эцэгтэйгээ ярихад нь хүүд нөлөөлсөн байна. Энэ ярианы үрээр эцгийнх нь амьдралд өөрчлөлт орсон. Тэрхүү эцэг хүүдээ хайртай болохоо, түүнтэйгээ үүрд хамт байхыг хүсч байгаагаа ухаарчээ. Яваандаа, гэр бүлийн нэгэн гишүүн багш хүү гэр бүлдээ хайр хүндэтгэл эв нэгдлийг бий болгохыг хүссэн учраас тэр гэр бүл ариун сүмд цаг хугацааны туршид болон мөнхөд батлуулсан.

ЭНХ АМГАЛАНГ ЗОХИЦУУЛАГЧ БАЙ

Гэр бүлдээ болон Сүмд энх амгаланг зохицуулагч байснаар бид багшийн хувьд үүргээ биелүүлэх болно. Энэ үүргээ гүйцэлдүүлэх нэг арга зам нь бид бусдын сайн талыг олж харах явдал юм. Өөр аргууд гэвэл, бусдын нэр хүндийг гутаасан цуу үг, худал ярианаас зайлсхийж, бусадтай харилцахдаа үргэлж хайр хүндэтгэл, нигүүлслийг агуулах явдал юм. Эдгээрийг хөгжүүлж, хэрэглэснээр бид олон хүмүүст амьдралдаа амар амгаланг мэдрэхэд нь туслах болно.

Дүгнэлт

Багш бид Сүмээ бэхжүүлэхийг үргэлж чармайн, эв нэгдэл, хайр хүндэтгэлийг дэмжиж, гишүүдийг үүргээ биелүүлэхэд нь туслах учиртай. Залуу, эсвэл Сүмийн шинэхэн гишүүд байж болох ч, бид бусдыг сайн сайханд уриалан нөлөөлөх хүчийг агуулдаг. “Зарлиг болгосон зүйлийнхээ замыг бэлдэлгүйгээр” Их Эзэн бидэнд ямар ч зарлиг буулгадаггүй болохыг бид үргэлж санаж байх хэрэгтэй (1 Нефай 3:7).

Гишүүдийн хамтаар Сүмийн нэгдэлдээ эв нэгдэл, хайр хүндэтгэлийг байгуулахад тус дэм болохуйц үйлчилгээний хөтөлбөр боловсруул.

Уриалга

1. Томилогдсон айлуудынхаа хэрэгцээг залбиралтайгаар анхаар.
2. Ариун Сүнсний заавраар гэр бүл бүрийн хэрэгцээнд нийцэх мэдээ бэлтгэ.
3. Томилогдсон айлууддаа гэрийн багшлалтын хамтрагчийнхаа хамтаар сар бүрийн эхэнд айлчил.
4. Томилогдсон гэр бүлүүдтэйгээ хамт залбир.
5. Томилогдсон гэр бүлүүдэд тань хэрэгцээтэй болон өөрийн чадах үйлчилгээг гүйцэтгэ. Эс чадах зүйлсээ чуулгын удирдагчтайгаа зөвлө.

Нэмэлт Судар

Жакоб 1:17–19 (Багш нар пристийн зэргийн дуудлагаа хэрхэн хичээнгүйлэн биелүүлэх нь)

Багшийн Бэлтгэл

Хичээлийг таниулахын өмнө:

1. С ба Г 20:53–60 ба “Пристийн Зэргийн Чуулга” Хичээл 4 -ийг унш.
2. Самбар, шохой бэлтгэ.
3. Хичээлийн ярилцлагт хэрэглэхээр багшийн үүргийг харуулсан дараах жагсаалтыг самбарт бичих буюу үзүүлэн гаргах байдлаар бэлтгэ.

Багшийн Үүрэг

1. Диконы бүх л үүргүүдийг гүйцэтгэх
 2. Сүмтэйгээ хамт байж сүмээ бэхжүүлэх
 3. Сүм дэх эв нэгдэл, хайр хүндэтгэлийг дэмжих
 4. Үүргээ биелүүлэхэд нь гишүүдэд туслах
4. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Энэ хичээлийн зорилго бол пристийн үүргийг ойлгоход бидэнд туслах явдал юм.

Оршил

Пристийн зэрэгтэн бүрт “өөрийн албандаа байж, өөрийн дуудлагаа гүйцэтгэхийг” Их Эзэн зарлигдсан (С ба Г 84:109). Ийн хийхийн тулд пристийн зэрэгт хүлээх өөр өөр хариуцлагуудаа бид эхлэн суралцаад, дараа нь биелүүлэх ёстой. Пристийн хувьд, бид заах, усаар батлах, ариун ёслолыг гүйцэтгэх, гишүүдийнд айлчлах болон бусдыг пристийн зэрэгт томилох үүргүүдийг хүлээдэг. Эдгээр үүргүүдийг гүйцэлдүүлснээр бид Бурханы хаант улсыг байгуулахад туслах төдийгүй Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авахдаа өөрсдийгөө бэлтгэдэг юм. Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авч ахлагчийн албанд томилогдсоныхоо дараа бид бүрэн цагийн номлолд үйчлчлэхээр дуудагдах боломжтой болно. Бүрэн цагийн номлогчийн хувьд бидний үр бүтээлтэй байдал маань үйлчлэхээр хэрхэн бэлтгэгдсэнээс хамаарна. Пристийн дуудлагаа хичээнгүйлэн биелүүлснээр бид сайн номлогч байхаар бэлтгэж чадах юм.

Пристийн Үүрэг

Дикон, багшийн үүргүүдийг оролцуулан Их Эзэн прист бидэнд гүйцэтгэх олон үүргийг оноожээ. Пристийн онцгой үүргүүдийг Сургаал ба Гэрээнд тодорхойлсон байдаг.

С ба Г 20:46–48 -ыг уншиж тэмдэглэхийг гишүүдээс хүс. Пристийн ямар үүргүүд байдаг вэ? Хариулыг самбарт жагсаа. (Эдгээр нь хичээлийн төгсгөлд байгаа “Багшийн Бэлтгэл” - д жагсаасан үүргүүдийг агуулах учиртай).

СУРГА

Пристийн хувьд бидний нэг үүрэг бол “номлох, сургах, тайлбарлах, уриалах явдал юм” (С ба Г 20:46). Энэ нь бид бусдад ариун сургаалын зарчмуудыг сургах ёстойг хэлж байгаа юм. Ариун сургаалын зарчмуудыг сургахын тулд бид эхлээд суралцах хэрэгтэй. Их Эзэн хэлэхдээ, “Үгийг минь тунхаглах гэж бүү эрэлхийл, харин үгийг минь олж авахыг эрэлхийл; ийн хичээвээс, хэлний тань ээдрээ арилж, тэр үед эрмэлзэх ахул, Сүнс минь, үг минь танд оршиж, та хүмүүсийг итгүүлэх Бурханы хүчийг агуулах болно” (С ба Г 11:21) .

Бурханы үгийг бид хэд хэдэн аргаар олж авдаг. Өрх гэртээ эцэг эхээсээ, пристийн зэргийн чуулгад бидэнд зааж байгаа хүмүүсээс,

Ням Гаригийн хичээлээс болон ариун ёслолын цуглаанаас олж авдаг. Бурханы үгийг олж авах хамгийн сайн аргуудын нэг нь өдөр бүр, судрын бие даасан сургалтаар олж авах явдал юм. Нэг ч пристийн зэрэгтэн судраас тогтмол суралцах боломжгүй болтлоо завгүй байх учиргүй. Судраас эрэлхийлж, түүнийгээ тунгаан бодсоноор, түүнийг ойлгоход маань Их Эзэн бидэнд туслах болно. Нэгэнтээ ариун сургаалыг ойлгосны дараа бид бусдад сургаж чадна.

Түүнчлэн зөв шударга жишээ үзүүлснээр бид бусдад ариун сургаалыг сургах үүргээ биелүүлж болох юм. Бидний сайн жишээ ариун сургаалаар амьдрахад нь олон удаа бусдыг урамшуулдаг.

Ариун сургаалыг сургахын тулд ямар онцгой зүйлийг бид хийж болох вэ?

7-а үзүүлэнг таниул, “Прист усаар батлахад, тухайн хүн Бурханы хаант улсад хөл тавьдаг.”

УСААР БАТАЛ

Пристүүдийн бас нэг үүрэг бол усаар батлах явдал юм (С ба Г 20:46 -г үз). Энэ ёслолоор Бурханы хаант улсад ордгийн хувьд, зохих эрх мэдлээр гүйцэтгэгдсэн усан баталгаа нь Сүмийн хамгийн чухал бөгөөд нандин ёслолуудын нэг болно. Дээгүүр эрх мэдэлтнүүдээсээ эрх мэдлийг хүртсэнийхээ дараа авралд хүргэх энэ ёслолыг гүйцэтгэх нь пристийн нандин үүрэг юм.

7-б үзүүлэнг таниул, “Пристүүд Сүмийн гишүүдэд ариун ёслолыг гүйцэтгэх нандин үүргийг хүлээдэг.”

АРИУН ЕСЛОЛЫГ ГҮЙЦЭТГЭ

Ариун ёслолыг гүйцэтгэх хүндэтгэл нь ихэвчлэн пристүүдэд оногддог. Ёслолыг ариун ёслолын залбирлыг үйлдсэнээр гүйцэтгэдэг. Пристүүд бид ариун ёслолын залбиралтай танилцаж, зохих ёсоор хувцаслан, ёслолыг гүйцэтгэхийн өмнө гараа угаасан байвал зохино. Хамгийн чухал нь Аврагчаа төлөөлж байгаагийнхаа хувьд бид энэ нандин ёслолыг гүйцэтгэхэд зохистой байх учиртай.

ГИШҮҮДЭД АЙЛЧИЛ

“Гишүүн бүрийн гэрт айлчилж, нийтийн өмнө болон ганцаар залбирч, гэр бүлийн үүргээ биелүүлэхэд нь уриал” хэмээн Их Эзэн пристүүдэд зарлигдсан байдаг (С ба Г 20:47). Томилгодсон гэр бүлүүддээ гэрийн багшлалтаа хийснээр бид энэхүү зарлигийг биелүүлнэ. Айлчлалынхаа үеэр бид гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг мэдэж авч болох юм. Бид тэдэнтэй залбирч болно. Бид тэдэнд ариун сургаалын зарчмуудыг зааж, гэр бүлийн үүргээ биелүүлэхэд нь тэднийг урамшуулж болно. Тэдгээр гэр бүлийнхэнтэй бид сүмийн цуглаанууд болон олон нийтийн газруудад дотно, нөхөрсгөөр харьцах нь зүйтэй. Бид сүм, сургууль болон нийтийн үйл ажиллагаанд тэдэнтэй хамтран оролцож болно.



БУСДЫГ ТОМИЛ

Зохих түлхүүрүүдийг атгаж буй болон зөвшөөрөл олгох эрх мэдэл бүхий пристийн зэргийн удирдлагаас зөвшөөрөл олгогдсон үед пристүүд бусад прист, багш, диконуудыг томилох эрх мэдлийг агуулдаг (С ба Г 20:48 -ыг үз). Бусдад пристийн зэрэг олгох энэ хүч нь нандин болой. Жозеф Смит, Оливэр Коудри нарт Аароны Пристийн Зэргийг олгохдоо, Жон Баптист энэ хүчийг дэлхий дээр дахин сэргээсэн юм (С ба Г 13-ыг үз). Жон Баптист өөрөө энэ эрх мэдлийг Бурханы нэрээр үйлдэж буй тэнгэрийн элчээс хүлээн авчээ (С ба Г 84:28 -ыг үз). Тиймээс ч, бусдыг томилох энэ хүч нь бидэнд Бурханаас өгөгддөг билээ. Энэ чухал ёслолыг гүйцэтгэхийн тулд бид зохистой байж, Ариун Сүнснийг агуулах учиртай. (Нэмэлт мэдээлэлд “Пристийн Зэргийн Дахин Сэргээлт” 3-р хичээлийг үз) 7-в үзүүлэнг таниул, “Номлогчдод туслах нь үүрэг бас нэр төрийн хэрэг болно.”

НОМЛОГЧ БАЙ

Пристийн дуудлага нь түүнчлэн номлогчийн ажилд туслах үүргийг агуулдаг. Энэ дуудлага нь эртний Сүмийн нэг хэсэг байсан бөгөөд өнөөдрийн Аароны Пристийн Зэрэгтэн гишүүд ахлагч нартаа номлолд нь туслах учиртайг Их Эзэн Жозеф Смитэд зааварлажээ. Тэд цаг товлон, ахлагч нарт замыг нь бэлтгэх онцгой үүрэгтэй (С ба Г 84:107–108 -ыг үз). Хичээл заах гэр бүлүүдийг олж, тэдэнтэй цаг товлон бүсийнхээ бүрэн цагийн номлогч нарт тусалснаар бид өнөөдөр номлогчийн ажилд тусламж үзүүлж чадна. Түүнчлэн өөрсдөө бүрэн цагийн номлогч болоход бэлтгэснээр бид номлогчийн ажилд туслаж чадах юм.

Пристийн Зэргийн Дуудлагаа Хичээнгүйлэн Биелүүлэх

Пристийн хувьд бид сургах, усаар батлах, ариун ёслолыг гүйцэтгэх, гишүүдийнд айлчлах, бусдыг батлах болон номлогчийн ажилд туслах үүргүүдээ суралцвал зохино. Эдгээр үүргүүдийг суралцаж, гүйцэтгэснээр бид Их Эзний хамгаалалт, удирдамжинд байдаг. Ерөнхийлөгч Уилфорд Уудрафф прист байх үедээ өөрийн хамтрагч болох ахлагчтай цуг номлол хийхдээ номлолынхоо талаар ингэж ярьсан:

“Би Прист, хамтрагч маань Ахлагч байсан бөгөөд бид мянга мянган бээрийг туулж гайхлыг маань төрүүлсэн олон зүйлүүдтэй учирсан. Хэрэв тухайн хүн дуудлагаа л хичээнгүйлэн биелүүлэх аваас, Прист , эсвэл Төлөөлөгч байх нь ямар ч ялгаагүй болохыг би та бүхэнд хэлэхийг эрмэлзнэм. Прист, тэнгэрийн элч нарын үйлчлэлийн түлхүүрүүдийг атгаж байдаг. Төлөөлөгч, Дал, Ахлагч

7-а, “Прист усаар батлахад тухайн хүн Бурханы хаант улсад ордог.”



байхдаа амьдралдаа хэзээ ч Пристийн албанд байснаасаа илүүгээр Их Эзний хамгаалалтыг хүртэж байсангүй. Үзэгдэл, илчлэл болон Ариун Сүнсээр дамжуулан Их Эзэн амьдралд маань тохиолдох олон зүйлийг надад илчилсэн.” (*Millennial Star*, 1891, 10 сар 5, х. 629.)

Пристүүд дуудлагаа хэрхэн хичээнгүйлэн биелүүлж болох талаар бишоп Виктор Л. Браун дараах түүхийг ярьсан юм:

“Нэгэн залуу эрэгтэй . . . дараах зүйлийг бичжээ: ‘Нэг удаа би бараг нэг ч Мэлкизэдэк Пристийн Зэрэгтэнгүй хэсэгт очсон. Гэвч, тэнд сүнслэг байдал дутагдаж үгүйлэгдээгүй. Харин ч, олон олон гишүүд нь гайхамшигт пристийн зэргийн хүч чадлыг гэрчилцгээсэн юм.

“ ‘Тэрхүү хүч нь пристүүдэд төвлөрч байв. Амьдралдаа анх удаагаа тэд пристийн бүх л үүргийг гүйцэтгэж, хэсгийнхээ гишүүдийн хэрэгцээг гүйцэлдүүлэхээр дуудагдсан байлаа. Тэд гэрийн багшийн ажлыг хийхээр ахлагч нарыг дагалдсан уйтгарт хамтрагч байх бус ах эгч нараа адислахаар үнэнээсээ дуудагдсан байлаа.

“ ‘Өнгөрснөөс одоог хүртэл би өөр өөр нөхцөлд тэдгээр пристүүдийн дөрөвтэй нь хамт байсан. Би тэднийг байдаг л нэг танхай жаалууд гэж боддог байв. Хоёр гурван сараар семинарийн багш нар тэднээс зугтдагсан. Скаутын аялалд тэд үймээн тарина. *Гэвч, хэрэг болсон үед, амин чухал үүрэгт томилогдон найдлага хүлээсэн үедээ тэд пристийн зэргийн үйлчилгээгээрээ бусдаас хамгийн их тодорч байсан.*

“ ‘Үүний нууц нь гэвэл, бишоп тэнгэрийн элч нарын ивээлийг хүртэхүйц эрчүүдийн жишигт хүрэн өсөж өндийхийг өөрийн Аароны Пристийн Зэрэгтнүүддээ уриалан дуудав; халамж дутсаныг халамжлан, хүч дутсаныг бэхжүүлэн, тэд тэрхүү жишигт хүрсэн. Хэсгийн бусад гишүүд төдийгүй чуулгын гишүүд төлөвшин хөгжсөн. Хэсэг даяар гайхамшигт эв нэгдэл бүрэлдэж, хүмүүс нэг оюун, нэг санаатай байхын учрыг хүн бүр ухаарч эхэлсэн. Үүнд гавъяатай зүйл үгүй; энэ нь Аароны Пристийн Зэргийн жирийн нэгэн зохих ёсны үйлдэл юм .’ ” (“The Vision of the Aaronic Priesthood,” *Ensign*, 1975, 11-р сар, х. 68.)

Пристийн зэргийн үүргээ биелүүлснээр шагнал болон ирсэн мэдрэмж, тохиолдлуудаасаа хуваалцахыг гишүүдээс хүс.

Үр Бүтээлтэй Номлогч Байхад Бэлтгэх нь

Хэрэв пристийн бүх үүргээ биелүүлвэл бид номлогч болохдоо хийх бүх зүйлдээ туршлагатай байх болно. Номлогч нарын адилаар бид ариун сургаалыг зааж, шинэ хүмүүсийг усаар батлаж, үе үе ариун ёслолыг гүйцэтгэн, гишүүдэд айлчлан, бусдыг пристийн зэрэгт

7-6, “Пристүүд, Сүмийн гишүүдэд зориулан ариун ёслолыг гүйцэтгэх нандин үүргийг хүлээдэг.”



томилох болно. Эдгээр үүргүүдийг гүйцэтгэснээр бид сүнслэг чанарын хувьд бэхжиж, номлогчоор дуудагдсан үедээ илүү сайн үйлчлэхээр бэлтгэгдсэн байх болно.

Аароны Пристийн Зэргийн нэг зорилго бол энэ пристийн зэргийг атгагчдыг Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авахад бэлтгэх явдал болно. Зохистой бөгөөд Аароны Пристийн Зэргээ хичээнгүйлэн биелүүлдэг пристүүд нь Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авч ахлагчийн албанд томилогдох боломжтой.

Ихэнх тохиолдолд ахлагч нар бүрэн цагийн номлогчийн ажлыг гүйцэтгэдэг. Аароны Пристийн Зэргийг зохистойгоор атгаж байгаа бидний ихэнх маань арван найман насандаа ахлагчийн албанд томилогддог. Энэ нь бидэнд ахлагчийн үүргийг суралцаж, хэрэгжүүлэх болон бүрэн цагийн номлолд бэлтгэх нэг жилийг олгодог. Энэ бэлтгэл нь Бурханы үйлст зүрх сэтгэлээ зориулах, Их Эзэнд үйлчлэхээр ажиллах, бусдыг зөв шударгаар удирдахад чиглэгдэнэ (С ба Г 121:34–38 -ыг үз). Эдгээрийг хийснээр бид Их Эзэнд итгэж сурна; Их Эзэнд итгэж сурснаар хэцүү бэрх цагт Тэр биднийг дэмжиж хамгаалах болно.

Амь насыг нь Их Эзэн хамгаалсан нэгэн учралын тухай Уилфорд Үүдроф ийн ярьсан юм. Нэг өдөр тэрээр Мормоны Ном нь муу ёрын сүнснээс ирсэн хэмээгч Хэйкмэн Эцэг гэгч урвагчид анхааруулахаар Сүнсний хүчээр хөдөлжээ. Тэрээр хэлсэн нь:

“Хэйкмэн Эцэгт анхааруулахаар гурван удаа миний сэтгэл хүчтэйгээр хөдлөсөн юм. . . . Гурав дахь удаад нь би түүнтэй уулзахад, түүний сууц нь нүгэлт сүнсээр дүүрэн мэт санагдаж, номлон хэлэх сүнс минь ээдэрсэн. Анхааруулгаа хэлж дуусаад би тэндээс гарав. Тэр намайг алахаар заналхийлэн, гэрээсээ гарч намайг дагалаа. Үзэгдлээр надад тодорхой болсон байсны учир би түүний санаанд огт эргэлзээгүй. Миний байсан газар хүрч ирэхдээ тэрээр тэнгэрийн аянга цахилгаанд ниргүүлсэн мэт хөлд минь үхэхдийн унав. Тэр үед прист байсан намайг Бурхан хамгаалж амийг минь аварсан юм.” (*The Discourses of Wilford Woodruff*, х. 297–298.)

Энэ мэт гайхамшигт тохиолдлууд зөв шударга пристийн зэрэгтний амьдралд тохиолдохгүй байж болох юм. Гэвч, бидний мэдэх мэдэхгүй олон замаар Их Эзэн итгэлт үйлчлэгчдээ хамгаалсаар байдаг.

Прист номлолд бэлтгэж төлөвлөх нь яагаад чухал вэ?

Дүгнэлт

Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл хэлсэн нь: “Олонтаа тавигддаг нэгэн асуулт бол залуу эрэгтэй хүн бүр номлолд явах ёстой юу? Их Эзэний өгсөн хариулт бол ‘Тийм.’ Залуу эрчүүд бүгдээрээ номлолд явах ёстой. Их Эзэн хэлэхдээ:

“ ‘Миний сүмийн ахлагч нарыг холын улсад . . . тэнгисийн арлуудад, харь нутагт оршиж байгаа үндэстнүүдэд номлол хийлгэхээр илгээ. Бүх үндэстнийг: эхлээд Жэнтайлуудыг дараа нь Еврэйчүүдийг дууд’ (С ба Г 133:8).” (“When the World Will Be Converted,” *Ensign*, 1974, 10 сар, х. 8.)

Уриалга

Та доорх зүйлийг хийхийн тулд Ароны Пристийн Зэргээ итгэлтэйгээр гүйцэтгэ:

1. Чуулга, хэсэг, салбарынхаа гишүүдийг бэхжүүлэх.
2. Мэлкизэдэк Пристийн зэргийг хүлээн авч номлогчоор үйлчлэхдээ өөрийгөө бэлтгэх.

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. С ба Г 20:46–49 -ийг унш.
2. Самбар, шохой бэлтгэ.
3. Дараах пристийн үүргийн жагсаалтыг самбарт бичиж хичээлийн ярилцлагын үеэр хэрэглэхэд бэлтгэ:

Пристийн Үүргүүд

1. Дикон болон багшийн үүргүүдийг гүйцэтгэх
 2. Ариун сургаалыг сургах
 3. Усаар батлах
 4. Ариун ёслолыг гүйцэтгэх
 5. Гишүүдэд айлчлах
 6. Бусдыг Ароны Пристийн Зэрэгт томилох
 7. Номлогчийн ажил хийх
4. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Бишоп ба Салбарын Ерөнхийлөгчийн Үүрэг

Хичээл 8

Энэ хичээлийн зорилго бол бишоп ба салбарын ерөнхийлөгчөө хэрхэн дэмжиж туслахаа мэдэхийн тулд тэдний хариуцлагыг ойлгоход бидэнд туслах явдал болно.

Оршил

Сүмийн үндсэн нэгдэл бол гэр бүл юм. Сүмийн гишүүд алслан тархаж амьдардаг дэлхийн бүс нутгуудад бие даасан гэр бүлүүд Сүмийн нэгдэл болдог. Зохистой пристийн зэрэгтний удирдлаган дор гэр бүлүүд ариун ёслолын цуглаан, Ням Гаригийн хичээл болон бусад цуглаануудаа явуулж, Сүмийн томоохон нэгдлүүдэд явагддаг олон үйл ажиллагааг зохион байгуулж болох талтай.

Хоёр ба түүнээс дээш гэр бүлүүд эсвэл хувь хүмүүс амьдардаг бүс нутагт тэдгээр гишүүдийн наандаж нэг нь зохистой прист эсвэл Мэлкизэдэк Пристийн Зэрэгтэн байвал Сүмийн салбар байгуулагдана. (*Салбарын Удирдамж* -ийг үз, х. 1.) Салбар нь хэсгийн арай бага хэлбэр бөгөөд үнэндээ гишүүдийн тоо хангалттай их болсон үед энэ нь хэсэг болон байгуулагддаг.

Салбарын ерөнхийлөгч салбараа, бишоп хэсгээ тэргүүлдэг. Сүм өсөж байгаа өнөө үед зохистой пристийн зэрэгтнүүд олон олноороо энэ удирдлагын албанд дуудагдаж байна. Тэдний олонх нь сүмийн туршлага, ариун сургаалын мэдлэг багатай. Гэвч, тэд даруу байх бөгөөд тэдэнд итгэл, залбирал, гишүүдийнх нь дэмжлэг хэрэгтэй байдаг.

Бишоп ба Салбарын Ерөнхийлөгчдийг Томилох нь

Бишопыг хэн томилодог вэ? Бишоп ямар пристийн зэрэгтэй байдаг вэ?

Бишоп нь Их Эзэний урам зоригоор дуудагдан, Сүмийн Тэргүүн Зөвлөл болон Арван Хоёрын Зөвлөлийн удирдлаган дор гадасны ерөнхийлөгчөөр томилогддог (С ба Г 68:14–15 -ыг үз). Хэсгийн бишопын зөвлөл нь бишоп ба хоёр зөвлөхөөс бүрдэх гурван дээд пристийг хамруулдаг. Бишоп нь ерөнхийлөх дээд прист бөгөөд хэсгийнхээ бүх гишүүдийг удирддаг. Түүнчлэн, тэрээр пристийн чуулгын ерөнхийлөгч болохын зэрэгцээ хэсгийнхээ залуу эмэгтэйчүүдийн сүнслэг болон цаг зуурын сайн сайхны төлөө хариуцлага хүлээдэг пристийн зэргийн удирдагч болно (С ба Г 107:13–17, 71–72 -ыг үз).

Салбарын ерөнхийлөгч нар салбарыг удирдах эрх мэдэлтнүүд болох номлолын ерөнхийлөгч эсвэл тойргийн ерөнхийлөгчийн аль нэгний урам зоригоор дуудагддаг. Тэд Мэлкизэдэк Пристийн Зэргийг атгах бөгөөд зөвлөхүүдийнхээ хамтаар үйлчилдэг. Тэдний хариуцлага нь бишопынхтой төстэй. Бишопуудад хандсан сүнслэг зөвлөмжүүд салбарын ерөнхийлөгч нарт бас хамаатай.

Сүмийн олон гишүүд бишоп ба салбарын ерөнхийлөгчөө зөвхөн хэсэг, салбарынхаа тэргүүлэх албан хаагч мэтээр ойлгодог. Бишоп ба салбарын ерөнхийлөгч нь цаг зуурын болон сүнслэг олон үүргүүдийг хүлээдэг бөгөөд эдгээрийг гүйцэтгэхээр тэдний дэмжлэгийг хүлээн авахаас нааш тэд үйлчилгээг бүрэнээр гүйцэтгэж эс чадахыг тэд мэддэггүй байна.

Бишоп ба Салбарын Ерөнхийлөгчдийн Цаг Зуурын Хариуцлагууд

Цаг зуурын хариуцлагууд нь хэсгийн болон салбарын гишүүдийн бие махбодийн сайн сайхан байдалтай хамаатай үүргүүд болно.

Бишоп ба салбарын ерөнхийлөгчийн цаг зуурын нэг чухал хариуцлага нь аравны нэг болон өргөлийг цуглуулах явдал юм. Их Эзэний төлөөний хүн болохын хувьд бишоп ба салбарын ерөнхийлөгч нь зохистой байдлаар өргөлийг хүлээн авах, тэмдэглэх болон хуваарилах зэрэгт Их Эзэний өмнө хариуцлага хүлээдэг. Ядуу нэгэнд туслахын тулд итгэлтэй гишүүд сард хоёр хоолны турш мацаг барьсныхаа өргөлийг өгдөг. (Эрүүл мэндийн хувьд мацаг барих боломжгүй нэгэн нь зөвхөн мацгийн өргөлийг өгөх боломжтой.) Бишоп ба салбарын ерөнхийлөгч хэсэг салбарынхаа гишүүдийг мэдэх бөгөөд тусламж хэрэгтэй үед нь тэдэнд гишүүдийн мацгийн өргөлийг ашиглан, эсвэл хэсгийнхээ гишүүдийг дуудан дэмжлэг үзүүлдэг (С ба Г 84:112 -ыг үз).

Дараах түүх гачигдалтай гэр бүлд бишоп хэрхэн тусалсныг үзүүлнэ:

“Солт Лэик Ситийг тойрсон чөлөөт замын дор байрласан нэгэн байшин зовиур, ганцаардалгүй нэг ч өдрийг үзээгүй өвчинд дийлдсэн жаран настай ганц бие өвгөнийх юм. Өвлийн нэгэн өдөр би тэднийд айлчилж очиход тэрээр удаж байж хаалгаа тайллаа. Нямбай гэрт нь ороход галын өрөөнөөс бусад нь хүйтэн ба 40 хэм (цөлсийн 4 хэм) байлаа. Шалтгаан нь: бусад өрөөгөө халаах хангалттай мөнгө үгүй, хананд нь цаас, таазанд нь зузаалга, шүүгээнд нь хоол хэрэгтэй байв.

“Би найзындаа айлчилсан явдалдаа санаа зовж тэрээр өвгөний бишоптой ярилцаж, гэрчлэлээр өдөөгдсөн хайрын гайхамшиг бий болов. Хэсгийн гишүүд зохион байгуулагдаж хайрын хөдөлмөр эхлэв. Сарын дараа найз Лү маань утасдаж, намайг очиж түүнд

тохиолдсоныг харахыг хүсэв. Би очлоо, үнэхээр гайхамшиг тохиолджээ. Том модны үндсэнд дийлдсэн явган хүний замыг сэргээж, байшингийн үүдний хэсгийг дахин барьж, шинэ хаалга суулган, таазны зузаалга тавин, ханыг цаасаар бүрж, модон эдлэлүүдийг будаж, дээвэрийг шинэчилж, шүүгээг нь дүүргэсэн байлаа. Тэр гэр хүйтэн, хөндий биш болжээ. Харин ч дулаанаар уриалан шивнэх мэт санагдлаа. Лү өөрийн бахархал баяр баясгалангаа хамгийн сүүлд надад үзүүлэхээр төлөвлөжээ. Орон дээр нь түүний гэр бүлийн МакДоналд сүлдийг урласан гоёмсог бүтээлэг байв. Үүнийг Нийгмийн Халамжийн Бүлгийн эмэгтэйчүүд хайр халамжаараа бүтээжээ. Долоо хоног бүр залуус халуун хоол авчирч, гэр бүлийн цуглаан хамтдаа явуулдаг болохыг явахынхаа өмнө би мэдэж авав. Дулаан нь хүйтнийг орлож, засвар нь олон жилийн элэгдлийг даржээ; гэвч хамгийн чухал нь цөхрөл найдвараар солигдож, хөхүүн хайр эзэгнэсэн байна.” (Томас С. Монсон, “The Way of the Lord,” *Ensign*, 1977, 11-р сар, х. 9.)

Бишоп ба салбарын ерөнхийлөгч нар нь Сүмийн үйл ажиллагаа, сүмийн барилгын засвар ашиглалт, эд хогшлын бичиг баримтын тэмдэглэлийг хөтлөх зэрэг цаг зуурын бусад үүрэгтэй. Тэд мөн Сүмийн гишүүдээс номлогчийг дэмжих гэх мэт санд өргөсөн хандивийг нь цуглуулдаг.

Бишоп ба Салбарын Ерөнхийлөгчдийн Сүнслэг Хариуцлагууд

Бишоп ба салбарын ерөнхийлөгч нар нь өөрсдийн Сүмийн нэгдлийнхээ гишүүдийн сүнслэг сайн сайхан байдалд анхаарал тавихаар дуудагддаг. Тэд Гэгээнтнүүдийн жирийн шүүгч нь байх онцгойлсон үүргийг хүлээдэг (С ба Г 107:74 -ийг үз). Эдгээр үүрэгт нь тэдэнд туслахын тулд Их Эзэн бишоп ба салбарын ерөнхийлөгч нарт үнэнийг таних бэлгийг амласан билээ (С ба Г 46:27 -г үз).

Үнэнийг таних бэлэг нь бишоп ба салбарын ерөнхийлөгчийг үнэнийг мэдэж, сайн муугийн ялгааг ойлгох, тэр ч бүү хэл тухайн хүний зүрх сэтгэлийн гүнд байгааг олж харах чадвартай болгодог. Тэрээр энэ бэлгийг агуулдгийн улмаас бид түүнээс сүнслэг байдлаар өсөхөд Их Эзэний бидэнд өгөх зөвлөмжийг эрэлхийлж болно.

Үнэнийг таних бэлгийн ачаар дараах түүхэнд дурдагдах бишоп хэсгийнхээ залуу хөвгүүнд туслах боломжтой байжээ.

16 настай прист Крэг гайхамшигтай залуу хөвгүүн байв. Тэрээр бишопынхоо даалгасныг хийхэд ямагт бэлэн байдаг байжээ. Гэвч нэг өдөр, Крэг өөрөөс нь зайлсхийгээд байгааг Бишоп Уэлс анзаарав. Пристийн зэргийн чуулгын цуглаанд ч тэрээр үргэлж өөр зүгт хараагаа хандуулна. Бишоп Уэлс Крэгийг пристийн чуулгын нарийн бичгээр дуудахыг хүсэж байсан хэдий ч түүнд ямар нэг

тоогүй юм тохиолдсон болохыг мэдэрчээ. Тиймээс, бишоп Крэйгийг ярилцлага хийхээр өрөөндөө дуудлаа. Ярилцлагын үеэр Крэйг өөрийн ёс суртахууны доголдлоо илчлэн хэллээ. Тэр энэ байдлаасаа ичиж пристийн зэрэгтээ зохисгүй хэмээн мэдэрч байв. Тэрээр наманчилж, өөрийнхөө талаар өөдрөг сэтгэгдэлтэй байж болохыг бишоп Уэлс түүнтэй ярилцаж сануулав. Энэ ярилцлагаар Крэйг өөрийн асуудлаа хэрхэн даван туулахыг суралцаж, наманчлалаар тэрээр өршөөгдөж, дахин аз жаргалтай сэтгэл дүүрэн байх болжээ. Тэр үед Бишоп Уэлс түүнийг пристийн чуулгын нарийн бичгээр дуудах боломжтой болсон байна.

Крэйгийг сүнслэг байдлаар өсөхөд нь бишоп үнэнийг таних бэлгээ хэрхэн ашигласан бэ?

Бишоп ба салбарын ерөнхийлөгч нь Израилийн жирийн шүүгч болохын учир бид өөрсдийн нүглээ түүнд илчилж, наманчлахад маань тэрээр бидэнд тусалж чадна. Гишүүд ноцтой нүгэл үйлдээд үл наманчлавал Сүмийн гишүүний байдлаа алдаж болзошгүй. Ийм тохиолдолд бишоп журмын зөвлөлийг зохион байгуулах хариуцлагыг хүлээдэг. Эдгээр зөвлөлүүдэд бишоп шүүлтүүдийг тарааж, гишүүдийг наманчлахад нь дэмждэг. Журмын зөвлөлүүд хайраар удирдагдаж, наманчлан ариун сургаалын адислалуудыг дахин баяртайгаар мэдрэхэд нь хувь хүнд туслах зорилготой. (С ба Г 58:42–43; С ба Г 58:14, 17– 18 -ыг үз.) Бишоп өөрийн шүүлтдээ хариуцлага хүлээдгийн учир энэ үүрэгт хайнга хандах учиргүй.

Номлолын салбаруудад гэм нүгэл учирсан үед, номлолын ерөнхийлөгч журмын зөвлөлийг удирдана (*General Handbook of Instructions* -ийг үз).

Бишоп ба салбарын ерөнхийлөгчдийн зарим нэмэлт сүнслэг хариуцлагуудыг дор дурдъя:

- Ариун ёслолын цуглааныг удирдаж, төлөвлөхөд нь туслах.
- Гэр бүлүүдэд гэрийн багшлалт хийхэд зааварлах.
- Цуглаануудыг удирдах (тэтгэлгийн үйлчилгээний олон нийтийн цуглаан гэх зэрэг).
- Хэсэг, салбарын албанд үйлчлүүлэхээр гишүүдийг дуудах.
- Аароны Пристийн Зэрэг хүртэх болон дэвших ёслолуудыг батлах.
- Ахан дүүсийг Мэлкизэдэк Пристийн Зэрэгт дэвшихэд тодорхойлох.
- Ариун Сүмийн зөвшөөрөл ба патриархын адислал авахад нь гишүүдтэй ярилцлага хийх.
- Аравны нэгийн тайланг хөтлөн явуулах.
- Тайтгарал ба зөвлөмжийн адислалуудыг хүртээх.

- Номлогчийн тодорхойлолтыг бэлтгэх.

Пристийн Зэргийн Удирдагчдаа Дэмжих нь

Бишоп ба салбарын ерөнхийлөгч маань Их Эзэнээр дуудагддаг. Тэрээр Их Эзэнийг ба Сүмийн Ерөнхийлөгчийг төлөөлдөг. Энэ шалтгааны улмаас бид энэ дуудлагт нь түүнд дэмжлэг үзүүлэх нь чухал юм. Ахлагч Боид К. Пакэр хэлэхдээ: “Сүмийн Ерөнхийлөгч, эсвэл Ерөнхий Эрх Мэдэлтнүүддээ дэмжлэг үзүүлнэ гэсэн хэдий ч, өөрийн бишопдоо дэмжлэг үзүүлж эс чадах аваас, тэр хүн өөрийгөө мэхэлж буй хэрэг. Хэсгийнхээ бишоп, гадасныхаа ерөнхийлөгчийг дэмжиж эс чадах нэгэн Сүмийн Ерөнхийлөгчид дэмжлэг үзүүлнэ гэж үгүй” гэжээ. (Ахлагч Боид К. Пакэр, “Follow the Brethren,” *Speeches of the Year*, BYU, 1965, 3 cap 25, x. 4–5).

Судрууд бидэнд пристийн зэргийн удирдагчиддаа хэрхэн дэмжлэг үзүүлэхийг сургадаг.

Судар бүрийг уншихад анхаарал тавин цуг уншихыг гишүүдээс хүс. Судар бүрийг уншсаны дараа удирдагчдаа дэмжихийн тулд бид юу хийхийг тухайн судар хэлж буй гишүүдээс асуу.

СУДАР	ЗӨВЛӨМЖ
С ба Г 6:9	Наманчлалыг сургаж, зарлигуудыг дагаж амьдар.
1 Нефай 3:7	Бидэнд өгөгдсөн бүх л дуудлагуудыг хүлээн зөвшөөрч биелүүл.
С ба Г 60:2	Авьяс чадвараа хуваалц.
Малакай 3:8–10	Мацгийн болон бусад өргөлөө төл.
Еврейчүүд 13:17	Удирдагчдынхаа зөвлөмжийг дуулгавартай дага.
С ба Г 64:9–10	Бусдын, түүнчлэн удирдагчдынхаа сул талд оршөөнгүй ханд.

Бишоп ба салбарын ерөнхийлөгчийн маань дуудлагаа биелүүлэх амжилт нь бид түүнийг хэрхэн дэмжихээс ихээр шалтгаалдаг. Бидэнд зөв замыг заахад нь Тэнгэрлэг Эцэг түүнд туслаг хэмээн бид түүний төлөө үргэлж залбирч байх нь зүйтэй.

Дүгнэлт

Бишоп ба салбарын ерөнхийлөгчдийн гүйцэтгэдэг үйлчилгээ нь бидний сайн сайханд амин чухал юм. Бишоп ба салбарын ерөнхийлөгчөөр дуудагдсан зохистой эрчүүд нь Сүмийн гишүүдэд зам заахаар дуудагддаг юм. Тэд бидэнд үйлчилж, биднийг хайрладаг, харин бид тэднийг үүргээ биелүүлэхэд нь туслахын тулд чадах бүхнээ хийх учиртай.

Уриалга

1. Хувийн болон гэр бүлийнхээ залбиралдаа Сүмийн удирдагчдынхаа төлөө залбир.
2. Сүмийн удирдагчдаа шүүмжлэх, тэдний талаар цуу үг хэлэхээс зайлсхий.
3. Тэдний зөв шударга зөвлөмжүүдийг дагаж Сүмийн удирдагчиддаа дэмжлэг үзүүл.

Нэмэлт Судрууд

1 Тимоти 3:1–7 (бишопын чанарууд)

Титүс 1:5–9 (бишопын чанарууд)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. Дуудлагынх нь талаар асуултуудад хариулуулахаар бишоп ба салбарын ерөнхийлөгчөө хичээлдээ урь.
2. Пристийн зэргийн цуглаандаа судраа авчрахыг гишүүдэд сануул.
3. Түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Ахлагч ба Дээд Пристийн Үүрэг

Хичээл 9

Энэ хичээлийн зорилго бол ахлагч ба дээд пристүүдийн үүргийг ойлгоход бидэнд туслах явдал болно.

Оршил

Пристийн зэргийн үүргээ суралцаж, гүйцэтгэснээр Аврагчаа төлөөлдгийнхөө хувьд бид бусдын амьдралыг адисладаг. Үүргээ гүйцэтгэснээр, бид үйлчилсэн хүмүүстээ мөнхийн амьдралд хүрэхээр хөгжихөд нь туслахад зориулан Тэрээр бидэнд пристийн зэргээ олгосон. Энэ нь ялангуяа Мэлкизэдэк Пристийн Зэрэгтнүүдийн хувьд үнэн юм, учир нь тэрхүү пристийн зэрэг сүмийн бүх л сүнслэг адислалуудын түлхүүрүүдийг агуулдаг (С ба Г 107:18 -ыг үз). Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авсан бидний зарим маань энэ пристийн зэрэг дэх ахлагч эсвэл дээд пристийн албанд томилогдсон байдаг. Эдгээр албууд нь тус бүрдээ өөрсдийн онцгой үүрэгтэй боловч тэдгээр хариуцлагуудын ихэнх нь ижил юм.

Мэлкизэдэк Пристийн Зэргийн Хариуцлагууд

Аароны Пристийн Зэргийн хариуцлагтаа итгэлтэй хандсанаар бид Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авахад өөрсдийгөө бэлтгэдэг. Мэлкизэдэк Пристийн Зэргийн ёслолыг хүртэх цаг ирэхэд эрх мэдэл бүхий хүмүүс бидэнтэй ярилцлага хийдэг. Мэлкизэдэк Пристийн Зэрэгт дэвших ярилцлагынхаа дараах мэдрэмжийн талаар нэгэн Аароны Пристийн Зэрэгтэн ийнхүү бичсэн байна:

“Сүүлчийн асуултаа тавьж хариулыг минь сонсохдоо гадасны ерөнхийлөгч нүд рүү минь эгцлэн харлаа. Тэгээд тэрээр, ‘Жорж, чи Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүртэж, Ахлагчаар батлуулахад бэлэн, мөн зохистой гэж надад санагдаж байна’ гэж хэлэв. Хэдэн хормын дараа би шөнийн агаараар амьсгалан алхаж байлаа. . . . Би урьд нь хэзээ ч ийм амгалан хэрнээ сэтгэл хөдөлсөн байдлыг мэдэрч байсангүй. . . . Удалгүй би орныхоо урд өвдөг сөгдөн суув. Пристийн зэргээ нэр төртэйгөөр ашиглахын тулд би чадах бүхнээ хийхээр шийдсэн. Хэзээ ч хараал хэлэхгүй, бохир үг хэрэглэхгүй, хэнийг ч гомдоохгүй гэж шийдвэрлэв. Үнэхээр Бурханы хүн байх болно гэж би өөртөө амлалаа. Би тэр үдшийг үргэлж санах болно. Тэр орой бол миний хувьд бүх юмны эхлэл байсан. Пристийн зэргийг атгахаар дуудагдана гэдэг үнэхээр сайхан байлаа. Пристийн зэргийг хэрэглэхэд зохистой хэмээн сонгогдон, гэр



бүлийнхэндээ . . . нөхөддөө адислал нь болсон нэгэн байхын тулд бүх зүрх сэтгэлээрээ чармайна гэдэг гайхамшигтай хэрэг.” (Жорж Д. Дуррант, *Kentucky Louisville Mission News Letter*, 1974, 10 сарын 19.)

Залуу хөвүүн ярилцлагынхаа дараа ямар андгай тавьсан вэ? Мэлкизэдэк Пристийн Зэрэгтэн болохдоо бид ямар андгай тавьбал зохих вэ?

Пристийн зэргээ хэрэглэхдээ зохистой байж өөрсдийн үүргээ сурахын тулд бид бүгдээрээ хичээх нь зүйтэй (С ба Г 107:99–100 -г үз). Мэлкизэдэк Пристийн Зэрэгтнүүдийн хувьд бид ямар алба хашдагаасаа үл хамааран тодорхой хариуцлагуудыг хүлээдэг.

9-а үзүүлэнг таниул, “ Бурханы эрх мэдлийг агуулсан хүмүүс Пристийн зэргийн эрх мэдлийг толгой дээр гараа тавин олгодог.”

Мэлкизэдэк Пристийн Зэргийн хариуцлагуудыг дор дурдсан болно:
ХУВИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бид хувь хүний ёсоор Исүс Христийн ариун сургаалын дагуу өөрчлөгдөж, зарчмаар нь амьдрахаар үнэнчээр андгайлсан байх учиртай.

ӨРХ, ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА

Бид гэр бүлийнхэндээ ариун сургаалын зарчмуудыг сургаж бүх л үүрэгтээ хайрлах, ойлгох чадвартай байхад нь тэднийг хөтлөх учиртай.

ГЭР БҮЛИЙН ТҮҮХ БА АРИУН СҮМИЙН АЖИЛ

Бид ариун сүмийн тодорхойлолт авахад зохистой байж, өөрсдийнхөө болон гэр бүлийнхнийхээ төлөө ариун сүмийн адислалуудыг хүртэх, өвөг дээдсийн нэрийг олох, түүнчлэн тэдний төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэх учиртай. Гэр бүлийн бүртгэл (хувийн тэмдэглэл, гэр бүлийн бичээс, гэр бүлийн түүх гэх мэт) хөтөлж, өрхийн бүртгэлийг хадгалснаар (С ба Г 128:17–18 -ыг үз) бид эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүдийнх нь зүг, хүүхдүүдийнхийг эцгүүдийнх нь зүгт хандуулахад тус нэмрээ оруулах ёстой.

ТЭТГЭЛГИЙН ҮЙЛЧЛЭЛ

Бид өөрсдийгөө болон гэр бүлийнхнийхээ, Их Эзэний замаар сэтгэлээр унасан ядарсан нэгний хэрэгцээг хангах учиртай.

НОМЛОГЧИЙН АЖИЛ

Гэр бүлийн гишүүдийг бүрэн цагийн номлолд бэлтгэж, үйлчлэхэд нь туслах, гишүүн бус хүмүүстэй нөхөрлөх, номлогч нарыг сонсогч

9-а, “Бурханы эрх мэдлийг агуулсан хүмүүс Пристийн зэргийн эрх мэдлийг толгой дээр гараа тавин олгодог.”



нараар хангах, бүрэн цагийн номлолд үйлчлэх, мөн номлогчийн ажлыг санхүүгийн хувьд дэмжих замаар бид номлогчийн зохих үйл ажиллагаанд оролцох учиртай.

ГЭРИЙН БАГШЛАЛТ

Бид гэрийн багшийн хувьд бүх хариуцлагаа ухамсарлаж, үйлчлэхээр дуудагдсан хүмүүстээ хичээнгүйлэн анхаарал тавьж, цуг байж, тэдний итгэлийг нэмэгдүүлэх учиртай (С ба Г 20:53 -ыг үз).

ЧУУЛГА, СҮМИЙН ИДЭВХ БА ҮЙЛЧИЛГЭЭ

Бид Сүмийн дуудлагандаа хичээнгүйгээр үйлчлэн, Сүмийн болон чуулгын бусад үүргээ биелүүлж, Сүмийн зохих цуглаан, үйл ажиллагаануудад оролцох замаар Бурханы хаант улсыг байгуулалцах учиртай.

ОЛОН НИЙТИЙН ИДЭВХ БА ҮЙЛЧИЛГЭЭ

Бид хуулийг хүндэтгэн, дуулгавартай дагаж, дэмжин, сайн иргэн, хөрш байж, оршин суудаг хөршийн холбоогоо хөгжүүлэх учиртай. (*Annual Guidelines 1978–79* -аас, “The Melchizedek Priesthood”, х. 1.)

9-6 үзүүлэнг таниул, “Мэлкизэдэк Пристийн Зэрэг нь бусдын сүнслэг амьдралыг адисладаг.”

Мэлкизэдэк Пристийн Зэргийг хүлээн авахдаа бид бас бусдын сүнслэг амьдралыг адислах хүч чадлыг хүлээн авдаг. Мэлкизэдэк Пристийн Зэрэг нь ариун сургаалыг гүйцэтгэж Бурханы мэдлэгийн түлхүүрийг атгадаг. Тиймээс пристийн зэргийн хүчээр гүйцэтгэгдсэн ёслолд бурханлаг байдлын хүч чадал гайхамшигтайгаар илэрдэг. (С ба Г 84:19–21 -ийг үз). Мэлкизэдэк Пристийн Зэргийн хүч чадлаар бид тосыг ариулж, өвчтэйг адислаж, пристийн зэргийг болон Ариун Сүнсний бэлгийг олгож, бусдыг пристийн зэргийн албанд томилон булшийг онцгойлон адислаж, тайтгарлын адислал хүртээн, хүүхдүүддээ эцгийн адислалаар ерөөж, ариун сүмийн дээд ёслолуудад оролцож чадна.

Эдгээр ёслолуудад Бурханы хүч хэрхэн илэрдэг вэ? Мэлкизэдэк Пристийн Зэргээр та ямар адислалуудыг хүлээн авсан бэ?

Ахлагч ба Дээд Пристийн Онцгой Үүргүүд

АХЛАГЧ

Ахлагч хэмээх үг нь Сүмд хоёр утгыг агуулдаг. Энэ нь Мэлкизэдэк Пристийн Зэргийг атгасан бүх хүмүүсийг ерөнхийд нь нэрлэнэ. Жишээ нь: номлогч нар, Сүмийн ерөнхийлөн удирдагчид, Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг бүгдийг нь ахлагч хэмээн дууддаг. *Ахлагч* гэдэг нь мөн Мэлкизэдэк Пристийн Зэргийн онцгой нэгэн алба болно.

9-6, “Мэлкизэдэк Пристийн Зэрэг нь бусдын сүнслэг амьдралыг адисладаг.”

С ба Г 124:137 -г уншихыг гишүүдээс хүс. Энэ сударт ахлагчийн албаны ямар үүргийг дурдсан бэ?

Сүмийн байнгын гүйцэтгэгч байхын зэрэгцээ ахлагч нар нь тэднээс шаардагдсан бүхий л дуудлагыг хаших учиртай. Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит, ахлагч нарт сүмд ажиллах, гэрийн үйлчлэлд хөдөлмөрлөх, мөн ертөнц дахинаа ариун сургаалыг номлоход хүчин зүтгэх санал тавигдаж болохыг тайлбарлажээ. (*Gospel Doctrine*, х. 184–85 -ыг үз).

ДЭЭД ПРИСТ

Дээд пристүүд сүнслэг хүч чадлыг болон Сүмийн адислалуудыг гүйцэтгэх хариуцлагыг хүлээдэг (С ба Г 107:10 -ыг үз). Тэд мөн удирдахаар дуудагддаг. Удирдах дуудлага нь Ерөнхий Эрх Мэдэлтэн, номлолын ерөнхийлөгч, гадасны ерөнхийлөгч, бишопын албуудыг хамруулна. Дээд пристийн дуудлагандаа удирдахдаа, тэд тодорхой нэгэн дуудлагын сүнслэг адислалуудыг удирдах болон ахлагч ба Аароны Пристийн Зэрэгтний хийж болох бүгдийг хийх хүч чадлыг агуулдаг.

Дүгнэлт

Мэлкизэдэк Пристийн Зэрэгтнүүд Сүмийн сүнслэг адислалуудын түлхүүрүүдийг атгадаг. Ахлагч ба дээд пристийн ялгаатай үүргүүд бол Мэлкизэдэк Пристийн Зэргийн үүргүүд болно. Тиймээс, ахлагчийн ба дээд пристийн хувьд пристийн зэргийн албаа хашихдаа бид үйлчилж байгаа хүмүүсийнхээ сүнслэг болон цаг зуурын амьдралыг адислаж чадна.

Уриалга

1. Пристийн зэрэг дэх өөрийнхөө албаны үүргүүдийг тодорхойлж, түүнийгээ илүү сайнаар биелүүлэхээр төлөвлө.
2. Эрх гэртээ нүүрлээд буй онцгой хэрэгцээг тодорхойл. Эрх гэртээ зөв шударгаар пристийн зэргээ ашигласнаар хэрхэн илүү сайн эцэг, гэр бүлийн нэгэн гишүүн байх талаар бодож шийдвэр гарга.

Нэмэлт Судрууд

Мозаяа 18:7–30 (Сүмийн гишүүдийн үүргүүд)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. С ба Г 107 -г унш.
2. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Патриарх ба Патриархын Адислалууд

Хичээл 10

Энэ хичээлийн зорилго бол патриархын үүргийг ойлгож патриархын адислалыг хүлээн авахад бэлтгэхэд бидэнд туслах явдал болно.

Оршил

Их Эзэн бүх хүүхдүүдээ хайрлаж, тэднийг адислахыг эрмэлздэг. Гэсэн хэдий ч бидний үйлс, бидний сонголт Тэрээр биднийг адислах эсэхэд нөлөөлнө. Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит хэлэхдээ: “Хүн бүр өөрийн хийсэн сайн зүйлс, үйлс бүхэндээ шударга шагналыг хүртэх болно. Гэвч чухалчлан санах нэг зүйл бол энд болон хожим бидний хүлээн авах бүхий л адислалууд нь тэдгээр адислалуудын үндэс суурь нь болсон Бурханы хуулиудад хандах бидний дуулгавартай байдлын үр дүн болно” гэжээ. (“What Is To Become of Such As Me?” *Improvement Era*, 1912, 11 сар, х. 71).

Патриархын адислал хүлээн авахад бидэнд Тэнгэрлэг Эцэгийн олон адислалууд энэ ертөнцөд болон мөнхөд биднийг хүлээж байгааг урьдчилан хэлдэг. Бид үнэн итгэлт амьдралаар амьдрах аваас, тэдгээр адислалууд нь биднийх болох юм. Энэ талаар урьдчилан мэдэх нь биднийг тэдгээр амлагдсан адислалуудыг хүлээн авахад зохистой болоход хөтөлдөг.

Патриарх Гэж Юу вэ?

Патриархууд бол эцгүүд юм. Хүн төрөлхтөний эцэг байсныхаа хувьд Адам анхны патриарх байжээ. Патриарх болохын учир тэрээр үр удмынхаа адислалд болон тэдэнд зөв шударгаар амьдрахад нь туслах үйлст хариуцлага хүлээсэн юм. Адамын хүүхдүүдийнхээ төлөө гүйцэтгэсэн сүүлчийн үйлчилгээнүүдийн нэг бол тэдэнд хүртээсэн патриархын адислал байжээ.

С ба Г 107:53–57 -г уншихыг гишүүдээс хүс.

Адам хүүхдүүдээ дуудаж цуглуулаад патриархын адислал хүртээснийг Жозеф Смит үзэгдлээр мэдсэн байна. Дараа нь Их Эзэн тэдний өмнө үзэгдэж, Адам ирээдүйд гэр бүлд нь юу тохиолдохыг хэлэхийг харжээ. Энэ гайхамшигт үйл явдлын талаар бошиглогч Жозеф Смит хэлэхдээ: “Адам үр удмаа Бурханы өмнө хүргэх гэсэндээ тэднийг адисласан юм” гэжээ. (*Teachings of the Prophet Joseph Smith*, х. 158–159.)

Патриарх хэмээх үг нь түүнчлэн Мэлкизэдэк Пристийн Зэргийн нэгэн алба юм. Исүсийн үе дэх Сүмийн байгууллагуудад патриархууд евангелистүүд хэмээн нэрлэгддэг байжээ (Эфэс 4:11 -ийг үз). Сүм дахин сэргээгдэхэд пристийн зэргийн алба бас сэргээгджээ. Жозеф Смит тайлбарлахдаа: “Евангелист бол Патриарх юм. . . Дэлхий дээр Христийн Сүм оршин тогтнох бүрд Гэгээнтнүүдийн үр удмын тусын тулд тэнд Патриарх байх учиртай” гэжээ. (*Teachings*, х. 151).

10-а үзүүлэнг таниул, “Патриархын адислалууд нь амьдралын шугам болон зөв шударга амьдралаас ирэх амлагдсан адислалуудыг илчилдэг.”

Сүмийн ихэнх гадаст наандаж нэг зохистой Мэлкизэдэк Пристийн Зэрэгтэн байдаг бөгөөд түүнийг Арван Хоёрын Чуулгын заавраар гадасны патриархаар дуудаж, томилдог. Дээд пристийн хувьд, гадасны патриарх нь дээд пристийн гүйцэтгэж болох бүх л үүргийг гүйцэлдүүлэх эрх мэдлийг агуулдаг төдийгүй патриарх болохынхоо хувьд патриархын адислал хүссэн гадасны гишүүдийн өмнө тэрээр адислал хүртээх нэгэн онцгой үүрэг хүлээдэг.

Патриархууд нь Их Эзэний нэрээр патриархын адислал өгөх урмаар тэтгэгддэг бөгөөд тэгэх ч эрхтэй болно. Эдгээр адислалууд нь зовлон зүдгүүрт тайтгарал авчирч, итгэлийг бататгаж, Их Эзэний бидэнд бэлтгэсэн адислалуудыг хүртэхэд бидэнд туслах болно. (*Doctrines of Salvation* 3:170 -ыг үз).

Патриархын Адислал Гэж Юу вэ?

1957 онд Сүмийн Тэргүүн Зөвлөлөөс патриархын адислал нь амьдралын шугамын урмаар тэтгэгдсэн тунхаглалыг агуулдаг болохыг тайлбарлажээ. Мөн амьдралын үүрэг хариуцлагыг маань тодорхойлох урам зориг бүхий бошгын заавар адислалууд бидэнд өгөгддөг. Эдгээр адислалууд нь амьдралын зорилгодоо хүрэхэд бидэнд туслах сүнслэг бэлэг, цаг зуурын адислалууд, зөвлөмж, анхааруулгыг агуулдаг (*General Handbook of Instructions*, х. 49 -ийг үз).

Патриархын адислалын нэгэн чухал хэсэг бол Израилын аль омгоос бид адислалаа хүлээж авдаг болохыг маань бидэнд хэлдэг бидний амьдралын шугамын тунхаглал юм. Өвөг дээдсийнхээ Бурхны ачаар, зөв шударга байдлаасаа хамааран, Адам, Абрахам, Жакоб болон бусад агуу бошиглогчдод өгөгдсөний адил адислалуудыг авахаар бид бэлтгэгдсэн байдаг. (Элдрэд Г. Смит, “All My Share in Adam’s Blessings,” -ийг үз, *Ensign*, 1971, 6-р сар, х.100–101).

Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд нэгдэхдээ бид Тэнгэрлэг Эцэгийн үр сад болцгоодог. Энэ нь зөв шударгаар

10-а, “Патриархын адислалууд нь амьдралын шугам ба зөв шударга амьдралаас ирэх амлагдсан адислалуудыг илчилдэг.”



амьдрал бид Тэнгэрлэг Эцэгийн бүх адислалуудыг хүлээн авах эрхээр хангагдсан байдагийг илэрхийлж байгаа юм. Зөвхөн Израилын үрс л энэ эрхийг агуулдаг. Сүмийн гишүүд нь үнэн ариун сургаалыг хүлээн зөвшөөрснөөрөө Абрахамын төрөл садан болох эсвэл Израилын омгуудын нэгд үрчлэгддэг. (Ромчууд 8:14–17, Галатианчууд 3:26–29, С ба Г 86:8–10, болон С ба Г 63:20 - ийг үз).

Энэ адислалын бас нэг чухал хэсэг бол энэ амьдрал дахь бидний үүрэг зорилгыг тодорхойлсон ойлголт юм. Патриархын адислалаар маань дамжуулан, Тэнгэрлэг Эцэг бидэнд энэ дэлхий дээрх бидний зорилго болон тэдгээрийг хэрхэн биелүүлэхийг хэлдэг. Гэвч, адислалын биелэлт нь учир шалтгааны хамааралтай.

Ахлагч Жон А. Уидцөгү эдгээр адислалуудын заримыг энэ амьдралд бид хүлээн авч чадахгүйг сургажээ: “Хийгдсэн амлалтуудын биелэлт нь энэ амьдралд эсвэл ирээдүйн амьдралд тохиож болохыг бид үргэлж санах учиртай. Энэ амьдралд амлагдсан адислалууд ирээгүйгээс болоод хүмүүс итгэл алдарч байсан нь бий. Ариун сургаалд амьдрал бүх л үйл ажиллагааныхаа хамтаар үүрд үргэлжлэн, дэлхийд эхэлсэн үйлс Тэнгэрт үргэлжилж болдог хэмээснийг санахаа тэд умартсан юм.” (*Evidences and Reconciliations*, х. 323.)

Патриархын адислал амьдралд нь хэрхэн удирдамж, түшиг тулгуур болж байгаа талаар гэрчлэлээ хуваалцахыг урьдаас товлосон гишүүнээс хүс.

Патриархын Адислал Хүлээн Авах нь

Патриархын адислал хүлээн авахын тулд бид тодорхой хувийн хэдэн шаардлагыг хангах учиртай. Тэдгээр нь:

- Зохистой, усаар батлуулсан Сүмийн гишүүн байх.
- Их Эзэний зааврыг хүлээн авах эрмэлзлэлтэй байх.
- Ариун сургаалаас суралцаж, патриархын адислалын зорилгыг ухаарсан байх.
- Адислалын онцлог чанарт талархан урамшууллыг хүлээн авч чадахуйц насанд хүрсэн байх.
- Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө тодорхойлолт авах.
- Патриархын адислал хүлээн авах зохих патриархтайгаа цаг товлох.

Адислал хүлээн авахаар явахын өмнө өөрсдийгөө сүнслэг байдлаар бэлтгэхийн тулд бид залбирч, боломжтой бол мацаг барих учиртай. Түүнчлэн патриарх бидний тусын тулд урам хайрагдсан байхын тулд бид түүний төлөө залбирвал зохино.

Патриархын адислал хүлээн авахаар хэрхэн бэлтгэснээ ярихыг урьдаас товлосон гишүүнээс хүс.

Патриархууд бидэнд адислал өгөхдөө түүнийгээ хуурцганд бичиж авдаг. Учир нь тэд адислалыг маань бичсэн хувийг бидэнд өгөх юм. Тэрхүү хувь нь түүнчлэн Сүмийн албан ёсны бүртгэлд хадгалагддаг. Ингэснээр, хэн нэгэн адислалын хувиа гээвэл тэрээр Сүмээс ахин нэг хувь авах боломжтой болно.

Патриархын адислал нь хувийн ба нандин зүйл болох учир найдвартай тохиромжтой хадгалагдах учиртай. Үүний агуулгыг бид зөвхөн хамгийн дотны хүмүүстээ Сүнсний зааварчилсны дагуу хуваалцах ёстой. Патриархын залбирлаасаа тусламж олохын тулд бид үүнийгээ тогтмол унших ёстой. Тэгснээр, амлагдсан адислалуудыг хүртэхийн тулд чухам юу хийх учиртайгаа бид мэдэх болно.

Дүгнэлт

Патриархын адислалынх нь нэг хэсэг болон өгөгдсөн зөвлөмжийг даган нэгэн хүн итгэлтэй хөдөлмөрлөснөөр, хэрхэн адислал хүртсэн болохыг дараах түүх өгүүлнэ:

“Амьдралд минь зорилго байгаа бөгөөд би агуу үүрэг гүйцэтгэх учиртай хэмээн үргэлж боддог байсан хэдий ч, би сайн уншиж бичиж суралгүйгээр насанд хүрсэн билээ.

“Би өөрийгөө бусад хөвгүүдийн адил ухаантай гэж боддог байсан хэдий ч бүх хичээлдээ муу үнэлгээтэй байсан. Хэд хэдэн хэсгээс бүрдсэн сургуулийн уншлагын шалгалт ухаалаг бус болохыг минь, тэр ч бүү хэл би ганцаар гадуур явахгүй байх нь дээр болохыг тодорхойлов. Бусад хөвгүүдийн хялбархнаар гүйцэтгэсэн мэдлэгийн түвшний зүйл надад тун хэцүү байлаа. Арван хэдэн насанд минь, нэг хөвгүүн надаас хий гэдэг үгийг үсэглэхийг хүсэхэд би чадаагүй. Муугаас өөр дүн авдаггүй учраас хүмүүс нуусаар байгаад одооноос л эхлэн миний талаар ярьж байсан тул би өөрийгөө тэнэг юм байх гэж бодож эхэлсэн.

“Гуравдугаар ангийн хүүхдийн түвшний энгийн зүйлийг ч уншиж чадахгүй гэж дүгнэсэн надад боловсрол олгох гэж оролдох нь төвөгтэй байсан учраас тэд намайг дунд сургууль төгсгөсөн.

“Хачирхалтайгаар, арван дөрвөн насандаа, би дахин сэргээгдсэн ариун сургаалын тухай анх сонсож, гэрийнхээ тавиураас олсон номнуудын нэгийг уншихаар шийдэв. Олон жилийн тэртээ Тэннэсси мужийн өмнө хэсэг дэх хөдөө нутагт Сүмийн гишүүн болон усаар батлуулсан ээжийнхээ Мормоны Номыг би олж авлаа. Бусад Сүмийн гишүүдээсээ тусгаарлагдсаны учир ээж маань ариун сургаалыг гүнзгийгээр заалгаж байгаагүй бөгөөд улмаар бүр харилцаа тасарсан учир тэрээр хүүхдүүддээ Мормоны Номонд агуулагдсан ариун сургаалыг заах мэдлэг, эрмэлзлэлээр дутагдаж байв.

“Зөвхөн энгийн үгсийг нь уншиж, ойлгогдохгүй, уртыг нь гэж би Жозеф Смитийн гэрчлэлийг унших гэж зүдэрсэн. Гайхалтай нь уншиж байгаа зүйлийнхээ утгыг би заримдаа огт ойлгохгүй байсан боловч ямар нэгэн шалтгаанаар сүнс надад уншихаар чармайж буй зүйл маань үнэн болохыг мэдрүүлэв. Уншсан зүйл минь надад Сүмийн тухай илүүг мэдэх эрмэлзлэлийг төрүүлж, дараах Ням гаригт нь би Мормон Сүмийн цуглаанд оролцохоор хотын нөгөө тал руу явган гарсан. Энэ бол ариун сургаалын гэрчлэлээ тордон өнгөрөөсөн найман жилийн минь эхлэл байсан бөгөөд эцэст нь би ‘хуурай’ Мормон байхаа больж, хорин хоёр насандаа усаар баталгаа хийлгэсэн юм.

“Ингээд би Сүмийн гишүүн болж, сэлэсчел өргөмжлөлд хүрэх замаа эхэлсэн тул хувийн хөгжил, бүтээлтийнхээ дутагдалд баригдахгүй боллоо. Би Түүний хаант улсад зохистой хэрэгтэй хувь хүн болон хөгжихийг хүссэн бөгөөд үүний тулд уншихаас эхлээд маш олон зүйлийг би сурах хэрэгтэй байв.

“Бидний гаргасан шийдвэр, төлөвлөгөө нь бидний мөнхийн хөгжилд нөлөөлнө хэмээн үргэлж зөвлөлгөө сонсдогийнхоо дагуу Их Эзэний удирдамжинд хандаж, ийн хэлсэн патриархын адислал хүлээн авлаа:

“ ‘Сайн үйлсийг гүйцэтгэх хүч чадал, чадавхиар хангагдан сонгогдсон үйлчлэгч эртний Паулын нэгэн адил та бол Бурханы мэлмий дэх сонголт болно. Мэдлэгийн эрлээ үргэлжлүүлж, төгс ухаанаараа Тэнгэрлэг Эцгээ алдаршуулахын учир мэргэн ухааныг хүсэн залбир.’

“Их Эзэн намайг сурах чадвартай гэж бодсон юм бол би *чадах учиртай!* Гэвч, энэ адислал нь хүч гаргалгүй өгөгдөх зүйл биш, миний зүгээс гарах бодол үйлсгүйгээр амархан биелэгдэх юм бус болохыг би ухаарсан. Бүх л патриархын адислалын адилаар, энэ адислалын биелэл нь миний зохистой байдал, тэдгээр адислалуудыг авчрахад шаардлагатай бүхнийг хийх хүсэл зоригт минь тулгуурлах байлаа.

“Хэрэв би зөвхөн хичээвэл Их Эзэний тусламжтайгаар би сурч чадна гэсэн итгэлтэй байсны үүднээс, би долоо хоногийн зургаан өдөрт өглөө зургаан цагаас шөнө дунд болтол суралцах болсон.

“Цагаан толгойн үсгүүдийг хялбар дуудлагаар нь агуулсан пянзны бүрдлийг тоглуулагчийнх нь хамт би \$300-оор худалдаж авлаа. Орой бүрийг өөртөө уншиж бичихийг заахын тулд би үсгүүдийг тогтоон, дуудлагыг нь цээжилж өнгөрөөдөг байв. Үсэглэх чадвар муутай байсан хэдий ч, би үгсийг үеэр нь таслан ойлгон ойлготлоо уншдаг байлаа.

“Шинэхэн илрүүлсэн уншиж үсэглэх чадвартаа бүрнээ найдан би Охаёо Мужийн Их Сургуульд бүртгүүллээ. Багш нарыг лекц уншихад нь би тэмдэглэл хөтлөхийг хичээв ч, тэмдэглэх үгсээ зөв үсэглэж чадахгүй хэцүүдэв. Бараг л үг бүрийг би үеэр таслан үсэглэдэг байсан бөгөөд үр дүнд нь би багшийн лекцийн маш өчүүхэн хэсгийг тэмдэглэлдээ буулгадаг байлаа. Нямбайлан бичсэн, бүрэн тэмдэглэлгүйгээр суралцаж, шалгалтанд бэлтгэнэ гэдэг нь миний хувьд боломжгүй байсан тул миний үнэлэлт муу дүн үзүүлж, би Их Сургуулиас хасагдлаа.

“Сэтгэлээр унаж, эрдмийн мөр хөөх чадвартаа эргэлзэж байсан хэдий ч, би суралцаж *чадна* хэмээсэн адислал амлалт хүртсэн байсан. Энэ амлалтын биелэлт нь зөвхөн миний итгэл *болон* үйлс дээр тулгуурлана гэдгийг ухаарсны үндсэн дээр би үсэглэх, унших чадвараа хөгжүүлэхээр хичээсээр байв.

“Би өөрийн хэсгийг хийвэл Тэр намайг адислах болно гэсэн Их Эзэний үгэнд бүрнээ итгэн, би Рикс Коллежд бүртгүүллээ. Би гэрийн багшлалтаа үргэлж гүйцэлдүүлж, Сүмээс надад өгсөн хариуцлагуудыг итгэлтэйгээр биелүүлж, өдөрт арван найман цаг суралцаж байсан. Би унших чадвартаа бас л хичээллэх хэрэгтэй байсан боловч үеэр таслан задалдаг байснаа бодвол үгсийг хялбархан нүдэлж чадах боллоо. Шалгалт өгөхийнхөө өмнө шалгалтан дээр зөв үсэглэхийн тулд би тэмдэглэл дээрх үг *бүрийг* тогтоодог байв. Риксийг төгсөхөд би сайтар уншиж чаддаг байсан бөгөөд хүндэт оюутан болж дүнгийн үнэлгээ минь 3.6 (онц) байлаа.

“Би одоо Бригхэм Янгийн Их Сургуулийн бакалаврийн зэрэгтэй бөгөөд өөрийн хүссэн сайн дүнтэйгээр сургуулиа дүүргэсэн.

“Хэрэв зөвхөн би Түүнд итгэж, тэдгээр адислалуудын бүрдлийг авчрахаар *ажиллах* аваас патриархын адислалд минь дурдагдсан бусад адислалуудын хамтаар, ‘Сайн үйлсийг гүйцэтгэх хүч чадал, чадавхиар хангагдана’ хэмээх Их Эзэний амлалт биелсээр байх юм” (Дорвис Роджэрс, “You Shall Glorify your Father in Heaven With your Intelligence,” *When Faith Writes the Story*, х. 34–37).

Энэ хүү бэлтгэлтэй бас дуулгавартай байсны үр дүнд патриархын адислал нь удирдамжийн эх сурвалж болж түүнийг тайтгаруулжээ. Бид үүний нэгэн адил патриархын адислалд амлагдсан адислалуудад хүрэхийн тулд итгэлээ амьдралд хэрэглэх учиртай.

Уриалга

1. Хэрэв та нар патриархын адислалаа хүлээн аваагүй байгаа бол өөрийгөө бэлтгэ.
2. Адислалаа хүлээн авсан бол тогтмол уншиж амлагдсан адислалуудыг хүлээн авахын тулд зохистой амьдрахаар чармай.

Нэмэлт Судрууд

Эхлэл 49:1–28 (Патриарх Израил хөвгүүдээ адислаж байна)

С ба Г 107:39–56 (үйлчэгч нарыг томилох Арван Хоёр; эрт цагийн патриархын пристийн зэрэг)

С ба Г 124:91–92 (патриархууд адислал хүртээх түлхүүрүүдийг хүлээн авдаг)

Мозэс 6:1–6 (дурдатгалын ном нь Адамын үрсийг адисласаар байсан)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. Патриархын адислал хүлээн авсан нэгэн гишүүнээс тэрхүү адислал нь амьдралд нь хэрхэн удирдамж, түшиг тулгуур болж байгаа талаар гэрчлэлээ хуваалцахыг хүс. (Түүнд патриархын адислал бол хувийнх учраас бусдад унших ёсгүй. Ийм шалтгаанаар адислалд өгсөн амлалт зөвлөмжүүдийн талаар тодорхой ярих ёсгүй.)
2. Патриархын адислал хүлээн авахаар хэрхэн бэлтгэсэнээ ярихыг бас нэгэн гишүүнээс хүс.

Ерөнхий Эрх Мэдэлтнүүдтэй Байхын Хэрэгцээ

Хичээл 11

Энэ хичээлийн зорилго бол Их Эзэн яагаад Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг дууддаг болон тэднийг дэмжснээр бид хэрхэн адислагддаг болохоо ойлгоход бидэнд туслах явдал юм.

Оршил

Энэ дэлхий дээр амьдарч байхдаа Аврагч өөрийн сүмээ байгуулж эрчүүдийг пристийн зэрэгт томилжээ. Дуудагдсан тэдгээр хүмүүсийн дунд Түүнийг гэрчлэх, Сүмийг харж хандахад нь туслах арван хоёр Дагалдагчид болон бусад хүмүүс байсан юм. Үхэл ба дахин амилалтынхаа дараа Тэрээр Америкт Нефайн хүмүүст айлчлан очиж, мөн ижил аргаар өөрийн Сүмээ байгуулжээ. Тэрээр Хуучин Ертөнц дэх Сүмд арван хоёр Дагалдагчид үйлчилж байсны адилаар Нефайчуудад үйлчлэх арван хоёр шавиа томилжээ.

Хожмын энэ өдрүүдэд Их Эзэн бошиглогч Жозеф Смитээр дамжуулан, Исүс Христийн үнэн Сүмийг дахин байгуулсан юм. Энэ нь илчлэлээр байгуулагдсан бөгөөд Аврагчийг дэлхий дээр байх үеийн Сүмтэй адил арван хоёр Дагалдагчтай. Дагалдагчдаас гадна Их Эзэн Сүмийг бүхэлд нь удирдахад туслах бусад хүмүүсийг дууддаг. Тэдгээр хүмүүсийг Ерөнхий Эрх Мэдэлтнүүд гэж нэрлэдэг.

Ерөнхий Эрх Мэдэлтэн нь дараах албан тушаалуудын нэгийг хашихаар Их Эзэнээр дуудагдсан Мэлкизэдэк Пристийн Зэрэгтэн юм.

11-а үзүүлэнг таниул, “Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүд”

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ

Тэргүүн зөвлөл нь Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болох Сүмийн Ерөнхийлөгч ба түүний хоёр зөвлөхөөс бүрдэнэ. Ерөнхийлөгч нь хожмын өдрүүдэд Сүмд дахин сэргээгдсэн бүх л түлхүүрүүд болон эрх мэдлийг атгадаг. Хоёр зөвлөхийнхөө хамтаар Ерөнхийлөгч Сүмийг бүхэлд нь харж хандах бөгөөд пристийн зэргийн болон Сүмийн бүх албыг хаших хүч чадал, эрх мэдлийг агуулдаг.

Сүмийн Ерөнхийлөгч Сүмийн бүх л сүнслэг болон цаг зуурын үйл ажиллагааг удирдах пристийн зэргийн “түлхүүрүүдийг” атгадаг. Тэрээр гадасны ерөнхийлөгч нар, бишопууд, патриархууд болон бусдад газар зүйн бүсдээ тодорхой нэгэн албыг хаших “түлхүүрүүдийг” олгох эрхтэй.

Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүд

Тэргүүн Зөвлөл



Ерөнхийлөгч Томас С. Монсон
Нэгдүгээр Зөвлөх



Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли



Ерөнхийлөгч Жэймс И. Фауст
Хоёрдугаар Зөвлөх

Арван Хоёрын Зөвлөл



Бойд К. Пакэр



Л. Том Пэрри



Дэвид Б. Хайт



Нил А. Максвэлл



Рассэлл М. Нэлсон



Даллин Х. Оүкс



М. Рассэлл Баллард



Жозеф Б. Вортлин



Ричард Ж. Скотт



Робэрт Д. Хэйлс



Жэффри Р. Холланд



Хэнри Б. Иринг

Энэ талаар Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит бичихдээ, “пристийн зэргийн ямар нэгэн түвшинд батлагдсан бүх эрчүүд энэхүү эрх мэдлийг агуулдаг. Гэхдээ, энэ эрх мэдлээр явагдсан бүхий л үйл ажиллагаа нь зохих цаг хугацаа, газарт, зохих байдлаар, зохих заавар өгөгдсөний дараа хэрэгжих ёстой. Эдгээр хөдөлмөрийг зааварлах хүч чадал нь пристийн зэргийн түлхүүрүүдийг бүрдүүлдэг” (*Gospel Doctrine*, х. 136).

АРВАН ХОЁР ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЧУУЛГА

Арван Хоёр Төлөөлөгчдийг Христийн онцгой гэрчлэгчид болгохоор Их Эзэн дууддаг. Тэд Тэргүүн Зөвлөлийн удирдлаган дор ажилладаг.

ДАЛ

Дал нь Их Эзэний нэрээр Арван Хоёрын удирдлаган дор Сүмийг бүтээн байгуулж бүх үндэстэнд хамрагдах үйл ажиллагааг зохицуулахаар ажилладаг юм (С ба Г 107:34 -ийг үз).

ЕРӨНХИЙЛӨН УДИРДАХ БИШОПЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхийлөн Удирдах Бишопын Зөвлөл нь Арван Хоёрын Чуулга болон Тэргүүн Зөвлөлийн удирдлаган дор ажилладаг бөгөөд Аароны Пристийн Зэргийн ерөнхийлөгчийн зөвлөл болно.

Ерөнхийлөн Удирдах Бишоп ба хоёр зөвлөхүүд нь Сүмийн бие хүний, цаг зуурын үйл ажиллагааг харж ханддаг.

Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн хамтаар олон тооны хүмүүс Арван Хоёрын Бүс Нутгийн Төлөөний Хүмүүс болон дуудагддаг. Тэд Ерөнхий Эрх Мэдэлтнүүд биш хэдий ч, Арван Хоёрыг төлөөлөн дэлхийн тодорхой бүс нутгуудад Сүмийг бүтээн байгуулахад туслахаар дуудагддаг болно.

Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн Үүрэг Хариуцлага

Ерөнхий Эрх Мэдэлтнүүд нь Исүс Христийн төлөөний хүмүүс юм. Сүмийн тэргүүн болох Аврагч өөрөө бошиглогчдод болон бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүдэд илчлэлийг хүргэн сүмээ удирддаг. Эдгээр хүмүүсээр дамжуулан Их Эзэн өөрийн хүсэл зоригоо илчилж авралд маань шаардлага бүхий бүх л зүйлсийг бидэнд сургадаг.

Ерөнхий Эрх Мэдэлтнүүд Аврагчийг олон арга замаар төлөөлдөг:

- Сүмийн гишүүд болон орон нутгийн Сүмийн удирдагчдыг зааварлан, туслахын тулд тэд дэлхий даяар аялдаг.
- Тэд Сүмийг эв нэгдэлтэй байлгаж Сүм зөв сургаалыг зааж байгааг бататгадаг.

11-а. Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүд. Сүүлийн үеийн зургийг Сүмийн сэтгүүлийн сүүлчийн чуулганы илтгэлээс үз.

- Тэд гадасны ерөнхийлөгч нар болон гадасны патриархууд гэх зэрэг пристийн зэргийн удирдагчдыг томилдог.
- Тэд ерөнхий чуулган, бүсийн чуулгад болон бусад цуглаануудад яриа бэлтгэж хийдэг. Эдгээр хүмүүс Ариун Сүнсний нөлөөгөөр ярих нь, Христ өөрөө ярьж байгаагаас ялгаа үгүй болно. Түүний үг өөрийнх нь дуу хоолойгоор сонсдсон, эсвэл үйлчлэгчдийнх нь дуу хоолойгоор сонсдсон нь ялгаа үгүй болохыг Их Эзэн хэлсэн байдаг (С ба Г 1:38 -ыг үз). Ийм байдлаар тэд Сүмийн гишүүдэд болон гишүүн бус хүмүүст сургаж урам хайрладаг.
- Арван Хоёр нь бүх ертөнцөд Исүс Христийн онцгой гэрчлэгчид байх дуудлагатай. Хаана ч очсон, тэд Христийн нандин чанарын талаар гэрчлэлээ хуваалцдаг. Бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүд ч мөн Аврагчийг гэрчилдэг болно.
- Тэд Сүмийн бүхий л удирдах үйл ажиллагааг зохион байгуулах хариуцлага хүлээдэг.
- Эдгээр олон үүргүүдийн хамтаар тэд мөн эцгүүд, нөхрүүд болно. Сүмийн бусад олон эцгүүдийн нэгэн адил тэд өөрсдийн гэр бүлүүдийг удирдах, тэднийгээ сэлэсчел хаант улс тийш хөтлөх хариуцлагатай.

Ерөнхий Эрх Мэдэлтнүүдэд хандах Бидний Хэрэгцээ

Түүхийн он жилүүдийн туршид Тэнгэрлэг Эцэг бошиглогчдоороо дамжуулан дэлхийн хүмүүст өөрийн хүсэл зоригоо илчилсээр иржээ. Энэ нь Мозэсийн, Христийн эсвэл Жозеф Смитийн цаг үеийг ярьж байгаагаас үл хамааран үнэн хэвээр байх болно. Нөхцөл байдал өөрчлөгдөж болох хэдий ч, үнэн болон Бурханы зааварт хандах бидний хэрэгцээ өөрчлөгдөшгүй юм. Их Эзний хайрын үрээр, өнөөдөр биднийг хөтлөн залах бошиглогч, Төлөөгчид болон Ерөнхий Эрх Мэдэлтнүүд байгаа болно.

Бошиглогчоо дуулгавартай дагаснаар хэсэг хүмүүс хэрхэн адислагдсаныг дараах түүх өгүүлнэ:

“1959 оны 7 сард төлөвлөгөө биеллээ. Хавайн Ариун Сүмд хүрэх аяллыг санхүүжүүлэх мөнгийг цуглуулахаар гучин итгэлт Тахитичууд хөдөлмөрлөж, хуримтлуулж, бас золиосложээ. Үүрэгт хэрэглэх *Параэта (Их Ахлагч)* усан онгоцыг хуурай эрэгт авчран, засварлаж, дахин будаж шинэчлэхэд ихээхэн хөдөлмөр зарцуулагджээ. Тэгтэл бас Францын засгийн газартай харилцах асуудал тулгарлаа. (Онгоцны ахмад Тапү ах боомтын эзнийг зөвшөөрүүлж, тэд хоёул, *Параэта* хөлгөн дээрх Гэгээнтнүүдийг Хавай тийш хөдлөхийг зөвшөөрүүлэхээр Францын засаг даргыг ятгав.)

“Тапү ах Францын албан хаагчдаас зөвшөөрөл хүсээд зогсоогүй, түүнчлэн Ерөнхийлөгч Дэвид О. МакКэйгээс зөвшөөрөл авахаар

Солт Лэйк Сити руу бичжээ. Зөвшөөрөл авч бүх зүйл бэлэн болсон байлаа.

“Тэгтэл номлолын албанаас золгүй тэр дуудлага ирлээ. Аялалд оролцохоор төлөвлөж байсан хүн бүр хөдлөхийн өмнө номлолын албан байранд цуглаанд хүрэлцэн очих хэрэгтэй байлаа. . .

“Тэр өдөр онцгой мэдээ хүргэгч Эрнэст С. Росситэр . . . Солт Лэйк Ситигээс Ерөнхийлөгч МакКэйнд дэргэдээс иржээ. Авчирсан мэдээ нь гайхал төрүүлэм байв. Гэгээнтнүүдийг удаан хүлээсэн аялалдаа гарахгүй байхыг хүсчээ. Тапү ахын хэлснээр, Ерөнхийлөгч МакКэй ямар ч тайлбар хэлээгүй байна. Тэрээр Росситэр ахад ‘яв, тэднийг зогсоо. Тэд аяллаа дуусгаж чадахгүй. Тэгээд ч тэднийг ирэхийг зөвшөөрвөл бид Францын засгийн газартай сөргөлдөх болно. Бид тэдний төлөө хариуцлага хүлээх болно. Тиймээс яв, тэднийг зогсоо’ хэмээжээ.

“Номлолын өдрийн тэмдэглэлдээ, (номлолын ерөнхийлөгч) Ерөнхийлөгч Кристиансэн онгоцон дээр гарахад бэлэн байсан Гэгээнтнүүдийн талаар сэтгэлийн түгшүүрээ ийн тэмдэглэжээ:

“ ‘Сэтгэл минь зовниж Их Эзэний Ариун Өргөөнд хишиг хүртэх өндөр найдлагатай байсан тэдгээр даруу итгэлт гишүүдэд тайлбар өгөхөд Түүний тусламж хэрэгтэй болохыг мэдэрсэн. Энэ талаар би мацаг барьж залбирлаа. 1959 оны 7 сарын 15-ны 8 цагт би пристийн зэргийн гишүүдийг цуглаанд дуудаж итгэлт зургаан ахыг өрөөнд минь 7:30-д ирэхийг хүсээд, Ерөнхийлөгч Росситерийн тусламжтайгаар Тэргүүн зөвлөлөөс ирсэн шийдвэрийн талаар 8 цагт ирэх Пристийн зэргэтнүүдэд танилцуулаад бидэнд тэдний итгэл, залбирал хэрэгтэй буйг мэдэгдэв. Ерөнхийлөгч Росситэр бид хоёр тэдэнтэй ярьсны дараа тэд өөрсдийн бодлоо хэлж, энэ дэлхий дээрх бидний бошиглогчийг дуулгавартай дагах эрмэлзлэлээ илэрхийлэхийг сонсон суухад, агуу баяр баясгалан цээжинд минь бялхсан.

“ ‘Пристийн зэргийн гишүүдтэй хийх уулзалтандаа бид очлоо. Тэргүүн Зөвлөлийн мэдээг сонссоныхоо дараа тэд, хэрэв энэ үг нь Сүмийн удирдагчдаас ирсэн бол энэ нь Их Эзэний урам зоригоор байх учиртай бөгөөд Түүний өгсөөр буй адислалуудад талархах талархал, хайр хүндэтгэлээ илэрхийлэх цорын ганц зам бол өгөгдсөн зөвлөмжийг дуулгавартай дагах явдал болохыг илэрхийллээ. Тэгээд би санал хураахад, гар болгоныг Тэргүүн Зөвлөлийн шийдвэрийг хүлээн зөвшөөрснөө мэдэгдэн өргөсөн байв.’

“Аялалыг зогсоож Ерөнхийлөгч Росситэр, Ерөнхийлөгч Кристиансэн болон Тахитийн итгэлт Гэгээнтнүүдийн хэн нь ч Бурханы бошиглогч юуны учир тэднийг явж болохгүй гэснийг мэдэлгүй өнгөрөв. Тэд бошиглогчид итгэлтэй байсны учир аялалаа зогсоожээ.

“Хожим нь, онгоцны ахмад Тапү ах хөлөг дээрээ ирэхэд, засварчин нэг жижиг араа эвдэрсэн байсан бөгөөд дөнгөж 100–150 цагийн үйлчилгээг л тэсвэрлэхээр болсон байсныг мэдэгджээ. Хөлгийг зогсоолд оруулж зангууг нь буулгасан байлаа.

“Тапү ах мэдэгдэхдээ, ‘Хэд хоногийн дараа би дуудлага хүлээн авлаа. Би номлолын албан байранд орон нутгийн Сүмийн сэтгүүл дээр ажиллаж байсан. Тэр дуудлага боомтын эзнээс ирсэн юм. Тэрээр, “Онгоц чинь живж байна” гэхэд, би хариуд нь, “Юу гэсэн үг вэ, би түүнийг дөнгөж л эргээс буулгаад байгаа шүү дээ” гэж хэлсэн. Гэвч тэрээр, “Түргэл, онгоц чинь живж байна!” гэсээр байв. Би ч боомт тийш сандран очиход онгоцны тал бие нь усан дор орсон байв. Анхны анд маань юу болсныг шалгахаар онгоцон доор оржээ. Гал зуухны хийн хоолой зэвэрч муудсан болохыг олж илрүүлэв. Засварчин идэгдсэн мод, зэвэрсэн хоолойг засалгүй будаж тэр нь хагарснаас, дотор нь ус оржээ.

“ ‘Хоёр гурван зуун милийн зайд бид аврагч завин дээр сууж байсан бол бид яах байсан бол? Хэрэв бид хуваарь ёсоор аялсан бол мод эвдэрч, зэвэрч муудсан хоолой хагарах үед бид эргээс нэлээн хол одсон байх байжээ.’

“Тахитийн Гэгээнтнүүд бошиглогчийн зөвлөмжийг хүлээн зөвшөөрөхдөө Ерөнхийлөгч МакКэйн сэтгэл зовсон шалтгааныг мэдээгүй билээ. Харин одоо, тэд Бурханы арга замыг ухаарчээ. Тапү ахын хэлсэн, ‘Энэ бол би Ерөнхийлөгч МакКэй бол Их Эзэний үнэн бошиглогч болох талаар үргэлжийн гэрчлэлтэй байдгийн учир юм’ хэмээх үг нь энэхүү мэдлэгийг илэрхийлжээ.” (R. Lanier and JoAnn M. Britsch, “Бошиглогчийн Анхааруулга,” *New Era*, 1976, 5-р сар, х.12, 14).

Ерөнхий Эрх Мэдэлтнүүд Христийг төлөөлөн ярьдаг. Ариун Сүнсний нөлөөнд ороход тэдний хэлсэн бүхэн нь судар болно, Их Эзний хүсэл зориг, Их Эзэний оюун, Их Эзэний үг, Их Эзэний дуу хоолой, авралд хүргэх Бурханы хүч чадал байх болно хэмээн Их Эзэн хэлсэн байдаг. (С ба Г 68:4 -ийг үз).

Тэдгээр хүмүүс дэлхий дээрх Аврагчийн төлөөний хүмүүс болохын учир тэдний хэлснийг бид мэдэж заавруудыг нь дагах нь чухал юм. Бидний үед Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн цохон тэмдэглэсэн Их Эзэний заавруудаас авч үзье. Тэд бидэнд гэр бүлийн цуглаан явуулахыг зөвлөсөн. Тэд ариун сүмүүдийг босгоход тусалж ургийн бичгээ хөтлөхийг биднээс хүссэн. Тэд бидэнд хувийн болон гэр бүлийн бэлтгэлтэй байдлын (хүнс хадгаламж) талаар сургасан. Түүнчлэн тэд гишүүн бүр номлогчийн ажлыг гүйцэтгэхийн чухлыг цохон тэмдэглэсэн билээ.

Сүүлийн арав, хорин жилд ертөнц ямар хурднаар өөрчлөгдөж байгаа тухай гишүүдээс бодохыг хүс. Өнөөгийн амьдрал дахь сорилтуудтай нүүр тулахад бошиглогчдыг сонсох нь хэрхэн тусалж байна вэ?

Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг Дэмжих нь

Үйлчлэгчдийг нь дуулгавартай дага хэмээн Их Эзэн биднийг хүчилдэггүй. Бид тэднийг хүлээн зөвшөөрч эсвэл татгалзаж болно. Гэвч, Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болон бусад удирдагчдаа хүлээн зөвшөөрч дэмжих боломжтой байна гэдэг нь гайхамшигтай адислал юм. Сүмийн удирдагчдаа дэмжих сонголтоо илэрхийлэхийг бид албан ёсны цуглаанууд дээр гүйцэтгэдэг. Бид тэднийг дэмжих эрмэлзлэлээ баруун гараа өргөн илэрхийлдэг. Гэвч Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг дэмжих нь энгийнээр баруун гараа өргөхөөс илүүг шаардана. Бид үнэндээ тэдний заавруудыг хүлээн зөвшөөрч, зөвлөмж, удирдлагуудыг нь дагаснаараа Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг дэмжих юм.

Эдгээр хүмүүс нь Исүс Христийн төлөөний хүмүүс бөгөөд Түүнээс тогтмол илчлэлүүдийг хүлээн авдаг болно. Бид Аврагчийнхаа төлөөний хүмүүсийг нь алдаршуулснаар Түүнийг алдаршуулна. Заавруудыг нь дуулгавартай дагаж тэдний төлөө залбирч, тэднийг дагах чадлын төлөө залбирснаар бид амьд бошиглогчдоо алдаршуулж хүндэтгэдэг. (Жүүд 13:17–19 болон С ба Г 107:22 -ыг үз). Бид бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөө дэмжсэнээр, тэрээр удирдлаган дор нь ажилладгийн учир тэднийг дэмждэг.

Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг дэмжигчдэд агуу адислалууд ирнэ. Бошиглогчдын заавруудад итгэж эцсээ хүртэл итгэлтэйгээр тэвчигчид Бурханд байгаа бүхнийг хүлээн авах болно хэмээн Их Эзэн хэлсэн байдаг. (С ба Г 84:36–38 -ыг үз). Бурханы бошиглогчийг хүлээн авсан агуу нэгэн эр Амулэкийн тухай Мормоны Номонд өгүүлдэг. Тэнгэрийн элч Амулэкт айлчлан ирж бошиглогч Алма тэднийд айлчлах гэж байгааг хэлсэн. Алмаг гэртээ оруулж хоолло хэмээн Тэнгэрийн элч хэлсэн. Алма Амулэкийг болон өрх гэрийг нь адислах бөгөөд Их Эзэний тэрхүү адислал түүнд болон гэрт нь үлдэх болохыг Бурханы элч Амулэкт хэлжээ. (Алма 10:7 -г үз). Амулэк Алмаг гэртээ оруулсан бөгөөд хожим нь бошиглогчийг хүлээн авсны учир тэр өөрөө болон гэр бүлийнхэн нь хүлээн авсан агуу адислалуудын талаар гэрчлэлээ хэлдэг.

Алма 10:10–11-г унш. Амулэкийн дүрсэлсэн адислалуудыг бид хэрхэн хүртэж чадах вэ?

Ерөнхий Эрх Мэдэлтэн гэрт маань хэзээ ч айлчилж ирэхгүй байж мэдэх хэдий ч, өрх гэртээ урмаар тэтгэгдсэн зөвлөмжүүдийг нь дагаж Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг хүлээн зөвшөөрөх аваас, бид үүнтэй адил адислалуудыг хүртэж болно.

Хэрэв хэн нэгэн гишүүн Ерөнхий Эрх Мэдэлтэнтэй уулзсан, эсвэл яриаг нь сонссон бол түүнээс тэр тохиолдлоосоо ярьж, Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг сонсож дуулгавартай дагах нь ямар чухал ач холбогдолтой болох талаар мэдрэмжээ хуваалцахыг хүс.

Дүгнэлт

Ерөнхий Эрх мэдэлтнүүд нь Аврагчийн бие төлөөний хүмүүс болно. Тэд пристийн зэргийг болон Их Эзний Сүмийн ажлыг удирдах түлхүүрүүдийг атгадаг. Зөвлөмжүүдийг нь дагаж итгэл, дуулгавартай байдал, залбирлууддаа тэднийг дэмжихдээ бид агуу адислалуудыг хүлээн авдаг.

Ерөнхийлөгч Харолд Б. Ли хэлэхдээ: “Нэгэн хүн ийн хэлсэн байдаг . . . бөгөөд энэ үг туйлбаргүй үнэн болоход би итгэж байна. ‘Тухайн хүн Бурханы хүч сүмийн удирдагчдад оршин, түүний зүрх сэтгэл тийш гал мэт урсан орох хүртэл үнэхээр өөрчлөгддөггүй.’ Сүмийн гишүүд тэд зөв замд хөтлөгдөж байгаа хэмээх үнэмшил, тэдгээр Бурханы хүмүүс нь Бурханы гараар урам хайрлагдаж зохих ёсоор томилогдсон хүмүүс хэмээх үнэмшлийг агуулах хүртлээ, үнэхээр өөрчлөгддөггүй.” (“Пристийн Зэргийн Хүч Чадал,” *Ensign*, 1972, 7-р сар, х. 103).

Уриалга

1. Өнөөдөр үдшийн гэр бүлийн залбирал болон хувийн залбиралдаа Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийг адислахыг Их Эзэнээс хүс.
2. Бошиглогч ба бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн талаар гэрчлэл болон тэднийг дагах чадлын төлөө залбир.

Нэмэлт Судрууд

Тоонууд 12:6 (Их Эзэн бошиглогчдынхоо өмнө үзэгддэг)

Амос 3:7 (Их Эзэн бошиглогчиддоо нууцаа илчилдэг)

Лүк 1:59–79 (Их Эзэн үргэлж бошиглогчдоороо дамжуулан хүмүүст ханддаг)

С ба Г 21:4–6 (Бошиглогчид Бурханы амнаас гарч байгаатай адил ярьдаг)

С ба Г 43:1–7 (Сүмийн төлөөх илчлэлүүд зөвхөн бошиглогчоор дамжуулан өгөгддөг)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийн өмнө:

1. Хичээлийг “We Thank Thee, O God, For a Prophet,” – *Hymns* no. 19– дуугаар эхлэх эсвэл өндөрлөхөөр төлөвлө.
2. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Гэр Бүлийнхээ Сайн Сайхны Төлөө Хүлээх Эцгийн Хариуцлага

Хичээл 12

Энэ хичээлийн зорилго бол гэр бүлийн хэрэгцээг төлөвлөж хангахад эцгийн хүлээх хариуцлагыг ойлгоход бидэнд туслах явдал юм.

Оршил

Их Эзэний бошиглогч хэлэхдээ: “Цаг зууртаа болон мөнхөд гэр бүл хамгийн чухал байгууллага болдог. Энэ амьдрал дахь зорилго маань мөнхийн гэр бүлийн нэгдлээ үүсгэх явдал юм.” (Жозеф Филдинг Смит, “Гэгээнтнүүдэд болон Ертөнцөд Хүргэх Зөвлөмж,” *Ensign*, 1972, 7-р сар, х. 27.)

Мөнхийн гэр бүл бол патриархын гэр бүл юм. Энэ нь эцэг нь гэр бүлийг тэргүүлж эхнэр нөхөр хоёр ариун сүмд мөнхөд холбогдсон байхыг хэлж байгаа юм. Гэр бүлийн бүхий л нэгдлүүд эцэг нь гэр бүлээ үнэнээр тэргүүлэх замаар мөнхийн гэр бүлийг үлгэр болговол зохино.

Эцэг нь Гэр Бүлийнхээ Хэрэгцээг Хангах Ёстой

Эцэг нь гэр бүлийн тэргүүн болохыг судрууд бидэнд сургадаг (Эфэс 5:23 -ыг үз) . Тиймээс, тэр гэр бүлийнхээ бодит ба сүнслэг хэрэгцээг хангах учиртай (Мозая 4:14–15- ыг үз). Их Эзэнээс бидэнд өгөгдсөн нандин хариуцлага нь эцгийн гүйцэтгэх хамгийн чухал ажил юм. Ерөнхийлөгч Дэвид О. МакКэй ийн мэдэгджээ: “Гэр бүл дэх уналтыг ямар ч амжилт нөхөж төлөхгүй” (Дэвид О. МакКэй, *Чуулганы Илтгэл*, 1964, 4-р сар, х. 4).

Гэр бүлд хүүхдүүдийг халамжлаж мөнхийн зарчмуудыг заах нь зүйтэй. “Их Эзэний хамгийн чухал ажил бидний гэртээ хийдэг зүйлүүд болно” хэмээн Ерөнхийлөгч Харолд Б. Ли хэлжээ (Бүс Нутгийн Төлөөний Хүмүүсийн Семинарын Илтгэл, 1972, 4-р сар, х. 2). Нэг ч багш бидний, эцэг эхчүүдийн адилаар хүүхдүүдэд маань нөлөөлж чадахгүй. Иймээс бид үр хүүхдүүддээ үгээрээ болон үлгэр жишээгээрээ сургах учиртай. Бид эхнэр хүүхдүүдийнхээ хамтаар ариун сүмд мөнхөд холбогдож ариун сургаалын зарчмуудад үнэнчээр амьдрал бид сэлэсчел хаант улсад мөнхийн гэр бүл болон амьдарч чадна хэмээн амлагдсан билээ (*Ариун Сургаалын Зарчмууд* гарын авлага, “Өргөмжлөл” 47-р бүлгийг үз).



Гэр Бүлийнхээ Бодит Хэрэгцээг Хангах нь

Эцгийн хувьд бид гэр бүлийнхээ бодит хэрэгцээг хангах учиртай. Гэр бүлийнхээ бодит хэрэгцээг хангахын тулд бид:

- Гэр бүлийн хэрэгцээг хангах шударга ажил хийх.
- Эхнэрийнхээ хамтаар гэр бүлийн орлогоо зарцуулах төсөв гаргах.
- Хүүхдүүдээ хэрхэн хөдөлмөрлөхийг сургах.
- Гэрийн үйлдвэрлэл ба хадгалалтын хөтөлбөрийг удирдах нь зүйтэй.

Ажиллах чадвартай хэдий ч, үл хөдлөгсөд хөдөлмөрлөгсдийн талхыг идэж, хувцсыг өмсөж үл болно хэмээн орчин цагийн судрууд бидэнд сургадаг (С ба Г 42:42 -ыг үз) . Их Эзэн, хэрэв залуу хүн арга барилаа өөрчлөхгүй бол хөдөлмөрлөгсдийн хүртдэг адислалыг үл хүртэнэ. Тэр ч бүү хэл Сүм дэх өөрийн байраа ч алдана хэмээжээ (С ба Г 75:29 -ийг үз) . Бидний хийж буй ажил шударга бөгөөд сэтгэлд таатай байвал бид чухам юу хийх нь чухал биш юм.

Эхнэрийнхээ хамтаар нөхөр нь гэр бүлийн төсвөө тооцоолох нь зүйтэй. Түүний олдог орлого зөвхөн түүнийх бус, бүх л гэр бүлийнх болно; тэрээр зөвхөн түүнийг гүйцэтгэгч болно. Тэрээр зөвхөн түүнийх бус, гэр бүлийн бүх хүний санхүүгийн хэрэгцээг хангасан байх хариуцлага хүлээнэ. Гэр бүлийнхнийхээ бодит шаардлагыг хангахаар чадах бүхнээ хийхэд Их Эзэн гэр бүлийн зохих ажиллагааг явуулахад нь түүнийг болон эхнэр хүүхдүүдийг нь адислана.

12-а үзүүлэнг таниул, “Хамтран ажилладаг гэр бүлүүд ердийн амьдралдаа болон сүнслэг байдалдаа адислагдана.”

Ирээдүйнхээ амьдралын ажил хөдөлмөрт шаардлагатай гэж үзэх хэмжээний мэдлэг боловсрол эзэмшихээр хүүхдүүд урамшуулагдаж зөвшөөрөгдсөн байвал зохино. Боломжтой бол тэд ажил хийхээр сургуулиас хөндийрөхгүй байх нь чухал. Энэ нь хүүхдүүд маань гэртээ ажиллахгүй байх учиртай гэсэн үг биш юм. Ерөнхийлөгч Харолд Б. Ли хүүхдүүдэд онцгой даалгавар оноож, тэднийг ажиллах чадвартай болж, цагийг дэмий өнгөрөөхгүй байлгахыг эцэг эхчүүдэд зааварласан (“Залуу Үеэ Бэлтгэх нь,” *Утышпт*, 1971, 3-р сар, х. 3 -ыг үз).

Хүүхдүүдэд оноогдож болохуйц нэг үүрэг бол гэрийнхээ цэцэрлэгийг арчлах явдал болно. Хүнсний хэрэгцээгээ хангаж хангалттай хэмжээний хүнс хадгалж нөөцлөхөөр өрх гэртээ цэцэрлэг талбайтай байх зөвлөмжийг бид хүлээн авсан.

12-а. Хамтран ажилладаг гэр бүлүүд ердийн амьдралдаа болон сүнслэг байдалдаа адислагдана.

Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл айл өрх бүр “Эзэмшил газартаа ургуулж болох бүх л хүнсээ тариал. . . . Хоол хүнсээ цэвэрлэж хадгалах чадвараа нэмэгдүүл. Сүмийн урьдын зөвлөмжүүдэд дурдагдсан жилийн хэрэгцээг хангахуйц хадгаламж, нөөцтэй байх зөвлөмжийг бид бататгаж байна” хэмээн зөвлөсөн байдаг. (Спэнсэр В. Кимболл, “Гэр Бүлийн Бэлтгэлтэй Байдал,” *Ensign*, 1976, 5-р сар, х. 124).

Хүүхдүүдээ ажиллах чадварт сургах ямар үйл ажиллагаанууд байж болох вэ? Гэр бүлийнхээ бодит хэрэгцээг хангаж чадахгүй үедээ бид хаанаас тусламж хүсэж болох вэ? (Юуны түрүүнд бид гэр бүлийн гишүүд, хамаатан садан гэх зэрэг туслах боломжтой хүмүүсээс асууж болно. Хэрэв тэд боломжгүй бол бид Сүмд хандан чуулгын удирдагчтайгаа харилцах хэрэгтэй. Сүм бидний хэрэгцээнд нийцэх байдлаар туслах боломжгүй үед л, бид засгийн газрын тэтгэлгийн товчоотой холбоо тогтоох нь зүйтэй.)

Гэр Бүлийнхээ Сүнслэг Хэрэгцээг Хангах нь

Гэр бүлийнхээ сүнслэг хэрэгцээг хангахын тулд бид:

- Эхнэр хүүхдүүддээ ариун сургаалаас заах.
- Өдөр бүр гэр бүлийн залбирал хийх.
- Өрх гэрээ Их Эзэний Сүнсийг бидэнтэй хамт байлгахаар урьдаг газар болгох.
- Их Эзэнд аравны нэг болон өргөл өргөх.
- Зохистой, тустай гэр бүлийн цуглаануудыг явуулах нь зүйтэй.

Эдгээр нь нандин үүргүүд юм. Сургаал ба Гэрээнүүдэд эдгээр үүргүүдийн нэгний ач холбогдлыг онцгойлон цохон тэмдэглэсэн байдаг:

С ба Г 68:25, 28 -ыг уншихыг гишүүдээс хүс. Үр хүүхдүүддээ юу заахыг Их Эзэн бидэнд зарлигдсан бэ?

Гэр бүл нь гэртээ ариун сургаалыг заалгасан эсэхэд эцэг нь анхаарал тавих ёстой. Ингэж зааж эхлэх хамгийн сайн аргуудын нэг нь гэр бүлийн цуглаан юм. Энэ нь гэр бүлийнхэнтэйгээ ярьж тэдэнд зааварлах цагийг бидэнд олгодог. Тэргүүн Зөвлөл бүх эцэг эхчүүдийг “Даваа гариг бүрийн үдэш гэр бүлийнхэнтэйгээ уулзах, тэдэнд судраас заах, . . . тэдэнд гэрчлэлээ хэлэхийг шаарддаг. Эцэг эхчүүд энэ боломжийг ашиглан хүүхдүүдтэйгээ дотносож, ярилцан, тэдэнд тулгарч буй асуудлууд, зорилгуудыг сонсон, тэдэнд хэрэгтэй хувийн заавар зөвлөлгөө өгөх нь зүйтэй.” (“Тэргүүн Зөвлөлийн Захиас,” *Гэр Бүлийн Цуглаан* гарын авлага, 1976–77, х. 3).



Эцгийн хувьд хүүхдүүддээ зохих ёсоор заахын тулд тэрээр өөрийн цагаа гэртээ гэр бүлтэйгээ тогтмол байхаар зохицуулах нь чухал. Түүнчлэн тэрээр, итгэлтэйгээр аравны нэг болон өргөлүүдээ Сүмд өгөх, Сүмийн дуудлагуудыг хүлээн зөвшөөрч биелүүлэх, бусад зарлигуудыг сахих замаар өрх гэртээ ариун сургаалаар амьдрахын баяр баясгаланг үзүүлэх хэрэгтэй.

Хүүхдүүддээ зааж сургахад Сүм бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Эцэг ба Гэр Бүлд Хүрэх Адислалууд

12-6 үзүүлэнг таниул, “Бинжамин хаан гэр бүлийнхнийхээ бодит ба сүнслэг хэрэгцээг хангасан.”

Агуу бошиглогч-хаан ба эцэг, Бинжамин Хааны талаар Мормоны Ном бидэнд сургадаг (Мозая 2:12, 14 -ийг үз). Хаан бас бошиглогч байсан хэдий ч, гэр бүлийнхээ хэрэгцээг хангахын тулд тэрээр өөрийн гараар хөдөлмөрлөсөн. Тэр бусдын дэмжлэгийг хүлээгээгүй. Эцгийн хувьд бид түүний жишээг даган, гэр бүлийнхээ хэрэгцээг хангах учиртай.

Абрахам бол бид амьдралдаа үлгэр болгон үзэх өөр нэгэн эцэг юм. Итгэлтэй байдлынх нь үрээр, түүнд зөв шударга гэр бүл, агуу үр удам амлагдсан байсан (Эхлэл 17:3–8 -ыг үз). Тэрээр өөрийн Их Эзэнийг дагасан, гэр бүлийнхнийхээ хэрэгцээг хангасан тэнгэрлэг чанарынхаа улмаас адислагджээ. Нэгэнт бид Абрахамын үр удам тул бид гэр бүлийнхнийхээ ердийн амьдралын болон сүнслэг хэрэгцээг хангаснаар, түүний хүртсэний адил адислалуудыг хүртэх боломжтой. Чухалчлан хэлэхэд, гэр бүлд маань хайр хүндэтгэл нэмэгдэж гэр бүлийнхэн маань зүрх сэтгэлээрээ өсөх болно.

Дүгнэлт

Ариун сургаалыг хүлээн зөвшөөрч, түүгээр амьдарснаар эцэг ба гэр бүлийнхэн нь хэрхэн адислагдсан талаар дараах түүх өгүүлнэ. Сүмд нэгдэхийнхээ өмнө, Жозеф Гарсиа нөхдийнхөө хамт ууж наргин, гэртээ маш бага цаг өнгөрөөдөг байжээ. Үр дүнд нь, гэр бүлийнхнээ тэтгэхийн тулд эхнэр нь заримдаа цэвэрлэгээний ажил хийж мөнгө олох хэрэгтэй болдог байлаа. Хүүхдүүд нь түүнийг бараг мэддэггүй байв. Тэд түүнийг хайрлаж хүндэтгэхээсээ илүү түүнээс айдаг байжээ.

Нэг өдөр тэрээр Мормон номлогч нартай танилцав. Зургаан сарын турш номлогч нартай уулзсаны эцэст тэр бүрэн өөрчлөгдсөн байна. Бааранд хань татан суудгаа больж Сүмд нэгджээ. Тэрээр хүүхдүүдтэйгээ цагаа өнгөрөөж эхлэн, гэр бүлийн цуглаан явуулж, эхнэр хүүхдүүдтэйгээ гадагш гарах нь ихсэв. Эхнэр нь ажиллах хэрэггүй болж цагаа гэртээ өнгөрөөж болохуйцаар нямбайгаар гэр бүлийн төсвөө төлөвлөв.

Урьдын нөхдөөсөө илүүгээр гэртээ хүүхдүүдтэйгээ, эхнэртэйгээ өнгөрөөсөн цагтаа сэтгэл хангалуун байгаагаа тэр удалгүй мэдэрсэн байна. Хүүхдүүд нь түүнийг хайрлан хүндэтгэх болж өнөөдөр тэд түүний зөв шударга амьдралын жишээг дагахыг хичээж байна.

Уриалга

1. Гэр бүлийнхнийхээ бодит ба сүнслэг хэрэгцээ шаардлагуудыг хангахад хэр амжилттай байгаагаа дүгнэ.
2. Гэр бүлийнхнийхээ хэрэгцээ шаардлагуудыг хангахыг өөртөө амла.
3. Эхнэр хүүхдүүдийнхээ хамтаар амьдралаа судрууд болон Сүмийн удирдагчдын зөвлөмжтэй нэгтгэх төлөвлөгөө гарга.

Нэмэлт Судрууд

1 Тимоти 5:8 (эцгүүд гэр бүлийнхнийхээ хэрэгцээг хангах ёстой)
 Мозаяа 27:14, 22–24 (Их Эзэн эцгүүдийн хүүхдүүдийнхээ төлөө хэлсэн залбирлуудыг сонсдог)
 С ба Г 68:30–31 (залхуу хүүхдүүд нүгэлтэй болж өсдөг)
 С ба Г 75:25, 28–29 (эцгүүд гэр бүлийн гишүүдийнхээ хэрэгцээг хангах учиртай)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Work and Personal Responsibility,” 27 ба “The Family Can Be Eternal,” 36-р бүлгүүдийг унш.
2. Самбар, шохой бэлтгэ.
3. Самбарт, эсвэл үзүүлэн болгохуйц цаасан дээр эцгийн гэр бүлийнхнийхээ бодит ба сүнслэг хэрэгцээг хангах арга замуудыг жагсаа.
4. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Гэр Бүлийн Гишүүдтэйгээ Зөвлөх нь

Хичээл 13

Энэ хичээлийн зорилго бол эхнэр хүүхдүүдтэйгээ зөвлөснөөр гэр бүлээ бэхжүүлэхэд бидэнд туслах явдал юм.

Оршил

“Эргэн Тойрон Үзэсгэлэн Цогцолно” дууг дуул.

Пристийн Зэрэгтэн Өрх Гэртээ Удирддаг

Дэлхий дээрх өрх гэр маань бидний тэнгэрлэг өрх гэрийн эхлэл болдог. Эцэг эхийн ёс нь биднийг бурханлаг чанарт бэлтгэдэг. Үүнийг мэдсэн эцгүүд гэр бүлээ зөв шударга ёсоор хөтөлж, удирдаж, зааварлах нандин үүрэгтэй болохоо ойлгодог. Ерөнхийлөгч Н. Элдон Таннэр хэлэхдээ: “Хожмын Үеийн Гэгээнтэн өрх гэр нь, эцэг нь хайр хүндэтгэлтэйгээр эхийн зөв шударга эрмэлзэл бүхий бүрэн эв нэгдлээр өдөр бүр өрхийнхөө тэргүүн нь болон удирдаж байх үлгэр жишээ өрх гэр байх учиртай. Хамтдаа тэд гэр бүлээрээ ижил зорилгыг эрэлхийлж хүүхдүүд нь хайр хүндэтгэл, эв нэгдлийг мэдрэх сөтой.” (“Эцгийн Ёс,” *Ensign*, 1977, 6-р сар, х. 2).

Гэрлэсэн пристийн зэрэгтнүүдийн хувьд бид зөв шударга гэр бүл өсгөх хариуцлагатай ч, бид энэ ачааг ганцаар үүрдэггүй. Эхнэрүүдийн маань тусламж бидэнд бий. Хамтдаа бид гэрлэлтээ бататгаж гэр бүлээ Их Эзэний мэлмийд дахин хүргэж чадна. Энэ нь хэрэв Их Эзэний Сүнсийг өрх гэртээ талархалтайгаар агуулахыг хүсвэл бид эхнэрээ хайрлан хүндэтгэж тэдэнтэйгээ зөвлөлдөх хэрэгтэй.

Эхнэртээ Хайр Халамжаа Үзүүлэх нь

Мозая 4:14 -ийг унш.

Энэ сударт амар амгалан, хайр хүндэтгэлийн өрх гэрийг бий болгохыг Их Эзэн бидэнд зааварладаг. Ийм өрх гэртэй байхын тулд бид гэрлэлтийнхээ эхний мөчөөс чин сэтгэлийн хайр хүндэтгэл болон хуваалцах чадварыг агуулах учиртай. Эдгээр нь бидний өрх гэрт үл оршивол бид үүнийг бий болгох ёстой. Энэ нь хамтдаа тогтмол залбирах, нэг нэгэндээ хайр хүндэтгэлээ үзүүлэх, судраас хамтдаа суралцах зэргийг шаарддаг. Хамгийн чухал нь, Бурханы зарлигууд болон гэрлэлтийн тангаргаа өргөхөд хийгдсэн гэрээнүүдээ сахин биелүүлэх явдал юм.

Хүчирхэг пристийн зэргийн удирдагч нь энэрэнгүй бөгөөд эхнэртээ халамжтай байдаг (Эфэс 5:25 -ыг үз) . Ерөнхийлөгч Рүбэн Ж. Кларк Жр.: гэр бүл сэлэсчөл болохын тулд эхнэр нөхөр хоёр бие биенээ хайрлаж, дээдлэн хүндэтгэх учиртай. Бие биендээ хүлээцтэй хандаж, тэд гэрлэлтийн тангарагтаа үнэнч байх ёстой. Итгэл нь “энэрэлт гэрэл мэт өрх гэрийг нь дүүргэх” учиртай. Ийн хийх аваас, тэдний Бурханд дуулгавартай байх байдал нь “тэднийг хөтөлж, урмаар тэтгэх” болохыг мэдэгджээ. (*Immortality and Eternal Life*, Vol. 2 [Melchizedek Priesthood study guide, 1969], х. 14–15 -ыг үз).

Эхнэртээ хайр халамжаа үзүүлэхийн тулд бид юу хийж болох вэ? Эхнэртээ хайр халамжаа үзүүлэх нь амар амгалан, хайр хүндэтгэлийн өрх гэр байгуулахад хэрхэн туслах вэ?

Эхнэртэйгээ Зөвлөх нь

13-а үзүүлэнг таниул, “Нөхөр нь эхнэртэйгээ зөвлөхөд гэр бүлээ удирдах байдал нь илүү хялбар бөгөөд үр бүтээлтэй болно.”

Бид эхнэртэйгээ харилцан ярилцах нь чухал. Эхнэртэйгээ зөвлөлдөж Их Эзэний тусламж болон удирдамжийг эрэлхийлэвэл ихэнх гэрлэлт гэр бүлийн асуудлуудыг даван туулж чаддаг.

Алма 37:37 -г унш. Их Эзэнтэй зөвлөлдөх нь бидэнд хэрхэн туслах вэ?

Ухаалаг пристийн зэрэгтнүүд байхын тулд бид тулгарсан асуудал, тавьсан зорилтуудаа эхнэртэйгээ залбиралтайгаар ярилцаж, шийдвэр гаргахдаа оролцуулах учиртай. Хэрэв эхнэртээ хайртай бол гэр бүлийн ноцтой асуудлуудыг толгой мэдэн шийдэхийн оронд бид үргэлж тэдний санаа бодол, тус дэмийг эрэлхийлэх учиртай. Иймээс бид хүүхдүүд, санхүүгийн байдал, шашин шүтлэг, гэр бүлийн цуглаанууд болон бидэнд тулгараад байгаа бусад хувийн бөгөөд гэр бүлийн асуудлуудыг ярилцахад тусгайлан цаг гаргах нь зүйтэй. Зөвхөн Түүний замаар л бид гэр бүлээ хөтлөхөд нэгдэх юм.

Эхнэрүүд маань гэрлэлтээр бидний хамтрагчид болохын учир гэрлэлтийн хамтран ажиллах чухал түншлэл болдог. Зарим эрчүүд пристийн зэрэг агуулдгийнхаа хувьд тэд л бүх шийдвэрийг гаргах ёстой гэж үздэг, гэвч үүнийг буруу болохыг судрууд бидэнд хэлдэг билээ.

С ба Г 121:39, 41 -ийг унш.

“Шударга бус ёсыг хэрэглэх” нь пристийн зэргийг буруу ашигласан хэрэг болно. Мэлкизэдэк Пристийн Зэрэгтнүүдийн хувьд бид эхнэрийнхээ үгийг хайр хүндэтгэл анхаарал халамжтайгаар сонсох үүрэгтэй. Сонсохдоо бид тэднээс дээгүүр зиндааны хувьд бус, хамтрагч ижил түвшний хувьд сонсох учиртай. Нэгэн пристийн зэрэгтэн эхнэртэйгээ хэрхэн зөвлөлддөг байсан туршлагаасаа дараах түүхэнд өгүүлнэ:



Жаксон ах боловсролтой ухаалаг хүн байлаа. Тэрээр гэр бүлийнхэндээ тулгарсан асуудлуудыг толгой мэдэн хялбархан шийдэх чадвартай байсан. Гэсэн хэдий ч, тэр үргэлжид эхнэрийнхээ хамт суун бүх л асуудлуудын боломжтой шийдвэрүүдийг ярилцдаг байв. Долоо хоногтоо нэгээс доошгүй удаа, голдуу Ням гаригийн үдэш, тэд галын өрөөний ширээнээ сууцгаан гэр бүлийн асуудлуудаа хэлэлцэнэ. Зарим үед хүүхдүүдтэй холбоотой асуудлууд ярилцна. Хамтран зөвлөлдсөнөөр, тэрээр эхнэртэйгээ хүүхдүүдээ хэрхэн өсгөх талаар бараг үргэлжид санаа нэгддэг байсан. Тэд хэзээ ч ам мурийж, мэтгэлцэж байсангүй, харин бие биенээ хайрлан хүндэтгэдэг байлаа. Энэ эрэгтэй эхнэрийнхээ үнэтэй зөвлөмжүүдийг асууснаараа ухаалаг байсан юм. Тэрээр сэлэсчел гэж хэлж болохуйц өрх гэрийг үлгэрлэн харуулсан бөгөөд зургаан хүүхэд нь одоо түүний жишгийг өөрсдийн өрх гэртээ дагаж байна.

Хамтран зөвлөлдөх нь эхнэр нөхрийг өрх гэртээ ам мурийж, мэтгэлцэхээс зайлсхийхэд хэрхэн туслах вэ? Энэ нь гэрлэлтэн дэх хайр хүндэтгэлийг хэрхэн нэмэгдүүлэх вэ?

Гэр Бүлийнхэнтэйгээ Зөвлөх нь

13-б үзүүлэнг таниул, “Гэр бүлээрээ зөвлөлдөх нь эцэг нь хүүхдүүдээ зөв шударгаар хөтлөхөд тусалдаг.”

Нөхөр нь эхнэртэйгээ зөвлөлдсөний дараа, тэд хүүхдүүдээ дуудан хамтдаа гэр бүлийнхээ ирээдүйн зорилго төлөвлөгөөг ярилцвал зохино. Нийт гэр бүлээрээ зөвлөлдөх нь үр бүтээлтэй. Энэ нь гэр бүлийн амьдралыг дээшлүүлж тэдний дундах хайр хүндэтгэлийг батжуулна. Гэр бүлийн төлөвлөгөөг урьдчилан мэдсэн хүүхдүүд бусдынхаа юу хийж байгааг мэдэх бөгөөд үр дүнд нь гэр бүл эмх журам, эв нэгдэлтэй байх болно. Боломжтой үед хүүхдүүд шийдвэр гаргах бөгөөд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд оролцох нь зүйтэй.

Гэр бүлээрээ зөвлөлдөх хамгийн тохиромжтой цаг хэзээ байж болох вэ? (Гэр бүлийн цуглаан байж болох хэдий ч, гэр бүлээрээ зөвлөлдөх явдал хичээлийг орлох учиргүй.) Ийн зөвлөлдөхдөө ямар асуудлуудыг хэлэлцэж болох вэ?

13-в үзүүлэнг таниул, “Эцэг нь хүүхдүүдтэйгээ тогтмол ярилцлага хийх ёстой.”

Түүнчлэн, эцэг нь хүүхдүүдтэйгээ нэг бүрчлэн зөвлөлдөх нь чухал. “Эцэг нь охинтойгоо, хүүтэйгээ тогтмол ярилцах нь зөвхөн сайн нөлөө үзүүлнэ. Тэрээр тэдэнд тулгарсан асуудлууд, тэдний хүсэл найдваруудыг мэдэх болно. Тэр өөрийгөө тэдний байнгын анд нөхөр болгож чадна.” (А. Теодор Таттл, “Эцгүүдийн Үүрэг,” *The Ensign*, 1974, 1-р сар, х. 67).

13-а, Нөхөр нь эхнэртэйгээ зөвлөхөд гэр бүлээ удирдах байдал нь илүү хялбар бөгөөд үр бүтээлтэй болно.



Ийм ярилцлаганд та хүүхдүүдтэйгээ юуны талаар ярилцаж болох вэ? Энэ нь таныг тэдэнтэй хэрхэн ойртуулах вэ? (Ярилцлагуудаа хүүхдүүдийнхээ санаа зовсон асуудлуудыг нь *сонсох* цаг болгоход нь ахан дүүсийг урамшуул.)

Хүүхдүүдтэйгээ зөвлөлдөх нь үргэлж албан ёсны байх учиргүй. Хэзээ ч, хаан ч, боломж гарах бүрт тэдний санаа бодлыг бид сонсох учиртай. Тэдэнтэй зөвлөхдөө тэдний асуудлуудыг бид тэдний үзэл бодлын үүднээс харвал зохино. Бид тэдний асуудлыг үл тоомсорлон, хэрэгсэлгүй өнгөрөхгүй, харин ч хичээнгүйлэн сонсож, ойлгож, тэдэнд туслахыг чармайх нь зүйтэй.

“Эцэг нь, эсвэл эх нь хүүтэйгээ, мөн охинтойгоо цуг суугаад хувийн асуудлуудыг нь ярилцах нь гайхамшигтай явдал юм (тэдэнд өөрсдийн асуудал байгаа бөгөөд бид ухаалаг хандаж түүнийг нь үл тоомсорлохгүй.) Хөвгүүд охид маань хамгаалуулбал зохих дарамтууд, буруу ятгалгууд, тэр ч бүү хэл шударга бус гүтгэлгүүдтэй тулгарна. . . . Ийм чин сэтгэлийн ярианд, эцэг эхчүүд үр хүүхдүүддээ зорилго тавихад нь тусална.” (ЭлРэе Л. Кристиансэн, “Successful Parenthood—A Noteworthy Accomplishment,” *Ensign*, 1972, 7-р сар, х. 55).

Залуу хүү эцэг эхтэйгээ юун тухай ярилцаж болох вэ? Эцэг нь хүүхдүүдтэйгээ юун тухай ярилцах нь зүйтэй вэ? (Бусдын үзэл бодлыг дагахгүй байх нь чухал болохыг гишүүдэд сануул. Нэг хүнд тулгарсан асуудлууд бусдынхтай адилгүй.)

Ахлагч Ричард Л. Эванс бид хүүхдүүдтэйгээ хэрхэн зөвлөлдөх талаар ийн хэлжээ: “Та болон тэд хамтдаа сууж бодол санаагаа ярилцах, шийдвэрээ хэлэлцэх, бие биенээ сонсон хүндэтгэж, хамтран ажиллаж, залбиран, үргэлж мөнхийн аз жаргалаа бүрдүүлэх төлөвлөгөөгөө зөвлөлдөх завшаан, эрх болон үүрэгтэй.” (“Эцэг Эхчүүд болон Үр Хүүхдүүд Нэг Түвшинд Ирэхэд”, *Improvement Era*, 1956, 5-р сар, х. 342).

Дүгнэлт

Сэлэсчел хаант улсын амар амгалан, эв нэгдэл дунд бид амьдрана гэсэн амлалт байдаг. Бид байгалаас бидэнд шууд үл заяадаг эв нэгдэл хайрыг олж мэдрэхийг одооноос хичээх ёстой. Ерөнхийлөгч Дэвид О. МакКэй хэлсэн нь: “Өрх гэр эв нэгдэлгүй байхаас илүү татгалзмаар зүйл бараг үгүй байдаг юм гэхэд тун ховор хэмээн би төсөөлж байна. Нөгөөтэйгүүр, эв нэгдэл, тус, хайр хүндэтгэлээр дүүрэн өрх гэр нь . . . дэлхий дээрх тэнгэртэй адил буй заа.” (“Эв Нэгдлийн Зорилго нь Бурханы Ажлын Гүйцэтгэлд Чухал Юм” Шьзкцмуьуте Укф, Вус 1967 з. 34).

Эхнэр хүүхдүүдтэйгээ зөвлөснөөр бид гэр бүлээ бэхжүүлж илүү их хайр хүндэтгэл, дотно холбоог мэдрэнэ.

13-6. Гэр бүлээрээ зөвлөлдөх нь эцэг нь хүүхдүүдээ зөв шударгаар хөтлөхөд тустай.



Уриалга

1. Эхнэртэйгээ тогтмол хамтран залбирч, зөвлө.
2. Гэр бүлээрээ зөвлөлд.
3. Ярилцахдаа залбиралтай, бодолтой байхыг санаж, хүүхэд нэг бүртэйгээ ярилцах цагийг товло.

Нэмэлт Судрууд

Галатианс 5:22 (Сүнсний үр жимс)

Жэкоб 2:35 (гэр бүлийн гишүүдийн муу жишээний үр дагавар)

Жэкоб 3:7 (эхнэр нөхрийн хоорондох хайр хүндэтгэлийн ач холбогдол)

С ба Г 121:36–38 (пристийн зэргийн хүч чадал хэрхэн олгогдож хянагдах нь)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Family Responsibilities,” 37-р бүлгийг унш.
2. Хичээлд судраа авчрахыг гишүүдээс хүс.

Гэр Бүлийн Залбирлыг Удирдах нь

Хичээл 14

Энэ хичээлийн зорилго бол өдөр бүр гэр бүлээрээ залбирахад биднийг урамшуулах явдал юм.

Оршил

14-а үзүүлэнг таниул, “ Гэр бүл өдөрт хоёр удаа залбирвал зохино.”

Эцгүүдийн хувьд бид гэр бүлийнхнээ залбиралд цуглуулан, Тэнгэрлэг Эцэгтээ талархан, зааврыг хүсэмжлэх нь зүйтэй. Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл хэлэхдээ:

“Олон өрхийн тэргүүнүүдтэй би ярилцахад. . . .гэр бүлийн залбирал нь тогтмол бус, хийхээсээ мартагдах нь олонтаа болохыг хүлээн зөвшөөрсөн юм. Зарим нь өдөрт нэг удаа гэр бүлээрээ залбирахыг хичээдэг гэхэд бусад нь гэр бүлээ цуглуулж чаддаггүй хэмээсэн. Энэхүү амин чухал асуудал болох залбирлын талаар үл тоосон хандлага нь намайг ихээр бухимдуулсан. . . . Өглөө үдэш бүр гэр бүлийн залбиралтай байхыг Сүмээс уриалдаг. Энэ нь өвдөг сөгдсөн залбирал. . . . Олон хүн хамгийн боломжтой цаг бол өглөөний болон оройн хоолны ширээ тойрон сууцгаах мөч болохыг нотлосон. Тэр үед гэр бүлийнхнийг цуглуулахад хамгийн бага саад учирна. Эдгээр залбирлууд нь, ялангуяа бага насны хүүхэд өвдөг сөхрөн сууж буй үед урт байх хэрэггүй. Гэр бүлийн бүх гишүүд, бага хүүхдүүд ч залбирал хэлэх боломжтой байх учиртай” гэсэн. (“Бүтээгчийнхээ Өмнө Би Өвдөг Сөгдсөн,” *Instructor*, 1966, 4-р сар, х. 132).

Гэр Бүлийн Залбирал: Уруу Таталтыг Эсэргүүцэх Тусламж

Бидэнд Тэнгэрлэг Эцэгтээ хандан гэр бүлийнхнийхээ хамтаар залбирах зарлигийг өгсөн.

3 Нефай 18:18–21 дэх Христийн үгийг унш. Аврагч залбиралд ямар чухал зорилгыг өгч байна вэ?

Залбирал Сатаны уруу таталтыг эсэргүүцэхэд гэр бүлийнхэнд маань туслана. Залбирлаар тулгарсан асуудлуудаа даван туулах илүү чадвартай байх зоригийг бид хүлээн авч чадна.

Эцгүүдийн хувьд бид гэр бүлийнхнээ залбиралд дуудан үлгэр үзүүлэх учиртай. Ингэснээр бидэнд юуны түрүүнд гэр бүлийнхэндээ хэрхэн залбирахыг заах шаардлага гарч магадгүй. Сургаал ба Гэрээнүүдэд эцэг эхчүүдэд хүүхдүүддээ залбирахыг заахыг

14-а, Бид гэр бүлийн залбирлыг өдөрт хоёр удаа хийх ёстой.



тушаасан байдаг (С ба Г 68:28 -ыг үз). Залбирлын зарчмыг заах хамгийн сайн арга зам бол хүүхдүүддээ жишээ үзүүлэх явдал мөн. Бид тэдэнтэйгээ хамтран залбирах зүтгэл гаргавал хүүхдүүд маань залбирлын ач холбогдлыг ухааран, амьдралдаа хэрэглэх болно.

Хүүхдүүдээ удирдан, тэдэнд сургах нь бүх эцэгт оногдсон үүрэг юм. Гэр бүлийн залбирлыг удирдахын тулд хэн ч Мэлкизэдэк Пристийн Зэрэгтэн байх шаардлагагүй.

Өрх Гэртээ Гэр Бүлийн Залбирлыг Ажил Хэрэг Болгох нь

Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд “үргэлж залбирахыг” сургасан байдаг (С ба Г 10:5). Өвдөг сөгдөх боломжгүй байсан ч, үргэлж залбирах нь боломжтой болохыг бошиглогч маань бидэнд тайлбарласан байдаг.

Алма 34:27 г унш. Сэтгэл зүрхэндээ үргэлжийн залбиралтай байна гэж юу гэсэн үг вэ?

Боломжтой мөч бүрт, бодол санаа, хүсэл эрмэлзлээ Их Эзэнд дэлгэн, бид сэтгэл зүрхэндээ үргэлжийн залбиралтай байж чадна.

Өрх гэртээ гэр бүлийн залбирлыг ажил хэрэг болгохын тулд өрх гэртээ залбирлын онцгой цагийг товлох нь зүйтэй. Сүмийн удирдагчид маань гэр бүлийнхнээ өдөрт хоёр удаа цуглуулахыг айлдсан. Үүний тулд бид гэр бүлийнхэн маань хамтран цугларч чадах хамгийн тохиромжтой цагийг олох учиртай. Энэ нь бүх хүүхдүүд маань гэртээ байдаг цаг байвал зохимжтой. Эдгээр цагууд нь голдуу өглөө эрт бүгд ажил сургуульдаа явахын өмнө, мөн үдэш хүүхдүүдийг унтахын өмнөхөн байдаг юм.

Залбирлууд маань урт байх шаардлагагүй. Үнэндээ, хүүхдүүдийн залбирал ихэнхдээ богинохон байдгийн учир товч залбирлууд нь тэднийг залбирахад урамшуулдаг. Өглөөний залбирлууд нь бидний тэр өдрийн төлөвлөгөөг багтаавал зохимжтой. Үдшийн залбирлууддаа бид хамгаалалт, удирдамжинд нь Их Эзэнд талархвал зохино. Хоолоо адислах нь гэр бүлийн ердийн залбирлыг орлохгүй байх учиртай ч, бид гэр бүлийн залбирлыг идэхийнхээ өмнө хийвэл, үүнийг хамтатгаж болно.

Залбиралдаа багтаах ёстой бусад адислалуудын талаар Амулэк Мормоны Номонд дурддаг.

Алма 34:23–25 -ыг унш.

Бидний залбиралдаа хамруулах зүйлүүдийн жагсаалт Амулэкийн жагсаалтнаас өөр байж магадгүй боловч түүний хэлсэн зарчим нь ижил юм. Нэг зарчим нь бид өдөр бүрийнхээ үйл ажиллагааны тухай залбирах. Нөгөө нь бол муу ёрын сүнсний уруу таталтыг эсэргүүцэх зориг чадлын төлөө залбирах. Айл өрх бүр зорилго хэрэгцээндээ тохируулан өөрсдийнхөө хамгийн чухал шаардлагын төлөө чин сэтгэлээсээ залбирах нь чухал. Ингэвэл залбирлууд

маань бидний өдөр бүр давтан хэлж буй хоосон үг бус, чин сэтгэлийн бөгөөд үр дүнтэй байх болно. Бага хүүхдүүддээ залбирах бүрдээ нэгэн ижил үгийг давтахаас зайлсхийхэд нь эцгүүд бид туславал зохино. Ингэхдээ, бид Сүнсний нөлөөг эрэлхийлэх ёстой (С ба Г 42:14 -ийг үз). Хүүхдүүддээ залбирахыг ямар ч байдлаар заасан, бид тэднийг шахаж, эсвэл эвгүй байдалд оруулж болохгүй. Үр нөлөө бүхий гэр бүлийн залбиралтай байж чадахгүй байлаа ч бид сэтгэлээр унаж болохгүй. Энэ асуудал нь ихэвчлэн Сатаны хийж буй ажил юм.

2 Нефай 32:8 -ыг унш.

Тогтмол залбирдаггүй гэр бүлд нөлөөлөхөд хялбар байдгийн учир Сатан хувийн болон гэр бүлийн залбирлуудыг зогсоохыг хичээдэг. Тиймээс, гэр бүлээрээ залбирах заншил нь эцэг нь эзгүй үед ч, эх нь гэр бүлийнхнээ дуудан цуглуулж залбирахуйц хүчтэй байх учиртай. Эцэг эх хоёул эзгүй байвал тэд ууган хүүхдээ гэр бүлээ залбиралд удирдахыг хүсэж болно.

Аароны Пристийн Зэрэгтэй залуус гэр бүлийн залбирлыг хэрхэн дэмжиж, урамшуулж чадах вэ?

Гэр Бүлийн Залбирлаар Ирэх Сүнслэг Адислалууд

Гэр бүлээрээ залбирснаар бидэнд агуу адислалууд ирдэг. Хайр хүндэтгэл, ойлгох чадвар маань өсөж, өрх гэр дэх Сатаны үр нөлөө буурна. Зарлигийг зохих ёсоор гүйцэлдүүлж байгаагаас үүдэх амар амгалангийн мэдрэмж бидний зүрх сэтгэлд бялхана.

Гэр бүлийн залбирал нь мөнхийн өрх гэрийг үүсгэх нэг алхам юм. Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл хэлсэн нь: “Гэр бүлийн залбиралд бид өвдөг сөгдөхөд, хүүхдүүд маань . . . амьдралынх нь туршид тэдэнтэй үлдэх нэгэн заншлыг суралцаж байгаа юм. Бид залбиралд цагаа үл зориулах байдлаараа хүүхдүүддээ, ‘Яахав дээ, энэ нь тийм ч чухал биш, . . .’ гэж хэлж байгаа юм. Нөгөө талаар, эцэг эх нь хүүхдүүдээ гэрлэсний дараа гэрт нь айлчлан очихдоо хамтдаа өвдөг сөгдөн урьдын ёсоор залбирахаар тийм заншлыг тогтооно гэдэг нь баяр хөөртэй зүйл юм.” (*Өршөөлийн Гайхамшиг*, х. 253).

Дүгнэлт

Гэр бүлийн залбирлаар хүүхдүүд маань үнэхээр Христийн талаар мэдэж, Түүний оршин буйг мэдэрч байгаа эсэхэд бид эргэлзэж болох юм. Гэвч, хүүхдүүд заримдаа бидний санаснаас илүүгээр Сүнсэнд ойрхон байдаг. Ерөнхийлөгч Хэбэр Ж. Грант хүүхэд байхдаа Ерөнхийлөгч Бригхэм Янгийн гэрт залбирсан тохиолдолоосоо дор өгүүлжээ:

“Бригхэм Янгийн гэрт . . . гэр бүлийн залбирлуудад нь, би хүүхэд байхдаа бас залуу хөвгүүн болсон хойноо ч өвдөг сөгдөн нэгддэг

байв. Бага байхдаа хэд хэдэн удаа Бригхэм Янг Бурханы удирдамжийг асууж байхад нь Их Эзэний түүнд хайрладаг урмын улмаас, би толгой өргөн, Бригхэм Янгийн байгаа зүг тийш Их Эзэнийг тэнд . . . байгаа эсэхийг мэдэхээр хардаг байсан. Нэг хүн нөгөөтэйгөө ярьдгийн адилаар л тэрээр Их Эзэнтэй ярьж байх шиг надад санагддаг байлаа.” (Хэбэр Ж. Грант, *Gospel Standards*, х. 223–24).

Залбирал нь Хэбэр Ж. Грантад санагддаг байсны адилаар хүүхэд бүрийн хувьд сэтгэл хөдлөм байх учиртай. Дараах түүх гэр бүлийн залбирал зохих ёсоор явагдахад юу болж болохыг өгүүлнэ:

“Нэгэн дуу цөөтэй түвшин эцэг гэр бүлийнхэндээ хайр хүндэтгэлээ илэрхийлэхэд хэцүү болохыг мэдэрчээ. Эхнэрийнх нь саналаар тэд гэр бүлээрээ залбирч эхэлсэн бөгөөд энэ нь түүний зүрх сэтгэлдээ байгааг гаргаж хэлэх боломж болсон байна. Эцгийнхээ зан аашийг үл тоомсорлосон байдал хэмээн ташаарсан охинд нь энэ явдал илчлэл болов. Түүний үг энгийн заримдаа болхидуу байсан хэдий ч, түүний ‘хайрт охиныг минь сайныг хийхэд адислаач’ гэж хэлэх нь охиныг баярлуулжээ.

“Өөрийгөө ‘хулчгар нэгэн’ хэмээн боддог байсан халирхай хүү нь аав ээжийгээ ‘сайхан сэтгэлт, энэрэнгүй хүүтэйдээ’ Бурханд талархахад бахархах сэтгэл, өөртөө итгэлтэй байдлыг мэдэрчээ. Хүүгийн өөртөө итгэх чадвар нь бага дүү нь ‘том, хүчтэй ахтайдаа’ Тэнгэрлэг Эцэгт баярласнаа илэрхийлсэн залбиралын дараа ч үргэлжлэн өсчээ.

“Гэр бүлээрээ салхинд гарахаар бэлдэхдээ нөхөр маань гэр бүлийг маань бие биенийхээ нөхөрлөлд хөгжиж, баясахад биднийг адислахыг Их Эзнээс хүслээ. Бидний явуулсан номлол сонсдолгүй мартагдсан хэдий ч, тэрхүү бишрэлт залбирал хамтын нөхөрлөлийг авчирсан.

“Өсвөр насны хүү маань тулгарсан асуудлыг түүнтэй ярилцахыг хүсэх бүрд түгшин дүнсгэр болж байв. Түүнийг илүү найрсаг болсон үед ярилцахаар төлөвлөх нь чухал хэмээн бид шийдсэн бөгөөд тэр цаг нь өглөөний гэр бүлийн залбирал мэт санагдлаа. Гэрт нам гүм, бид даруухан чин сэтгэлийн мэдрэмжээ хуваалцах үе байв. Залбирлаар эхэлсэн ярилцлагын үед түүний түгшсэн байдал нь арилсныг бид мэдэрсэн.

“Гэр бүлийн залбирлын тэр нам гүм мөчүүдэд бид бие биетэйгээ болон Тэнгэр дэх Эцэгтэйгээ харилцдаг.” (Анн Х. Байнкс, “Залбирлын Нэмэлт Адислалууд,” *Ensign*, 1976, 1-р сар, х. 37).

Өрх гэртээ залбирлыг тогтмолжуулахын тулд юу хийсэн болохыг нь гишүүдээс асуу. Залбирлыг илүү үр бүтээлтэй болгох саналуудыг ярилц. Гэр бүлийн амжилттай залбирлуудын талаар туршлагаасаа хуваалцахыг ахан дүүсээс хүс.

Уриалга

1. Гэр бүлийн залбирал явуулдаггүй бол одооноос эхэл.
2. Гэр бүлийн залбирал тогтмол явуулдаг бол залбирлуудаа дүгнэ.
Гэр бүлийн залбирлуудаа хэрхэн сайжруулах талаар эхнэр хүүхдүүдтэйгээ ярилц.

Нэмэлт Судрууд

Матай 5:44 (хавчиж мөрдөгсдийн төлөө бид залбирвал зохино)

Матай 7:7 (чин сэтгэлийн залбирлуудад хариу өгөгддөг)

Матай 26:41 (уруу таталтын эсрэг хамгаалалтын төлөө бид залбирвал зохино)

Алма 13:28 (уруу таталтын эсрэг хамгаалалтын төлөө бид залбирвал зохино)

Алма 37:36–37 (бид бүх л үйл ажиллагааныхаа талаар залбирвал зохино)

С ба Г 88:119 (бид залбирлын өргөөг байгуулах учиртай)

С ба Г 88:126 (бид үргэлж залбирах учиртай)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Praying to Our Heavenly Father,” 8-р бүлгийг унш.
2. Хэрэв хүсвэл, гэр бүлийн залбирлынхаа амжилттай туршлагуудаас хуваалцахыг нэгэн гишүүнээс хүс.
3. “God, Our Father, Hear Us Pray,” эсвэл “Prayer Is the Soul’s Sincere Desire” дуунуудын нэгээр цуглааныг эхлэх буюу өндөрлө.
4. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Өрх Гэр: Ариун Сургаалаас Суралцах Төв

Хичээл 15

Энэ хичээлийн зорилго бол өрх гэрээ ариун сургаалаас суралцах төв болгоход биднийг урамшуулах явдал юм.

Оршил

Бошиглогчийн хүү Инос эцгийнхээ мөнхийн үнэний тухай ярихыг олонтаа сонсчээ. Нэгэн өдөр тэрээр ан хийхээр ойд очив. Тэнд мөнхийн амьдралын тухай эцгийнх нь үг түүний зүрхэнд гүн шингэжээ. Зүрх сэтгэл нь догдолсон тэрээр Бурханд хандан өвдөг сөгдөв. (Инос 1:3–4 -ийг үз). Бүх л өдөржингөө залбирсны дараа түүний нүгэл өршөөгдсөн хэмээн хэлэх дууг сонслоо. Энэ явдал түүнд тун их нөлөөлж тэрээр бүх л амьдралынхаа турш ариун сургаалыг бусдад сургасан юм.

Инос ариун сургаалаас гэртээ суралцсан залуу хүү байсан. Хуучин Гэрээнд Их Эзэн хүүхдийг явах ёстой замд нь хөтөл, нас тогтсон үедээ тэр энэ замаасаа гажихгүй хэмээн сургадаг. (Зүйр Үгс 22:6 -г үз). Итгэлтэй эцгийн ёсоор энэ зөвлөмжийг дагавал биднийг болон Их Эзнийг маань дуулгавартай дагах үнэнч хүүхдүүдээр бид адислагдах юм.

Өрх Гэрээ Ариун Сургаалаас Суралцах Төв Болгох нь

Гэр бүл бол Сүмийн ба нийгмийн хамгийн чухал байгууллага. Тиймээс ч, энэ нь мөнхөд оршин тогтнох цорын ганц байгууллага юм. Иймээс бид өрх гэрээ насанд хүрэгсэд болон хүүхдүүд ариун сургаалаас суралцаж хамтдаа хөгжих газар болгох ёстой хэмээн Их Эзэн тушаасан.

С ба Г 68:25–28 -ыг унш. Ертөнцийн тухай анхны мэдэгдэхүүнээ хүүхдүүд хаанаас олж авдаг вэ? Тэд *мөнхийн* амьдралын тухай хэрхэн суралцаж чадах вэ?

Энэ амьдралын тухай хүүхдүүд гэртээ, сургууль дээрээ, хамт тоглодог нөхдөөсөө мэдэж авдаг. Гэвч сургууль болон нөхөд нь хүүхдүүдэд маань ариун сургаалыг заахгүй. Бурханаас өгөгдсөн энэ нандин үүрэг нь биднийх. Хүүхдүүддээ түүний энэ амьдралд тэдэнд заах байсныг заахгүй бол бид тэднийгээ мөнхөд алдах аюултай тулгарна.

Мэдээж, хүүхдүүддээ ариун сургаалыг заахын өмнө бид өөрсдөө суралцах учиртай. Ерөнхийлөгч Марион Г. Ромни хэлсэн нь: “Пристийн зэрэгтэн бүр өөрийн гэртээ дуудлагынхаа эрхэм дээд

чанар, хүч чадлаар эмх цэгц тогтоог. Гэрийн цуглааныг тогтмол явуулж, бусад үед ч ‘хүүхдүүдээ гэрэл ба үнэнд’ (С ба Г 93:40) авчраг.” (“Гэрийн Багшлалт ба Гэрийн Цуглаан,” *Improvement Era*, 1969, 6-р сар, х. 97).

Энэ нь эхнэрийнхээ хамт бид үр хүүхдүүддээ ариун сургаалын зарчмуудыг заах хариуцлага хүлээдэг гэсэн үг юм. Хариуцлагаа гүйцэтгэхийн тулд бид эхнэрийнхээ хамтаар өрх гэртээ ариун сургаалаас суралцаж хүүхдүүдээ өөрсдийн үлгэрийг дагахад урамшуулах учиртай. Бинжамин хаан эцэг эхчүүдэд, “үр хүүхдээ Бурханы хуулийг зөрчин, бие биетэйгээ маргалдан, хараал хэлж, муу ёрын сүнсэнд үйлчлэхийг зөвшөөрч огт болохгүй.

Харин ч тэд үр хүүхдэдээ үнэн, эрүүл ухааны гэрэлд алхан, бие биенээ хайрлаж, үйлчлэхэд сургах учиртайг” захижээ (Мозаяа 4:14–15 -ыг үз).

Ариун Сургаалаас Суралцах Гэр Бүлийн Маань Төлөвлөгөө

Бошиглогчдынхоо зарлигийг дагахыг хүсвэл, бид эхнэрийнхээ хамтаар хүүхдүүддээ заах хамгийн шилдэг аргыг төлөвлөх хэрэгтэй. Бид тус бүрдээ энэ зорилгод өөр өөр замаар хүрч болох ч, өрх гэрээ ариун сургаалаас суралцах газар болгох хамгийн шилдэг төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрмэлзэлтэй байх ёстой.

Ярилцлагынхаа явцад дараах зөвлөлгөөг самбарт бич.

СУРАЛЦАХ УУР АМЬСГАЛЫГ БИЙ БОЛГОХ

Орон гэр маань хүүхдүүд маань бидэнтэй чөлөөтэй ярилцах газар байх учиртай. Түгшүүрт байдлаар дүүрэн орон гэр нь хүүхдүүдийг асуулт тавьж сэтгэгдлээ илэрхийлэх урамгүй болгодог. Ерөнхийлөгч Дэвид О. МакКэй, “эцэг эхчүүд . . . асуултанд нь дуртайяа хариулах ёстой. Асуулт тавьж байгаа хүүхдүүд амьдралд тань аз жаргалын үрийг суулгаж буйг” хэлжээ. (*Gospel Ideals*, х. 480.) Бид хүүхдүүдийг асуулт, ялангуяа ариун сургаалын тухай асуухад нь урамшуулах ёстой. Бид бүх асуултыг нь мэдэхгүй байж болох ч хамтдаа суралцаж болно.

Өрх гэртээ бид ямар замаар ариун сургаалын ярицлагыг дэмжиж болох вэ?

ГЭР БҮЛЭЭРЭЭ ЗАЛБИРАХ НЬ

Хүүхдүүддээ сургах бас нэгэн арга бол гэр бүлийн залбирал. Залбирахдаа бид өөрсдийн найдлага, сэтгэлийн шаналал, бодол санаагаа гэрийнхэнтэйгээ хуваалцвал зохино. Гэр бүлийнхнийхээ болон бусдын төлөө залбирахдаа бусдын хэрэгцээнд нь анхаарал тавихыг бид сургаж болно. Бид Тэнгэрлэг Эцэгтээ талархлаа илэрхийлэхдээ оногдсон адислалуудынхаа төлөө сэтгэл ханамжтай байхыг сургаж бас болно.

ХООЛНЫ ҮЕЭР БОЛОН УНТАХЫН ӨМНӨ АРИУН СУРГААЛААС ЯРИЛЦАХ НЬ
Ариун сургаалын ярилцлагыг дэмжүүштэй өөр цагууд бол хоолны үеэр болон унтахын өмнө байж болно. Ярилцлагууд нь бидний өдөр тутмын шашны үйлийг хамруулбал зохино. Хүүхдүүдийг тэр талаар асуулт тавихад нь урамшуулж насанд хүрэгсдэд тохирох ариун сургаалын зарчмыг тайлбарлаж болно. Хүүхдүүдээ оронд нь оруулах үе бол үүнд хамгийн тохиромжтой цаг юм. Тэдний асуултыг урамшуулахын тулд бид тэдэнд *Мормоны Ном* болон *Библи* дэх ариун сургаалын холбогдолтой түүхүүд болон өөрсдийнхөө сүнслэг тохиолдлуудаа ярьж өгөх нь зүйтэй.

15-а үзүүлэнг таниул. “Өрх гэр нь ариун сургаалаас суралцах төв байвал зохино.”

СУДРААС ТОГТМОЛ СУРАЛЦАХ НЬ

Судрын тогтмол уншлаганд дөхөм болгон, ариун сургаалын номын сан болгон нэг номын тавиурыг тусад нь ашиглаж болно. Үүнд, гэр бүлийнхний хэрэгцээнд тохируулан ном, хуурцаг, хуурцаг тоглуулагч болон бусад сургалтын хэрэгслүүдийг хадгалах нь зохимжтой. Сүмийн жишиг бүтээл болон *Ариун Сургаалын Зарчмууд* гарын авлага нь энэ номын сангийн үндсэн ном хэрэгсэл байх учиртай. Боломжтой бол хүүхэд бүр өөрийн *Мормоны Ном* ба Библитэй байвал зохино.

Бид судрыг гэр бүлийнхэнтэйгээ болон ганцаарчлан суралцаж болно. Хувийн сургалтыг урамшуулахын тулд үлгэр жишээ үзүүлэх ёстой. Бие даан суралцах зарим аргуудыг дор дурдвал:

- Өдөр бүр нэг буюу түүнээс дээш бүлгийг 15 минутын турш унших замаар удраа эхнээс нь дуустал нь уншихыг хичээ.
- Тодорхой сэдэвт тохирох онцгой судруудыг олж (залбирал, дуулгавартай байдал гэх зэрэг), уг сэдвээр унш.
- Тулгарсан асуудалдаа хариулт өгөхүйц судрыг эрэлхийл.
- Танд урам хайрласан судруудын жагсаалт гарга.
- Тогтмол суралцах төлөвлөгөөндөө судруудыг онцгойлон ангилж оруул.

Судраас суралцах өөр аргуудыг бодоход гишүүдийг дэмж.

Ариун сургаалыг гэр бүлээрээ суралцахын тулд энэ зорилгоор тодорхой цаг гарган хамтдаа уулзахаар эцэг нь эхнэр хүүхдүүдтэйгээ хуваарь гаргах ёстой. Гэр бүлээрээ судраас суралцах зарим аргуудаас дор дурдвал:

- Бид ажилдаа, хүүхдүүд хичээлдээ явахаас өмнө өглөө бүр судраас суралцах арван таван минут, эсвэл хүүхдүүдийг унтахын өмнө орой бүр богино хугацаанд судраас суралцах цаг гарга.

15-а, Өрх гэр бол ариун сургаалаас суралцах төв байх учиртай.



- Бага хүүхдүүддээ судрын түүхүүдээс ярьж өг.
- Судрын онцгой шүлгүүдээс сонгон, хуудас цаасан дээр бичиж гэр бүлийнхнийхээ харахуйц газар хана болон самбарт хад.
- Судраас цээжлэхэд нь гэр бүлийнхнээ дэмж.
- Зарчмаас зааж буй судрыг сонгож, зарчмын бүрэн утга санааг амьдрал дээр хэрхэн илэрхийлэх боломжийг бодож ол. Жишээ нь: Матай 25:31–40 -ийг уншаад хэрэгцээ шаардлагатай гэр бүлд тусал. Жэймс 1:27, буюу Галатиан 6:2-ыг уншаад настай хүмүүст тусал.
- Хамгийн сүүлийн ерөнхий чуулганы илтгэлүүдээс уншиж Ах Нарын өгсөн зөвлөмжүүдийг амьдралдаа хэрэгжүүл.

Ямар ч аргыг сонгосон, судрын уншлагаа бид үргэлж Тэнгэрлэг Эцэгээс удирдамж, ойлгох чадварыг хүсэмжлэн залбирлаар эхлэх учиртай. Уншлагынхаа дараа бид юу уншсанаа болон ариун сургаалын тэдгээр зарчмуудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхээ бодох нь зүйтэй.

Ерөнхийлөн Удирдах Бишопын Зөвлөлийн Бишоп Х. Бүркэ Питерсон хэлсэн нь: “Өдөр бүр судраас унших цаг гаргадаггүй нэг ч гэр бүл Сүмд байж зохихгүй, байх ч ёсгүй. Айл өрх бүр өөрсдийн арга барилаар үүнийг зохион байгуулж болно.” (“Эцэг Эхэд Тусламж”, *Ensign*, 1975, 5-р сар, х. 53–54) .

Зөвхөн унших бус, судраас амжилттайгаар суралцаж буй гишүүнээс өөрийн арга туршлагаасаа хуваалцахыг хүс. Эсвэл Аароны Пристийн зэрэг шинэхэн хүртсэн залуу хүүгээс тэрээр яагаад ариун сургаалыг ялангуяа номлолд явахынхаа өмнө сурах учиртай болох талаар мэдрэмжийг нь яриул. (Алма 37:35 -ыг уншуулж болно).

15-6 үзүүлэнг таниул, “Гэрийн цуглаан бол ариун сургаалаас гэр бүлээрээ суралцах тохиромжтой цаг юм.”

ГЭР БҮЛИЙН ЦУГЛААНЫГ ТОГТМОЛ ЯВУУЛАХ НЬ

Ням гаригийн гэр бүлийн сургалт болон Даваа гаригийн үдшийн гэр бүлийн цуглаан нь хүүхдүүдэд ариун сургаалаас заах тохиромжтой цагууд юм. Гэр бүлийн цуглааны гарын авлагатай хүмүүс түүнийгээ ашиглах нь зүйтэй. Хэрэв гарын авлага үгүй бол, бид судрууд болон *Евангелийн Үндсүүд* гарын авлагаас суралцаж, ариун сургаалын хуурцагт бичлэгүүдийг сонсон, эсвэл Сүмийн талаар бодол сэтгэгдлээ хуваалцаж болно. Сэтгэлд дотно уур амьсгалыг бүрдүүлэх нь хүүхдүүдэд үдшийг хөгжилтэй өнгөрөөж илүү идэвхтэйгээр оролцоход тустай. Гэр бүлийн цуглаан бол гэр бүлийнхэндээ номлох цаг биш юм.

15-6. Гэр бүлийн цуглаан бол ариун сургаалаас гэр бүлээрээ суралцах тохиромжтой цаг юм.



ХҮҮХДҮҮДТЭЙГЭЭ ГЭРЧЛЭЛЭЭ ХУВААЛЦАХ НЬ

Боломж бүрдсэн үед бид хүүхдүүддээ гэрчлэлээ хэлэх учиртай. Гэрчлэлээ хэлэх цаг хооллох үе, судрын уншлага, гэр бүлийн цуглаан, эсвэл хүүхдүүдтэйгээ хийх ариун сургаалын ярилцлагын үеэр байж болно. Бидний гэрчлэлээ хэлэхийг сонсож, зарлигуудаар амьдрахыг харах нь тэдний ариун сургаалын талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ.

Хүүхдүүддээ ариун сургаалаас заасан туршлагаасаа хуваалцахыг гишүүдээс хүс.

Дүгнэлт

Ариун сургаалыг бие даан мөн гэр бүлийнхэнтэйгээ суралцсанаар бидний гэрчлэл болон өрх гэр маань бэхждэг. Исүс Христ ба Тэнгэрлэг Эцэгтэй илүү ойртохыг эрмэлзэж байгаагийн учир, бид тулгарсан асуудлууддаа тохирох хариултыг олж, оюун бодолдоо амар амгаланг илүүтэй мэдэрнэ. Ахлагч Брюс Р. МакКонки хэлэхдээ: “Бид энэ амьдралдаа амар амгалан, баяр баясгалан, аз жаргалтай байж, ирэх ертөнцөд мөнхийн амьдралыг залгамжлахыг хүснэ. Эдгээр нь хүн төрөлхтөн өвлөн авч чадах хамгийн агуу хоёр адислал юм. Эдгээр адислалуудыг бид мөнхийн амьдралын үгээс уншин суралцаж, зарлигуудыг дагаснаар хүртэх учиртай.” (“Ундаргаас Хүрт”, *Ensign*, 1975, 4-р сар, х. 70) .

Уриалга

1. Ариун сургаалаас тогтмол суралц.
2. Өдөр бүр гэр бүлээрээ залбир.
3. Гэр бүлийнхэндээ ариун сургаалаас заах боломж бүрийг ашигла.

Нэмэлт Судрууд

Ром 15:4 (бүх судрууд бидэнд туслахын тулд бичигдсэн)

2 Тимоти 3:14–17 (судрын хэрэгцээ)

2 Нефай 4:15 (бид судраас эргэцүүлэн бодож хүүхдүүддээ заах учиртай)

С ба Г 1:37 (бид судраас эрэлхийлэн суралцах учиртай)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Хичээлийн төгсгөлд дурдсан нэмэлт судруудыг унш.
2. Хичээлд дурдсан ариун сургаалаас суралцах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга замуудыг самбарт жагсааж бэлтгэ.
3. Ариун сургаалаас суралцах болон заах талаар туршлагаа хуваалцахыг ангийн гишүүдэд даалга.
4. Энэ хичээлд байгаа түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Энэ хичээлийн зорилго бол ариун сургаалыг үр бүтээлтэйгээр заахад бэлтгэхдээ хариуцлагаа ойлгоход бидэнд туслах явдал болно.

Оршил

Их Эзэний үгийг тунхаглахыг эрэлхийлэхээс өмнө бид Түүний үгээс суралцахыг эрэлхийлэх ёстой. Бид эрмэлзэлтэй байх юм бол Түүний Сүнсний мөн Түүний үгийг, түгээр ч зогсохгүй хүмүүсийг ухааруулах Бурханы хүч чадлыг агуулах болно хэмээн Их Эзэн айлджээ (С ба Г 11:21 -ийг үз).

Бие Биендээ Заах нь

С ба Г 88:77–78 -ыг уншихыг гишүүдээс хүс. Бид хэнд заах учиртай вэ?

Ариун сургаалыг заах нөхцөл бололцоонууд нь өөр өөр юм. Бид гэр бүлийнхэндээ, нөхөддөө, хөршүүддээ, хамтран ажиллагсаддаа болон ангийнхандаа зааж болно. Бид Сүмийн гишүүдэд зохион байгуулалттай хичээлээр, харин Сүмийн гишүүн бус хүмүүст ажилд нь туслах замаар зааж болно.

16-а үзүүлэнг таниул, “Эцэг нь ариун сургаалыг хүүхдүүддээ заах үүрэг хариуцлагатай.”

ӨРХ ГЭРТЭЭ ЗААХ НЬ

Дэлхийн үүслээс эхлэн, бидэнд хүүхдүүддээ ариун сургаалыг заах агуу үүрэг хариуцлага буйг Их Эзэн бидэнд хэлсээр иржээ. Гэр бүлийнхэндээ заах тохиромжтой цагууд нь Ням гариг эсвэл Даваа гаригийн үдшийн гэр бүлийн цуглаан байдаг хэдий ч, бас өөр олон боломжтой цаг мөч байж болох юм. Дараах түүх нь нэгэн эцэг гэр бүлийнхэндээ хэрхэн зааж сургасныг өгүүлж байна:

Хэд хэдэн эцгүүд гэр бүлийн цуглааны талаархи сургалтанд хамрагдсан байлаа. Ихэнх нь “Би багш биш, би хэзээ ч багш байгаагүй, хэзээ ч болохгүй” гэсэн сэтгэгдэлтэй байв. Хэрэв долоо хоног бүр гэр бүлийнхнээ дотносог, амар тайван орчинд дуудан цуглуулж чадвал хичээл заах хэсэг нь тэдний санасан мэт тийм хэцүү биш байх болно гэдгийг тэдэнд амлажээ.

Жэрри хэмээх нэгэн эцэг энэхүү шаардлагын талаар сэтгэл дундуур байв. Тэрээр “Би зааж чадахгүй” гээд хариуцлагаас мултрахыг хичээв. Гэвч тэрээр өөртөө амласан тэр амлалтаа биелүүлэх хэрэгтэй байв.

Гурван сарын дараа түүнээс туршлагыг нь асуухад тэрээр нөхөрсөг байсан бөгөөд хүүхдүүд нь гэрийн цуглаануудад болсон зүйлүүдэд сэтгэл өндөр байгаа гэж хэлжээ.

Эхнэр нь, “Энэ бол бидэнд тохиолдсон гайхамшигт тохиолдол байсан. Жэрригийн заасан хичээл нь бидний сонссон хамгийн сайхан хичээлүүд юм,” гэжээ.

Жэрри доош харж хэсэг чимээгүй байснаа, “Би тийм сайн байгаагүй,” гэв.

“Жэрри, чи бидэнд зааж байхад ер бусын хүчтэй санагдсан. Бид нэг гэр бүл гэдгээ мэдэрсэн. Бид хэлсэнийг чинь хэзээ ч мартахгүй,” гэж эхнэр нь чин сэтгэлээсээ хэлэв.

Зүрх сэтгэлд хүрсэн энэ үг Жэрригийн сэтгэлийг үнэхээр хөдөлгөлөө. Тэрээр толгойгоо өндийлгөн, “Би сайн заасан байлгүй дээ. Би тэр гэр бүлийн цуглааныг хийхийг хүсээгүй. Чадахгүй гэж бодож байсан. Гэвч нэг долоо хоног эхнэр маань, дараа долоо хоногт нь охин маань хичээл заасны дараа би нэг орой туршиж үзэхээр шийдсэн юм,” гэв.

Нүдэнд нь нулимс цийлэгнэн тэрээр ийн хэл эв: ‘Гэр бүлийнхэнтэйгээ сайн зүйлсийн талаар ярихдаа сэтгэлдээ төрсөн мэдрэмжийг би хэзээ ч мартахгүй. Анх удаагаа би яг л Эцэг хүний байх ёстой байдлаар байгаа юм шиг надад санагдсан.’ (Жорж Д. Дуррант, *Love at Home, Starring Father*, х. 41–43 -ыг үз.)

Энэ түүх гэр бүлийнхэндээ заах хариуцлагаа ухаарах нь юунд хүргэж болохыг өгүүлж байна.

Хүүхдүүддээ ариун сургаалаас заах талаар туршлагаасаа хуваалцахыг ахан дүү нараасаа хүс.

Ахлагч Байд К. Пакэр ийнхүү хэлжээ: “Бидний хийдэг зүйлсийн ихэнх нь сургах явдал байдаг. Багачуулдаа гутлаа яаж үдэх, . . . охиндоо шинэ хоол яаж хийх, сүм дээр үг хэлэх, гэрчлэлээ хуваалцах, удирдагчдын цуглааныг хөтлөх, мөн хичээл заах–энэ бүгд нь сургах, тэгээд ч бид эдгээр зүйлсээ өөрсдөө тогтмол гүйцэтгэдэг. . . . Бид цуглаан дээр номлож, үг хэлж, хариулахдаа сургаж байдаг.” (*Teach Ye Diligently*, х. 2–3.)

СҮМД ЗААХ НЬ

Бид ихэнхдээ нэг нэгэнтэй ярих замаар энгийн байдлаар заадаг. Гэвч, Сүм зохион байгуулалттай ангиудад заах олон боломжоор биднийг хангадаг.

Ахлагч Байд К. Пакэрийн бичсэнээр: “Сүмийн гишүүн бүр бүх л амьдралынхаа туршид бодитойгоор сургадаг. . . . Сүмийн бүх л



байгууллагуудад үйлчилж байгаа багш нар бидэнд байна. Пристийн зэргийн чуулгуудад ихээхэн сургалт явагдсаар байна. Бүх л пристийн зэрэгтнүүд пристийн зэргийн гэрийн *багш нар* болох учиртай. . . . Үүргээ биелүүлсэн сургалтын хүчээр Сүм урагшилж байна. Хэрэв сургалт үр бүтээлтэй явагдахгүй бол Хаант Улсын ажил саатах болно.” (*Teach Ye Diligently*, х. 2–3.)

Заримдаа бидний сургалт анги танхимд бус, харин Сүмд бусадтай хамт явагддаг. Анги танхимаас гадуур заасан жишээг дараах түүх өгүүлнэ:

“Бишоп Фрэд Карролтой би гэр бүлээрээ түүний хэсэгт нүүж очсоныхоо дараа танилцсан юм. Тэр үед миний нас Аароны Пристийн зэргээс хэтэрч диконий насанд хүрсэн байлаа. Энэ агуу хүний надад шулуухнаар хэлсэн тавь хүрэхгүй үгийнх нь тэн хагас нь миний оюун ухаанд гүн шингэсэн. Нэг өдөр надад чимээгүйхэн ганцаарчлан: ‘Сүмийн цуглаанд ямар их бишрэлтэй байгааг чинь би ажиглалаа. Энэ нь бусад хөвгүүдэд сайн жишээ болно,’ гэж хэлсэн тэр арван таван алтан үг надад асар их нөлөө үзүүлсэнийг тэр сайн бишоп мэдээгүй нь лавтай.

“Ердөө л хэдхэн үг боловч ямар их хүчтэй гээч! Миний гүйцэтгэж байсан зуу гаруй даалгавраас маань ч илүүтэйгээр надад нөлөөлсөн. Энэ үеийг хүртэл би өөрийгөө тийм бишрэлтэй гэж огт төсөөлөөгүй. Бишоп Каррол миний ичимхий байдлыг бишрэлтэй байгаагаар ойлгосон нь гарцаагүй. Гэвч энэ хамаагүй л дээ. Тэр цагаас хойш би амьдралд маань бишрэл ямар утга учиртайг бодох болсон. Удалгүй би бишрэлтэй байдлыг мэдэрч эхэлсэн. Магадгүй, бишоп Каррол намайг бишрэлтэй байна гэж бодсон л юм бол би үнэхээр биширч байсан! Бишоп Каррол үрийг нь суулгасан энэ хандлага амьдралд минь нөлөө үзүүлсээр л.” (Линн Ф. Стодарт, “Гайхамшигт Нөлөө”, *Зааварлагч*, 1970, 9-р сар, х. 326–27.)

Ахлагч Томас С. Монсоны бичсэнээр: “Бүхий л чадвараа ажилдаа зориулсан багш нар Аврагчийн ‘Наашаа ир, надаас суралц’ гэсэн урилгыг хүлээн авснаар түүний тэнгэрлэг хүч чадлыг хүртэгчид болж суралцдаг. Хөвгүүн байхдаа ийм нэгэн багшийн нөлөөнд орсон нь надад тохиосон нэгэн явдал байсан юм. Ням Гаригийн хичээл дээр тэрээр бидэнд ертөнцийн үүсэл, Адамын уналт, Исүсийн цагаатгах золиослолын талаар бидэнд заалаа. Тэр эмэгтэй ангидаа Мозэс, Жошуа, Пэтэр, Томас, Паул ба Исүс Христийг зочин болгон авчирсан. Хэдийгээр тэднийг хараагүй ч, бид тэднийг хайрлан, алдаршуулж, бас дагахад суралцсан.

“Нэгэн гишүүний маань ээж нас барсан болохыг багш гунигтайгаар зарласан тэр өглөө шиг сэтгэлд шингэтэл бодолд автсан хичээл хэзээ ч байгаагүй биз ээ. Бид Биллийг үгүйлж байсан хэдий ч

ирээгүйн учир шалтгааныг нь мэдэхгүй байсан юм. Хичээл ‘Бусдад өгөх нь бусдаас авахаас илүүтэй адислалыг бидэнд авчирдаг’ сэдвийн дор явагдсан. Хичээлийн дундуур багш маань гарын авлагаа хаагаад Бурханы сүр жавхлан тийш тэмүүлэх бидний нүд, чих, зүрх сэтгэлийг нээлээ. Тэрээр, ‘Бидний ангийн үдэшлэгийн санд хэр их мөнгө байгаа билээ?’ гэж асуулаа.

“Бэрхшээлийн үе байсан ч бид: ‘Дөрвөн доллар, далан таван цент,’ хэмээн бардам хариулав.

“ ‘Биллийн гэр бүл ядуу, зовлонд автсан энэ үед бид гэр бүлийн гишүүдэд нь өөрсдийн санд байгаа мөнгийг аваачиж өгөхөөр айлчилж очвол ямар вэ?’ гэж тэр намуухнаар асуусан юм.

“Хотын гудамжаар бид хэдүүлхнээ алхан Биллийн гэрт очиж түүнтэй болон түүний ах, эгч нар, аавтай нь мэндэлж байснаа би үргэлж санах болно. Ээж нь байхгүй байгаа нь илэрхий байв. Бидний үдэшлэгийн санд байгаа мөнгө цагаан дугтуйнд орон, багшийн минь гараар дамжин гунигт автсан эцгийн тусламж үгүйлсэн гарт очиход бүх хүний нүдэнд цийлэгнэж байсан тэр нулимсыг би үргэлж нандигнан санах болно. Бид сүмдээ хүрэх замдаа золтой л сүмээ өнгөрөөд явчихаагүй бөгөөд бидний зүрх гэрэл гэгээг мэдэрч, бид баяр баясгалангаар бялхаж, бидний хоорондын ойлголцол хэзээ ч ийм гүн гүнзгий байгаагүй мэт. Бурханы урам зоригийг хүртсэн багш маань ‘Бусдад өгөх нь бусдаас авахаас илүүтэй адислалыг бидэнд авчирдаг’ хэмээх тэнгэрлэг үнэн, мөнхийн хичээлийг бидэнд заасан.” (“Зөвхөн л Багш”, *Ensign*, 1973, 5-р сар, х. 29.)

ДЭЛХИЙ ЕРТӨНЦӨД ЗААХ НЬ

Сүмийн гишүүн бүр өөрсдийн үг, үйлсээрээ эргэн тойрныхоо хүн бүрт ариун сургаалаас заах хариуцлага бүхий номлогч юм. Усаар батлуулахдаа бид “хэзээ ч, хаана ч, юунд ч эцсийн мөчөө хүртэл Бурханы гэрч байх болно” (Мозаяа 18:9) хэмээн гэрээ байгуулсан. Ариун сургаалыг нөхөддөө, хөршүүддээ даруу хүлцэнгүй байдлаар заах учиртай. (С ба Г 38:40–41 -ийг үз.)

Бид зөвхөн хүүхдүүддээ эсвэл сүмийн гишүүдэд заах бус, уулзсан хүн бүхэнд заах агуу хариуцлагатай.

Үзүүлэнгүүдийг таниул, 16-б. “Бүх л гишүүдийг оюун ухаандаа тунгаан хичээлийг бэлтгэвэл зохино” ба 16-в, “Судраас суралцах ба залбирах нь хичээлийн бэлтгэлийн нэг хэсэг юм.”

Ариун Сургаалыг Заахаар Бэлтгэх нь

Сайн багш болохын тулд сайтар бэлтгэх хэрэгтэй. Ерөнхийлөгч Дэвид О. МакКэй хэлсэн нь: “Өөрийн мэдэхгүй зүйлийг ямар ч

багш зааж чадахгүй. Өөрийн хараагүй, мэдрээгүй байгаа зүйлийг ямар ч багш зааж чадахгүй.” (*Амьдралын Өв Хөрөнгө*, х. 476.)

Залуу эрэгтэйчүүдийг оролцуулаад бид бүгд заахын тулд сайтар бэлтгэх нь яагаад чухал вэ? Дараах зөвлөмжөөс та хичээлд бэлтгэх ямар санаануудыг олж чадах вэ?

Хичээлээ төлөвлөх тусгай цаг гаргаж газраа сонго. Судар, хичээлийн гарын авлага, тайлбар толь, цаас, харандаа гэх мэт боломжтой материалуудаа бэлтгэ. Эх Хөтөлбөр буюу төлөвлөх ажлаа Их Эзэнтэй зөвлөлдөн эхэл. Энэ бол Их Эзэний ариун сургаал; та бол хүүхдүүдэд нь зааж байгаа түүний багш. Мэдээг яаж бусдад хүргэвэл зохихыг Их Эзэнээс асуу. Онцгой шаардлагатай гэж үзвэл, Их Эзэний Сүнсийг агуулахын тулд залбирахын зэрэгцээгээр мацаг барьж болох юм. (*Багшийн Хөгжлийн Хөтөлбөр*, Үндсэн Сургалт, х. 133.)

Хичээлд бэлтгэхийн тулд таны хийвэл зохих зүйлс болон танд байвал зохих зүйлсийг самбарт жагсаа.

Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнээр дуудагдахын өмнө Ерөнхийлөгч Дэвид О. МакКэй мэргэжлийн багш байжээ. Хичээлд бэлтгэх дөрвөн үе шатыг тэрээр зөвлөсөн байна.

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛ

Зорилго бол бүх гишүүд мэдэж авч амьдралдаа хэрэгжүүлээсэй хэмээн таны хүсч буй санаа юм. Зорилгоо бичиж тэмдэглэн, хичээлд бэлтгэх үедээ тэр талаараа сайтар тунгаа.

ХИЧЭЭЛД ТАНИУЛАХ МАТЕРИАЛЫГ МЭДЭЖ БАЙХ

Өөрийнхөө үгээр зааж чадахуйц хэмжээнд хичээлийг сайтар мэдэж ав. Мэдээж судрууд ба ишлэлүүдийг гарын авлагаас харж болно.

СУДЛАН СУРАЛЦАХ ЗАМААР ҮЗҮҮЛЭН ТАНИУЛАХ МАТЕРИАЛЫГ ЦУГЛУУЛ

Хичээлийг сонирхолтой болгохын тулд гишүүд харж болох биет зүйл, хүснэгт, зураг гэх мэт үзүүлэн таниулах материалыг хэрэглэ. Бүх л насны хүмүүст заах үед хичээлийг сонирхолтой болгох нь чухал юм.

ХИЧЭЭЛД АШИГЛАХ МАТЕРИАЛУУДЫГ ЦЭГЦЭЛ

Хичээлд хэрэглэх шохой, самбарын алчуур, үзэг, харандаа, үзүүлэн таниулах материал гээд бүх л зүйлсээ бэлтгэ. Эдгээрийг хичээлд хэрэглэх дэс дараагаар эмхлэх нь хичээлийн үед будилж сандрахаас хамгаалах болно.

Зааж Байгаа Хүмүүсээ Хайрлан Хүндэтгэхийг Сурах нь

Ахлагч Боид К. Пакэр хэлсэн нь: “Сайн багш байнга хичээлийг судалчихсан байдаг. Онцсайн багш сурагчдаа бас анхааралтайгаар



судалдаг. . . . Сурагчдынхаа онцлог, сэтгэлийн хөдөлгөөнийг анхаарал тавин ажигласнаар. . . . зүрх сэтгэлд тань Христийн энэрэл төрж магад; энэрэл нь урам онгодод хамааралтай мэдрэхүй юм. Энэ нь Түүний хонийг тэжээх, Их Эзэний ажлыг хийхэд зориулан өгөх хайр хүндэтгэл болно.” (“Сурагчдаа Судал”, *Зааварлагч*, 1963, 1-р сар, х. 61.)

Нөгөө талаар, хайр хүндэтгэл хүлээсэн сурагчид илүү өөрсөддөө итгэлтэй, өөрсдийгөө хөгжүүлэх эрмэлзэлтэй болдог. Тэд хичээлийн үеэр илүү анхаарал тавин, харилцан ярилцаж туслах болно.

Хамгийн гол нь хайр хүндэтгэл хүлээсэн сурагчид бусдыг хайрлан хүндэтгэж сурах юм.

Сүнстэйгээр Заах нь

Сурагчидаа хайрлан хүндэтгэхийн тулд багш нь Их Эзэнээс ирэх урам зоригийг мэдрэх чадвартай байх учиртай. Зөвхөн ийм замаар л тэрээр сурагчдынхаа хэрэгцээг ойлгож чадна. Ерөнхийлөгч Бригхэм Янг хэлэхдээ: “Хамгийн сайн номнуудаас мэргэн ухааныг олж авахаар бүхий л чармайлтаа гаргасны дараа л бүгдэд хүрэлцэх эх ундарга үлддэг; ‘Хэрэв хүнд мэргэн ухаан дутваас Бурханаас асуу.’ ” (Discourses of Brigham Young, х. 261.)

Заах чадвар нь бидний Тэнгэр дэх Эцгээсээ хүлээн авдаг бэлэг юм. Бид Түнээс асуувал Тэрээр бидэнд хичээлд бэлтгэх, сурагчдаа мэдэж авах, тэднийг хайрлан хүндэтгэх, мөн заах урмыг хайрлах болно. Түүний Сүнстэйгээр зааснаар бид хүч чадалтайгаар заадаг. (Тодорхой мэдээллийг 18-р хичээлийн “Ариун Сүнсний Хүчээр Заах” - аас үз.)

Дүгнэлт

“Ерөнхийлөгч Дэвид О. МакКэй хэлэхдээ: ‘Хүмүүний бие сэтгэлийг бэлтгэхээс илүүтэй үүрэг гэж энэ ертөнцөд үгүй.’ Сүмд байгаа эцэг эх, багш бүрийн хувийн үйлчлэлийн хамгийн агуу хэсэг бол заах, сургах явдал болно.” (Ван Ж. Фидэрстөүн, “Нөлөөтэй Багш”, *Ensign*, 1976, 11-р сар, х. 103.) Бид Исүс Христийн Ариун Сургаалыг хүүхдүүддээ, Сүмийн гишүүд нөхөддөө болон гишүүн бус хөршүүддээ заах үүрэгтэй. Үүний тулд ариун сургаалыг суралцан түүний дагуу амьдснаар бид өөрсдийгөө бэлтгэх учиртай.

Ариун сургаалыг илүү үр бүтээлтэй заахад зөв шударга амьдрал бидэнд хэрхэн туслах вэ?

Уриалга

Дараагийн гэр бүлийн цуглаан дээр Ариун Сүнсний нөлөөгөөр суралцаж, хичээлдээ бэлтгээд заа.



Нэмэлт Судрууд

Дүтэрономи 6:1–7 (хүүхдүүдэд тогтмол заахын ач холбогдол)

Мозаяа 4:14–15 (хүүхдүүдэд хэрхэн зохих ёсоор заах нь)

С ба Г 68:25–28 (эцэг эхчүүд ариун сургаалыг хүүхдүүддээ заах учиртай)

С ба Г 130:18 (энэ амьдралд олж авсан бидний мэдлэг дахин амилахад маань хадгалагдах болно)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Хичээлд судраа авчрахыг гишүүдээс хүс.
2. Хэрэв та хүсвэл хүүхдүүддээ заах талаар өөрсдийн туршлагаасаа хуваалцахыг хэд хэдэн гишүүнээс хүс.
3. Ангийн гишүүдэд энэ хичээлийн түүх ба судраас танилцуулахыг даалга.

Энэ хичээлийн зорилго бол Сүмийн хичээлийг заахдаа яагаад судар хэрэглэх ёстойг ойлгоход бидэнд туслах явдал болно.

Оршил

Үзүүлэнгүүдийг таниул, 17-а, “Бид судраас заах ёстой учраас судраа сайн судлах учиртай,” 17-б, “Ариун сургаалыг заах нь биднээс судрын гүнзгий мэдлэгийг шаарддаг.”

Ерөнхийлөгч Ж. Рүбэн Кларк нэгэн удаа Сүмийн хэсэг багш нарт хэлсэн үгэндээ” Таны хамгийн чухал үүрэг бол Их Эзэн Исүс Христийн Ариун Сургаалыг заах явдал юм. Та өөрийн эх сурвалжаас болон Сүмийн Жишиг Бүтээлийн (судрууд), мөн хожмын өдрүүдэд Бурханы хүмүүсийг удирдан чиглүүлэхээр дуудагдсан Түүний бошиглогчдын үгийн тусламжтайгаар энэхүү ариун сургаалыг заах ёстой.” (*The Charted Course of the Church in Education*, х. 9.)

Судраа мэдэж түүнийгээ ашиглах нь хичээл заах хамгийн хэрэгтэй арга юм.

Судраас Заахын Ач Холбогдол

Их Эзэн судруудыг судлаад түүнийгээ бусдад заахын чухлыг сургасан байдаг. Тэр Нефайчууд дээр айлчлан очихдоо судруудаа идэвх зүтгэлтэйгээр судлахыг тэдэнд зарлиг болгожээ (3 Нефай 23:1 -ийг үз). Судрууд бидэнд Исүс Христийн тухай сургадаг ба эдгээр нь үнэн ба итгэлтэй бөгөөд үүнд буй амлалт ба бошгууд нь биелэгдэх учраас бид судалдаг юм. (С ба Г 1:37-г үз).

С ба Г 68:1–4- ийг унш. Жишиг Бүтээлүүдээс гадна бидэнд өөр ямар судрууд байдаг вэ? Бид эдгээр судруудыг хаанаас олж авч чадах вэ? (*The Ensign* ба Ерөнхий Чуулганы илтгэлүүд.)

Судрыг Үр Өгөөжтэй Заах нь

Лихай ба түүний гэр бүлийнхэн амласан газарт ирээд Нефай ах нартаа ойлгомжтой байдлаар судраас заадаг. Нефай хэлэхдээ тэдэнд үр ашигтай зүйл сурч мэдэхэд нь туслахын тулд судрыг өөрсдийнхөө амьдралтай холбосон гэжээ. Бид бусдад үр өгөөжтэй заахыг хүсвэл судруудыг амьдралтайгаа холбох нь их чухал юм. “Судраас судла, бошиглогчдыг чих тавин сонс, тэгээд өөрт чинь хамаарах зүйлийг олж сур” гэж бошиглогч Жозеф Смит хэлсэн.

(Бошиглогч Жозеф Смитийн Сургаалууд,” х.12.) Чадвартай сайн багш нар байнга урьд болсон явдал өнөөдөр бидэнд яаж тусдаг болохыг үзүүлэн судруудыг өөрийн байгаа нөхцөл байдалтай харьцуулж чаддаг.

17-в үзүүлэнг таниул. “Лихай, Нефай нар Лиахонаг Олсон нь”

Мормоны Номон дахь энэ түүхийг Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл өөрийнхөө үгээр ийн өгүүлжээ:

Аав нь асрынхаа яг гаднаас нэгэн сонин зүйл олоод бусдыгаа дуудаж байгааг сонссон Нефайн оронд өөрийгөө тавь. Энэ нь тэдний хэн ч амьдралдаа ер үзэж хараагүй уран хийцийн гуулин бөмбөлөг байжээ. (1Нефай 16:10 -ыг үз.)


Хэрэв энэ ер бусын бөмбөлгийг сонирхон сайн ажиглавал, хаашаа явахыг чинь итгэл, анхаарал болон идэвх зүтгэлийн чинь дагуу заадаг болохыг та мэдэж авах болно (1 Нефай 16:28) . . . Бүр нарийн ажиглавал бөмбөлөг дээр Их Эзэний замуудыг тайлбарласан уншихад хялбар бичээсийг та олж харна. [Их Эзэнээс хүсэмжлэх ахул, зааврууд нь гэр бүлийн тань итгэл болон таны идэвх зүтгэлийн дагуу өөрчлөгдөнө. (1 Нефай 16:28).]

Бөмбөлөг буюу Лиахона нь, өөрөөр хэлбэл, луужинг Их Эзэн цөлд Лихайн аялах замыг нь заахаар тусгайлан бэлдэж өгсөн. Та нар тийм бөмбөлөгтэй болохыг хүсэхгүй байна гэж үү? Алдаа төөрөгдөл эсвэл буруу замд орох бүрт тань луужин таныг зөв замд хөтөлж, мэдээллийг бичиж өгөх болно, ингэснээр та бүхэн хаана алдаа гаргасан, эсвэл хаана буруу замаар явснаа үргэлж мэдэж болно.

Гэвч ахан дүүс минь хүн бүрд тийм бөмбөлөг бий. Буруу замд орох хандлага гарч ирэх болгонд таныг сэргийлэн хамгаалж байдаг ухамсарыг Их Эзэн бидэнд өгсөн. Тэр дандаа сануулж явдаг, гэвч хүмүүс тэдгээр санамжийг авсаар сүүлдээ үл ойшоож хүлээж авахаа больдог.

Та нарт луужингийн нэгэн адил ямар нэг бие мах бодын систем байдгийг ухамсарлах ёстой. Энэ нь хүүхэд бүрт өгөгдсөн . Тэр өөртөө байгаа Лиахонаг үл ойшоовол түүнийг чихэндээ дахин шивнэхийг сонсохгүйд хүрнэ. Гэвч биднийг зөв замд хөтлөх Лиахона байдаг гэдгийг санаж ухамсар гэж нэрлэдэг өөрсдийн Лиахонагийн зааврыг сонсох юм бол бидний усан онгоц хэзээ ч буруу чиглэлд явахгүй.

Ерөнхийлөгч Кимболл амьдралд сургамжтай үнэнийг бидэнд заахдаа судрыг яаж ашигласан бэ?



Хэрвээ бид судраа мэдэж байвал түүнд сургасан зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлж болно. Аав нь судар ашиглан хүүхдүүддээ сургасан тухай дараах хүүрнэлд өгүүлжээ.

БУСДАД ШҮҮГДЭХГҮЙН ТУЛД БУСДЫГ БҮҮ ШҮҮ

Машин зам дээр дугуйгаа тавьж болохгүй гэдгийг Лара, Тодд хоёр олон дахин хэлүүлдэг байжээ. Нэг өдөр аав нь гэртээ ирээд хоёулангийнхан дугуй машин зам дээр байхыг олж харжээ. Эхлээд аав нь Тоддтой нүүр тулан “Тодд оо, би Ларагийн дугуйг машин зам дээр байхыг харлаа. Би юу хийх ёстой вэ?” гэж асуухад Тодд:

“Та бидэнд хэлж байсан шигээ түүнийг долоо хоног гэртээ хорь,” гэж хариулжээ.

Дараа нь Ларагаас “Би сая Тоддын дугуй машин зам дээр байхыг нь харлаа. Би юу хийх ёстой вэ?” гэж асуухад,

“Түүнд дахин нэг боломж өг. Дараагийн удаа тэр санах болно,” гэж Лара хэлжээ.

Аав нь хоёр хүүхдээ дуудаад Матай 7:1–2 -ыг хамтдаа уншжээ.

Матай 7:1–2 -ыг унш.

Уншиж дууссанахаа дараа аав нь “Тодд оо, чи долоо хоног гэрийн хорионд орох болно. Харин Лара одоо очоод дугуйгаа холдуул, би чамд сануулга өгье,” гэж хэлжээ.

ХӨДӨЛМӨРЛӨСӨН ХҮН ЗОХИСТОЙ ХУВИА ХҮРТЭНЭ

Рон гэрийнхээ бүх цонхыг угааж түүний ах Рик бас хоолны өрөөг будахаар болцгоож шанд нь хоёулаа 10 доллар тус тус авахаар аавтайгаа тохиролцжээ. Цонх угаахад Рон хагас өдөр зарцуулж байхад Рик хоёр өдрийн дараа будаж дуусжээ. Аав нь хоёр хүүдээ тэнцүүхэн арав арван доллар өгөхөд Рик удаан ажилласнаараа илүү авах ёстой хэмээн эсэргүүцжээ. Хариуд нь аав нь Матай 20:1–15-ыг уншиж өгчээ.

МАТАЙ 20:1–15-ЫГ УНШ.

Амласнаараа аав нь шийдвэрээ өөрчлөөгүй бөгөөд Рикэд уурлах учиргүй хэмээн нэмж хэлжээ.

Эдгээр судрыг бид өдөр тутмын амьдралдаа яаж хэрэгжүүлж болох вэ? Матай 25:1–13, Иннос 2–8, С ба Г 40:1–3 -ыг уншаад ярилц.

Судраас Заахаар Бэлтгэх нь

Ерөнхийлөгч Харолд Б. Ли онцлон хэлэхдээ “Бид хүмүүстээ судраас хариултаа олоход нь тусалж, тэдэнд заах хэрэгтэй байна. . . .

Харамсалтай нь бидний дунд судраа уншдаггүй хүн олон байдаг.



Тэнд юу байдгийг бид мэдэхгүй, тийм учраас бид өөрсдөө судраас олох ёстой зүйлийн талаар эргэцүүлэн боддог билээ. Судраа уншихгүй байгаа нь өнөөдрийн бидэнд байгаа түгшүүрүүдийн нэг юм. (“Хариултаа Судраас Хай” *Ensign*, 1972 он, 12-р сар, х.3.)

Биднийг судраа унш гэж хэн ч шахаж шаардахгүй. Хэрэв бид хүсвэл судрыг судлах ач холбогдолгүй болох олон тааруухан шалтгаануудыг олж болно. Бид судрыг судлахаа өөртөө амлаж тогтмол унших төлөвлөгөө гаргах ёстой. Бид тэгж чадвал аль хэдийнээ сонголтоо хийчихсэн учраас судрууд эсвэл сонин сэтгүүлийн аль нэгийг нь сонгох явдалтай нүүр тулгарвал бид судруудаа сонгох болно.

Судрыг уншиж, ойлгон бусдад заах чадвар нь зөвхөн төлөвлөлт шаардаад зогсохгүй бэлтгэл, залбиралыг шаарддаг.

Моронай 10:3 -ыг унш. Судраас унших талаар Моронай юу гэж сургадаг вэ?

Судраас уншихдаа бид зүрх сэтгэлдээ эргэцүүлэн бодож унших ёстой. Ерөнхийлөгч Марион Ж. Ромни хэлэхдээ “Би судраа уншиж байхдаа *эргэцүүлэх* гэдэг үгийг их сонирхож байсан юм. . . . Толь бичигт энэ үгийг тайлбарлахдаа ухаан бодлоо цэгнэх, тунгаан бодох, дүгнэх, бясалгах гэсэн утгатай гэжээ. Миний хувьд *эргэцүүлэх* гэдэг бол залбирлын нэг хэлбэр юм. Энэ нь Их Эзний Сүнсэнд дөхөх арга болно. (“Пристийн Зэрэгтний Дуудлагыг Дээшлүүлэх нь,” *Ensign*, 1973 он, 7-р сар, х.90.)

Моронай 10:4 -т ийн хэлсэн байдаг. . . . Судрыг уншиж ухаан бодолдоо эргэцүүлэн бодсоны дараа, бид эдгээр нь үнэн эсэхийг асуух ёстой. Тэгэхэд Тэнгэрлэг Эцэг Ариун Сүнсний хүч чадлаар бидэнд үнэнийг илчлэх учиртай.

ДҮГНЭЛТ

Хичээлээ үр дүнтэй заахын тулд бид судраа тогтмол унших ёстой. Бид уншсан зүйлийнхээ талаар эргэцүүлэн бодож, түүнийг мэдэрч, чин сэтгэлээсээ залбирах ёстой. Дараа нь бид Сүнсний тусламжтайгаар мэдэж ойлгон авснаа амьдралд хэрэгжүүлэх ёстой. Энэ бүхнийг хийсний эцэст бид хичээлээ хүч чадалтайгаар мөн итгэл дүүрнээр зааж чадна.

Уриалга

1. Өдөр бүр судраа уншихдаа их ач холбогдолтой гэсэн хэсгийн доогуур зурж тэмдэглэ. Тэдгээрийг бид амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар бод.
2. Гэр бүлийн цуглаан дээр хоолны ширээний ард тойрон суусан үед эсвэл гэр бүлийн бусад тохиолдлуудад судрын түүхүүдээс, түүнийг гэр бүлийнхээ хэрэгцээнд тохируулж гэрийнхэндээ заа.



Нэмэлт Судрууд

2 Нефай 4:15–16 (Судар дах Нефайн баяр баясгалан)

С ба Г 11:21–22 (заахаасаа өмнө бид суралцвал зохино)

С ба Г 42:12–15 (бид судраас заавал зохино)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Gospel Principles гарын авлагаас “Scriptures,” 10-р бүлгийг унш.
2. Хичээлд судраа авчрахыг ангийн гишүүдээс хүс.
3. Ангийн гишүүдэд энэ хичээлийн судар ба түүхээс танилцуулахыг даалга.

Энэ хичээлийн зорилго бол Ариун Сургаалыг Ариун Сүнсний хүчээр заах ёстой болохыг ойлгоход бидэнд туслах явдал юм.

Оршил

Ерөнхийлөгч Дэвид О. МакКэй хэлэхдээ: “Багш нар аа, хичээлийнхээ бэлтгэлийг залбирлаар эхэл. Зүрх сэтгэлдээ залбиралтайгаар заа. Тэгээд таны хүргэж буй мэдээг ариун Сүнснийхээ нөлөөгөөр баяжуулахыг Бурханаас гуйн залбир.” (Gospel Ideals, х. 223.)

Исүс Христийн Ариун Сургаалыг заахын тулд бид Ариун Сүнсний зааврыг авсан байх ёстой. Зөвхөн ингэж л бид үнэнийг бусдад хүргэж чадна, учир нь бидний бодол бол Бурханы бодол биш, бидний зам бол Бурханы зам биш юм. (Аизаяа 55:8–9 -ийг үз.)

Ариун Сүнсний Нөлөөгөөр Заах нь

С ба Г 42:12–14 -ийг уншихыг гишүүдээс хүс. Энэ сударт бид юу заах ёстойг хэлсэн байдаг вэ? Тэдгээр зарчмуудыг бид хаанаас олох вэ? Бид хамтран заах Сүнсээ хэрхэн олж авч чадах вэ? Ариун Сүнсний нөлөө байхгүй үед бид яагаад хичээл заах ёсгүй вэ?

Юуг хэзээ заахаа мэдэхийн тулд бид Ариун Сүнсний нөлөөг мэдэрч сурах хэрэгтэй. Ахлагч А. Теодор Татлл Ариун Сүнсний хүчээр ярих ямар байдгийг тайлбарлан хэлсэн байдаг:

Илчлэл авч байгаага та мэдэрдэг үү? Энэ туршлагаасаа би та нартаа хуваалцъя.

Ахлагч Марион Ж. Ромнитой цуг Солт Лэйк рүү хуралд явж байх замд, бидний хамт аялж байсан ах нарын нэг: “Ромни ах аа, энэ орой та Ариун Сүнсний урам зоригоор ярьсан шүү” гэжээ.

Ромни ах тэгэхэд “Нээрээ тийм шүү. Би яаж мэдсэн гээч. Яагаад гэвэл би ч мэддэггүй байсан зүйлээ мэдэж авсан юм,” гэжээ. (“Өсвөр Үеийнхэнд Сургамжлах нь,” 1970 оны 7-р сарын 10-нд БЯИС-ийн Зуны Сургууль дээр өгсөн хэвлэгдээгүй яриа, х.9–10).

Ерөнхийлөгч Ромнид Ариун Сүнс хэрхэн нөлөөлсөн бэ? Ариун Сүнс бидний заах чадварыг хэрхэн дээшлүүлж чадах вэ?

Ариун Сүнс багш нарт нөлөөлөхөөс гадна сонсогчдын зүрх сэтгэлд хүрч чадах үгийг багшид хэлж өгдөг. “Хүн Ариун Сүнсний хүчээр ярьж байгаа үед, Ариун Сүнсний хүч чадлаар тэр үгийг хүмүүний хүүхдүүдийн зүрх сэтгэлд хүргэдэг” (2Нефай 33:1).

Заалгуулж байгаа хүмүүст Ариун Сүнс хэрхэн нөлөөлдөг вэ?

18-а үзүүлэнг таниул, ” Бинжамин Хаан Ариун Сүнсний хүч чадлаар зааж олон хүмүүсийн амьдралыг өөрчилсөн нь”.

Мормоны Номын бошиглогч Бинжамин Хаан амьдралынхаа эцсийн мөчид өөрийн хүмүүсийг зүрх сэтгэлээр нь бэхжүүлэн бусад онцгой заавруудыг өгөхийн тулд дуудаж цуглуулжээ.

Мосаяа 5:1–2 -ыг уншихыг гишүүдээс хүс. Бинжамин хааны үгэнд итгэхэд хүмүүст юу нөлөөлөв? Мосаяа 5:3–4 -ийг унш. Яагаад эдгээр хүмүүс Ариун Сүнсний нөлөөнд автагдсан бэ?

Ариун Сүнсний Зааварчилгаа Олж Авах нь

Мормоны Номонд тэр үеийн олон бошиглогч, номлогч нар Ариун Сүнсний удирдлагаар зааварлуулан сургаалаа айлддаг тухай бичсэн байдаг. Тэдний дунд Мосаяагийн дөрвөн хүү байжээ.

Алма 17:2–3 -ыг уншихыг гишүүдээс хүс. Хүч чадлаар заахын тулд Мосаяагийн хөвгүүд ямар гурван алхам хийсэн бэ? Гурван алхмыг самбарт жагсаа: судраас судлах, мацаг барих, залбирах.

Ерөнхийлөгч Марион Ж. Ромни, эхнэр нь Эцэг ба Хүүг харсан бошиглогч Жозеф Смитийн үзэгдлийн тухай хичээлийг бэлтгэхдээ эдгээр алхамуудыг дагасан тухай явдлаас хуваалцсан байдаг. Хичээл заах ангид нь дээд сургууль төгссөн, сүмийн гишүүн бус нэгэн авьяаслаг залуу эмэгтэй ирдэг байв. Тэр үед Ромни эгч туршлага муутай залуухан байсан бөгөөд заах хичээлийг нь тэр ухаалаг эмэгтэй хүлээн авахгүй байх хэмээн эмээж байжээ.

Энэ тухай ээжтэйгээ ярьж суусан Ромни эгч: “Ээж ээ, би энэ хичээлийг зааж чадахгүй. Би Жозеф Смитийг үзэгдэл харсан гэдгийг мэдэхгүй шүү дээ” гэж хэлжээ. . . .

“Түүний ээж боловсролтой хүн байгаагүй. Гэвч тэр гэрчлэлтэй байсан. Тэр охиндоо: “Бошиглогч яаж үзэгдлийг харсан гэдгийг чи мэднэ, тийм биз дээ?” гэхэд

“Тиймээ, тэр мэргэн ухааныг эрж Бурханд залбиран олж авсан,” гэж охин нь хариулжээ. . . .

“Дараа нь Ромни эгч өрөө рүүгээ явж үүнийг хийхийг оролдсон; Энос шиг Бурханаас гуйсан. Үүний үр дүнд тэр өөрийн жирийн чадвараасаа илүү хүч чадлаар хичээлээ итгэлтэй заасан. Тэр үүнийг яаж хийж чадсан бэ? Түүний гуйлтын хариуд Ариун Сүнс түүн дээр ирсэн. Тэр өөрийн сэтгэлдээ халуу шатаж буйг мэдэрсэн. Түүн шиг тэр бас Жозеф Смит үзэгдэл харсан гэдгийг мэдсэн. Бошиглогчийн харсан зүйлийг нүдээрээ хараагүй ч гэсэн тэр адилхан мэдлэгтэй болсон. Тэр Жозеф Смитийн харсан зүйлийнх

18-а, Бинжамин Хаан Ариун Сүнсний хүч чадлаар зааж олон хүмүүсийн амьдралыг өөрчилсөн нь.



нь дүрслэлээс мэдэж авч түүний ярьсан зүйл үнэн гэдгийн гэрчлэлийг Ариун Сүнснээс авсан.” (How to Gain a Testimony, “New Era” 5-р сар 1976, хх 10–11.)

Ромни эгч хичээлдээ хэрхэн бэлтгэсэн бэ? Ганцаараа бэлтгэх нь яагаад түүд хичээл заах урам зориг өгөөгүй вэ? Ромни эгчийн авсан тэр гэрчлэлийг бид юу гэж нэрлэдэг вэ?

Үнэнийг хэн нэгэн гэрчилж буй болон үнэнийг энгийнээр унших хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ? Ангийн гишүүнээр Моронай 10: 4–5-ыг уншуул. Ариун Сүнс ямар замаар бидэнд үнэнийг сурахад тусалдаг вэ? Гэрчлэл хүлээн авахын тулд бид юу хийх шаардлагатай вэ?

Гэрчлэл Заах Хүч Чадлыг Өгдөг

Гэрчлэлтэйгээр хичээл заана гэдэг бол ариун сургаал үнэн гэдгийг мэдээд зааж байна гэсэн үг юм. Зааж байгаа зүйлдээ гэрчлэлтэй байвал биднийг сонсогчид Сүнсний хүчийг мэдэрч, ариун сургаалыг илүү сайн ойлгох болно. Биднийг үнэний гэрчлэл хуваалцахад Ариун Сүнс бидний гэрчлэл үнэн гэдгийг гэрчилдэг. (С ба Г 50:21–22).

18-6 үзүүлэнг таниул.” Ариун Сүнс ариун сургаалын үнэнийг гэрчилсэн нэгний гэрчлэлийг баталдаг”.

Ахлагч Алвин Р.Дайр дараах түүхийг өгүүлжээ:

Үдэш болоход хоёр номлогч нэгэн айлд очжээ. Тэр айлынхан оройн хоолоо идэх гэж байх үед нь таарсан учир тэд үүдэнд нь мэдээгээ хүргээд л буцжээ. Гэрийн эзэгтэй хаалгаа хаах үед хоёр номлогч Ариун Сургаалын үнэний гэрчлэлээ хэлжээ. Тэдний нэг нь гэр доторхи хүмүүст сонсогдохоор дуугаа өндөрсгөн хэлжээ. Дараа нь бороо орж эхэлсэн учраас тэр хоёр яаран буцав. Гудамж өнгөрөн явж байтал хэн нэгэн тэднийг дуудахыг сонсжээ. Арван дөрөв орчим настай хүү гүйцэж ирээд: “Та хоёрыг аав буцаж ирээч гэж байна” гэж хэлжээ. Буцаад очиход аав нь үүдэнд нь хэлсэн мэдээг сонссон бөгөөд тэдний гэрчлэл сэтгэлийг нь их догдуулсан гэдгээ хэлжээ. Тэр:” Нэгэн хачин совин татаад, та нарыг буцааснаараа буруу юм хийж байна гэдгээ би мэдсэн.” Даруухан ахлагчийн хэлсэн тэрхүү гэрчлэл тэдний гэр бүлийг усан баталгаа хийлгэхэд хүргэжээ. (“When Thou Art Converted”, 6-р сар 1961, х. 225.)

Аав нь яагаад номлогч нарыг буцаан дуудсан бэ? Ариун сургаалыг заалгаж байх үеийн туршлагаасаа хуваалцахыг гишүүдэд даалга.

Дүгнэлт

Сүмийн багш болон эцэг эхийн хувьд бид зааж байгаа хүмүүсийнхээ амьдралыг өөрчлөх үүрэг хариуцлагатай. Гэхдээ бид үүнийг зөвхөн Ариун Сүнсний хүчээр л хийж чадна. Хэрэв бид

18-6. Ариун Сүнс ариун сургаалын үнэнийг гэрчилсэн нэгний гэрчлэлийг баталдаг.



Сүнсээр заах юм бол зөвхөн зааж байгаа хүмүүсийнхээ бус мөн өөрсдийнхөө мэдлэг болон итгэлээ нэмэгдүүлнэ.

Зөвхөн Ариун Сүнсний хүч чадлаар л бид үнэнийг зааж чадна. Ариун Сүнсний хүч чадлаар заахын тулд бид зохистой бөгөөд Бурхны зарлигуудын дагуу амьдарч, суралцаж, залбирч байх ёстой.

“Итгэлтэй залбирсны эцэст л танд Сүнсээ өгнө. Хэрвээ Сүнсийг хүлээн авахгүй бол та зааж чадахгүй,” гэж Их Эзэн хэлсэн.

Та тайтгаруулагчийн хүчээр ярьвал Их Эзэнд тааламжтайгаар ярьж зөгнөх болно.

Тайтгаруулагч бүх зүйлийг мэддэг. (С ба Г 42:14, 16–17 -г үз).

Уриалга

1. Ариун Сүнсний удирдамжийг хайж судраа унших, залбирах болон мацаг барьж хичээлдээ бэлтгэ.
2. Хүүхдүүд, найз нөхөд болон хөршүүддээ заах боломжийг хай.

Нэмэлт Судрууд

Лүк 24:32 (Ариун Сүнсний урмыг мэдрэх нь ямар байх вэ)

Жон 14:26 (Тайтгаруулагч бидэнд бүхнийг заадаг)

2 Нефай 32:7–8 (Сүнс бидэнд залбирах урам зоригийг өгдөг)

Мосая 23:14 (Бурханы зарлигуудыг биелүүлдэг багш нарт л бид итгэх ёстой)

Алма 5:43–52 (мацаг барих ба залбирах нь Ариун Сүнсний удирдамжийг авахад тусална)

Моронай 10:7–10 (Бурханаас итгэлээр дамжуулж бэлэг өгөгдөнө)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Хичээлд бэлтгэхдээ Ариун Сүнсний нөлөөг мэдрэхийн тулд тодруулан бичсэн алхамуудыг дага.
2. Хүсвэл ариун сургаалыг заалгаж байх үеийн туршлагаасаа хуваалцахыг хоёр гишүүнд даалга.
3. Самбар, шохой бэлтгэ.
4. Ангийн гишүүдэд энэ хичээлийн судар ба түүхээс танилцуулахыг даалга.

Даруу Байдал ба Ариун Журмыг Өрх Гэртээ Заах нь

Хичээл 19

Энэ хичээлийн зорилго бол бидэнд өрх гэртээ даруу байдал ба ариун журмыг заахад туслах явдал болно.

Оршил

Даруу байдал ба ариун журмын үнэ цэнийн талаар Ахлагч Бойд К. Пакэр хэлэхдээ: “Өрх гэрт эдгээр нандин зүйлийг заах хариуцлага ба эрхийг эцэг эхэд өгсөн байдаг. Энэ нь ерөнхий боловсролын сургуулиуд болон Сүмийн байгууллагуудын хариуцлага гэдэгт би итгэдэггүй. Үүнд өргөх Сүмийн нэмэр хандив нь Их Эзэний илчилсэн ёс суртахууны жишгийг эцэг эхэд таниулах, түүнчлэн эдгээр нандин сэдвүүдийг үр хүүхдүүддээ танилцуулах хариуцлагаа биелүүлэхэд нь туслах явдал юм.” (*Teach Ye Diligently*, х. 256.)

Бошиглогч Мормон, хүү Моронайдаа ёс суртахууны цэвэр нандин байдлын агуу чанарын тухай сургаж захидал бичсэн байдаг. Ариун явдал ба ариун журам нь юу юунаас илүүтэй эрхэм бөгөөд үнэт зүйлүүд болохыг хэлдэг (Моронай 9:9 -ийг үз). Бидний бие махбод бол нандин; бид үргэлж даруухан хувцаслаж, өөрсдийгөө цэвэр нандин, сайн сайхнаар нь хадгалвал зохино.

Даруу Байдал ба Ариун Журам

Их Эзэн ариун журмыг агуу ихээр үнэлдэг. Тиймээс, даруу байдал, ариун журамтай байснаар Их Эзэн чухам юуг хэлж буйг ойлгох нь чухал. Даруу байдлыг ихэвчлэн бидний ярьж хувцаслаж буй байдлаар тодорхойлно. Ариун журам нь бидний үйл хэргээ явуулж буй байдал юм. Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл хэлэхдээ:

“Ариун бус явдалд хөтлөгч олон зүйлүүдийн нэг нь даруу бус байдал юм. Өнөөдөр олон залуу эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд амьдралын бодит байдлын талаарх мэдлэгээрээ бардамнадаг. Тэд бүх л хариултуудыг мэддэг гэж боддог. Тэд эр эмийн ёсны талаар ярихдаа машин, үзвэр, хувцасны талаар ярьж буй мэт чөлөөтэй хүүрнэдэг. Даруу бус явдлын сүнс энэ үед бүх л зүйлийг нандин бус болгодог.

“Даруу бус байдлыг өөгшүүлэгч, ёс суртахууны түвшинг бууруулагч нэгэн хүчин зүйл нь орчин үеийн хувцас юм. Зарим залуу охидын ба эхчүүдийн өмсөж буй даруу бус хувцас шууд ба шууд бус байдлаар тухайн насныханд нөлөөлдөг. Заримдаа эцгүүд ч үүнийг өөгшүүлэх нь бий. Биеийн зарим хэсгээ ил гарган гайхуулснаар тэд залуу

хөвгүүдийн өмнө уруу таталт болдгоо залуу эгч нар маань ухаардаг эсэхт би эргэлздэг. . . .

“Өмсдөг хувцас маань бидний ариун журмын хүндэтгэл, ариун явдлын тогтвортой байдлыг доройтуулдаг томоохон хэсэг болдог нь тодорхой” гэдэгт би итгэдэг. (*Faith Precedes the Miracle*, х. 163, 168.)

Бие махбодоо нандин болохыг мэдэх нь бидний хувцаслалт ба үйлдэлд хэрхэн нөлөөлөх вэ?

Бид Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд гэдгээ мэдэх нь бидний хувцаслалт ба үйлдэлд хэрхэн нөлөөлөх вэ?

Ахлагч Вон Ж. Фидэрстөун хэн болохоо, юу хийхээ мэддэг нэгэн хаан хүүгийн тухай түүхийг өгүүлсэн юм. Францын ЧМШ Луис Хааныг ширээнээс нь зайлуулж шоронд хорьжээ. Хааныг олзолсон хүмүүс мөн түүний залуу хүү агийг нь олзолсон байна. Залуу агь дараагийн хаан болох учиртай байсан тул тэд түүнийг ёс суртахууных нь хувьд устгахыг хүсчээ. Хэрэв тэд ийн хийх юм бол тэрээр хэзээ ч Францын хаан болох боломжгүй болно гэдгийг мэдэж байв.

Тэдгээр хүмүүс агийг алс хол хотод аваачин, бүх л муу муухай зүйлсэд уруу татжээ. Өөрийгөө хянах чадвараа алдахаар тийм хоолыг тэд түүнд идүүлж, дэргэд нь үргэлж бохир хэллэг хэрэглэн, нүгэлт эмсээр түүнийг уруу татаж байв. Нэр төр, итгэл найдварыг нь алдагдуулах гэж тэд хичээж байсан. Хүний ёс суртахууных нь эрхэм чанарыг устгах бүх л зүйлээр тэрээр өдрийн хорин дөрвөн цагийн туршид хүрээлүүлж байжээ. Энэ байдал зургаан сар илүүтэй үргэлжилсэн байна. Гэвч хүү нэг ч удаа тэрхүү уруу таталтанд орсонгүй. Эцэст нь, боломжтой бүх л зүйлийг хийж үзсэнийхээ дараа тэд хүүгээс яагаад тэрээр уруу татагдаагүй болохыг асуухад, тэрээр, “Би Хаан болон төрсөний учир хүссэнийг чинь хийж чадахгүй.” хэмээн хариулжээ. (*New Era*, “Хааны Хүү”-ээс авав. 1975. х. 35.)

Бид ч бас хаад болохоор мэндэлсэн (1 Пэтэр 2:9, Илчлэл 1:6). Гэхдээ, амьдралын маань зорилго нэгэн гүрний хаан байхаас илүү юм. Бид Бурханы хүүхдүүд, бид Түүнтэй адил болохоор мэндэлсэн. Хэрэв бид даруу бөгөөд ариун журамгүй байвал ийм зорилгыг гүйцэлдүүлж дийлэхгүй болно.

Үлгэр Жишээний Ач Холбогдол

Бурханы Сүмийн гишүүдийн хувьд бидний хамгийн чухал хариуцлагуудын нэг бол даруу байдал ба ариун журмын зохих үлгэр жишээг үзүүлэх явдал болно. Бид оюун ухаан, бие махбодио цэвэр ариунаар нь байлгаад зогсохгүй, үг яриа, баяр хөөр, уншиж буй ном зохиолоороо бие махбодь маань нандин гэдгийг үзүүлэх учиртай. Энэ нь ялангуяа эцэг эхчүүд болон өсвөр насны хүүхдүүдийн хувьд

чухал юм. Бид зохих үлгэр жишээг үзүүлэхэд, хүүхдүүд болон ах, дүү нар маань бидний эрхэмлэдэг зүйлийг эрхэмлэн, бидний зан чанарыг өвлөх болно.

Өөрсдийн хандлага болон зан суртахууны талаар хэдэн хором тунгаан бодож, дараах асуултуудыг өөрсөддөө тавихыг гишүүдээс хүс:

“Заахаар хичээж буй хүмүүст маань муугаар үлгэрлэж болох тийм зүйл миний хандлага болон зан чанарт бий юу?”

“Хүүхдүүд маань хийж, сэтгэхийг ч үл хүсэх тийм зүйлийг би хийж, сэтгэдэг билүү?”

Жакоб 2:35 -д өгүүлсэнчлэн муу үлгэр жишээ үзүүлсэн учраас Жакоб Нефайчуудыг зэмлэж буйг унш. Зохих үлгэр жишээ үзүүлэх нь яагаад чухал вэ?

Даруу Байдал ба Даруу Төлөв Байдлыг Заах нь

Даруу байдал ба даруу төлөв байдлыг заах нь гүн гүнзгий сүнслэг чанарыг шаарддаг. Ахлагч Боид К. Пакэр хэлэхдээ: “Ёс суртахууны ба сэтгэлийн хүнлэг чанарыг заахад зайлшгүй хэрэгтэй ганц зүйл гэвэл . . . заах үедээ Их Эзэний Сүнсийг агуулах явдал юм.” (*Teach Ye Diligently*, х. 272).

Түүнчлэн энэ сэдвийг бишрэлтэйгээр ба хүнлэг байдлаар хөндөж ярих нь маш чухал. Туйлын бишрэлтэйгээр даруу байдал ба ач буяныг заах Ахлагч Пакэрийн хандлага нь нэгэн сайн жишээ юм:

Бидний бие махбодид энэхүү нандин бүтээх хүч чадал өгөгдсөн юм. Өөрөөр хэлбэл, гэрэл нь бусад гэрлийг асаах хүч бүхий тийм нэгэн гэрлийг агуулдаг. Энэ бэлгийг зөвхөн гэрлэлтийн нандин холбооны хүрээнд хэрэглэх учиртай. Энэхүү бүтээх хүч чадлын үрээр, мөнх бус бие махбод бүрэлдэж, сүнс үүнд нь нэвтрэн орж, амьдралд нэгэн бодьгал мэндэлдэг. Энэ хүч нь сайн зүйл. Энэ нь гэр бүлийн амьдралыг бүтээж дэмждэг бөгөөд гэр бүлийн амьдралд бид аз жаргалын эх ундаргыг олдог. Энэ нь ерөнхийдөө мөнх бус амьдралд мэндэлсэн хүн бүрт өгөгддөг юм. Энэ нь нандин бөгөөд учир холбогдол бүхий хүч болно . . .

“Энэхүү нандин хүчинд гар хүрэх байнгын урилгаар дүүрэн тийм нийгэмд та өсч байна. . . . Бие махбодид тань хүрч, оролдохыг хэнд ч бүү зөвшөөр. Хэнд ч тэр! Танд өөрөөр хэлж буй хүмүүс зөвхөн өөрсдийн гэмийг тантай хуваалцах гэж буй юм. Гэм нүгэлгүй байдлаа хадгалахыг бид танд хэлж байна. . . . Энэхүү нандин хүчний цорын ганц зөв шударга хэрэглээ нь гэрлэлтийн гэрээнд байх болно. Энэ нандин хүчийг хэзээ ч буруугаар бүү хэрэглэ.” (*Teach Ye Diligently*, х. 259, 262.)

Гэр бүлдээ энэ зарчмыг амжилттайгаар заахын тулд бид өрх гэрээ ямар нэгэн цэвэр бус зүйлээс хамгаалахдаа маш анхааралтай байх учиртай. Ахлагч А. Теодор Таттл бидэнд ийн хэлсэн байдаг: “Эцэг нь өрх гэрийн хамгаалагч юм. Тэрээр гаднаас ирэх муу ёрын сүнсний аюулын эсрэг хамгаалан зогсдог. Дээр үед тэрээр өрх



гэрээ зэвсэг үүрээд хамгаалдаг байсан. Өнөөдөр энэ үйл хэрэг нь илүү нарийн уялдаатай ажиллагаа болно. Цоожтой хаалга цонх нь зөвхөн бодит зүйлсээс л хамгаална. Гэр бүлийнхнийх нь оюун болон сэтгэлд нэвтрэхээр тэмүүлж буй муу ёрын сүнснээс гэр бүлийнхнээ хамгаална гэдэг хялбар хэрэг биш ээ. Эдгээр нь өрх гэрт чөлөөтэй нэвтрэх боломжтой. Сатан уран арга зальтайн учир, өрх гэрт нэвтрэхийн тулд хаалга үүд эвдлэх шаардлаггүй.” (“Эцгийн Үүрэг,” *Ensign*, 1974, 1-р сар, х. 67).

Өнөөдөр нүгэл хилэнц өрх гэрт тань нүүрлэн орж ирж болох ямар арга замууд байж болох вэ? (Ёс суртахуунгүй сэтгүүлүүд, радио нэвтрүүлгүүд, зурагтын хөтөлбөрүүд ба номнууд г.м.)

Энэ мэт зүйлээс гэр бүлээ хамгаалахын тулд эцэг юу хийх ёстой вэ? (Унших материал, зурагт ба радиогоор цацагдаж буй нэвтрүүлгүүддээ анхааралтай бай.)

С ба Г 93:40–43 -ыг уншиж ярилц.

Хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хүргэх хариуцлагаа биелүүлээгүй Фрэдирик Г. Уиллиамсыг Их Эзэн буруушаасан.

Даруу байдал ба даруу төлөв байдлын ач холбогдлыг хүүхдүүддээ заахдаа итгэл үгүй байсан хэмээн Их Эзэн танд хэлэх юм бол танд ямар сэтгэгдэл төрөх вэ?

Заахад Тохиромжтой Цаг

19-а үзүүлэнг таниул, “Эцэг нь хүүхдүүдтэйгээ тогтмол ярилцлага хийх нь зүйтэй.”

Өрх гэрийн цуглаан бол даруу байдал ба даруу төлөв байдлын тухай сургахад хамгийн тохиромжтой цаг юм. Олон эцгүүд хүүхдүүдтэйгээ тэр ч бүү хэл эхнэртэйгээ албан ёсны ярилцлага хийх хэрэгтэй гэж ярьдаг. Жишээ дурдахад, нэг эцэг сар бүрийн мацаг барилтын Ням гаригт хүүхэд бүртэйгээ ярилцлага хийдэг байна. Тэрээр ёс суртахууны цэвэр нандин байдлынх нь талаар асуултууд тавьж тэдэнд тулгарч болзошгүй асуудлуудыг нь сонсдог ажээ. Тэрээр сургаж, гэрчлэлээ хуваалцаж, тэдэнд ханддаг өөрийн хайраа илэрхийлдэг байна.

Ийм маягийн ярилцлага хүүхдүүдэд хэрхэн нөлөөлнө гэж та нар бодож байна вэ?

19-б үзүүлэнг таниул, “Заах боломж урьднаас төлөвлөөгүй мөчид тохиолдох нь олонтаа.”

Хэдийгээр ярилцлага ба гэр бүлийн цуглааны үед гэх зэрэг албан ёсны байдлаар үр хүүхдүүддээ заах нь зайлшгүй чухал боловч, бид хүүхдүүдийнхээ хэрэгцээг байнга мэдэрч ойлгож байх хэрэгтэй. Тэдэнд хэлж ухааруулахыг хүсч буйг маань тэд хэдийд хамгийн сайн ойлгохыг ажиглах нь зүйтэй. Хэрэв бид тогтмол тэдэнтэй ярилцаж хайраа үзүүлвэл хүүхдүүд маань өөрсдийн бодол санаа, тулгарсан асуудлуудаа ярилцах шаардлагатай үедээ бидэнд хандах болно.

19-а, Эцэг нь хүүхдүүдтэйгээ тогтмол ярилцлага хийх нь зүйтэй.



Дүгнэлт

Үр хүүхдүүддээ заах боломжтой мөч бүрийг ашиглахыг Их Эзэн бидэнд зарлигдсан байдаг (Дүтэрэноми 6:5–7 -ыг үз). Зааж болох боломжуудыг эрэлхийлвэл, бид заримдаа маш санаандгүй байдалд хүчтэй нөлөөтэйгөөр зааж чаддаг. Тухайлбал, бид зугаалгаар явахдаа, ариун ёслолын цуглааны дараа салхинд гарахдаа, машин дотор, амралтаар явахдаа, сургууль хүрэх замдаа, эсвэл хүнд хэцүү мөч тохиолдоход бид даруу байдал, ариун журмын талаар чухал үнэнүүдийг заах боломжтой байж болох юм.

Хүүхдүүдтэйгээ болон эцэг эхтэйгээ байх үедээ чин сэтгэлээсээ ярилцаж, сургах боломжтой байсан тийм тохиолдлыг та нар санаж байна уу? Хэзээ, хаана болсон бэ? Энэ явдал төлөвлөгдсөн байсан уу, эсвэл санаандгүй тохиолдсон уу?

Уриалга

1. Даруу төлөв байдал ба даруу байдлын талаар гэр бүлийн цуглаан дээр ярилцахаар төлөвлө.
2. Өмссөн хувцас, үйлдлээрээ даруу байдал ба даруу төлөв байдлаараа үлгэр жишээ үзүүл.
3. Хэрэв та залуу эрэгтэй бол мэдэх залуу эмэгтэйчүүдээ даруу хувцаслахад нь урамшуулан дэмж.

Нэмэлт Судар

1 Тимоти 4:12 (үлгэр жишээний ач холбогдол)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Энэ хичээлийг хэрхэн заахаа сайтар төлөвлө. Хэрэв пристийн зэргийн хичээлд тань залуу пристийн зэрэгтнүүд оролцож байгаа бол хичээлийг тэдэнд хандсан ёс суртахууны заавар болгохоос сэрэмжил. Энэ эмзэг сэдвийн талаар залуу үе маань эцэг, эхдээ хэрхэн тусалж болохыг та тэдэнтэй ярилцаж болох юм. Ариун явдал ба даруу байдал нь яагаад тун чухал болох мөн бусдад үлгэр жишээ үзүүлэхийн тулд гишүүд юу хийж болохыг ярилц.
2. Хэрэв хүсвэл, эцэг эх, хүүхдүүдийн хооронд болсон чин сэтгэлийн ярилцлага болох сургалтын туршлагаасаа хэлэхийг хэн нэгнээс хүс. Туршлагыг ярилцаж, эцэг эх ба хүүхдүүд яагаад ийн ярилцах боломжтой байсныг дүгнэ. (Энэ ярилцлагыг хийх тохиромжтой цаг нь “Заахад Тохиромжтой Цаг”-ийн тавдугаар хэсэг дэх санаануудыг хэлэлцэх үе юм.)
3. Түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Гэр Бүлийн Асуудлыг Эвээр Шийдвэрлэх нь

Хичээл 20

Энэ хичээлийн зорилго бол амьдралаа аз жаргалтай болгохын тулд гэр бүлийн асуудлуудаа эв нэгдэлтэйгээр зохицуулахад биднийг урамшуулах зорилготой юм.

Оршил

20-а үзүүлэнг таниул, “Хайр бол эв найртай гэр бүлийн үндэс мөн.”

Төгс төгөлдөр өрх гэртэй болохын тулд юу хийх ёстойг Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит хэлсэн байдаг.

“Төгс төгөлдөр . . . өрх гэр гэж . . . юу вэ? Энэ бол . . . эцэг нь гэр бүлийнхээ хайрлаж тэднийгээ хамгийн чухалд тооцдог, үүндээ Бурханаас адис ивээл хүртдэг, хариуд нь тэд ч зүрх сэтгэлээрээ Түүнийгээ хүлээн зөвшөөрдөг гэр бүл юм. Эцэг, эхийн дунд болон хүүхдүүд, эцэг эхийн хооронд итгэлтэй байдал, эв нэгдэл, хайр хүндэтгэл, нандин хайр оршдог гэр бүл болно.” (*Gospel Doctrine*, х. 302–3.)

Төгс төгөлдөр гэр бүлтэй болохыг бид бүгд зорьдог ч бидэнд заримдаа саад бэрхшээл тохиолддог. Бошиглогч Жозеф Смит ч гэсэн үе үе гэртээ найрсаг бус байдлыг мэдэрдэг байсан юм.

Жишээлбэл, нэгэн өглөө тэр Мормоны Номыг орчуулж байхдаа эхнэрийнхээ хийсэн нэгэн зүйлд сэтгэл ханамжгүй байснаас уурлав. Дараа нь түүнээсээ болж Мормоны Номынхоо орчуулгыг хийж чадахгүй байгаагаа мэдрэв. Тэр цэцэрлэгт очиж залбираад, буцаж ирснийхээ дараа Эммагаас уучлал гуйжээ. Гагцхүү ийн үйлдсэний дараа л тэр орчуулгаа хийж чадав. (9-р сарын 15-нд Давид Витмэрийн өгсөн мэдэгдэлээс, 1882, Сүмийн Дэлгэрэнгүй Түүх, Боть 1, х.131.)

Гэрт зөрчилдөөн гарах эх үүсвэрийг намжааж асуудлыг шийдвэрлэхийг Их Эзэн биднээс хүсдэг.

Гэр Бүлд Зөрчилдөөн Гарах Эх Үүсвэрүүд

Зөрчилдөөн ба хэрүүл маргаан гарах нэгэн үндсэн шалтгаан бол Сатаны нөлөө байдгийг судрууд бидэнд хэлдэг.

3 Нефай 11:29–30 - г унш.

Хэрүүл маргааны сүнс гэрт ирвэл Их Эзний Сүнс гэрийг орхин явдаг. Харин Их Эзний Сүнсгүйгээр бидний гэр бүл аз жаргалтай

байж, Их Эзэн ба Түүний ариун сургаалын баяр баясгаланг эдэлж чадахгүй.

Мөн бидний сул тал бусадтай маргаан үүсгэхэд хүргэдэг (Жэймс 4:1 үз). Хэрэв хүн амар амгаланг мэдэрч чадахгүй бол бусадтай эв найртай байх хэцүү байдаг. Зөрчил үүсгэгч сул талуудын дотор сувдаг сэтгэл, шунал, цэвэр бус хүсэл, шудрага бус зан чанар багтдаг. Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл тодорхой нэгэн сул талын талаар онцлон хэлэхдээ: “Гэрлэсэн хос ядуу зүдүү байдал, өвчин, найдвар тасрах, гарз хохирол, тэр ч бүү хэл гэр бүлийнхээ нэгнийг алдах гэх мэт байдалтай тулгарч болох юм, гэхдээ энэ бүхэн нь тэднээс амар амгалан байдлыг булаан авч чадахгүй. Аминч үзэл гэр бүлд халдаагүй цагт гэрлэлт нь тогтвортой байж чадна. Аминч үзэл огт байхгүй тэр цагт л зовлон бэрхшээл ханилсан хосуудыг салшгүй нэгдэлд хүргэнэ.” (Гэрлэлт ба Салалт, х.19, 22.)

Ерөнхийлөгч Кимболлын хэлснээр гэрлэлт зөрчилтэй, аз жаргалгүй байхын эх үүсвэр юу вэ?

Ерөнхийлөгч Кимболлын хэлснээр ядуу зүдүү байдал, өвчин эмгэг нь олон хүний боддогоор аз жаргалгүй байдлыг авчрах бус, харин гэр бүлийг ойртуулж дотно болгодог.

Бидний ярилцсанаар гэр бүлд зөрчил үүсгэгч гурван ямар зүйл байдаг вэ? (Харилтуудыг самбар дээр бич. Сатаны нөлөө, хувийн зөрчил, аминч үзэл зэргийг багтаасан байх ёстой.)

Гэр Бүлийн Асуудлуудыг Зохицуулах нь

Гэр бүлийн асуудлуудыг шийдвэрлэхэд Их Эзэн дараах арга замыг бидэнд өгсөн:

ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭН АВАХ

Эцэг эх хүүхдүүд харилцан бие биеийнхээ өмнө хариуцлага хүлээдэг.

Эдгээр хариуцлагын заримыг Ефис 6:1–4 -өөс унш. Залуу хүн эцэг эхийнхээ өмнө ямар үүрэгтэй вэ? Эцэг, эхчүүд хүүхдүүдийнхээ өмнө ямар үүрэгтэй вэ? Эдгээр үүргийг хүлээн авах нь гэр бүлийг эв найртай болгоход хэрхэн туслах вэ?

БҮДҮҮЛЭГ ҮГНЭЭС ЗАЙЛ

Гэр оронд маань омогтой бүдүүлэг үг байх ёсгүй. Ахлагч Боид К. Пакэр бидэнд зөвлөхдөө: “Та гэрлэлтийн гэрээндээ орсныхоо дараа хэзээ ч ханьтайгаа үг сөрж болохгүй. Энэ нь шаардлагатай бөгөөд хүсүүштэй зүйл биш юм. Олон хүн гэр бүлийн харьцаанд маргаан байх нь энгийн бөгөөд байж болох зүйлийн нэг гэж үздэг. Ханьтайгаа нэг ч үг сөрөхгүйгээр хамтдаа хайр дурлалд амьдарч болно гэдгийг би мэднэ.” (“Мөнхийн гэрлэлт,” Жилийн шилдэг илтгэл, БЯИС, 4-р сар 14, 1970, х.6). Намуун тогтуун хариу биднийг



тайвшруулдаг, уурандаа хэлсэн бүдүүлэг үг зөвхөн зөрчилд хүргэнэ (Зүйр Үгс 15:1 -ийг үз).

Маргалдах ба ярилцах хоёр ямар ялгаатай вэ?

БУРУУГАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨР

Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл дараах зөвлөмжийг өгсөн юм:

“Хувь хүний хувьд танд жижиг маргаанд хүргэж болох үзэл бодлын зөрүү гарч болох юм. . . Бие биенээ гомдоосон өрөвдөх сэтгэлгүй үг хэлж, сэтгэл зүрхийг шаналгаж гэж бодъё. Аль аль нь бие биенээ буруутай хэмээн бодож сэтгэлийнхээ шархыг эдгэрүүлэхээр юу ч хийсэнгүй. Цаг хугацаа өнгөрөхөд шөнжингөө шаналсан зүрхтэй, гомдсон сэтгэлтэй дүнсгэр өдөр, буруу ойлгох явдал лавширсаар. Шархан дээр шарх нэмэгдсээр өмгөөлөгч холслөхөд хүрч, эцэст нь өрх гэр задран бутарч, эцэг эх ба хүүхдүүдийн амьдрал сүйрнэ.

Гэвч нэгэн анагаах гаварыг өмнө нь хэрэглэсэн бол тэр таныг зөв бодолд тань буцаан авчирах бөгөөд хэрэв та үүний эсрэг тэмцсээр байвал, гэр бүл, таны туйлын зорилго, өргөмжлөл болон мөнх байдлаа алдаж өөр ямар ч боломж олдохгүй байх болно. Биеэ тоосон бардам зангаа номхотгож эхнэртээ зоригтойгоор: “Хайрт минь, намайг уучил. Би чамайгаа гомдооё гэж бодоогүй юм. Намайг уучил,” гэж хэлэх ёстой. Эхнэр чинь хариуд нь: “Хайрт минь, би л чамаас илүү их буруутай. Намайг уучил,” гэнэ. Дараа нь та хоёр бие биенээ тэврэн амьдрал буцаад сайхан хэвэндээ орно. Унтаж амрах цаг болоход гомдсон сэтгэл арилсан байх бөгөөд гэр бүлийн залбирлаа хийх үед та хоёрын дунд ямар ч ангал үгүй болно.” (Faith Presedes the Miracles; pp.134–36).

Хэрүүл маргаан, зөрчлийг үүсгэгч ямар эх үүсвэрүүд байдаг вэ? Тэдгээр асуудлуудын шалтгааныг тогтоож мэдэх нь бидэнд хэрхэн туслах вэ? Буруугаа хүлээх нь бидэнд яагаад хэцүү байдаг вэ?

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл бидэнд “Намайг уучил” гэж хэлж буруугаа хүлээн зөвшөөрч чаддаг байх тухай хэлсэн байдаг. Хэрэв бид үүнийг сэтгэлээсээ хийж чадвал гэр бүл дэх зөрчлийг зохицуулахад нэгэн том алхам болох юм. Энэ нь зөвхөн эцэг эх хоорондоо харилцах асуудал бус, хүүхдүүдтэйгээ ч гэсэн адилхан харилцах ёстой.

ЗАЛБИРАЛ

Бид үзэл бодлын ялгаагаа даван туулахыг Их Эзэнээсээ гэр бүлийн ба хувийн залбиралаараа хүсэн гуйснаар гэр бүлд найрсаг байдлыг бий болгоно.

3 Нефай 18:19–21-ийг унш. Гэд бүлээрээ залбирах нь бидний үүрэг гэдгийг сана. Гэр бүлийн асуудлыг зохицуулахад залбирал хэрхэн тусалж чадах вэ?

20-а, Хайр бол эв найртай гэр бүл дэх амьдралын эх үндэс билээ.

ЭЕЛДЭГ БАЙДАЛ

Гэр бүлээ илүү аз жаргалтай болгох талаар сударт бичсэн зарчмуудын нэг бол эелдэг байдал юм. Өрөвч нинжин сэтгэлтэй, эелдэг байх ёстой зарлиг бидэнд байдаг. Христийн үзүүлсэн шиг тийм хайр хүндэтгэлтэй, эелдэг байдлаар бид бие биедээ хандаж байх ёстойг хүүхдүүд ч, эцэг эх ч мэдэх учиртай. Христ үргэлж бидний үлгэр жишээ байх ёстой. (Эфэс 4:29–32).

Эв найртай гэр бүл бий болгоход залуу эрэгтэйчүүд юу хийж чадах талаар Аароны Пристийн Зэрэгтнээр яриа хийлгэ.

Гэр бүлийн аз жаргалд хүрэх талаар Ерөнхийлөгч Спэнсэр В. Кимболл хэлсэн үгэндээ:” Аз жаргалыг ямар үнээр олж авдаг вэ? гэж та нар асууж магад. Та нар хариулт нь энгийн байгаад нь гайхах болно. Та нар дараах түлхүүрүүдийг хэрэглэвэл аз жаргалын эрдэнэсийн үүд нээгдэж хаагдахгүй байх болно: Нэгдүгээрт, Исүс Христийн Ариун Сургаалын бүх цэвэр нандин энгийн байдлыг нь хадгалан амьдарч, . . . хоёрдугаарт, өөрийгөө мартаж, ханиа өөрөөсөө илүү хайрлаж чаддаг хүмүүст л аз жаргалын ордны хаалга үргэлж нээлттэй байх болно. Хэрэв та нар үүнийг хийвэл, энэ агуу мөнхийн аз жаргал таных болно.” (Гайхамшиг итгэлийг залгамжилдаг, х.126.)

Гэр бүлийн асуудлыг зохицуулахад залбирал ба эелдэг байдал ямар үүрэгтэй вэ?

Нэгэн эх гэр бүлдээ эвтэй найрсаг байдлыг хэрхэн байлгаж чаддаг тухай доор өгүүлнэ:

“Сүмийн Индиан Хүүхдийн Хөтөлбөрийн дагуу бид 10 настай Вэйн гэдэг хүүг гэртээ байрлуулаад долоо хонож байлаа. Тэр хурц ухаантай, хөөрхөн хүү байсан бөгөөд мэдээжийн хэрэг, бусад хүүхдүүдэд өөрийгөө батлах ёстой байлаа. Тэр хамгийн сайнуудад ч мөчөөгөө өгөхгүйгээр хүүхдүүдтэй ойр ойрхон зодоон хийдэг байв.

Нэг өдөр сургуулийн багш нь над руу утастаад Вэйн сургууль дээр өөртэй нь болон бусад багш нартай хүндэтгэлгүй харьцаж байна гэж мэдэгдэв. Энэ нь надад хүнд цохилт болов. Өөрийн хүүхдүүдтэйгээ ийм асуудалд орж байгаагүй учир миний уур хүрч цухалдан Вэйн сургуулиасаа ирэхэд нь хэлэх үгээ бэлдэн суулаа. ‘Оройтойгүй байгаа дээр нь би энэ асуудлыг шийдэх ёстой,’ гэж өөртөө хэлэв.

Гал дээр тос нэмнэ гэгчээр Вэйн хөрш айлын хүүхэдтэй зодолдсоноос болж гэртээ оройтож иржээ. Тэд автобусны буудлаас гэр хүртлээ зодолдсоор гэрийн гадаа ирэхэд нь үнэхээр тоглоомоор бус жинхэнээсээ зодолдож байгааг нь мэдээд гарч Вэйнийг дуудав.

Гэвч тэр намайг хайхрахгүй, нөгөө хүүхдээсээ салах шинжгүй

болохоор нь би тэсэхгүй Вэйнийг гэртээ ор гэж тушаасан. Би маш их уурлаж асуудлыг шийдвэрлэх тэнхээгүй байсан учраас түүнийг өрөө рүү нь явуулав.

Уурласандаа болж чичирсээр би унтлагын өрөөндөө орж өвдөг сөгдөн энэ асуудлыг шийдэх мэргэн ухаан мөн Сүнсний тусламжтайгаар юу хэлэх тухай гуйн залбирсан юм. Залбираад босоход нэгэн тайтгаруулсан мэдрэмж миний толгойноос доошлон хөл хүртэл гүйхыг би мэдрэв.

Би Вэйний өрөөний хаалгыг онгойлгоход, тэр гартаа ном барьчихсан орныхоо захад сууж байгааг нь хараад миний толгойд түмэн бодол орж ирэв. Тэр өмгөр өрөө түүний сууж байх ёстой газар биш байв. Тэр урьдах шигээ чөлөөтэй гүйж харайсан гаднах орчлонд харьяалагдаж байв. Түрхэн зуур миний зүрх тэр ганцаардан байгаа бяцхан хүү рүү тэмүүлж, дасаж өссөн газраас нь өөр дэг журамтай өөр ертөнцөд ирсэн бяцхан хүү бусдаас дээр биш юм гэхэд бусадтай адил гэдгээ харуулах ёстой байсныг би ойлгов.

Би түүний дэргэд очин тэвэрч суугаад өөрөө ч гайхсаар “Вэйн, чамтай ширүүн харьцсанд намайг уучил” гэж хэлэв. Дараа нь би багш нь утсаар ярьсан тухай хэлж түүнд өөрийгөө тайлбарлах боломж өгсөн юм. Тэр надад итгэн үнэнээ илчилж, бид хоёр их дотно шивнэлдэн ярилцсан билээ. Би Тэнгэрлэг Эцэгээс тусламж эрэн асуухаас өмнө төлөвлөж байснаас хамаагүй өөр дуугаар ярьж байлаа. Энэ нь үнэхээр сүнслэг тохиолдол байсан бөгөөд Вэйн бид хоёрын харьцаанд юунаас ч илүүтэйгээр нөлөөлж чадсан юм.

“Хэрэв бид хүсвэл залбирал болон Ариун Сүнсний бэлэг бидэнд зөвлөхөд бэлэн байдаг нь ямар их ачтай зүйл вэ.” (Myrna Behunin, “We Talked in Whispers” *Ensign*, Jan, 1976, x. 51–52.)

Дүгнэлт

Гэр бүлийн асуудлуудал гарахаас сэргийлэх ба зохицуулах хүчин зүйлс—

- Хариуцлагыг Хүлээн Зөвшөөрөх
- Бүдүүлэг үг хэлэхээс зайлах
- Буруугаа хүлээн зөвшөөрөх
- Залбирал
- Эелдэг байдал
- Ариун сургаалыг дуулгавартайгаар бүрэн дагах
- Өөрсдөөсөө илүү ханиа хайрлах

Уриалга

1. Гэр бүлд зөрчилдөөн гарч болох эх үүсвэрийг намжааж гэр бүлээ аз жаргалтай болгох.
2. Гэр бүлийнхээ гишүүнтэй ярихдаа эвгүй үг хэрэглэсэн бол буруугаа хүлээх.
3. Гэр бүлийнхээ гишүүдтэй эелдэг харьцах.

Нэмэлт Судрууд

Матай 7:12 (бусадтай харьцах нь)

Галаачууд 5:22 (Сүнсний үр жимс)

С ба Г 88:119–26 (Сүмийн гишүүдэд зориулсан Их Эзний зөвлөмж)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө

1. *Gospel Principles* гарын авлагаас “The Family Can Be Eternal,” 36-р бүлгийг унш.
2. Самбар, шохой бэлтгэ.
3. Хүсвэл эв найртай гэр бүл бий болгоход залуу эрэгтэйчүүд юу хийж чадах ёстой тухай Аароны Пристийн Зэрэгтнээр яриа хийлгэж болно.
4. “There is Beauty All Around” дууг хичээлийнхээ төгсгөлд дуулахад бэлтгэ.
5. Ангийн гишүүдэд энэ хичээлд байгаа судар, түүхээс танилцуулахыг даалга.

Гэр Бүлийн Санхүүг Зохицуулах нь

Хичээл 21

Энэ хичээлийн зорилго бол бидэнд мөнгөний ухаалаг зохицуулалтын үндсэн зарчмуудыг суралцан хэрэгжүүлэхэд туслах явдал болно.

Оршил

Судрууд дахь мөнгө баялгийн талаарх олон шүлгүүд биднийг эд баялагт бүү шуна хэмээн сэрэмжлүүлдэг. Энэ шалтгааны улмаас олон хүн мөнгө бол нүгэл хилэнц, хэрэв тэд цаг хугацаа, эрч хүчээ мөнгө олох ба хадгалах явдалд зарцуулбал Их Эзэний дургүйцлийг хүргэж магад хэмээн эмээдэг. Гэвч энэ нь буруу: Мөнгө өөрөө бус мөнгийг хайрлах хайр бол “бүх нүгэл хилэнцийн үндэс суурь” юм (1Тимот 6:10үз).

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбол: “Мөнгө болгон бузар бус. Цэвэр ариун мөнгө бий— хоол, хүнс, хувцас, оромж худалдан авах, хандив өргөх цэвэр ариун мөнгө байдаг” хэмээн хэлжээ. Цэвэр ариун мөнгө гэдэг нь бид үнэнч шударга хөдөлмөрийнхөө төлөө хүлээн авсан төлбөрийг хэлж байгаа юм гэдгийг Ерөнхийлөгч Кимболл тайлбарлажээ. Мөнгө нь ямар нэгэн шударга бус байдлаар олж авсан үед л бузар болдог хэмээн тэр хэлсэн билээ. (Faith Precedes the Miracle-аас үз, хх 235–36.)

Чинээлэг ба ядуу тарчиг байдлын аль аль нь хувийн зохистой байдлын шинж тэмдэг биш юм. Бурханы агуу хүмүүсийн зарим нь баян, зарим нь ядуу байсан. Бидэнд буй мөнгөний хэмжээ чухал бус, харин бид үүнийг хэрхэн олж зарцуулж байна гэдэг нь чухал юм. Жишээлбэл, гэр бүлийнхнийхээ бие махбодын хэрэгцээг хангахын тулд мөнгө зарцуулах нь зөвөөр болоод зогсохгүй, үүнийг Бурхан бидэнд тушаасан юм. (1Тимот 5:8 үз). Гэр бүлийнхнийхээ хэрэгцээг хангах зарлиг нь мөнгөний ухаалаг зохицуулалтын үндсэн зарчмуудыг суралцан, хэрэгжүүлснээр үүнийг дуулгавартай дагах явдлыг улам хялбар болгодог.

Мөнгөний Ухаалаг Зохицуулалтын Зарчмууд

Дэлхий дээрх бүх зүйл Их Эзэнд хамаардаг ч гэсэн (Дуулал 24:1 үз) Тэр бидэнд өөрийнхөө дэлхийн зарим нэг зүйлийг ашиглан эзэмшихийг зөвшөөрдөг. Гэсэн хэдий ч Түүний бидэнд ашиглахыг зөвшөөрсөн зүйлд Их Эзэн биднийг хариуцлага бүхий байх хэрэгтэй хэмээн бидэнд сануулсан байдаг. Жишээ нь авьяасын талаарх сургаалт үлгэрээр Аврагч бидэнд энэ дэлхийд байгаа зүйлээ ухаалгаар зарцуулахын чухлыг заасан билээ.

Анги дахь урьдчилан томилсон гишүүнийг Матайн 25:14–30-д буй авьяасын тухай сургаалт үлгэрийг ярихыг хүс. (Исүсийн үед ефдуге буюу авьяас бол мөнгөний нэгж байсан юм.)

Мөнгөө ухаалгаар зохицуулах явдлын талаар бид авч үзэх ёстой хэд хэдэн үндсэн зарчмууд байдаг.

Ярилцаж буй мөнгөний ухаалаг зохицуулалтын зарчим бүрийг самбарт жагсааж бич.

ИХ ЭЗЭНИЙГ НЭГДҮГЭЭРТ ТАВЬ

Бидний хийх ёстой нэн тэргүүний ба хамгийн чухал төлбөр бол аравны нэг юм. Аравны нэгээ итгэлтэйгээр төлж буй тэдгээр хүмүүст Тэрээр тэнгэрийн цонхыг нээж, хүлээн авах өрөөгүй болтол нь адислал асгах болно хэмээн Их Эзэн амласан билээ (Маланкой 3:10). Хэдийгээр Их Эзэн бидний аравны нэг ба өргөлөө төлсөн явдалд маань агуу их эд баялаг амлаагүй ч, Тэрээр биднийг бие махбод ба сүнслэг байдлын аль алинаар нь адислах болно хэмээн амласан билээ.

АЖИЛ

Ажил нь хараал бус, бидэнд гэр бүлээ хангах боломжийг олгодог адислал юм. Баталгаатай материаллаг байдал нь бидэнд зөвхөн тогтвортой ажлаас л ирж чадна. (Энэ гарын авлага дахь 23-р хичээл нь ажил эрхлэх чадвараа сайжруулж хөгжүүлэх зөвлөгөөг агуулдаг.)

ХЭРЭГЦЭЭГҮЙ ӨРНӨӨС ЗАЙЛСХИЙ

Бид найз нөхөдтэйгөө шударга байх ёстой. Бид өртэй бол уг өрөө нэг дор эсвэл бага багаар ч гэсэн тогтмол төлөн өрнөөсөө салах ёстой. Арван Хоёрын Зөвлөлийн Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон, “Орлогынхоо хэрээр амьдарцгаая. Олсныхоо дагуу төлье. . .

Сүмийн удирдлагын зөвлөгөөг анхааран сонсоцгооё. Өрнөөсөө сал” хэмээн хэлсэн юм. (“Pay Thy Debt, and Live” Speech of the Year, BYU, Feb 28, 1962, p.12).

Бид хэрэгцээгүй өрнөөс хэрхэн зайлж чадах вэ?

ЗАРЦУУЛАХААСАА ӨМНӨ ТӨЛӨВЛӨ

Лүк 24:28-ыг унш. “Өртгөө тооц” гэдэг нь ямар утга илэрхийлж байна вэ ?

Энэ сударт бидэнд хэлсний дагуу, мөнгөө зарцуулахаасаа өмнө хянамгай төлөвлөх ёстой. Олон хүн зарлагаа хянадаггүйн улмаас өрөнд ордог. Хэрэв гэр бүл мөнгөө хэрхэн зарцуулахаа төлөвлөвөл тэд санхүүгийн төвөгтэй байдалд орохгүй.

ХАДГАЛ

Мөнгөө хадгалах явдал нь олон хүний хувьд хэцүү байдаг. Гэвч Сүмийн гишүүдийн хувьд биднийг орлогоосоо бага хэсгийг нь хадгал хэмээн зөвлөсөн билээ. Хэрэв бид мөнгө ч бай, материал ч бай орлогоосоо жижиг хэсгийг ч гэсэн хадгалъя гэж шийдвэл, бид

хэзээ нэгэн цагт үүнийг хийсэндээ баяртай байх болно. Хадгалах төлөвлөгөөг бий болгохдоо, бид номлол, ариун сүмд батлуулахаар явах гэх мэт онцгой зорилготойгоор хадгалбал энэ нь хялбар байх болно гэдгийг ойлгох хэрэгтэй.

ХЯНАМГАЙ ЗАРЦУУЛ

Худалдан авах гэж буй зүйл бүрээ бид авахаасаа өмнө түүний чухал эсэхийг хянамгайгаар хэлэлцэх ёстой. Бидний худалдан авдаг олон зүйл бидэнд болон гэр бүлийнхэнд маань үнэн хэрэгтээ ач холбогдолгүй байдаг. Хэрэв бид ямар нэгэн зүйл худалдан авахынхаа өмнө ирээдүйн хэрэгцээнийх нь талаар сайтар бодвол бид онцын хэрэггүй зүйл худалдан авахаас зайлсхийж болно. Бидний бараг олонх маань эдгээр зүйлүүдийн ихэнхэд нь эсвэл аль нэгэнд нь амжилт гаргаж чадна. Хэрэв бид Их Эзэнийг нэгдүгээрт тавьж, мөнгөний ухаалаг зохицуулалтын зарчмуудыг дагавал Их Эзэн бидэнд амжилттай байхад маань туслах болно.

2 Нефай 9:51-ийг унш. Бид уруу татагдан мөнгөө үрэн худалдаж авдаг “хэрэггүй” ямар ямар зүйлс байдаг вэ?

Мөнгөө Зохицуулахдаа Гэр Бүлийн Зөвлөлүүдийг Ашиглах

Ихэнхдээ бид олсныхоо хэрээр мөнгөө зарцуулдаг. Бидний хүсэл бидний орлоготой адил эсвэл түүнээс ч хурдан өсөж байгаа мэт санагддаг. Ийм учраас бид мөнгөө хянамгай төлөвлөх нь маш чухал юм. Гэр бүл бүр хэрэгцээ, хүслээрээ ялгаатай ч, ихэнх гэр бүлүүд дараах төлөвлөгөөг мөрдөх нь ашигтай юм байна гэдгийг олж мэджээ:

“Гэр бүлийн зөвлөл бол төсвөө төлөвлөх тохиромжтой цаг мөн” 21-а үзүүлэнг таниул.

Гэр бүлийн бүх гишүүд санхүүгийн асуудлаа хэлэлцэж, санхүүгийн зохицуулалтаа зөвшөөрөх ёстой. Үүнийг эцэг нь удирдаж гэр бүлийн бусад гишүүд оролцдог гэр бүлийн зөвлөл дээр хийж болно. Энэ зөвлөл дээр гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулсан бүх төрлийн орлогоо гэр бүл жагсаах хэрэгтэй. Энэ жагсаалтанд гэр бүлийн гишүүдийн орлого, талбайн хүнсний ногоо, үр тариа, эсвэл бусдад худалдахаар гэртээ хийж бүтээсэн зүйл зэрэг орж болно.

Тэгээд, гэр бүлүүд эхлээд хамгийн чухал зарлагаа, дараа нь хүсэж байгаа боловч нэн чухал бус эд зүйлээ жагсааж бичнэ. Уг жагсаалтанд Сүмийн хандив, хадгаламж (ариун сүм рүү явах, номлолд үйлчлэх, боловсрол эзэмших зэрэгт зориулсан), татвар ба байр сууц, хоол хүнс, хувцас, багаж, тээврийн хөлс, амралт зэргийг оруулж болно.

Эцэст нь, гэр бүл эд юмс бүрд хичнээн төгрөг зориулж болох талаар санал нэгдэх хэрэгтэй. Жагсаалтын төгсгөлд буй зарим нэг зүйлсийг огт худалдан аваагүй байж болох боловч бид чухал бус



予算

一ヶ月に支給される給料 300000円

一分の金	30000円
取組金	10000円
預金	20000円
食費	30000円
衣類	20000円
住居費	10000円
交通費	30000円
雑費	25000円
税金	20000円
その他	25000円
合計	270,000



зүйлсээ нэгдүгээрт авснаар дараа нь чухал зүйлсээ авах хангалттай мөнгөгүй байхаас илүү, чухал зүйлээ авах нь ухаалаг байж болно. Ерөнхийлөгч Бригхэм Янг нэгэн удаа, “Бидний хүсэж байгаа зүйлүүд олон байдаг боловч, бидний жинхэнэ хэрэгцээ цөөн байдаг. Бид хэрэгцээгүй зүйлд мөнгө үрэх шаардлагагүй болохын тулд хүслээ хэрэгцээгээрээ хянацгаая. (Discourses of Brigham Young p.297-г үз). Ядуурлын өөр нэг шалтгаан нь ухаалаг бус зохицуулалтаас болдог хэмээн тэрээр тайлбарлажээ. Бага орлоготой хүмүүс хэрэгцээгүй зүйлд бага багаар мөнгөө үрсээр нэг мэдэхэд их хэмжээний өрөнд унадаг” гэж тэрээр тэмдэглэжээ. (Discourses of Brigham Young, p. 317-г үз).

“Төсвийн загвар” хэмээх 21-б үзүүлэнг таниул.

Хэрэв бид мөнгөнийхээ орлого зарлагыг сайтар төлөвлөх юм бол асар ихээр адислагдах болно. Зорилго тавин, төлөвлөгөө гаргаж түүнд хүрэхийн тулд хамтран ажиллах нь Их Эзний тушаасан ёсоор гэр бүлээ халамжлах боломжийг (бидэнд) олгоно. Хамтран ажилласнаар гэр бүл нь эв нэгдэлтэй болж, бие биенээ хайрлаж баяр баясгалантай байх адислалыг бас гэр бүлд авчирдаг.

Урьдчилан томилсон ангийнхаа гишүүнээс дараах Өмнөд Номхон Далайд орших Ваха И Тонга хэмээх арал дээр амьдардаг нэгэн гэгээнтний тухай түүхийг ярьж өгөхийг хүс.

“Би өөрийнхөө дөрвөн хүүхэддээ хэрвээ тэд туслах юм бол, бид хамтдаа Ариун Сүмд орж болно гэж амласан. Чи хүүхдүүдтэйгээ Ариун Сүмд батлуулаагүй байж, яаж сайн хүү, сайн охин бай гэж хэлж чадах юм бэ? гэж би өөрөөсөө асуув. Тэд нар минийх биш юм шиг сэтгэгдэл надад төрөв.”

Бүтэн хоёр жилийн турш бид бараг бүх зүйлээ золиослов. Би сургуулийнхаа цалинг хүн нэг бүрт хуваагаад түүнийгээ нөөцлөв. Харин бид Аравны нэг ба Мацаг барилтын мөнгөө төлж байсан. Бидний гарт сар болгон 70 цент үлдэж байв. Би гэр бүлийнхнийхээ хамт хоёр жилийн турш сар болгон 70 центээр амьдарч байлаа. Бид ургуулж цуглуулж байсан зүйлээрээ л амьдарч байв. Миний эхнэр бидний гадил жимс ба наргил модны самрын сүүт салатыг бэлэн болгохын тулд маш эртлэн босч байсныг санаж байна. Хүүхдүүд маань чихэр, гутал авах ч юм уу аль эсвэл кино үзэхээр явж чаддаггүй байв. Яагаад гэвэл тэд Ариун Сүмд орохын тулд мөнгөө хэмнэж байсан юм.

“Золиослолын хүчээр бид гэр бүлээрээ Шинэ Зеландад очиж Ариун Сүмд баталгаа хийлгэх боломжтой болов. Зорилгодоо хүрэхийн тулд бид зарим илүү зүйлийг хийх хэрэггүй байсан бөгөөд харин энэ

Төсөв

Нийт орлого

Аравны нэгийн хууль—10 хувь

Сүмийн хандив

Хадгаламж

Хоол хүнс

Хувцас

Байр

Эмнэлгийн зардал

Тээврийн зардал

Ахуйн хэрэгцээ

Бусад

Бусад

Бусад

Нийт зардал

нь бидэнд гайхамшигтай адислал байсан.” (“We lived on 70 cents a month for the Temple” *Ensign* 2-р сар 1976, х. 31)

Дүгнэлт

Тэнгэрлэг Эцэг маань биднийг мөнгөтэйгөө зөв харьцаж улмаар гэр бүлээ халамжилж аз жаргалтай бай гэж зөвлөсөн. Хэрэв бид гэр бүлдээ халамж тавихгүй бол Их Эзэн бидэнтэй хариуцлага тооцох болно. Гэр бүлээ халамжлахын тулд бид мөнгөө ухаалаг зарцуулах зарчмын удирдамж болон үндсэн алхмуудыг дагах ёстой. Хэрэв бид сүнслэг зүйлсийг эхэнд нь тавибал, Их Эзэн бидэнд санхүүгээ зөв зохицуулахад туслах болно.

Уриалга

Өөрийн бодит зардалдаа шинжилгээ хийж, хичээлд заасан гол санаа болох зарчмуудын дагуу хийж болмоор орлого зарлагын төсөв боловсруул.

Нэмэлт Судрууд

Сургаал үгс 22:7 (Мөнгө зээлэгч зээлдүүлэгчийн зарц нь юм.)

Малакай 3:8–11 (Аравны нэг ба мацаг барилтын төлбөр адислалыг авчирдаг)

Якоб 2:18–19 (Бид баяжихыг эрэлхийлэхийн өмнө Бурханы хаант улсыг эрэлхийлэх ёстой)

С ба Г 56:16–17 (Баян ба ядуучуудад зориулсан сэрэмжлүүлгүүд)

С ба Г 104:11–13 (Дэлхийн адислалуудын төлөө бүх хүн хариуцлага бүхий байдаг)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Пщызуд Экштсшздуу* гарын авлагаас “Work and Personal Responsibility,” 27-р бүлгийг унш.
2. Мөн энэ гарын авлагаас “Developing and Improving Employments Skills”, 23-р бүлгийг унш.
3. Самбар, шохой бэлд
4. Энэ хичээлд холбогдолтой түүх ба судраас танилцуулахыг гишүүдэд даалга.

Гэрийн Үйлдвэрлэл ба Хадгалалт

Хичээл 22

Энэ хичээлийн зорилго бол Пристийн зэрэгтэн бүрт гэрийн үйлдвэрлэл ба хадгалалтын ач холбогдлыг ойлгож хэрэгжүүлэхэд туслах явдал болно.

Оршил

Ерөнхийлөгч Спенсэр В.Кимболл Хожмын үеийн бүх Гэгээнтнүүдэд өөртөө найдах чадвартай, бие даасан бай хэмээн зөвлөсөн билээ. (“Family Preparedness” *Ensign*, 1976, 5-р сар хх 124–126-г үз). Энэ зөвлөмжийг өгөх хэд хэдэн сайн шалтгаан бий. Ерөнхийлөгч Марион Ж.Ромни “Бид хожмын өдрүүдэд амьдарч байна. Бид Их Эзэн Исүс Христийн хоёр дахь [ирэлтийн] өмнөх эринд амьдарч байна. Сэлэсчэл Хаант Улсад бусад ямар ч амьтдаас илүү их эрх чөлөөтэй байхад бэлтгэгдэн амьдар хэмээн бидэнд хэлсэн билээ” хэмээн тайлбарласан юм. (Conference Report, 4-р сар 1975, х 165, мөн С ба Г 78:13–14-г үз.)

“Хэлж ирдэггүй аюул гамшиг бидэнд учирч болно” 22-а үзүүлэнг таниул.

Ерөнхийлөгч Кимболл эртний үеийн бошгууд биелэлээ олж байгаа учраас биднийг бие даах чадвартай болохыг уриалсан билээ.

Тэрээр: “Улам их аюул гамшиг, улам их хар салхи, улам их үер. . . газар хөдлөлт болох цаг ирж байна гэж би бодож байна. . . . Бид төгсгөлдөө ойртох тусам эдгээр нь ихсэх болно гэж би бодож байна. . . Иймээс бид үүнд бэлтгэх ёстой” гэж хэлсэн билээ. (Conference Report 4-р сар 1974, х 184.)

Тэрээр мөн: “Нүгэлт цаг ирэхэд олон хүн жимсний саваа дүүргэж арын талбайн цэцэрлэгээ боловсруулж, жимсний хэдэн мод ба жимсний бут тарьж өргөн хэмжээний хэрэгцээгээ хангахгүй яв даа хэмээн харамсаж болно. Их Эзэн биднийг бусад бүх бүтээлээсээ илүү бие даасан байхаар төлөвлөсөн хэдий ч фермийн эзэд цагаан идээний мухлагаас сүү худалдан авч, гэрийн эзэд цэцэрлэгийнхээ хүнсний ногоог дэлгүүрээс худалдаж авдаг билээ. Мөн ачааны тэргүүд дэлгүүрийн тавиуруудыг бараагаар дүүргэхээ зогсоовол, олон хүн өлсгөлөн явах болно” гэж хэлжээ. (Conference Report 10-р сар 1974 х. 6.)

Дэлгүүрүүд хаагдаж тэд өөрсдийнхөө бүх хэрэгцээг хангах хэрэгтэй боллоо хэмээн ахан дүүсээр төсөөлүүл. Хэрэв тэр төсөөлсөн нөхцөл байдал нь тохиолдвол тэд ямар зүйлтэй байхыг, эсвэл ямар зүйл гэртээ үйлдвэрлэхийг хүсэж буйг асуу.

22-а Хэлж ирдэггүй аюул гамшиг бидэнд учирч болно.



22-a

Хэрэгцээгээ Хангах нь

Ерөнхийлөгч Кимболл “хувийн хоол хүнсээ хангах хамгийн сайн арга барилуудыг суралц . . . Хэрэв гэрт тань хүүхдүүд байвал тэдэнд үүрэг даалгавар өгч уг үйл явцад оролцуул” хэмээн бидэнд сургасан билээ. (“Family Preparedness”, x 124.)

Бишоп Вон Ж.Фидэрстөун бидэнд хэрэв бид өөрсдийн хувийн хэрэгцээгээ хангах хэрэгтэй бол ямар ур чадвараа хөгжүүлэх ёстойг хэлсэн юм: “Гэрийн үйлдвэрлэлийн талаар: Орон нутгийн хуулинд зөвшөөрөгдсөн бол бололцоотой үедээ тэжээвэр амьтан өсгөн үржүүл. Жимсний мод, усан үзмийн мод, жимсний бут ба хүнсний ногоо тариал. Ингэвэл та бүхэн гэр бүлийнхнээ шинэхнээр нь идэх их хэмжээний хоол хүнсээр хангах болно. Тариалж буй бусад хоол хүнсээ та бүхэн гэрийн хадгалалтынхаа нэг хэсэг болгон хадгалж болно. Боломжтой үедээ амьдралынхаа хүнсний бус хэрэгцээнүүдийг үйлдвэрлэ. Шаардлагатай эд зүйлсээ хийх буюу барьж байгуул. Бүх эд хогшлоо гоё сайхан болгож, засаж янзлан торд хэмээн би нэмж хэлж болох юм” (“Food shortage” *Ensign* 5-р сар 1976, x 117.)

Дараах зүйлүүдийг харуулсан үзүүлэнг таниул:

Гэрийн тэжээвэр амьтан өсгөн үржүүлэх.

Жимсний мод, жимсний бут ба усан үзэм тариалах.

Хүнсний ногооны талбай тариалах.

Хоол хүнс хадгалан нөөцлөх.

Шаардлагатай эд зүйлсийг хийх буюу барьж байгуулах.

Эд хогшлоо засаж янзлан тордох.

ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТАН ӨСГӨН ҮРЖҮҮЛЭХ

“Тахиаг өсгөн үржүүлэхэд хялбар байдаг” 22-б үзүүлэнг таниул.

Хэрэв хангалттай газартай бол бид хуулинд зөвшөөрөгдсөнөөр мал аж ахуй эрхлэх боломжтой бол бид зарим нэг амьтдыг худалдан авч өсгөх хэрэгтэй. Бид ямар амьтан өсгөх вэ гэдгээ шийдэхийн өмнө, тэдгээрийг зөв асран тэжээхэд бэлтгэгдсэн байх ёстой. Энэ нь хоол хүнс, байр болон эрүүл байлгахад шаардагдах асаргаа сувилгааг суралц гэсэн үг юм. Өсгөн бойжуулахад хялбар байдаг зарим нэг амьтад бол тахиа, туулай, нугас ба сүүний ямаа зэрэг амьтад юм.

Тухайн бүсэд нийтлэг өсгөн үржүүлдэг мал амьтдын тухай ярилц. Амьтан бүрд шаардлагатай хоол хүнс, байр, асаргааны талаар ярилц.

ЖИМСНИЙ МОД, ЖИМСНИЙ БУТ БА УСАН ҮЗЭМ ТАРИАЛАХ

Жимсний мод, бут, усан үзмийн мод зэрэг нь жил бүр, эсвэл хоёр жилд нэг удаа жимс ургуулдаг учир тэдгээрийг хүнсний ногооны

22-б. Тахиа өсгөж үржүүлэхэд хялбар байдаг.



адил жил бүр тариалах шаардлагагүй байдаг. Тарьсны дараа тэдгээр нь хэдэн жилийн турш жимс ургуулахгүй байж болзошгүй тул бид хамгийн их шаардлагатай үедээ жимстэй байхын тулд уг моднуудыг аль болох эрт тарьж суулгах хэрэгтэй. Тэдгээрийг суулгахын өмнө мод бүрийг гүйцэд ургатал нь аль хир газар шаардагдах вэ гэдгийг, уг моднуудаа хэрхэн зөв арчлах вэ гэдэг талаар сайн суралцах хэрэгтэй.

Тухайн бүсэд ямар төрлийн жимсний мод, усан үзэм, болон жимсний бутнууд сайн ургадаг талаар ярилц. Мод бүрд шаардлагатай асаргааны талаар ярилц.

ХҮНСНИЙ НОГООНЫ ТАЛБАЙ БАЙГУУЛАХ

“Гэр бүл бүр хүнсний ногооны талбай тариалах ёстой” 22-в үзүүлэнг таниул.

Ерөнхийлөгч Кимболл Сүмийн гэр бүл бүрийг хүнсний ногооны талбайтай болохыг уриалсан билээ. Тэрээр хэлэхдээ бид энэ төслөөр мөнгө хэмнэхгүй байсан ч гэр бүл бүр өөрсдийгөө хэрхэн хангах вэ гэдгийг суралцах хэрэгтэй гэсэн билээ. Талбайгаас бид шинэхэн хүнс ногоогоо авахаас гадна бас нөөцлөн хадгалах хүнсээ авдаг юм.

ХООЛ ХҮНСЭЭ НӨӨЦЛӨХ

Зарим улс оронд хоол хүнс нөөцлөхийг хориглосон хууль дүрэм байдаг. Ерөнхийлөгч Кимболл эдгээр улс оронд амьдардаг хүмүүс улс орныхоо хуулийг хүндэтгэн дуулгавартай дагаж дэмжих хэрэгтэй ба хоол хүнс хадгалах ёсгүй гэсэн билээ. (Family Preparedness, х 124 үз). Гэвч хоол хүнс нөөцлөх явдал нь зөвшөөрөгдсөн газар нутагт, бид хоол хүнс олдох боломжгүй цаг хугацаа ирэхэд бэлтгэлтэй байхын тулд Их Эзэний хоол хүнс нөөцөл гэсэн зөвлөмжийг дагах ёстой. 1974 онд Гондурасыг хар шуурга нэрвэхэд, хоол хүнсээ хатаан нөөцөлсөн Сүмийн гишүүд үүнийг хийсэндээ талархаж байжээ. Хар шуурга болохоос хэдхэн сарын өмнө номлолын ерөнхийлөгч нь тэднийг нүүрлэсэн аюулаас сэрэмжлүүлж, хүнс нөөцлөх хөтөлбөрөө эхлэхийг уриалжээ. Хадгалсан эрдэнэ шиш, гурил, будаа ба бусад хоол хүнс нь Гэгээнтнүүдийг өлсгөлөнгөөс аварчээ. (Брюс Б.Чалмэн, “Hurricane in Honduras”-ийг үз. *New Era* 1-р сар 1975 х. 31.)

Хоол хүнсээ хадгалан нөөцлөх хэд хэдэн арга байдаг. Бид— Газар дор нөөцөлж болно. Бидний хадгалах гэж буй газар маань сэрүүн ба хуурай бол энэ арга нь үндсэрхэг ногоо, зарим нэг хүнсний навчлаг ногоо зэрэгт тохирох сайн арга юм. Хэт их бороо эсвэл хуурайшил нь тэдгээрийг муутгана.



Тэдгээрийг хатаа. Уур амьсгал дулаан, нарлаг байвал, жимс ба хүнсний ногоог наранд хатааж болно. Ганц асуудал бол бороо орж буй үед тэдгээрийг бүтээх эсвэл дотогш оруулах хэрэгтэй.

Шилэн саванд хий. Энэ арга нь энгийн боловч буруу хийвэл аюултай байдаг. Хэрэв зөв хийсэн бол шилэн саванд хүнс хийж амтлан хадгалах нь тохиромжтой сайн арга юм. Зөв савлах арга нь хүйтнээр нь савлахыг шаарддаг. (Холбогдох тоног төхөөрөмжийг хэд хэдэн гэр бүлүүд дундаа хэрэглэж болно). Энэ арга нь мөн шилэн савнуудыг хагарч эвдрэхээс хамгаалахыг шаарддаг.

Давслах эсвэл давсны уусмалд хий. Энэ нь жимс, ногоо, мах зэргийг хадгалахад тохиромжтой хямд төсөр арга ба тоног төхөөрөмж бага зэрэг эсвэл бараг хэрэггүй байдаг.

ШААРДЛАГАТАЙ ЭД ЗҮЙЛСЭЭ ХИЙЖ ЭСВЭЛ БАРЬЖ БАЙГУУЛ

Хэрэв бид байгалын гамшигтай тулгарвал хоол хүнс хийх, гэр орноо дулаацуулах, хувцас хунар, бие ба орчин тойрноо угааж цэвэрлэхэд бэлтгэлтэй байхыг хүсэх болно. Энэ шалтгааны улмаас бид түлш шатахуун ба саван нөөцлөх, эсвэл онц аюулын үед тэдгээрийг хийж сурах нь онц чухал юм. Мөн анхны тусламжийн нэр төрөл, зөвлөсөн эм тариа, саван болон цэвэрлэгээний бусад зүйл, лаа, шүдэнз, ба гэр бүлийн сайн сайханд зориулсан шаардлагатай бусад бүх эд зүйлс нь чухал юм. Боломжтой үедээ бид эдгээр зүйлийг нөөцлөөд зогсохгүй, тэдгээрийг үйлдвэрлэхийг суралцах хэрэгтэй.

ЭД ХОГШЛОО ЗАСАЖ ТОРД

Бид мөн онц аюул тулгарсан үед гэр, зоорь, эсвэл малын хашаа зэргээ сэргээн барих шаардлагатай тулгарч болно. Гэр бүлийн гишүүд маань мод ба барилгын бусад материалтай ажиллахыг суралцаж, багаж төхөөрөмж ашиглаж сурах нь чухал юм. Ингэснээр тэд гэрийн тавилга ба бусад хэрэгцээтэй эд зүйлсээ засаж чадах болно. Бид эд хогшлоо засаж янзлан тордохыг сурснаараа цаг хугацаа ба мөнгөө хэмнэж, бусдын эрхшээлд орохоос зайлж чадна.

Эд хогшлоо сайнаар нь байлгах явдал яагаад чухал вэ?

Шинэ Ур Чадварт Суралцах нь

Бидний зарим нэг нь ур чадварт суралцаж, ингэснээр бусаддаа заах боломжтой болдог. Хэрэв бидний хэн нь ч суралцаагүй зүйл байвал, бид түүнийг ном, сэтгүүл, дамжаа, засгийн газрын ажилчид, эсвэл сургуулийн хөтөлбөр зэргээс суралцаж чадна.

Бидний хэн нь бусад заах ур чадвартай вэ? Бидний суралцахыг хүсэж байгаа ур чадварыг бидэнд зааж чадах тэдгээр хүмүүс хаана байна вэ? Ашигтай ур чадварт суралцуулахын тулд сургуулийнхаа аль дамжаанд суралцахыг бид хүүхдүүддээ уриалах вэ? Эдгээр ур чадварт гэр бүлийнхнээ сургахын тулд бид тэднийг хэрхэн уриалж чадах вэ?

Дүгнэлт

Бэрхшээл ба сорилтууд бол дэлхий дээрх бидний ердийн тохиолдлуудын нэг хэсэг юм. Хэрэв бид өөрсөддөө санаа тавин хоол хүнс үйлдвэрлэж сурвал, бид хэцүү цаг мөчөөс айхгүй байх бөгөөд бид үүнд бэлтгэгдсэн байх болно. Их Эзэн хэлэхдээ “Та нар бэлтгэлтэй байвал айх юмгүй байх болно,” гэсэн билээ. (С ба Г 38:30).

Уриалга

1. Эхнэр ба гэр бүлийнхэнтэйгээ гэрийн үйлдвэрлэл ба хадгалалтын тухай ярилцах цагийг энэ долоо хоногт товл.
2. Жилийн хэрэгцээнд тань ямар зүйл шаардлагатай болохыг тогтоо.
3. Тариалалт эхлэх буюу үргэлжлүүлэх, ур чадварт суралцах, эсвэл өөр нэгэн төсөл дээр ажиллаж гэр бүлийнхнийхээ хэрэгцээг хангах төлөвлөгөө боловсруул.

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Төрийн ажилчид ба дадлагажсан хүмүүстэй дараах зүйлийн талаар ярилц:
 - А. Танай бүсэд ямар төрлийн мал өсгөдөг ба алийг нь өсгөхөд илүү хялбар байдаг талаар мэдэж ав.
 - Б. Танай бүсэд ямар төрлийн жимсний мод, усан үзэм ба бутнууд сайн ургадаг мөн ямар төрлийн арчилгаа шаардагддаг талаар мэдэж ав.
 - В. Гэр бүлийн гишүүдэд гэр орон, тавилга ба бусад шаардлагатай зүйлийг хийхийг заадаг дамжаа байдаг эсэхийг мэдэж ав. Хэрэв тийм дамжаа байдаггүй бол эдгээр ур чадваруудыг эзэмшсэн дуртайяа тэдэнд заах хүмүүсийг ол.
2. Хичээлд дурьдсан үзүүлэнг бэлд.
3. Хичээл дэх түүх ба судруудыг уншиж танилцуулахыг ангийн гишүүдэд даалга.

Ажлын Ур Чадвараа Хөгжүүлэн Сайжруулах нь

Хичээл 23

Энэ хичээлийн зорилго бол бидэнд Их Эзэний хөдөлмөрт тавьдаг чухал шаардлага, ажил албаа хэрхэн ухаалгаар сонгох, ажлын ур чадвараа хэрхэн сайжруулахыг ойлгох явдал болно .

Оршил

Уналтын дараа Адамд өгсөн анхны бичигдсэн зааварчилгаа бол хөдөлмөрийн тухай мөнхийн зарчим байсан юм. Их Эзэн Адамд “Газар шороондоо эргэж очих хүртлээ духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ” гэж хэлсэн билээ. (Эхлэл 3:19 үз).

Тэнгэрлэг Эцэг маань бидэнд үүнтэй нэгэн адил зарлигийг өгсөн юм. Сүмийн Тэргүүн Зөвлөл “Бид хөдөлмөрлөх шаардлагатай нь адислал юм. Иймээс бид үүнийг гомдол гаргалгүй хүслээрээ хийх ёстой” хэмээн тунхагласан билээ. (First Presidency Urges Frugality, “*Ensign*”, 3-р сар 1975 х 75). Ажил хөдөлмөр бол мөнхийн амьдралд хүрэх түлхүүрүүдийн нэг юм. Бидний хайрт ухаалаг Тэнгэрлэг Эцэг маань хялбар амьдралаас илүү ажил хөдөлмөрийн амьдралаас бид илүү ихийг суралцаж, улам их өсөн, олон зүйлд хүрч улам их ашиг олох болно гэдгийг мэддэг билээ.

“Хөдөлмөр бол Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгсөн адислал юм” 23-а үзүүлэнг таниул.

Ажлаа Ухаалгаар Сонгох нь

Ажил мэргэжлээ сонгох нь маш чухал юм. Бид баримтуудыг цуглуулж, залбиралтайгаар шийдвэрүүдийг гаргаж, туршлага дадлага олж авсныхаа дараа гэр бүлийнхээ хэрэгцээг хангахад маань биднийг бололцоотой болгох ажил албыг эрж судлах хэрэгтэй. Дараах дөрвөн шатыг салбарт жагсааж бич.

БАРИМТУУДЫГ ЦУГЛУУЛ

Бид залуудаа бидний авьяас, чадвар ба сонирхолд нийцсэн хамгийн сайн тохирох ажил албыг тодорхойлох хэрэгтэй. Бид ямар нэг сонирхолтой зүйлээ хийвэл илүү их амжилтанд хүрэх болно гэдгийг бид ухаарах нь чухал юм. Бидний зарим нэг нь хийж буй ажил албаа сонгох боломжгүйгээр уг ажлаа эртнээс хийж байгаа хэдий ч, ажил байдлаа сайжруулахын тулд ижил төрлийн шатуудыг мөрдөж чадна.

Ажил мэргэжлээ сонгохын өмнө, бид уг ажил хэр ирээдүйтэй талаар тунгаан бодох хэрэгтэй: Дэлхий үргэлж өөрчлөгддөг улмаас

23-а. Хөдөлмөр бол Тэнгэрлэг Эцэгээс бидэнд өгсөн адислал юм.



олон ажил алба оршин байгаа больж, өөр ажлууд шинээр бий болдог. Бид бодож эргэцүүлж байгаа ажил албаныхаа ирээдүйн талаар мэдэх нэг арга бол бид үүнийхээ талаар найз нөхөд, хамаатан садан, пристийн зэрэгтэн ах нар ба Сүмийн удирдагчдаасаа асуух явдал юм. Зарим хотуудад туслаж чадах ажил албаны талаарх зөвлөх буюу албууд байдаг. Худалдааны сургуулиуд, дунд сургуулиуд ба их сургуулиуд нь бидэнд аль ажил нь илүү боломжтойг хэлж өгч чаддаг. Сонин сэтгүүлийн “Тусламж хэрэгтэй” гэсэн буланд ямар ажил илүү их эрэлт хэрэгцээтэй байгааг мэдэхэд тусалдаг.

Бид ажлаа сонгохдоо Сүмтэй ойр байхад маань туслах ажлыг эрж хайх хэрэгтэй. Биднийг гэр орноос маань удаан хугацаагаар хол байлгах эсвэл биднийг ариун сургаалаар бүрэн дүүрэн амьдрах ёстой байдалд маань саад болох зарим нэгэн ажлууд байдаг. Бид ажил төрлөө хянуур сонгосноор иймэрхүү нөхцөл байдлаас зайлж чадна. Хэрэв бид өөрсдийн эрхэлдэг ажилдаа сэтгэл ханамжгүй байгаагаа мэдвэл бид өөрсдийгөө өөр ажилд ороход бэлтгэж болно.

“Хэрэв бид асуувал Их Эзэн бидний ажлын сонголтыг маань батлах болно”
23-б үзүүлэнг таниул.

ЗАЛБИР

Бид ажил хайж байхдаа Их Эзэний тусламжийг эрэлхийлэх нь маш чухал билээ. Бид шийдвэрээ гаргах ёстой ч, хэрэв бид чин сэтгэлээсээ залбирвал Их Эзэн бидэнд ухаалгаар сонгоход маань туслах болно. Гэвч залбирал нь дангаараа хангалттай бус юм. Ерөнхийлөгч Бригхэм Янг: “Их Эзэн биднийг шарсан гахайн мах, цөцгийн тос түрхсэн талхаар хангах болно . . . гэсэн бодол уруу миний итгэл намайг хөтөлдөггүй. Тэр бидэнд үр тариа ургуулах, дэлхий дээрх жимсийг хүртэх, байр сууц хийх чадварыг өгөх болно.” гэжээ (Discourses of Brigham Young х. 291).

Эцсийн шийдээ гаргахдаа бид залбирч, Ариун Сүнсээр удирдуулж байгаагаа мэдэж байх үед маань ирдэг амар амгаланг оюун санаандаа хүлээн авах хэрэгтэй. Дараа нь бид өөрсдийн шийдвэрээ хэрэгжүүлэх хэрэгтэй. Өөрийн амьдрал ба ажлаа өөрчлөхийн тулд эдгээр зарчмуудыг ашигласан нэгэн ах бол Японы Тайшо Комура билээ.

Дараах түүхийг унш:

Тайшо Комура Японд үсчиний ажил хийдэг байжээ. Нэг өдөр тэр номлогчидтой уулзаад хожим нь усаар батлуулсан билээ.

Ярилцлагынхаа үеэр тэрээр Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь байлгах тухай суралцжээ. Хүндэтгэлийн өдөр үсчингийн газрын



хамгийн их ажилтай өдөр байжээ. Ингээд Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь байлгах бэрхшээлийн талаар залбирсны дараа тэр ажил албаа өөрчлөхийн тулд сургуульд элсэн оржээ.

Хэд хэдэн ангийн гишүүнээс залбирал тэдэнд сайн шийдвэр гаргахад нь хэрхэн тусалсан тухай ярихыг хүс.

АЖЛЫН УР ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛ

Ур чадвараа хөгжүүлэх нь цаг хугацаа ба хичээл зүтгэл шаарддаг, 23-в үзүүлэнг таниул.

Ажлын ур чадвараа хөгжүүлэхэд цаг хугацаа хичээл зүтгэл шаарддаг. Хэрэв бид ажлынхаа нөхцөл байдлыг сайжруулахыг хүсвэл бид шаардлагатай ур чадвар ба дадлага олж авахын тулд сурч хөдөлмөрлөх хүсэлтэй байх хэрэгтэй.

Харилцааны дамжаа, мэргэжил олгох дамжаа, мэргэжлийн сургуульд суралцах болон гарын авлагууд ба ном зэрэг нь бүгд бидэнд ур чадвараа хөгжүүлэхэд маань туслах болно.

Чадвартай ажилчинг хөлслөгчтэй хийх ярилцлага, ажлын байруудаар айлчлах мөн янз бүрийн ажил хийх зэрэг нь бидний мэдлэг ба ур чадварыг дээшлүүлэх болно.

Ажил олоход тусалдаг хоёр үндсэн ур чадвар бол унших, бичих явдал юм. Хэрэв бид ажил хайж байхдаа уншиж, бичиж чадахгүй бол чаддаг хүнээсээ тусламж эрэх хэрэгтэй. Бид Сүмийн нөхөд, гэр бүлийнхэн ба нийгмийнхээ бусад ямар ч хүний мэдлэг ба мэдээллийг ашиглахдаа эргэлзэх ёсгүй.

Бид чуулгынхаа ахан дүүстэй ямар ур чадвар ба авьяасаа хуваалцаж чадах вэ? Урьдчилан даалгасан хүнээр тухайн бүсэд боломжтой байдаг ажлын талаарх мэдээлэл хийлгүүл.

Бидэнд хүрэх ёстой зорилго байвал, бид түүндээ хүрэхийн тулд хувийн асар том золиослол хийхэд бэлтгэгдсэн байх ёстой. Энэ нь ур чадвараа хөгжүүлэхэд шаардлагатай бүхнийг хийх хүсэлтэй байна гэсэн үг юм. Амжилт нь зөвхөн бид шаардлагатай зүйлүүдээ биелүүлж, түүндээ хүрэхийн тулд шаардагдах хичээл чармайлт гаргасан үед л ирдэг билээ. “Хүн тарьснаа л хурааж авдаг” (Галат 6:7) хэмээн Паул заасан.

Дараах түүх нь Өмнөд хэсгийн Номхон далай дахь Сүмийн гишүүн ажиллах ур чадвараа сайжруулж гэр бүлийнхнээ тэжээх хичээл зүтгэлээр хэрхэн амжилт олсныг өгүүлэх болно.

Вилиали Хавили залуу байхдаа л ирээдүйн гэр бүлээ тэтгэхэд нь боломж олгох ур чадваруудыг суралцаж сайжруулахад хувийн хичээл зүтгэл маш чухал болохыг сурч мэдэж авчээ. Эцэст нь гэрлэснийхээ дараа Хавили ах хямд үнээр зарах газар худалдаж

23-в. Чадвараа хөгжүүлэх явдал нь цаг хугацаа ба хичээл зүтгэлийг шаарддаг.



авахын тулд хүрэлцээтэй мөнгө олж хадгалахын төлөө шаргуу хөдөлмөрлөв.

Түүний худалдаж авсан газар нь дов толгодтой газар байсан ба үр тариаг салхи сүйтгэхээр далайн ойролцоо байсан учраас нэг их сайн газарт тооцогддоггүй байв. Гэвч тэрээр уг газрыг тариаланд бэлтгэхийн тулд маш шаргуу ажиллав. Тэрээр мөн аж ахуй эрхлэлтийн сүүлийн үеийн аргыг суралцахад их хугацаа зарцуулжээ. Түүний мэдэх шаардлагатай зарим нэг мэдээлэл нь зөвхөн франц номнуудад байсан тул газар тариалангийн талаар юу сургасныг уншиж чадахуйц франц хэлийг бие даан сурчээ.

Эдгээр номнуудаас тэрээр тухайн бүс дэх өөр бусад олон аж ахуйтнуудын хэзээ ч сурахыг эрмэлзээгүй хөрс хэрхэн бордох аргыг сурчээ. Тэрээр хорхой шавьжийг устгахад мөн ургамлын өвчнийг эмчлэхэд зарим нэг химийн бодисыг хэрхэн хэрэглэхийг суралцжээ. Тэрээр мөн ямар ургааг нь гүйлгээ сайтай ба өндөр үнээр экспортлогдож байгааг олж мэджээ. Мэдээж хэрэг, өөрийн нөр их хичээл зүтгэл ба Их Эзэний тусламжтайгаар Хавили ах амжилттай аж ахуйтан болжээ.

Манай бүсэд ажил албаны ямар ямар боломжууд байдаг вэ?

Бид шаардлагатай ур чадварт өөрсдийгөө бэлтгэсэн үед л эдгээр ба бусад ажлууд бидэнд боломжтой байх болно.

АЖИЛ ЭРЖ СУДАЛ

Боловсрол эзэмшсэн хүн боломжтой ажил олгогчтой холбоо тогтоогоогүй цагт ажил олж чадахгүй. Үүний адил өөрөө ажил эрхэлдэг хүн өөрийн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг үйлчлүүлэгч олох хүртлээ худалдаж үйлчилж чадахгүй. Ажил эрхэлдэггүй пристийн зэрэгтэн идэвхтэйгээр ажил эрэх үүрэгтэй байдаг.

Үүнийг олох нь хэцүү юм шиг түүнд санагдвал, тэрээр пристийн зэргийн чуулгаасаа тусламж авах хэрэгтэй байж болно. Сүмийн нэгэн удирдагч “Пристийн зэргийн чуулгаар дамжуулан ажлынхаа орон тоо ба хүсэлт гаргах мэдээлэл хангагдах ёстой. Манай чуулгууд ажил хэрэгтэй эсвэл арай дээр ажил хайж байгаа хүмүүсийг тодорхойлж, гишүүддээ ажил эрхлэх боломжтой болоход нь туслахын тулд хийж чадах бүхнээ хийх хэрэгтэй” гэж хэлжээ.

(Ховард В.Хантэр, Prepare For Honorable Employment, *Ensign* 11-р сар 1975 х 123.)

Чуулгын гишүүдийн хувьд бид ахан дүүстээ ажил олоход нь туслахын тулд юу хийж чадах вэ?

Ажиллах Зуршлаа Сайжруулах нь

Төлөөлөгч Пол Сүмийн ахан дүүст “Ажилдаа бүү хойрго ханд” (Ром 12:11) хэмээн зөвлөсөн билээ. Бид үргэлж бүх чадлаараа хичээж

ажиллах зуршлаа сайжруулах арга замыг эрж хайж байх ёстой. Үүнийг хийхийн тулд бид ажил хөдөлмөрийн талаар сайн чиг хандлагатай байх ёстой. Дараах хяналтын жагсаалт нь зарим нэг маш чухал ажиллах зуршлыг оюун ухаандаа байнга бодож байхад маань тусалж болох юм.

- Би цагаа үр бүтээлтэй ашигладаг уу?
- Би ажил олгогч, дарга ба хамтран ажиллагсадтайгаа хамтран ажилладаг уу?
- Би ажлынхаа хэрэгсэл, эд хөрөнгийг хувийн эсвэл сүмийн хэрэгцээнд зөвшөөрөл авалгүй, эсвэл мөнгийг нь төлөлгүй ашигладаг уу?
- Би ажилдаа ирэхдээ болон үдийн завсарлагаанаасаа буцаж ирэхдээ товлосон цагтаа ямагт ирж чадах уу?
- Би ажил үүргээ өөрийнхөө мэддэг хамгийн сайн аргаар хийж гүйцэтгэдэг үү?
- Би дарга, ажил олгогч хамтран ажиллагсадтайгаа эелдэг харьцдаг уу?

Дараах түүхийг унш:

Ерөнхийлөгч Хибэр Ж.Грант өсвөр насандаа ажлын ур чадвараа сайжруулах ба илүү их хичээл чармайлт гаргах нь чухал болохыг сурч мэджээ. Нэг өдөр тэрээр найз хөвгүүдтэйгээ бөмбөг тоглож байгаад банкны нягтлан бодогч явж байхыг харжээ. Хөвгүүдийн нэг нь “Энэ хүн сард 150 долларын цалин авдаг” гэв. Хибэр дотроо хэрэв би сард ийм хэмжээний мөнгө олох хэрэгтэй бол өдөр бүр 120 хос гутал тослох хэрэгтэй юм байна хэмээн бодов. Ингээд тэрээр тэнд байхдаа нь хэзээ нэгэн өдөр банкны нягтлан бодогч болно хэмээн шийджээ.

Тэр үед банкны бүх тооцоо бүртгэлүүдийг үзгээр бичдэг байжээ. Ингээд сайн нягтлан бодогчоос шаарддаг шаардлагуудын нэг бол сайн бичиж чаддаг байх явдал байв. Энэ ажилд орохын тулд Хибэр эхлээд бичих чадвараа сайжруулав.

Эхэндээ түүний бичих чадвар маш муу байсан учир найз нөхөд нь түүгээр доог тохуу хийдэг байв. Энэ явдал түүний бардам занг нь хөндөж, тэрээр “Хэзээ нэгэн өдөр найз нар минь би та нарт хэл бичгийн хичээл заах болно” хэмээн хэлэв. Түүний ур чадвараа хөгжүүлэх хичээл зүтгэлийн үрээр тэрээр их сургуулийн хэл бичгийн багш болжээ. Тэрээр мэндчилгээний үг, хуримын мэндчилгээ, даатгалын гэрээ, хөрөнгийн гэрчилгээ ба хуулийн бичиг баримт зэргийг бичдэг байжээ.

Тэр хэлэхдээ, “Нэг удаа би Шинэ жилийн өдөр “Шинэ жилийн мэнд хүргэе” гэж бичээд буланд нь хүний нэр бичсэн 40 багц мэндчилгээ

бичиж 20 доллар олж байсан. Дараагийн Шинэ жилийн өмнөх орой болоход би албан өрөөндөө дэндүү орой болтол суугаад бас л мэндчилгээ бичиж байв. Миний дарга болох ноён Вадсворф орж ирээд хийж буй ажлыг маань хараад сайн байна хэмээн хэлсэн билээ. Тэр ямар ч мөнгө авалгүйгээр миний номнуудад зөвлөгөө өгүүлэхээр тэдгээрийг өөр нэгэн компани уруу илгээсэн билээ. Тэр намайг маш ихээр баярлуулсан олон сайшаалын үг хэлдэг байсан юм. Тэр дараа нь миний илүү цагийн ажлыг хоёр дахин нугалж болохуйц 100 доллар надад төлсөн юм. Даргынхаа итгэл ба талархлыг хүлээсэн намайг эзэмдсэн баяр баясгалан нь 100 доллараас хоёр дахин илүү үнэ цэнэтэй байлаа.” (Брайэнт С. Хинкли, Хибэр Ж. Грант: Highlight in the life of a Great Leader, х.х. 39–42 үз.)

Дүгнэлт

Хөдөлмөрлөх чадвар бол адислал юм. Их Эзэн бошиглогчдоороо дамжуулан бидэнд хэлэхдээ бид хөдмөрлөж гэр бүлийнхнээ тэтгэх нь бидний үүрэг хариуцлага юм гэсэн билээ. Бид ажиллах сайн зуршил ба ур чадварыг дадлага туршлагатай хүмүүсээс сурдгийн нэгэн адил ажил дээрээ бас сурч чадна. Үр ашигтай ажил олохын тулд бид баримт цуглуулж шийдвэрийнхээ төлөө залбирч, ажлын ур чадвараа дээшлүүлэх ёстой.

Уриалга

Энэ бүлэгт байгаа хөдөлмөрлөх зуршилтай холбоотой хувь хүний хийх ёстой ажлын хувийн жагсаалтанд дурдсан хэсгүүдээс нэгийг нь өөрийн болго.

НЭМЭЛТ СУДРУУД

С ба Г 31:5 (Хөдөлмөрлөгсөд ажил хийхээр зохистой)

С ба Г 42:42 (Залхуу хүн хөдөлмөрч хүний адислалуудыг авч чадахгүй)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Work and Personal Responsibility,” 27-р бүлгийг унш.
2. Энэ гарын авлага дахь “The Father’s Responsibility for the Welfare of His Family,” 12-р хичээлийг давт.
3. Самбар, шохой бэлд.
4. Та хүсвэл ангийн гишүүдэд, тухайн бүсэд хөдөлмөрлөх боломж ба чадвараа сайжруулах боломжтой ямар сургууль ба албан газрууд байгаа талаар олж мэдэхийг даалга.
5. Хичээл дэх түүх ба судруудыг танилцуулахыг ангийн гишүүдэд даалга.

Энэ хичээлийн зорилго бол бидэнд биеэ эрүүл байлгах нь яагаад маш их чухал болохыг ойлгоход маань туслах явдал болно.

Оршил

Бидний дэлхий дээр ирсэн нэг шалтгаан бол бие махбодтой болох явдал юм. Ерөнхийлөгч Бригхэм Янг, “Бидний мөнх бус бие маань бидэнд маш их чухал; биегүйгээр бид ирээдүйн мөнхийн амьдралд хэзээ ч алдаршиж чадахгүй” хэмээн тунхагласан билээ (Discourses of Brigham Young, х.56).

Бидний бие махбод мөнхөд алдарших хэдий ч (Алма 11:42–44 үз), энэ амьдралд бие маань өвчин эмгэг ба гэмтлээс болж өвдөж шаналдаг. Зарим нь түр хугацаагаар тахир дутуу болдог. Зарим нь амьдралынхаа туршид тахир дутуу байдаг. Гэвч тэдний нөхцөл байдал ямар ч байсан бидний бие махбод төгс төгөлдөр болон өсөж хөгжихөд маань тусалдаг тул чухал билээ.

Хүн бол сүнс ба бие махбод хоёроос бүтсэн бүтээл юм. Ийм учир сүнслэг байдал ба бие махбод нь салшгүй холбоотой. Сүнслэг ба оюун ухааны бүтээл нь бие махбодын дэмжлэг ба хүч чадалгүйгээр бүрэн гүйцэд чадавхитай байж чадахгүй. (С ба Г 93:33–34 үз). Гэвч энэ байдлыг үл хайхран пристийн зэрэгтэн олон хүмүүс өөрсдийгөө сүнслэг ба оюун санааны байдлаараа хөгжүүлээд, харин бие махбодоо хөгжүүлэхээ умартдаг юм.

Ерөнхийлөгч Дэвид О.МакКэй “Бие махбоддоо санаа тавьдаг эрүүл хүн хүч чадал ба амьдрах тэнхээтэй байдаг; түүний ариун сүм бол сүнс нь байрлахад тохиромжтой газар юм. . . Бие махбоддоо санаа тавьж эрүүл мэнд ба аз жаргалын хуулиудыг дуулгавартай дагах нь зайлшгүй чухал юм,” гэсэн билээ. (“The whole man” Improvement Era, 4-р сар 1952, х. 221.)

Эрүүл Байхын Ашиг Тус

Дараах зүйлүүд нь эрүүл бие махбодтой байхын зарим нэг ашиг тусыг харуулж байна:

БИД УЛАМ САЙН ҮЙЛЧЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА

Бид эрүүл саруул байх тусам төдий чинээ бусдад үйлчилж тэдэнд ба өөрсөддөө аз жаргалыг авчирах чадалтай байна.

БИД ИЛҮҮ САЙН УДИРДАГЧ БАЙНА

Удирдагч хүнд тавьдаг шаардлагын үүднээс, тэр хүч чадал ба эрч хүчтэй байх хэрэгтэй. Түүний дуудлага түүнийг боломжтой л бол эрүүл бай хэмээн шаарддаг.

БИД ӨӨРСӨДДӨӨ БА БУСДАД СЭТГЭЛ ӨНДӨР БАЙХ БОЛНО

Бид бие махбодоо эрүүл байлгавал, бид өөрсөддөө сэтгэл өндөр байж ажилдаа дур сонирхолтой байх болно. Бид мөн бусдыг хайрлаж тэдэнд эелдэг, тэвчээртэй хандах болно.

БИД ӨӨРСДИЙГӨӨ ТЭТГЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА

Бидний бие махбод эрүүл байх тусам, бид сайн ажиллах бололцоотой байж өөрсдийгөө ба гэр бүлийнхнээ тэтгэх болно.

Эрүүл Мэндээ Сахих нь

Эрүүл мэндийн ихэнх асуудлууд бол бохир орчин, өвчин эмгэг, илүү жин, ядмаг хоол хүнс, ядаргаа сульдаа ба дасгалын дутагдалтай байдлын үр дүн юм. Хаана амьдардгаасаа үл шалтгаалан бид эрүүл мэндийн эдгээр асуудлуудад өртөгдөж болох юм. Мэдээж хэрэг эрүүл мэндийн эдгээр асуудлуудыг шийдэх, тэдгээрээс сэргийлэхийн тулд бид хувийн эрүүл мэндийн асуудлуудын талаар олж мэдэх хэрэгтэй. Үүнийг сурсныхаа дараа бид цагийн хуваарьт тохирсон, биднийг эрүүл саруул бие махбодтой байлгахад туслах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хувийн эрүүл мэндийн хөтөлбөрөө боловсруулахад маань туслах газар бол орон нутгийн эрүүл мэндийн төв юм.

Урьдчилан томилогдсон ангийн гишүүнээр орон нутгийн эрүүл мэндийн төвөөр явж олж мэдсэн зүйлийнх нь талаар яриул.

Бидний хувийн ба гэр бүлийн эрүүл мэндийн хөтөлбөр нь дараах зүйлсийг оруулах ёстой:

МЭРГЭН УХААНЫ ҮГЭНД ДУУЛГАВАРТАИ БАИХ НЬ

Их Эзэн бидэнд хэрэглэж хүртэж болохгүй тодорхой хэдэн зүйл байдаг хэмээн хэлсэн билээ. Үүнд тамхи, кофе, цай, согтууруулах ундаа ба зарим нэг хоол хүнс ордог. Нөгөөтэйгүүр, Тэр биднийг бие махбодоо тордохын тулд зарим нэг хүнсийг хэрэглэх ёстой хэмээн зөвлөсөн билээ. Мэргэн Ухааны Үгийг мөрдсөн хүмүүст эрүүл мэнд, мэргэн ухаан ба хамгаалалт амлагдсан билээ (С ба Г 89:18–21 үз).

С ба Г 89: 1–17-оос Мэргэн Ухааны Үгийн агуулгын талаар ярихыг ангийн гишүүнээс хүс.

Дараах түүх Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагаснаар ирдэг зарим нэг адислалуудын тухай өгүүлдэг юм.

“Одоогоос 60 жилийн өмнө би арван хоёр нас арай хүрээгүй байхдаа аавынхаа хамтаар тариа хураах ажил хийж байсан юм. Тэр үр тариа хадаж би түүнийг нь багладаг байсан бөгөөд өдрөөс өдөрт энэ нь биднийг ядраадаг байлаа.”

Нэгэн бямба гаригт бид үүр цайхад (ажлаа) эхэлж тэр оройноо 8:30-ийн үед дуусгаж билээ. Би маш их ядарч, оройн хоолоо ч хүлээлгүй унтахыг хүсэж байлаа.

“Аав маань над уруу хараад намуухнаар” Ли, өнөөдрийн миний хадсан тариа их ногоон байсан. Хэрэв бид үүнийг [баглахаа] Даваа гариг хүртэл хойшлуулбал, үр нь агшчихна. Бид үүнийг өнөөдөр дуусгах ёстой. Гадаа сарны гэрэл тод байна. Чи надад тусалж чадна гэж бодож байна уу?” гэв.

“Би нулимсаа нуун толгой дохив.

Миний эцэг, “За, тэгвэл жаахан хоол идчих” гэв.

“Удалгүй бид сүү талхаа идэж дууссан боловч би толгойгоо өндийлгөж чадахааргүй маш их ядарсан хэвээр байлаа. Эцэг маань гахайгаа хооллохоор гарсны дараа би ширээний хажууд суугаад хорсолтойгоор” Би хэзээ ч архи тамхи хэрэглэж байгаагүй; Би Мэргэн Ухааны Үгийг үргэлж дагаж байсан. Сургаал ба Гэрээнд хэрэв чи Мэргэн Ухааны Үгийг дагавал гүйсэн ч ядрахгүй, алхсан ч сульдахгүй гэж сургадаг. Одоо би маш их ядарч байна, толгойгоо би арайхийж өндийлгөж байна.’ Би ядарч туйлдан нулимсаа барих гэж хичээхэд миний ам өөрийн эрхгүй татганав.”

“Юу тохиолдсоныг дүрслэхэд хэцүү боловч цагаан гэрлийн маш сайхан туяа миний эд эс бүрийг дүүргэн биед минь нэвтрэн орох шиг болов. Аав буцаж ирэхэд би босож талбай руугаа явав.”

“Эцэг маань маш хурдан шаламгай ажилчин байсан боловч тэр орой тэр хичнээн хурдан ажилласан ч намайг гүйцэхгүй байлаа. Би энд тэнд тарсан хүнд баглануудыг цуглуулан [нэг мөрөөс нөгөө мөр үрүү] шидэлж байлаа. Эцгийн минь гайхсан харцыг би хэзээ ч мартажгүй.” (Лео. В. Спэнсэр “To Run and Not be Weary,” *Ensign* 3-р сар 1974, х 45.)

АЖИЛ

Ажил бол адислал болохоос хараал биш юм. Энэ нь гэр бүлийнхнийг маань эрүүл мэндээр хангах болоцоог өгөөд зогсохгүй бидний бие ба ухаан санааг идэвхтэй сэргэлэн байлгадаг юм. (1 Тесалоник 4:11–12 ба Дуулал 128:2–3 үз.)



ХАНГАЛТТАЙ АМРАЛТ

Зарим хүмүүс зохистой амрахад шаардагдахуйцаар хангалттай унтдаггүй бол зарим хүмүүс хэт их унтдаг. Их Эзэн бидэнд унтах ёстой хугацаандаа унтаж түүнээс илүү бүү унт хэмээн сануулсан билээ. Бид бүгд ялгаатай тул хэрэгцээнийхээ хэрээр амрах хэрэгтэй боловч Тэр бидэнд бие ба оюун санаагаа хүч чадалтай байлгахын тулд эрт унтаж эрт сэргж бай хэмээн хэлсэн билээ. (С ба Г 88:124 үз.)

ХУВИЙН АРИУН ЦЭВЭР

Өвчнөөс сэргийлэхийн тулд бид тогтмол усанд орж нүдээ угаан гараа тогтмол угаах хэрэгтэй. Бид хувцас, цагаан хэрэглэл ба аяга тавгаа тогтмол угаах хэрэгтэй.

Элдэв нянгаас ангижирснаар бид өвчин эмгэгээс сэргийлж чадна. Бид хорхой шавьж, амьтдыг гэрээс гадуур байлгаж, амьтан ба хүний хог хаягдлыг цэвэрлэснээр нянгуудаас ангижирч чадна. Үүний нэгэн адил хоол хүнсийг цэвэр, найдвартай газар хадгалах хэрэгтэй.

ЗӨВ ХООЛНЫ ДЭГЛЭМ

Зөв хоолны дэглэм нь хоол бүрд хоол хүнсний гурван бүлгийг оролцуулдаг. Бидний өсөлтөд мах ба амьтны гаралтай бүтээгдэхүүн хэрэгтэй; жимс ногоо нь өвчин эмгэгээс хамгаалж, үр тариа ба цардуултай үндэс нь эрч хүчтэй болоход маань хэрэгтэй байдаг. (Нэмэлт мэдээллийг Хожмын Үеийн Гэгээнтэн Эмэгтэй: Эмэгтэйчүүдэд зориулсан гарын авлага, А хэсэг, 22-р хичээл: “Гэр Бүлд зориулсан Хүнс Тэжээл”-ээс үз.)

ЭМЧИЛГЭЭ БА ШҮДЭЭ АНХААРАХ НЬ

Бид дархлалын тарилга хийлгэснээр зарим нэг өвчнөөс өөрсдийгөө ба гэр бүлийнхнээ хамгаалж чадна. Дэлхийн ихэнх хэсгүүдэд тарилгыг эрүүл мэндийн клиник эсвэл эмч нар хийдэг. Бид мөн шүдний эмчид шүдээ тогтмол үзүүлж байх хэрэгтэй.

БИЕИЙН ДАСГАЛ

“Биеийн тогтмол дасгал нь эрүүл мэнд сайн байхад зайлшгүй хэрэгтэй”
24-а үзүүлэнг таниул.

Дасгал нь хувиараа ба гэр бүлээрээ хийн баясаж болох зүйл юм. Бараг хүн болгон хийж чадах хамгийн сайн дасгалуудын нэг бол гүйлт юм. Бид ямар ч цагт, хаана ч гүйж болох бөгөөд энэ нь бага хугацаанд асар их сайжруулдаг юм. Дороо гүйн алхах зэрэг нь мөн сайн дасгал юм. Сагс, хөл бөмбөг, гар бөмбөг, сэлэлт ба бусад төрлийн спорт нь дасгал, амралт хоёулангаар нь хангаж чадна.

24-а Биеийн тогтмол дасгал нь эрүүл мэндэд зайлшгүй хэрэгтэй.



Биеийн хүчний хөтөлбөр эхлэхийнхээ өмнө бид биеээ үзүүлэх хэрэгтэй. Дасгалын хөтөлбөрийнхөө талаар эмчийн зөвлөгөөг авч түүнийгээ мөрдөх нь, тус болохгүй харин хор хөнөөл учруулах зүйл хийхээс биднийг сэргийлж чадна.

“Дасгал бол гэр бүлийн гойд сайн төсөл юм” 24-6 үзүүлэнг таниул.

АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ

Бидний өдөр тутмын үүрэг хариуцлагуудаас үүдэн гарч ирэх дарамт, зовиур зэргийг биеийн идэвхитэй ажиллагаа тайлдаг учир амралт, чөлөөт цаг нь биеийн идэвхитэй ажиллагаанаас бүрдэх ёстой. Энэ нь бидэнд тархи мэдрэл ба бие махбодоо эрүүл мэнд байлгахад маань туслах болно. Амралт, чөлөөт цагийн дасгалын хөтөлбөрийн нэг ашиг тус бол биднийг гэр бүлтэйгээ хамтдаа байх сайхан боломжоор хангадаг явдал юм. Гэр бүлийн гишүүн бүрийг дасгал хийхэд хүргээд зогсохгүй, мөн гэр бүлийнхээ бусад гишүүдийнхээ тухай улам ойр дотно сэтгэгдэлтэй болгоно.

Дүгнэлт

Тэнцвэр нь аз жаргалтай амьдралд зайлшгүй хэрэгтэй байдаг. Энэ нь бид ажил, амралт ба чөлөөт цагаа тэнцвэртэй болгохыг хичээх хэрэгтэй гэсэн үг билээ. Ерөнхийлөгч Бригхэм Янг:

“Эрүүл мэндийн хууль бүрийг мөрдөж, мөн ажил, хичээл, амралт, чөлөөт цагаа зөвөөр тэнцүүлж. . . . илүү сайхан амьдралд бэлтгэхийн тулд одоогийн амьдралаа дээд зэрэгт хүртэл нь үргэлжлүүлэн ахихыг хичээцгээе. Эдгээр зарчмуудыг үр хүүхдүүддээ заацгаая, ингэснээр тэд эрүүл мэнд ба хүч чадлын суурийг бий болгохыг заалгасан байх болно” (Discourses of Brigham Young, p.186)

Эрүүл мэнд сайтай байх нь биднийг олон үүрэг хариуцлагаа үр дүнтэй биелүүлэхэд тусалдаг тул Сүмд өөрсдийгөө сүнс, оюун санаа ба бие махбодын хувьд бэлтгэсэн пристийн зэрэгтнүүд хэрэгтэй байдаг.

Уриалга

1. Эрүүл мэндийн асуудлуудаа судал.
2. Хувийн ба гэр бүлийн биеийн эрүүл мэндийн хөтөлбөрөө хөгжүүл.

Нэмэлт Судрууд

Сургаалт үгс 23:19–23 (идэж уух зүйлээ сонгохдоо бид ухаалаг байх ёстой)

Сургаалт үгс 31:1–4 (согтууруулах ундаа ба ёс суртахуунгүй байдлаар бид өөрсдийгөө бузарлах ёсгүй)

24-6. Дасгал бол гэр бүлийн гойд сайн төсөл юм.

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө

1. *Gospel Principles* гарын авлагаас “Work and Personal Responsibility,” 27-р бүлэг ба “The Lord’s Law of Health,” 29-р бүлгийг унш.
2. Ангийн нэг гишүүнд чуулга дахь гишүүд эрүүл мэндийн хэрэгцээгээ шийдэж болох өөрийн бүс дэх эрүүл мэндийн төвд очсон тухайгаа илтгэхийг даалга.
3. Ангийн өөр нэг гишүүнд Мэргэн Ухааны Үгийн агуулгын талаар таван минутын яриа хийхийг даалга (С ба Г 89:1–17).
4. Хичээл дэх түүх ба судруудыг танилцуулахыг ангийн гишүүдэд даалга.

Нийгэм ба Үндэстэндээ Үйлчлэх нь

Хичээл 25

Энэ хичээлийн зорилго бол нийгэм ба үндэстнийхээ үүрэг хариуцлагыг ойлгоход бидэнд туслах явдал юм.

Оршил

Исүс Христийн Сүмийн гишүүдийн хувьд бид дэлхийн бүх үндэстэн ялангуяа өөрсдийн хөрш, нэгдэл ба үндэстний бүх хүмүүсийг хайрлан ахан дүүсийн барилдлагаатай байх ёстой. Бид өөрсдийн эх орон ба ард түмэндээ үнэнч шударга байж засгийн газартаа удирдаж буй хүмүүсийнхээ хэрэгцээг хангахад нь туслахын тулд чадах бүхнээ хийх ёстой.

Сургаал ба Гэрээнд тунхагласнаар засгийн газрыг хүний ашиг тусын тулд Бурхан байгуулж, Бурхан хүмүүсийг үйл хэргийнх нь дагуу хариуцлага бүхий байлгадаг гэдэгт бид итгэдэг (С ба Г 134:1).

Хувь Хүний Үүрэг Хариуцлага

Зарим нэг хувь хүмүүс ба гэр бүлүүд шударга бус ба ёс суртахуунгүй амьдралаар амьдардаг, мөн өөрсдийгөө тэтгэхийн тулд ажил хөдөлмөр эрхэлдэггүйн улмаас нийгмийн олон бэрхшээлтэй асуудлууд гарч ирдэг. Бид нийгэм ба үндэстэнд үйлчлэхийн өмнө өөрсдөө зөв шударга сайхан амьдрах ёстой. Бид нэн тэргүүнд өөрсдийгөө ба гэр бүлийнхнээ халамжлан мөн тэдэнд тулгарч буй ямар ч асуудлуудыг даван туулахыг хичээх хэрэгтэй.

Бидний хамгийн чухал үүрэг хариуцлага бол ариун сургаалаар амьдрах явдал юм. Үүнийг хийснээр, бид өөрсөддөө туслаад зогсохгүй мөн бусдад туслах болно. Бидний амьдралын үлгэр жишээ нь бидний хэлж болох ямар ч зүйлээс илүүтэйгээр бусдад нөлөөлөх болно. Жишээлбэл, Мормоны Номонд нэгэн гэм нүгэлтэй хотын хүмүүсийг Их Эзэн уг газар нутагт байсан зөв шударга хүмүүсийн залбирлаар дамжуулан амийг нь хэлтрүүлсэн хэмээн өгүүлдэг билээ.

Алма 10:33–23-ыг уншихыг ангийн гишүүдээс хүс.

Их Эзэн зарим үед бүхэл бүтэн нийгмийн цөөхөн тооны зөв шудрага хүмүүсээс хамааран адислах болно. Ерөнхийлөгч Дэвид О.МакКэй Сүмийн гишүүд сайн үлгэр жишээг бий болгох хэрэгтэй талаар ярьсан билээ: “Итгэл найдвар, тэвчээр, ариун явдал, шударга байдал, шударга ёсонд зориулсан Мормонизм гэдэг [үгийг] хэлэхдээ бид бүгд бардам байх хэрэгтэй—эдгээр нь Исүс Христийн

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн суурь зарчмууд бөгөөд эдгээрийг амьдралдаа үлгэр жишээ болгосноор бид нийгмийн [өөрчлөлтөд] хувь нэмрээ оруулж нийгмийг илүү сайн нөхцөл байдалд шилжүүлж энд хүмүүст амар амгалан ба авралыг авчрах болно” хэмээн манай шашин номлодог. (Чуулганы Илтгэл 10-р сар 1927, х 14.)

Бид зөв шударга сайхан амьдарч, гэр бүлийнхнээ халамжлан, зөв жишээ байх хүч зоригийн төлөө залбирснаар улс эх орон ба нийгэмдээ асар их хүч чадлыг өгч чадна.

Бидний Хөршийн Ба Нийгмийн Үүрэг Хариуцлага

Их Эзэн биднээс хөрш болон найз нөхөддөө үйлчлэж хайрлаж байхыг шаарддаг. Энэ нь асар их золиослол шаарддаггүй; нөхөрлөл нь ихэнхдээ эелдэг байдлын жижиг үйлдлүүд дээр үндэслэдэг бөгөөд сайн хөрш байхын нэг хэсэг бол бэлэвсэн ба өнчин хүмүүсийн хэрэгцээг анхаарах явдал юм. Бид хөршүүддээ үзүүлж болох агуу их үйлчлэл бол ариун сургаалыг тэдэнд танилцуулах явдал юм. Тэдний хүлээн зөвшөөрсөн, үгүй эсэх нь хамаагүй, бид тэднийг хайрлаж тэдэнд үйлчлэх ёстой.

Манай нийгэмд чин сэтгэлээсээ туслахыг хүсдэг найдвартай үнэнч шударга иргэд асар их хэрэгтэй билээ.

Ангийн гишүүнээс С ба Г 58:27–28-ыг уншихыг хүс. Хүмүүст маань нийгэмд тулгарч буй зарим нэг бэрхшээлийг товч ярилц. Бидэнд хот сууриндаа үзүүлж чадах ямар асар сайн нөлөөнүүд байдаг вэ?

“Бурханы өмнө хүлээх бидний хариуцлагад найз нөхөддөө үйлчлэх үйлчлэл багтдаг” 25-а үзүүлэнг таниул.

БОЛОВСРОЛ

Зарим газруудад сургуулиудыг байгуулах эсвэл өргөтгөх хэрэгтэй байдаг. Өөр бусад газрын сургуулиудад сурах бичиг, сургалтын туслах материалууд, сонгон суралцах дамжаа зэрэг шаардлагатай байдаг. Дараах түүх Хожмын-үеийн Гэгээнтнүүд хүүхдүүдийнх нь сургуулийн боловсролын чанарыг хэрхэн сайжруулсан тухай өгүүлнэ:

“Бидний дуртай хот болох Вашингтоны Сиэтлийн өвөрмөц шинжүүдийн нэг бол дүүргийн улсын сургуулийн гойд сайн систем байсан билээ. Биднийг тэнд амьдарсан хорин жилийн туршид бид хотын зах уруу нүүхийг үе үе хүсдэг байсан боловч улсын сургууль гурван хүүхдэд маань өгч буй боловсролын аятай боломжийг үнэлдгийн учир бид эцэст нь хотдоо үлдэхээр үргэлж шийддэг байлаа. . . .”

25-а. Бурханы өмнө хүлээх бидний хариуцлагад найз нөхөддөө үзүүлэх үйлчлэл багтдаг.



“Сүүлийн нэлээн хэдэн жилүүдэд, сургуулийн захиргаа өөрчлөгдөж урьд цагийн бат бөх ба батлагдсан санхүүгийн болон боловсролын бодлогоос салж эхэлж буйг бид харсан хэдий ч. . . . Тэд сургалтын төлөвлөгөө ба арга барилдаа онцгой том өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн билээ. . . . Бусад заавар дүрмүүд, аюулгүйн байдал, төлөв зан чанар, ба мансууруулах бодис хэрэглэх зэрэг ноцтой асуудлуудыг дэвэргэн оюутнуудын зан чанарыг эвдэж байлаа.”

“Энэ түгшүүрт явдлаас үүдэн Эцэг Эх Багш Нарын Холбоо ба сургуулийн зөвлөлгөө өгөхөөр сонгогдсон зөвлөлүүдэд хийж буй бидний үйл ажиллагаа ба үйлчлэлээ сайжруулах сонирхолд олонхийг маань хөтлөв. Манай хэсгийн хил хязгаарт ойр дөт байдаг томоохон дунд сургуулийн бүсийн сэтгэл нь зовсон эцэг эх ба найз нөхөд бидний зарим нэгийг маань уг хоёр байгууллагад хоёулангийнх нь ажилд [сонгов]”

“Цуглаануудад хамтран ажиллах талаар Сүмийн туршлагатай Хожмын Үеийн Гэгээнтэн гишүүд сургуулийн захиргаанд шахалт үзүүлж эхлэв. Сайн хөтөлбөрийг дэмжсэнээр бид уламжлалт сургалтын хөтөлбөр ба багшлах арга барилыг сайн дураар өөрчлөх боломжтой болов. Сургуулийн талбар, танхим дахь зодоон, айлган сүрдүүлэх явдлыг багасгаж, мөн мансууруулах бодис ба төлөв зан чанарын доголдлыг зогсоохын тулд бид аюулгүй байдлыг сайжруулав. Эцэг эхчүүд асар ихээр сонирхож бид тэднийг идэвхтэй оролцуулж [оюутнуудыг] ч мөн өөрсдийн байгууллагадаа нэгтгэв. . . . [Бид] хотын оршин суугчдад өөрсдийнх нь сонгосон хүмүүсийн шийдвэрт нөлөөлж чадна гэдгийг нь батлав. . . .”

“Энэ туршлага нь Хожмын үеийн Гэгээнтнүүд, хамтран нэгдэж үнэндээ өөрсдийнхөө эрхийг хамгаалсан үедээ маш олон энгийн ард түмэнд нөлөөлөх хүч чадалтай гэдгийг дахин баталсан билээ.”

“Энэ гэрчлэл намайг нийгэм улс төр ба үндсэн хуулийн хүрээнд байдаг бусад бүсүүд рүү хөтөлсөн юм. Энэ нь надад Хожмын үеийн Гэгээнтнүүд болох бидэнд маш их хэрэгтэй байгаа нийгмийн өөрчлөлтүүдийг зөвлөх ёстой бус, мөн хийхэд тусалж чадна гэдгийг итгүүлсэн билээ. (Дэвид Л.Томлинсон, We Changed Our Children`s Schools, “Ensign, 6-p cap 1976, 52–53.)

Манай нийгэмд ямар ямар боловсролын хэрэгцээ байдаг вэ? Бид хувь хүн болон пристийн зэрэгтний бүлэг болохынхоо хувьд туслахын тулд юу хийж чадах вэ?

ЕС СУРТАХУУН

Биеэ үнэлэх явдал, садар самуун ба ёс суртахууны бусад нүглийг бүлэг хүмүүс хамтран ажилласнаар л таслан зогсоож чадна. Энэ нь хэн нэгэн эхэлж бүлэг байгуулах хэрэгтэй гэсэн үг юм. Ингээд эдгээр нүглийн эсрэг удирдахад пристийн зэрэгтнүүдээс илүү дээр

байр суурьтай хүн байна гэж үү? Жишээлбэл, Солт Лэйк Ситийн пристийн зэргийн чуулгууд порнографи кино гаргадаг театруудын ажилчдыг ажил хаяхад уриалжээ.

Манай нийгэмд ёс суртахууны ямар ямар бэрхшээлтэй асуудлууд байдаг вэ? Эдгээр асуудлуудыг даван туулахын тулд бид юу хийж чадах вэ?

ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Ихэнх нийгэмд эрүүл мэнд ба аюулгүйн байдлынхаа нөхцөл байдлыг сайжруулах шаардлага байдаг. Зарим хотуудад замын хөдөлгөөний хяналт эсвэл аюулгүйн зохицуулалтаа илүү сайжруулах шаардлагатай байхад бусад газрууд ус эсвэл, эрүүл ахуйн тоног төхөөрөмжөө сайжруулах шаардлагатай байдаг.

Нийгэмдээ үйлчлэхээр хичээхдээ, бид нийгмийнхээ онцгой шаардлагуудыг хэлэлцэх ёстой. Ямар асуудлууд нь хамгийн онц чухал байна гэдгийг бид шийдвэрлэснийхээ дараа, нэгийг нь сонгон түүнийг шийдэхэд туслах төлөвлөгөө боловсруулж чадна. Сүмийн гишүүд нийгмийн олон төслүүдэд тусалж байсан билээ. Жишээ нь, Сүмийн гишүүд нийгмээ сайжруулахын тулд улс төрийн алба ажиллуулж, хороонд үйлчилж, мөн сайн дурын ажил хийдэг билээ.

Канадын Калгари хотын пристийн зэрэгтэн Тэд Брэвэртон бол нийгмээ сайжруулахын тулд нэг хүн юу хийж чадахын үлгэр жишээг үзүүлсэн хүн юм. Тэрээр мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэхийн эсрэг гарамгай эм зүйчээрээ муждаа хамгийн их нэр хүндтэй хүн билээ. Тэрээр товхимол тарааж, лекц уншин, сургуулиудаар айлчилж, мансууруулах бодис хэрэглэхийг таслан зогсооход хяналт тавьдаг төрийн албаны хүмүүст тусалдаг байжээ. Тэр олон зуун хүмүүсийн амьдралд үнэхээр том өөрчлөлтийг хийсэн юм. (Жэнийс Смит, *Making a Difference*, "Ensign", 6-р сар 1976 х. 50.)

Зарим нэг Хожмын Үеийн Гэгэнтнүүд нийгэмд сайн өөрчлөлтүүдийг хийж чадахгүй, эсвэл бид дэндүү завгүй хэмээн марган нийгэмдээ цаг хугацаагаа зориулахаас татгалздаг билээ. Гэвч Их Эзэн бид бүгдээс үүнд оролцож, Сүмийн үйлчлэлээс гадна ямар нэгэн зүйл хийгээсэй хэмээн найдан хүлээдэг. Нийгмийн амьдралыг сайжруулах явдал нь бас Их Эзэний ажил юм.

Өөрийн бүс дэх эрүүл мэнд ба аюулгүйн байдлын шаардлагын талаар ярилц. Эдгээр шаардлагыг хангахын тулд бид пристийн зэрэгтнийхээ хувьд юу хийж чадах вэ?

ТЭТГЭЛГИЙН ҮЙЛЧЛЭЛ

Ялангуяа яаралтай үед Хожмын-үеийн Гэгэнтнүүд бусдад туслах эрмэлзэлтэй байх нь их чухал юм. Үүний адил нэгэн сайн жишээ 1976 онд тохиолдсон юм. Айдахогийн Рексбург хотноо далан нурж хэд хэдэн хот үерт автжээ. Эргэн тойрны мужийн Сүмийн гишүүд нурж гэмтсэн хотуудыг янзлан цэвэрлэх ажилд туслахаар шийджээ.

Залуучууд ба пристийн зэргийн чуулгууд автобус хөлслөн үерт автсан бүс тийш явцгаав. Тэд цэвэрлэх, засвар хийх ба шинэ байшин барихад тусалжээ. Хэсэг эрэгтэй эмэгтэй хүмүүс хүүхдүүдийг асарснаар, эцэг эх нь өөрсдийн эвдэрч нурсан байшин дээрээ ажиллах боломжтой байжээ. Найз нөхөддөө үйлчлэхийг хүссэн ХҮГ Сүмийн гишүүдийн сайн дурын ажлын тусламжтайгаар хэдхэн долоо хоногийн дараа цэвэрлэгээний ихэнх ажил дуусжээ.

Хөрш ба нийгмийг маань бэхжүүлж чадах арга зам бол—

- Найз нөхөд ба хөршүүдтэйгээ ариун сургаалыг хуваалцах.
- Бага ч гэсэн тогтмол эелдэг харьцсанаар хөршүүдээ хайрлан үйлчлэх.
- Нийгмийн тустай ажил хэрэгт чин сэтгэлээсээ оролцох.
- Нийгмийн асуудлуудыг тодорхойлж тэдгээрийг даван туулахад туслах
- Нийгмийн удирдлагын албан ажилд үйлчлэх

Улс Эх Орондоо Хүлээх Бидний Үүрэг Хариуцлага

Ерөнхийлөгч Элдон Таннэр хэлэхдээ “Бид хүн бүрийг өөрсдийн ажиллаж, амьдарч, гэр бүлийнхнээ өсгөн өндийлгөж буй газартаа үнэнч байгаасаа хэмээн хүсэж байдаг,” гэсэн билээ. (If They Will But Serve the God of the Land, “*Ensign*, 5-р сар 1976, х.48). Бид улс эх орон, ард түмэндээ хайртай байж тэдэнд сайн сайхныг хүсдэг байх хэрэгтэй. Хэрэв бид улс үндэстнийхээ түүх ба золиослолуудыг үнэлж сурвал дээрх хайр аяндаа бий болдог юм.

Эх орондоо үнэнч байна гэдэг нь засаг төрийг удирдаж байгаа бүх хүмүүстэй санал нэг байна гэсэн үг биш юм. Засаг төрийн ихэнх албан хаагчид зөв зүйлийг чин сэтгэлээсээ хийхийг хичээдэг тул бид тэднийг дэмжих хэрэгтэй. Бид тэднийг зөв шийдвэр гаргаж зөв зүйл хийгээсэй хэмээн өдөр бүр залбирах хэрэгтэй. Ерөнхийлөгч Хэролд, Б.Ли Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчтэй уулзалт хийж байхдаа “түүний нэр эсвэл улс төрийн намаас хамааралгүйгээр, бид [Сүмийнхэн] өвдөг сөхрөн Бурханд хандаж тэр ба улс үндэстний болон дэлхийн удирдагчид биднийг өнөө үеийн бэрхшээлтэй асуудлуудаас ангижруулаасай хэмээн байнга залбирах болно гэдгээ батлан хэлжээ.” (A Time of Decision, “*Ensign* 7-р сар 1972, х. 29.)

Улс үндэстэндээ үйлчлэх явдалд улсынхаа хуулинд дуулгавартай байх явдал багтдаг. Хүн бүр хуулийг дуулгавартай дагаж байгаа нөхцөлд амар амгалан оршин тогтнож чадна. Итгэлийн арванхоёрдугаар Тунхагт “Бид хаан, ерөнхийлөгч, төр засгийн

удирдагч, албан хаагчдад захирагдаж, хуулийг хүндэтгэн дээдэлж, дагаж мөрдөх ёстой гэдэгт итгэдэг” гэж байдаг.

Хэрэв ангид залуу пристийн зэрэгтэн байвал, тэд хуулийн эрх мэдэл ба дуулгавартай байдалд хүндэтгэлээ хэрхэн үзүүлж чадахыг ярилц. Залуу хүмүүс өөрсдийгөө улс нийгэмдээ үйлчлэхэд хэрхэн бэлтгэж чадах вэ?

Улс бүр хуулиа янз бүрийн замаар үндэслэдэг. Зарим улс оронд иргэддээ хууль гаргахад тусалдаг албан ёсны төлөөлөгчдийн төлөө саналаа өгөхийг зөвшөөрдөг. Ялангуяа эдгээр улс орнуудын Хожмын-үеийн Гэгээнтнүүд олон нийтийн ашиг сонирхлын талаар мэдээлэлтэй байж албан тушаалд нэр дэвшигч сайн хүмүүсийг дэмжих үүрэгтэй байдаг. Ард түмний сонгууль явагддаг улс оронд иргэн бүр сонгууль өгөх ёстой.

Дүгнэлт

Хожмын-үеийн Гэгээнтнүүдийн хувьд бид улс эх орон ба нийгэмдээ үүрэг хариуцлага хүлээдэг. Бид зөв шударга амьдарч, асуудлыг шийдэхэд туслан, бүхэл бүтэн нийгмийнхээ хэрэгцээг анхаарах үүрэг хүлээдэг.

Улс эх орондоо үүргээ биелүүлэх зарим нэг арга бол—

- Улс эх орон ба ард түмэндээ үнэнч байх
- Удирдагчдынхаа төлөө залбирах
- Хуулийг дуулгавартай дагах
- Олон нийтийн асуудлаар мэдээлэлтэй байх
- Шударга ухаалаг удирдагчдыг дэмжих

Уриалга

1. Нийгэм ба хөршдөө тусалж чадах нэг аргыг сонгож ав. Хувийн төлөвлөгөө гаргаж түүнийгээ энэ долоо хоногт биелүүлж эхэл.
2. Чуулгынхаа хамтаар нийгмээ сайжруулахад пристийн зэргийн бүлэг юу хийж чадах талаар ярилцаж шийд.
3. Гэр бүлийн залбиралдаа өөрсдийгөө зөв шударга ёсоор удирдуулахын тулд улс үндэстэн ба нийгмийнхээ удирдагчдын төлөө залбир.

Нэмэлт Судрууд

1 Тимот 1:8–10 (хуулийн хэрэгцээ)

1 Тимот 2:1–2 (төр засгийн удирдагчдынхаа төлөө бид залбирах ёстой)

Титас 3:1 (Төр засгаа бид дуулгавартай дагах ёстой)

1 Петр 2:13–14 (төр засгаас үндэслэсэн хуулиудад бид дуулгавартай байх хэрэгтэй)

Мозая 29 (Мозая Хааны төр засгийн талаар ярьсан яриа)

С ба Г 134 (Хууль ба төр засгийн зарчмуудын шаардлагын тухай яриа)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Хөршийн холбоо ба нийгэм дэх ямар сайн зүйлүүдэд танай чуулгын дэмжлэгийг ашиглаж болох талаар судал.
2. Хичээл дэх түүх ба судруудаас танилцуулахыг ангийн гишүүдэд даалга.

Исүс Христийн Ариун Сургаалын Гэрчлэл

Хичээл 26

Энэ хичээлийн зорилго бол бидэнд Исүс Христийн Ариун Сургаалын хүчтэй гэрчлэлийг хэрхэн олж авч хүчтэй болгохыг ойлгоход туслах явдал болно.

Оршил

Исүс Христийн Ариун Сургаалын гэрчлэл бол бидний авч чадах хамгийн үнэтэй зүйлсийн маань нэг юм. Ерөнхийлөгч Дэвид. О. МакКэй бага залуу байхдаа үүнийг ойлгожээ. Тэрээр: “Энэ нь надад дутагдаж байсан. Хэрэв би тэр [гэрчлэлтэй] болж чадвал бусад бүх зүйл үнэн хэрэгтээ өчүүхэн мэт харагдах болно гэдгийг би мэдэрсэн юм” гэжээ. (“A Personal Testimony”, *Improvement Era*, 9-р сар 1962, х. 628).

Гэрчлэл нь хүнд хэцүү зовлон, сорилтууд ирэх үед амьдралын маань туршид биднийг дэмжих болно. Ийм цаг үед, бусдын гэрчлэлүүд биднийг дэмжиж чадахгүй, харин сорилтуудаа итгэлтэйгээр даван туулахын тулд өөрсдийнхөө гэрчлэлд найдах хэрэгтэй болно.

Гэрчлэл Гэж Юу Вэ?

Магадгүй бид номлогч нартай анх уулзаж ариун сургаалаас суралцаж байснаа эсвэл бидэнд гэрчлэлтэй болоход маань тусалсан хүнтэй харьцаатай байснаа дурсаж болно. Эсвэл магадгүй хэн нэгний бидэнтэй гэрчлэлээ хуваалцахыг сонсоод мэдэрсэн тэр таатай, дулаахан мэдрэмжийг бид санаж болох юм. Энэ мэдрэмж бол Ариун Сүнс зүрх сэтгэлд маань бидний сонссон зүйл үнэн гэдэг гэрчлэлийг өгч байгаа юм. Энэ нь тайван, мятаршгүй үнэний мэдрэмж юм. Энэ мэдрэмжээр бид Исүс Христ бол Бурханы Хүү, Жозеф Смит бошиглогч байсан, мөн Исүс Христийн Хожмын-Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол дэлхий дээрх цорын ганц үнэн сүм гэдгийг мэддэг. Энэ мэдрэмж нь бидэнд Мэргэн Ухааны Үг, аравны нэгийн зарчим, Мормоны Номын үнэн гэдэг гэрчлэлийг өгч чадна.

Эдгээр хожмын өдрүүдэд Сүмийн гишүүн байгаагийнхаа хувьд, амьдарч буй бошиглогчдынхоо талаар гэрчлэлтэй байх нь зайлшгүй чухал билээ. Ерөнхийлөгч Хэролд.Б.Ли энэ мэдлэг чухал болохыг тайлбарлахдаа:

“Би үүнийг та бүхний сэтгэлд үлдээсэй гэж хүсэж байна. Хэн нэгэн ингэж хэлсэн бөгөөд энэ нь үнэхээр үнэн гэдэгт би итгэдэг: “Тэр хүн Бурханы хүч чадал энэ Сүмийн удирдагчид дээр ирэхийг харж, мөн энэ нь түүний зүрх сэтгэл рүү гал мэт ирэхээс нааш үнэн сэтгэлээсээ өөрчлөгдөж чадахгүй. Мөн энэ Сүмийн гишүүд зөв замаар удирдуулж байгаа мөн тэд Бурханы эдгээр хүмүүсийг урамшуулсан мөн чухамдаа Бурханы томилсон гэдэгт үнэмших хүртлээ тэр үнэхээр өөрчлөгдөхгүй” гэжээ. (“The Strength of the Priesthood, *Ensign* 7-р сар 1972, х.103.)

Ангийн гишүүдээс хэдэн минут өөрсдийн гэрчлэлийн талаар бодохыг хүс. Тэднээс ариун сургаалын үнэн тэдэнд илчлэгдсэн талаар, мөн тэд Сүм үнэн, Исүс бол Христ, эсвэл Мормоны ном бол үнэн болох сүнслэг гэрчлэлийг хэрхэн хүлээн авсан талаар дурсан санахыг хүс. Эдгээр мэдрэмжүүд нь ямар байсан, мөн тэд гэрчлэл хүлээн авснаа хэрхэн таньж мэдсэн зэргийг тэднээс асуу.

Гэрчлэл Хүлээн Авах нь

Гэрчлэл нь Ариун Сүнснээс ирсэн илчлэл дээр үндэслэгддэг. Энэ нь Их Эзэний Сүнс бидний зүрх сэтгэл, сүнстэй ярьж бидэнд үнэнийг батлах үед ирдэг юм. (С ба Г 8:2–3 үз). Христ Пэтрт түүний гэрчлэл нь хүнээс бус Бурханаас ирдэг юм гэдгийг тайлбарлаж өгсөн юм. (Матай 16:13–17 үз).

Ахлагч Парлэй.П.Пратт Мормоны Ном үнэн гэдгийн талаар хүлээн авсан гэрчлэлийнхээ тухай дараах мэдээллийг бичсэн юм:

“Би [Мормоны Номыг] нээх гэж тэсч ядан эхний хуудсыг уншлаа хэмээн тэр хэлэв. Дараа нь би энэ номыг олж орчуулсан тухай гэрчилсэн хэд хэдэн хүний гэрчлэлийг уншив. . . . Би бүх л өдөржин уншив; юм идэх нь яршигтай санагдаж, хоол унд идэх хүсэл ч төрөхгүй байв; орой болоход түүнийг унших нь унтахаас илүү санагдаж байсан тул унтах нь хүртэл яршигтай санагдаж байв.”

“Намайг унших үед, Их Эзэний сүнс над дээр ирж, би уг ном нь үнэн гэдгийг хүн өөрийгөө оршин байгаагаа илт ойлгон ухаарч мэддэгтэй нэгэн адилаар мэдэж бүрэн ойлгов. Би баяр баясгалангаар бялхаж, амьдралын маань бүх уйтгар гуниг золиослол ба нөр их хөдөлмөрийг маань тэр баяр баясгалан нөхөн төлөв.” (Autobiography of Parley P.Pratt, х 37.)

Зарим хүмүүст гэрчлэл хүлээн авах нь их тод мэдрэмж болдог. Зарим хүмүүст энэ нь нэг их сонирхолтой бус боловч, энэ нь чухал буюу үнэтэй юм. Ахлагч Лорэр С.Данн, “Энэ нь гэрлийн гялбаа мэт ирэхгүй байж болно. (Их Эзэн та бүхэнтэй хэрхэн холбоо барих гэж буйг би мэдэхгүй). Энэ нь өөрөө мэддэг болохоо ухаарах хүртэл өдрөөс өдөрт бодит замаар ирэх баталгаа боловч ихэнхдээ зүрх сэтгэлийн тань доторх итгэл ба мэдрэмж байх болно.” (“Watch

Therefore: For Ye Know Not What Hour”, University of Utah Institute devotional, 11-p cap 1972 .x. 5.)

Ерөнхийлөгч Марион.Г.Ромни гэрчлэлээ хүлээн авсан арга замаа ийнхүү тайлбарласан юм:

“Зарим үед гэрчлэл нь хүмүүст урт удаан хугацааны дараа ирдэг. Надад гэрчлэл гэнэт ирснийг би санахгүй байна. . . Гэрчлэлгүй үеийг би санахгүй байна. Энэ нь мэдээж хэрэг олон жилийн туршид улам хүчтэй болсон ба би итгэж байгаагүй өдрүүдийг санахгүй байна. Гэрчлэл гэнэт ч бай, аажмаар ирэх ч бай, энэ нь хүнд ямар нэг зүйлээр нөлөөлдөг юм. Гэрчлэлээ хүлээн авсны дараа ямар нэгэн өөрчлөлт гардаг.” (“How to Gain a Testimony,” *New Era*, 5-p cap 1976, x 11.)

Гэрчлэл хүлээн авахын тулд бид хэд хэдэн зүйлийг хийх ёстой. Ялангуяа дараах таван алхам их чухал юм:

Дараах таван алхмыг салбарт жагсааж бич:

1. Итгэх Хүсэл. Үнэний талаар мэдлэг олж авах анхны алхам бол итгэх хүсэл юм гэдгийг Алма тайлбарладаг. (Алма 32:26–27-г үз.)
2. Судраас Судал. Бошиглогч Жозеф Смит бидэнд “судраас судал—бидний хэвлэн гаргадаг илчлэлүүдийг судлан, Тэнгэрлэг Эцэгээсээ Түүний Хүү Исүс Христийн нэрээр үнэнийг илэрхийлж өгөхийг гуй, хэрэв та бүхэн үүнийг ямар ч эргэлзээгүйгээр Түүний алдар хүнд рүү мэлмийгээ чиглүүлж харвал, Тэр Ариун Сүнснийхээ хүч чадлаар та нарт хариу өгөх болно. Үүний дараа та бүхэн бусдад бус өөртөө хариулт авах болно. Бурханы талаарх мэдлэгтээ та нар хүнээс шалтгаалахгүй байж; ямар нэгэн эргэлзээ будлиангүй байх болно.” (Teachings of the Prophet Joseph Smith, хх 11–12.)
3. Бурханы Хүслийг Гүйцэтгэ. Хүн Сургаал нь Бурханых гэдгийг мэдэхийнхээ өмнө, эхлээд сургаалаар амьдрах хэрэгтэй гэдгийг Аврагч улам тодорхой болгодог. (Жон 7:16–18 үз).
4. Ариун сургаалын Зарчмуудыг эргэцүүлэн бод. Судруудыг эргэцүүлэн бодох гэдэг нь тэдгээрийн талаар суралцаж бодож тунгаагаад, дараа нь өөрсдийн маань бодол зөв эсэх талаар Ариун Сүнснээс мэдлэг хүлээн авахын тулд Христэд итгэн залбирахыг хэлж байгаа юм. (Моронай 10:3–5).
5. Ойр ойрхон залбиран мацаг барьж бай. Бошиглогч Алма олон өдрийн туршид мацаг барин залбирсан учраас ариун сургаалын үнэнийг өөрөө мэдэж авсан юм. Түүний мацгийн дараа Ариун Сүнс түүний зүрх сэтгэлд Бурханы сургаалын талаар гэрчлэлийг өгсөн юм. (Алма 5:56–46 үз).



Урьдчилан даалгасан ангийн гишүүнээр гэрчлэлээ хэрхэн олж авсан тухай туршлагыг нь яриул.

Илүү Хүчтэй Гэрчлэлийг Бий Болгох нь

Бид нэгэнт гэрчлэлтэй болсон бол үргэлж түүнтэйгээ байх уу? Ерөнхийлөгч Хэролд Б.Ли: “Гэрчлэл бол өнөөдөр, эсвэл үргэлж чамтай хамт байж чадах ямар нэгэн зүйл биш юм. Гэрчлэл нь хэврэг байдаг. Энэ нь сарны цацрагийг барихтай адил хэцүү. Энэ бол чи амьдралынхаа өдөр бүр тогтоон барьж байх ёстой зүйл юм,” хэмээн хэлсэн билээ. (Church News, 7-р сарын 15, 1972, х. 4.)

Гэрчлэлээ өдөр бүр бэхжүүлж, ариун сургаалд баяртай байхын тулд бид зөв шударгаар амьдрахыг хичээж, пристийн зэргийн үүргүүдээ биелүүлж, бусдад үйлчлэх хэрэгтэй. Гэрчлэлээ бэхжүүлэхийг хүсэж байвал гэрчлэл нь үйл хэргийн зарчим байх ёстой.

“Бид гэрчлэлээ бусадтай хуваалцсанаар бэхжүүлж чадна” 23-а үзүүлэнг таниул.

Бусадтай гэрчлэлээ хуваалцах нь бидний гэрчлэлийг бэхжүүлээд зогсохгүй, биднийг сонсож буй тэдгээр хүмүүсийн гэрчлэлийг мөн бэхжүүлэх болно. Сард нэг удаа болдог мацаг ба гэрчлэлийн цуглаан дээр гэрчлэлээ хуваалцах боломжийг бидэнд өгсөн бөгөөд бид найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ гэрчлэлээ хуваалцах боломж бүрийг ашиглах ёстой.

Сүмийн гишүүдийн хувьд, бид гишүүн, гишүүн бус бүх хүмүүстэй гэрчлэлээ хуваалцах үүрэг хариуцлагатай байдаг. Бид юу хийж, юу хэлж байгаагаараа өдөр бүр гэрчлэлээ бусдад үзүүлдэг. Бид гэрчлэлээ хуваалцах үед энэ нь бусдыг бидний нэгэн адил бэхжүүлдэг. Бид Исүсийн талаарх өөрсдийн гэрчлэлдээ зоригтой байх хэрэгтэй. (С ба Г 76:79-ийг үз.)

Пэтр: “Та нарын доторх найдлагын талаар асуусан хэн бүхэнд хариу өгөхөд үргэлжид бэлэн бай” хэмээн зөвлөсөн билээ (1 Пэтр 3:15). Бидний гэрчлэл бусдад үнэнийг гэрчилж тэдэнд ихийг сурч мэдэх хүсэлтэй болоход нь тусалдаг. Эдгээр гэрчлэлүүд тэднийг ч, биднийг ч бэхжүүлдэг.

Ангийн гишүүдээр С ба Г 62:3 ба С ба Г 84:61-ийг уншуул. Гэрчлэлээ хуваалцдаг хүмүүст Их Эзэн юу амласан бэ?

Бидний гэрчлэл гэр бүлд маань хүч чадлын эх сурвалж болж чадна. 1868 онд номлолд үйлчилж байсан нэгэн эцэг хүүдээ: “Хүү минь, эцгийн чинь гэрчлэл бүх л амьдралын чинь турш чамайг хөтлөх од болог.” хэмээн бичжээ. (Рэйнхард Мэйсэр Karl G. Masser- ээс иш татав х. 57)

Залуу хөвгүүдээс тэдний эцгийнх нь гэрчлэл тэдний амьдралд хэрхэн “хөтлөгч од” болж чадах тухай асуу. Эцгүүдээс тэд гэрчлэлээ илэрхийлснээр үр хүүхдүүддээ гэрчлэл олж авахад нь хэрхэн тусалж чадах талаар асуу.

Уриалга

1. Исүс Христийн ариун сургаалын талаар гэрчлэлтэй болж, түүнийгээ бэхжүүлж гэрчлэлээ хуваалцахыг эрэлхийл.
2. Их Эзэнтэй ойрхон амьдарч, пристийн зэргийн дуудлагатаа итгэлтэйгээр үйлчилснээр үнэний гэрчлэлээ нэмэгдүүлэн зохистой амьдрахыг хичээ.
3. Гэрчлэл гэсэн сэдэвтэйгээр гэр бүлийн цуглаан зохиохоор төлөвлө. Цуглаан дээр гэр бүлийнхэндээ гэрчлэлээ хуваалц.
4. Мацаг ба гэрчлэлийн цуглаан дээр гэрчлэлээ хуваалц.

Нэмэлт Судрууд

Дуулал 19:7 (гэрчлэлийн үнэ цэнэ)

1 Коринт 12:3 (гэрчлэлүүд Ариун Сүнснээс ирдэг)

2 Тимот 1:18 (бид гэрчлэхдээ ичих ёсгүй)

С ба Г 76:22–23 (Жозеф Смит ба Сиднэй Ригдоны гэрчлэл)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Самбар, шохой бэлд
2. Та хүсвэл ангийн гишүүнээс гэрчлэлтэй болсон туршлагаасаа ярихыг хүс.
3. “Аврагч маань Амьд Гэдгийг Би Мэднэ” . . . 6-р дууллаар цуглаанаа нээхэд бэлд.

Энэ хичээлийн зорилго бол бидэнд Исүс Христэд итгэх итгэлээ бэхжүүлэхэд маань туслах явдал юм.

Оршил

“Исүс Христэд итгэх итгэл бол ариун сургаалын анхны зарчим юм” 27-а үзүүлэнг таниул. Үүнийг тус хичээлийн туршид өлгөж байрлуул.

Их Эзэн Исүс Христэд итгэх итгэл бол ариун сургаалын анхны зарчим билээ. Хэрэв бидэнд Исүс Христэд итгэх итгэл байвал бид Түүнд найдаж Түүнийг ба Түүний сургаалыг хүлээн зөвшөөрөх болно. Төлөөлөгч Паул “Бид харж байгаагаар бус, харин итгэлээр явдаг,” хэмээн бичсэн билээ (2 Коринт 5:7). Энэ нь бидний харж сонсож чадахгүй байгаа зүйлсийн үнэн, мөн оршин байгаа гэдгийн сүнслэг баталгаа бол итгэл юм гэсэн утгыг илэрхийлж байгаа билээ. Жишээлбэл, Исүс бидний төлөө нас барсан буюу бидний нүглийн төлөө зовж шаналсан гэдгийг бид хараагүй боловч үүнийг итгэлээрээ дамжуулан мэддэг. Алма хэлэхдээ итгэл гэдэг бол аливаа зүйлсийн төгс төгөлдөр мэдлэг бус; иймээс хэрэв бидэнд итгэл байвал, бид хараагүй үнэн зүйлсдээ найдах болно (Алма 32:21).

Исүс Христэд Итгэх Итгэл

Исүс Христэд итгэх итгэлтэй байх нь золиослол хийж хүнд хүчир даалгавруудыг биелүүлэх боломжийг хүмүүст олгодог. Жишээ нь итгэлийнхээ хүчээр Абрахам өөрийн хүүгээ золиослол болгон өргөхийг хүсэж, Инох үхэлгүйгээр тэнгэр лүү явж, Ноа үерээс аврагдсан билээ (Еврей 11-ийг үз). Эдгээр болон бусад олон гайхамшгууд Исүс Христэд итгэх итгэлээр дамжин гүйцэтгэгдсэн юм. Гайхамшгууд итгэлээр дамжин гүйцэтгэгддэг хэмээн Моронай сургадаг билээ (Моронай 7:37-г үз).

Итгэл бидэнд сорилтууд ба зовлон гамшгийг тэвчин даах боломж өгдөг. Жишээлбэл, Жоб Христэд итгэх итгэлийнхээ ачаар асар их зовлон шаналалыг тэвчин өнгөрөөсөн билээ. Их Эзэн өөрт нь итгэж найдаж буй хүмүүсийг хайрлаж тэдэнд тусалдаг учраас Их Эзэн Жобыг хүч оруулан зоригжуулсан юм. (Нахум 1:7-г үз.)

Жоб бидний хэн нь ч түүнийг зовж шаналж үзээгүйгээр зовж шаналсан хэдий ч, тэрээр өөрийн гэрчлэл болон Бурханы эсрэг эргэн хэзээ ч тэднийг үгүйсгээгүй юм. Түүний байшин аймшигт салхинд нуран унахад хүүхдүүд нь бүгд амь үрэгдсэн билээ. Түүний



бие хатиганд баригдсан байлаа. Түүний найз нөхөд, тэр ч байтугай эхнэр нь хүртэл түүнд чи муу санаатай учир зовж шаналж байна хэмээн хэлж шоолж байлаа. Гэвч итгэлийнхээ хүчээр, Жоб өөрийн сорилтуудыг тэвчин өнгөрөөсөн билээ. Жоб хамгийн ихээр шаналж байхдаа Бурханыг магтан дуулж, Гэтэлгэгч амьд бөгөөд хожмын өдрүүдэд дэлхийд ирэх болно гэдгийг мэдэж байгаагаа гэрчилж байлаа. Өт, хатиг түүний биеийг сүйтгэсэн ч тэрээр Бурханыг бие махбодтой нь харах болно гэдгээ Жоб мэдэж байлаа. (Жоб 19:25–26 үз). Эцэст нь түүний итгэл шагналаа хүртсэн юм: түүний зовлон зүдүүр төгсөж, Их Эзэн түүнийг элбэг арвинаар адисласан билээ.

Жобын түүх, сорилтын цаг ирэхэд итгэл маань бидэнд өөрсдийн гэрчлэлдээ зангуу мэт гуйвшгүй тогтвортойгоор зогсоход хэрхэн тусалж чадахыг харуулсан билээ. (Ефер 12:4). Бид өвчин, ядуурал, үхэл эсвэл уруу таталтаас болж зовж шаналж болох боловч хэрэв бид Исүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлбэл хүч зоригтой болж адислагдах болно.

Бидний амьдралд тулгарч болох ямар бэрхшээлүүд байдаг вэ? Яагаад бэрхшээлтэй тулгарсан нэгнийг бид шүүж болохгүй вэ?

Христэд Итгэх Итгэлээ Бэхжүүлэх нь

Бид итгэлээ батжуулахыг үргэлж эрмэлзэж байх хэрэгтэй. Бид ингэснээр Их Эзэнтэй ойр байж адислалуудыг нь хүлээн авсныхаа баяр баясгаланг эдлэх болно. Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх гэдэг нь жимсний мод тарьж, хөрсийг нь боловсруулж, жимсээ хураан авахтай адил юм гэдгийг Алма бидэнд хэлсэн билээ.

“Ширхэг үр суулгаснаар Итгэл эхэлдэг” 27-б үзүүлэнг таниул.

Итгэлээ хөгжүүлэх явдлын анхны үе шатыг үр суулгахтай жишиж болно. Алма хэлэхдээ бид түүний үгийг нь туршиж бага ч гэсэн итгэлээ хөгжүүлэх хэрэгтэй. Итгэх хүслээс өөр юу ч хийж чадахгүй байсан ч, бид үр суулгахын тулд энэхүү хүсэлд өөрсөд дээрээ ажиллах боломжийг олгох хэрэгтэй гэсэн билээ. (Алма 32:27–28-ийг үз)

Бид өөрсдийн зүрх сэтгэлдээ итгэлийн үрийг хэрхэн суулгаж чадах вэ?

Итгэл ихэвчлэн бий болж эхэлдэг нэг арга зам бол, бид Бурханы үгийг унших буюу сонсож Түүнд итгэх хүсэлтэй болох үе юм. Итгэх хүч чармайлт гарган заалгасан зарчмуудаар амьдарснаар сонсож уншсан зүйлээ туршиж үзвэл, заалгасан зүйл маань үнэн юм байна гэдгийг бид зүрх сэтгэлдээ мэдэрч эхлэх болно. (Жон 7:16–17-г үз.)

“Ургамалд нарны гэрэл, агаар, ус хэрэгтэйн адил итгэлд тогтмол тэжээл хэрэгтэй байдаг” 27-в үзүүлэнг таниул.

27-а Исүс Христэд итгэх итгэл бол ариун сургаалын анхны зарчим юм



Хоёрдугаар шат бол ургамлыг арчлахтай адил юм. Ургамал ургахад нарны гэрэл, агаар, ус хэрэгтэй байдгийн нэгэн адил итгэлийг өсгөхөд арчилгаа тэжээл шаардагддаг.

Бид Исүс Христэд итгэх итгэлээ хэрхэн тэтгэж эсвэл хөгжүүлж чадах вэ?

Бид судруудыг уншин түүний талаар эргэцүүлэн бодож, мацаг барин залбирч, Их Эзэнд үйлчлэн Сүмийн удирдагчдаа дэмжиж, Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаснаар итгэлээ тэтгэж чадна. Ургамал усгүйн улмаас үхдэгийн адилаар, итгэл үйл хэрэггүйгээр мөхөх болно. Бид зөв шударга ажил үйлсээрээ итгэлээ тогтмол тэтгэх хэрэгтэй. (Иакоов 2:14–26-г үз.)

“Итгэлийн ургац бол амар амгалан, баяр баясгалан ба мөнхийн амьдрал юм” 27-г үзүүлэнг таниул.

Ургамлыг арчилснаар үр жимсийг нь хүртэх боломжтой болдгийн адил итгэлээ хөгжүүлсэн хичээл зүтгэлээрээ бид агуу их адислалуудыг хүртэх боломжтой болно.

Исүс Христэд итгэх итгэлийн ямар үр жимс ба адислалууд байдаг вэ?

Итгэл бидэнд дараах боломжуудыг олгодог—

- “Сайн зүйл бүрд итгэлтэй байх” (Моронай 7:28-ыг үз).
- Ирээдүйгээсээ айхгүй байгаа тул амар амгалан ба аз жаргалыг эдлэх.
- Залбиралдаа хариултуудыг хүлээн авах.
- Зовлон зүдүүрээ Бурханаар дамжуулж хөнгөлөх. (Матай 11:28–29 үз).
- Нүглээ наманчилснаар өршөөгдөх.
- Пристийн зэргийн хүч чадлаа хөгжүүлэх.
- Ариун Сүнснийг өөрсөдтөөгөө хамт байлгах. (Моронай 7:32-ыг үз).
- Амьдралдаа гайхамшгуудтай учрах. (2 Нефай 26:13-ыг үз).
- Дахин амилалтын дараа Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт амьдарахаар буцаж очих.

Арван хоёр жилийн туршид маш их хүнд өвчтэй байсан нэгэн эмэгтэйн тухай түүх Библид байдаг. Тэр эмч нараар эмчлүүлэхийг хичээн өөрт байсан бүх хөрөнгөө зарцуулсан боловч түүнийг эмчилж чадсангүй. Нэгэн өдөр Исүс түүний тосгонд иржээ. Тэр Исүсийн тухай сонссон байсан бөгөөд тэрээр Түүний нөмрөгөнд нь хүрэх л юм бол эдгэнэ гэдэгт итгэлтэй байжээ. Ингээд тэрээр итгэлтэйгээр түүний хажуугаар Аврагч өнгөрөхөд Түүнд хүрчээ. Түүний нөмрөгөнд хүрмэгц тэр тэр дороо эдгэрсэн бөгөөд Исүс түүн үрүү эргэн хараад “Охин минь итгэл чинь чамайг эрүүл болголоо. Амар тайван яв даа” гэжээ (Лүк 8:43–48-ыг үз).

27-6. Ширхэг үр суулгаснаар итгэл эхэлдэг.



Энэ түүхэн дэх эмэгтэй итгэх итгэлээ үйл хэрэг болгон хэрэгжүүлснээр Христэд итгэх итгэлээ хөгжүүлжээ. Тэрээр Аврагчийн нөмрөгт хүрснээр эдгэрч итгэлийнхээ адислалыг хүртжээ.

Өвчтөнг адислаж байхдаа, мөн адислагдаж байхдаа Иүсү Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх нь яагаад чухал вэ?

Дараах түүхийг урьдчилан даалгасан ангийн гишүүнээр яриул.

Рандалл Эйлсворф нь Гватемалд болсон газар хөдлөлтөнд өртөгдөн ноцтойгоор гэмтсэнийхээ дараа итгэлээ агуу ихээр хөгжүүлсэн нэгэн номлогч билээ. Газар хөдлөлтийн үеэр тэрээр нэгэн барилга дотор байсан ба уг барилга түүний дээрээс нуржээ. Ерөнхий Эрх Мэдэлтэн түүнд тохиолдсон явдлыг дараах байдлаар дүрсэлжээ:

[Тэр] арван хоёр цагийн турш дарагдсан гэж би бодож байна. Тэрээр бүсэлхийнээсээ доошоогоо мэдээ алдсанаа мэджээ. Бөөрний үйл ажиллагаа нь сайн биш байв. Дахин алхаж чадах найдвар үгүй байлаа . . .

Тэрээр . . . Мэриланд уруу . . . нисэн . . . эмнэлэгт байхдаа телевизийн сурвалжлагчтай ярилцжээ. Телевизийн сурвалжлагч түүнд, “Эмч нар таныг дахин явж чадахгүй гэсэн. Ахлагч Эйлсворф та юу гэж бодож байна” хэмээн асуув. Тэрээр “Би зөвхөн дахин яваад зогсохгүй, Гватемалд номлолд үйлчлэх дуудлага бошиглогчоос хүлээн авсан номлолд номлолоо дуусгахаар би Гватемала руу явах болно” гэж хариулжээ. . .

“Тэр эмч нарын зөвлөснөөс . . . хоёр дахин илүү хэмжээгээр. . . дасгал хийв. Тэр итгэлээ хүчтэй болгов. Тэрээр пристийн зэргийн адислал хүлээн авч, түүний тэнхрэн эрүүл болж буй нь гайхалтай байлаа. Энэ явдал нь эмч болон мэргэжилтнүүдийн гайхлыг төрүүлж байлаа. Тэр хөл дээрээ зогсох боломжтой болов. Дараа нь тэрээр суга таягтай явж чаддаг болоход эмч нар түүнд, Сүм чамайг зөвшөөрвөл чи номлолын талбар уруугаа явж болно” хэмээн хэлэв. Тэр явсан билээ. Бид түүнийг Гватемала уруу илгээв. Тэр дуудагдсан газар нутагтаа, хайрлаж байсан хүмүүстээ эргэн ирсэн билээ.

“Тэрээр хоёр гартаа хоёуланд нь суга таяг барин бүтэн цагаар номлол хийн явж байлаа. [Нэг өдөр түүний номлолын ерөнхийлөгч нь] түүн рүү хараад “Ахлагч Эйлворф, чи өөртөө буй итгэлийнхээ хүчээр эдгээр таягнуудаа авч хаян алхаж яагаад чадахгүй гэж? хэмээн хэлжээ. . . . Тэр таягнуудаа доош тавиад тэр цагаас хойш хэзээ ч дахин тэдгээрийг хэрэглээгүй юм.” (Марион. Г. Ромни, “Trust in the Lord”, *Ensign*, 11-р сар, 1977, х. 42-ыг үз.)

27-в. Ургамалд нарны гэрэл, агаар, ус хэрэгтэйн адил итгэлд тогтмол тэжээл хэрэгтэй байдаг.



Урьдчилан даалгасан чуулгын гишүүнээр сүмийн гишүүн болсон тухай түүхийг нь эсвэл хувийн хямрал, сорилтын үеийн турш итгэлээрээ амьдрах хэрэгтэй болсон тухайг нь яриул.

Дүгнэлт

Итгэлээ нэмэгдүүлэхийн тулд бид түүнийгээ тогтмол хөгжүүлэх хэрэгтэй. Энэ нь бидэнд цаг үргэлж хэрэгтэй байдаг бэлэг ба адислал юм. Сүмд бидний хийх ёстой зүйлс Исүс Христэд итгэх итгэлийг шаарддаг. Жишээ нь, аравны нэгээ төлөх, эсвэл Сүмд үйлчлэх, ариун сүмд явахын тулд мөнгө хадгалах зэрэг нь итгэлийг шаарддаг. Исүс Христэд итгэх итгэлээ бид Түүнийг дуулгавартай дагаж, Түүний ариун сургаалыг суралцаж, залбиран, мацаг барьж, цуглаандаа оролцож, Сүмдээ үйлчлэх зэргээр хөгжүүлбэл олон гайхамшигтай адислалуудыг хүлээн авах болно. Бид итгэлээ хөгжүүлснээр авч чадах хамгийн агуу адислал бол Тэнгэр дэхь Эцэгтээ буцаж очихдоо зохистой байх явдал юм.

Уриалга

1. Өвчтөн адислах пристийн зэргийн ёслолыг гүйцэтгэхээр дуудагдахдаа Исүс Христэд итгэх итгэлээ хөгжүүл.
2. Хувийн бэрхшээлтэй асуудалтай тулгарахдаа итгэлийн зарчмуудыг хэрэгжүүл.

Нэмэлт Судрууд

Марк 6:5–6 (Итгэл байхгүй үед гайхамшгууд тохиолдохгүй)

Еврей 11 (Итгэлийн хүч чадлын талаарх яриа)

1 Пэтр 1:3–9 (аврал итгэлээр ирдэг)

Инос 4–8, 15 (нүгэл итгэлээр өршөөгддөг)

Ефер 12:12–21 (Итгэлийн хүч чадлын талаарх жишээнүүд)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Faith in Jesus Christ,” 13-р бүлгийг унш .
2. Еврей 11-р бүлгийг судал.
3. Ангийн гишүүдэд хичээл дэх судар ба түүхүүдийг уншиж танилцуулахыг даалга.

Энэ хичээлийн зорилго бол наманчлал биднийг Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиход хэрхэн бэлтгэж чадахыг ойлгоход туслах явдал юм.

Оршил

Бошиглогч Жозеф Смит нэгэн удаа энэхүү уриалгыг гаргасан билээ: “Ингээд одоо бүх зүрх сэтгэлээсээ бид нүглээ бүрмөсөн авч хаяж, зөв шударга болцгоож энэ өдрийг цоо шинээр эхэлцгээе хэмээн хэлцгээе” (Teachings of the Prophet Joseph Smit, p. 364).

Бид дэлхийд сурч мэдэн, хөгжиж өсөхийн тулд ирсэн учир бид бүгд алдаа гаргадаг. Олон төрлийн алдаанууд байдаг. Эелдэг бус байх эсвэл бусдын зүйлсийг авах зэрэг хийж болохгүй гэж мэдэж байсан зүйлсийг бид заримдаа хийдэг. Эдгээрийг хууль бус нүглүүд хэмээн нэрлэдэг. Зарим үед бид хийх ёстой зүйлсээ хийхээс татгалздаг. Жишээ нь, аравны нэгээ төлөх, найз нөхөдтэйгээ нөхөрсөг байх гэх мэт. Эдгээрийг хайнга байдлын нүглүүд хэмээн нэрлэдэг.

Наманчлалын Хэрэгцээ

Бид буруу зүйл хийснээ мэдэж байгаа үедээ аз жаргалтай байж чаддаггүй. Хийсэн алдаанаасаа бид ичиж, Их Эзэнд зүй ёсоор үйлчилж чадахгүй байгаагаа ухамсарладаг. Зарим үед бидний баяр баясгалангүй байдал маань биднийг бусдад муухай зан гаргахад хүргэдэг. Тэнгэрлэг Эцэг маань биднийг аз жаргалгүй байхыг хүсдэггүй. Тэр биднийг бүгдийг нь өөрт нь буй адислалуудыг хүртээсэй гэж хүсдэг боловч Тэр бидэнд зүй ёсоор хүртэх ёсгүй адислалуудыг бидэнд өгөхгүй. Энэ нь Тэр биднээс нүүр буруулсан, эсвэл биднийг хайрладаг хайр нь багасдаг гэсэн үг биш юм. Энэ нь Тэр биднийг өөрсдөө сул дорой байдлаа даван туулаасай хэмээн хүсэж байгаа гэдгийг энгийнээр илэрхийлж байгаа бөгөөд хэрэв Тэр бидний буруу хийсэн зүйлд маань адиславал, бид сул дорой байдлаа даван туулахыг эрмэлзэхгүй байх болно. Наманчлал бол биднийг сул дорой байдлаа даван туулж, Түүнтэй хамт амьдрахад маань биднийг зохистой байлгахад туслахын тулд зохиогдсон Бурханы төлөвлөгөө юм.

Энэ шалтгааны улмаас Тэр бидэнд аль талаа сайжруулан бэхжүүлэх хэрэгтэйгээ олж мэдэхийн тулд амьдарч буй байдлаа шалга хэмээн хэлсэн билээ. Ерөнхийлөгч Жозеф Смит: “Өнөөдөр өчигдрөөсөө илүү сайн байж, маргаашаа өнөөдрөөсөө улам сайн

болгох нь бидний үүрэг. Яагаад? Учир нь бид зөвхөн дуулгавартай байдал болон зүрх сэтгэлдээ . . . нүглээ . . . даван туулах хүслээр дамжин төгс төгөлдөр тийш хөтлөх тэр зам дээр явж байна” хэмээн сургасан билээ. (Doctrine of Salvation, 2-р боть хх. 18–19.)

Алма 11:37-г унш. Наманчлал нь яагаад зайлшгүй хэрэгтэй вэ? 1 Иохан 1:8–10, Алма 34:33–34; 3 Нефай 30-ийг унш. Бид яагаад нэн даруй наманчлах хэрэгтэй вэ?

Хүн Хэрхэн Наманчилдаг вэ?

Нүгэл бол бидний бие махбодон дээр буй хир буртагтай адил. Энэ нь бидний оюун санааг бохирдуулдаг. Наманчлал нь хир буртгийг ус савангаар угаахтай адил юм. Наманчилсны дараа бид шинэ сэргэг ба цэвэр болдог. Ахлагч А.Теодор Таттл үүнийг ийм замаар тайлбарласан юм;

“Наманчлал нь савантай адил. Энэ нь амьдралын саван юм. Савангийн нэгэн адил энэ нь амьдралын нүглийг угаан арилгадаг. Энэ нь хэрэгцээнийхээ хэрээр тогтмол ашиглах зориулалттай юм. Хагас дутуу цэвэрлэгээ ба хагас дутуу хичээл зүтгэл гаргаж буруу хэрэглэх нь—таарахгүй, дутуу цэвэрлэх явдалд хүргэнэ гэдгийг ухаан санаандаа тунгаан ав. Зөв хэрэглэсэн амьдралын саван нь бүрэн гүйцэд, бүхэлд нь цэвэрлэдэг юм. . .

“Нэгэн өдөр бид . . . Их Эзэний шүүлтийн ширээний өмнө зогсох болно. Тэнд бид магадгүй нүглээр бохирдсон, хиртэй ариун бусаар зогсох эсвэл—агуу их гайхамшигтай амьдралын савангаас цэвэрлэгээ хүлээн авч хичээл зүтгэл гаргасан учраас цэвэр, өршөөгдсөн, ариунаар Их Эзэний өмнө зогсож болох юм. Дараагийн удаа та бүхэн саван хэрэглэхдээ, наманчлалын бүх нийтийн хууль болох амьдралын саван ашиглан сүнсээ цэвэрлэх талаар бодохыг хүсэж болох юм.” (“Repentance”, *Improvement Era*, 11-р сар. 1968. х. 64).

Наманчлахын тулд бид тодорхой хэсэг үе шатыг мөрдөх ёстой.

“Жинхэнэ наманчлал цаг хугацаа хичээл зүтгэлийг шаарддаг” 28-а үзүүлэнг таниул.

Евангелийн Үндсүүд гарын авлагын 14-р бүлэгт буй наманчлалын долоон хэсгийг ярилц. Хэрэв боломжтой бол хэд хэдэн ах нарт хэсэг болгоныг өгч, түүнийг ярилцахад бэлтгэн танилцуулахыг хүс. Тэдгээрийн талаар ярилцаж байх хооронд наманчлалын долоон хэсгийг жагсаасан картыг өлгөн тавь. (Нүглээ таньж мэдэх, нүгэлдээ гэмших, нүглээ бүрмөсөн хаях, нүглээ хүлээх, хохиролгүй болгох, бусдыг өршөөх. Бурханы зарлигуудыг биелүүлэх зэрэг долоон хэсэг юм.)

Үнэн сэтгэлээсээ наманчлах нь хялбар биш юм. Энэ нь цаг хугацаа ба хичээл зүтгэлийг шаарддаг. Энэ шалтгааны улмаас бид наманчлах өдрөө хойшлуулж болохгүй. (Алма 13:27-үз).

28-а. Жинхэнэ наманчлал цаг хугацаа, хичээл зүтгэлийг шаарддаг.

28-б. Исүс Христ бидний нүглийн төлөөсийг төлсөн тул наманчлал нь боломжтой болсон юм.





Наманчлалын Баяр Баясгалан

“Исүс Христ бидний нүглийн төлөөсийг төлсөн тул наманчлал нь боломжтой зүйл юм”
28-б үзүүлэнг таниул.

Бид нүглийнхээ өршөөлийг авахын тулд нүглээ наманчилдаг билээ. Гэвч хэрэв Исүс Христ бидний нүглийн төлөөсийг төлж, бидний төлөө үхээгүй бол бид хэзээ ч өршөөгдөж чадахгүй байх байсан. Энэ нь зөвхөн Түүний цагаатгах золиослолоор нигүүлсэл, шударга ёсыг хангаж, бид нүглээсээ цэвэрлэгдэж чадна (Алма 34:10–16-г үз). Энэ нь агуу адислал бөгөөд бид үүнд байнга талархаж байх ёстой.

Исүс Христ нүглийн төлөөсийг төлсөн ч, бид нүглээ наманчлахгүй л бол нүгэл маань биднээс салахгүй. Залуу Алма нүгэл хийснээ мэдээд, тамын зовиураар өөрийг нь зовоосон бүх нүгэл ба муу муухай явдлаа эргэн санасан хэмээн хэлжээ. . .

Тэрээр мөн Бурханы Хүү Исүс Христ дэлхийн нүглийг цагаатгахын тулд ирэх болно хэмээн эцгийнхээ хүмүүст номлож байсныг сонссоноо бас санажээ. . .

Тэр энэ бошигийн талаар санаад Исүсээс нигүүлсэл хүсэн залбирчээ. . .

Тэр үүний талаар бодоод, дахин тэр зовлон шаналлаа санасангүй. . .

“Тэр баяр баясгаланг мэдэрч гайхамшигтай гэрлийг харж түүний зүрх сэтгэл нь зовлон зүдүүрээр дүүрэн байсны нэгэн адилаар баяр баясгалангаар дүүрэв” (Алма 36:13,17–20-г үз).

Үрэлгэн хүүгийн тухай сургаалт үлгэрийг ярихыг ангийн гишүүнээс хүс (Лүк 15:11–32). Үрэлгэн хүү наманчлалын үе шатуудыг хийж эхэлснээр юу мэдэрсэн бэ? Эцэг нь юу мэдэрсэн бэ?

Хүмүүс нүгэл хийсээр байдаг бөгөөд наманчлах хэрэгтэй учир үрэлгэн хүүгийн түүх дараах түүхэнд ахин дахин давтагдан яригддаг билээ:

Урьдчилан даалгасан ангийн гишүүнээр орчин үеийн үрэлгэн хүүгийн тухай дараах түүхийг ярихыг хүс. Түүний мөрдсөн наманчлалын шатуудыг танин тогтоохыг ангийн гишүүдээс хүс.

“17 нас хүртлээ би сүмтэй холбоотой байж, бүх цуглаануудад оролцож, пристийн зэргийн үүрэг хариуцлагуудаа биелүүлж байсан билээ. Би үүнээс өөр зүйл хийх ёсгүй гэж би боддог байв. Би Сүм ба түүний хөтөлбөрүүдэд дуртай байлаа.”

“17 насандаа би бүх өсвөр насныхны адил өөрийгөө бие даасан хэмээн бодож, гэр бүлийнхээ зааварчилгааны эсрэг байж чөлөөт сонголтоо шаардаж байв. Миний сайн найз нарын нэг нь өөр сүмд харьяалагддаг байсан бөгөөд би түүний надад санал болгосон согтууруулах ундаа, тамхи зэрэг зарим нэг зүйлийг хүртэх урхинд орчихов. Би ХҮГ бус олон охидтой болзоонд явж, удалгүй нэгэн гайхамшигтай залуу эмэгтэйд дурлав. Түүний эцэг эх нь намайг

бямба, ням гаригуудад зуны байшиндаа урьж, энэ явдал нь мэдээж хэрэг намайг сүмийн үйл ажиллагаанаас тасрахад хүргэв.”

Ингээд Дэлхийн 2-р дайн болж, Бишоп маань надаас номлолд явахыг хүсэж байгаа эсэхийг асуухад нь, би түүнд цэрэгт явж эх орондоо үйлчлэх нь дээр гэж бодож буйгаа хэлэв. Эх орондоо үйлчлэх нь чухал гэдэгт би одоо ч итгэдэг ч гэсэн би Тэнгэрлэг Эцэгийнхээ номлолд эхэлж үйлчилсэн бол илүү ухаалаг байх байж гэдгийг би одоо мэднэ.

“Мөн одоо үеийг ярих юм бол, миний асар их бахархаж байсан Сүмийн зарим нэг гишүүд Сүмийн бүх жишгийг дагахгүй байгааг би анзаарч эхлэв. Би тэдний шүүгч, тэд миний хувьд хоёр нүүр гаргагчид хэмээн би өөртөө итгүүлэв. Ингээд, би хэрэв сүмийн жишгийг дагахаасаа татгалзсан л бол нэг зүйл ярьж, ярьсан зүйлээсээ эсрэг зүйл хийж хоёр нүүр гаргаснаас Сүмээс хол байсан нь дээр хэмээн өөрөө өөртэйгөө гэрээ хийв. Энэ бодол маань бас нэгэн ноцтой алдаа байлаа. Сүмээс холдох гэдэг нь миний хийсэн, мөн дайсны маань хүсэж байсан зүйл байв.”

“Дөрвөн жилийн нисэгчийн алба, 15 жилийн турш далайгаар аялуулсан мэргэжил маань намайг Сүмд идэвхгүй байхад хялбар болгосон ч, миний зүрх сэтгэлд гүнзгийгээр төлөвшүүлсэн үнэнд би энэ бүх жилүүдийн турш итгэсэн хэвээр л байв. Намайг 38 настай байхад, миний бага дүү Том маань бидэнтэй зургаан долоо хоногийн хугацаатайгаар амьдрахаар нүүж ирсэн билээ. Ням гариг бүр тэр ганцаараа пристийн зэргийн болон бусад цуглаанууддаа явдаг байсан тул миний ухамсар намайг хатгаж эхлэв. Би ямар ч баяр баясгалангүй байлаа. Ямар нэгэн зүйл буруу байна гэдгийг би мэдэрч байсан ба энэ мэдрэмж нь асар ихээр дахин дахин ирсээр л байв. Өмнө нь би тамхийг хүссэн цагтаа хаяж чаддаг байсан бол одоо хаяж чадахгүй гэдгээ би олж мэдлээ. Зарим үед би Томын албан өрөөнд очоод Сүмийг шүүмжлэн дайрч доромжлоё гэж бодовч, дараа нь түүндээ гэмшин Томд энэ тухайгаа хэзээ ч хэлэхгүй хэмээн шийддэг байлаа. Би буруутайгаа мэдэрдэг байв. “

“Би хямралд орсоор байсан бөгөөд тэр хямрал нь каунтри клубт болсон коктейлийн баяр болон бүжгийн дараах орой ирэв. Би орондоо нэлээд оройтож орсон боловч унтаж чадахгүй байлаа. Ямар нэгэн сонин зүйл надад мэдрэгдээд байв. Ингээд эцэст нь би хайрт эхнэрээ сэрээлгүй сэмээрхэн босож, өрөөндөө холхин явж, өөрчлөгдөх ёстойгоо амьдралдаа анх удаа ухамсарлав.”

“Хүнлэг чанар ба нулимсаараа би сэтгэлийн хөдөлгөөнөө үзүүлэх ямар ч боломжгүй байсан ч, миний дараагийн санаж байгаа зүйл маань, 19 жилийн дотор анх удаагаа сөхрөн сууж Тэнгэрлэг Эцэгээ царайчлан тусламж гуйж байснаа санаж байна. Намайг залбирч

байх хооронд, баяр баясгалан, нигүүлсэл, хайрын дийлдэшгүй мэдрэмж хамаг биеийг маань бүрхэн, Ариун Сүнс намайг нэлээд удаан хугацааны туршид эхэр татан уйлах хүч чадлаар хүрээлэв. Энэ бүхний дараа надад сайхан мэдрэмж төрөв. Талархал ба баяр баясгалан зүрх сэтгэлийг минь эзэмдлээ. Би амьдралдаа хэзээ ч тийм дулаан, таатай мэдрэмж байдаг гэдгийг мэдээгүй ба халуун элсээр бүх л биеийг минь асар их хүчтэйгээр дүүргээд би өөрийгөө шатах нь хэмээн бодов.”

“Би унтлагын өрөөндөө очиж эхнэрээ сэрээв. Би уйлсан хэвээр байсан тул тэр надаас юу болсныг асуулаа. Би түүнд амьдралаа өөрчлөх мөн Исүс Христийн ариун сургаалын дагуу амьдрах хүслээ хэлэхэд, агшин зуур тэрээр намайг дэмжихээ амлав. Тэр цагаас хойш тамхи татах, ямар ч төрлийн согтууруулах ундаа хэрэглэх, аяга кофе уух зэрэг хүсэл надад хэзээ ч төрөөгүй юм.”

“Их Эзэн намайг адислаж эхэлсэн ба энэ өдрийг хүртэл адислагдсаар л байна. Жилийн дотор би хүүхдүүдээ, дараа нь удалгүй эхнэрээ усаар батлуулах боломжтой байсан юм. Нэг жилийн дараа бид Логаны Ариун Сүмд очиж эхнэртэйгээ мөнхөд гэрлэж хүүхдүүдтэйгээ холболт хийлгэсэн юм.”

“Их Эзэн төөрсөн хонь нь гэртээ эргэн ирэхэд баярладаг. Бид нүглээ наманчлан Түүний зарлигуудыг биелүүлбэл Тэр өөрийн хайр ба энэрлийг бид бүгдэд үзүүлдэг юм гэдгийг би гэрчилж байна.” (Луис.В.Коттл, “The Return of the Prodigal” *Ensign*, 3-р сар.1974, хх. 43–44.)

Энэхүү орчин цагийн үрэлгэн хүү наманчилсныхаа дараа юу мэдэрсэн бэ? Лүк 15:10-ыг унш. Тэнгэрлэг Эцэг маань бидний наманчлалыг хэрхэн үздэг вэ? (С ба Г 58:42 ба Исая 1:18-ыг үз). Нүглээ наманчилсан хүнтэй бид хэрхэн харьцах ёстой вэ?

Дүгнэлт

Бид Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болж, Түүнтэй дахин хамт амьдрахыг хүсэж байвал бүгдээрээ наманчлах хэрэгтэй. Энэ шалтгааны улмаас Исүс Христ бидний нүглийг цагаатгаснаар үүнийг боломжтой болгосон юм. Бид нүглээ наманчилбал өөрсөддөө болон Тэнгэрлэг Эцэгтээ баяр баясгаланг авчирдаг.

Ерөнхийлөгч Хэролд.Б.Ли: “Бурханы зарлигуудын хамгийн чухал хэсэг бол өнөөдрийн таны дотроо хадгалж буй хүндрэл бэрхшээл юм. Хэрэв энэ чинь шударга бус байдлын нэг хэлбэр бол, хэрэв ариун явдлын хуулийг зөрчсөн бол, худал хуурмаг байдал гаргасан бол, үнэнийг хэлэхгүй байгаа бол өнөөдөр та сул дорой байдлаа ялах боломжтой болтлоо түүн дээрээ ажиллаж эхлэх өдөр юм” хэмээн сургажээ. (Church News, 5-р сар. 5. 1973, х 3.)

Уриалга

1. Тулгарсан асуудлуудаа даван туулахын тулд Их Эзэнээс хувийн залбиралдаа тусламж хүсэн гуй. Ахиц дэвшлийнхээ талаар Түүнд өдөр бүр илтгэ, чармайлт тань сайжирвал, өнгөрсөн алдаанууддаа өршөөл гуйн залбирахаа үргэлжлүүл.
2. Наманчлалын баяр баясгалангаа бусдад, ялангуяа гэр бүлийнхээ гишүүдэд харуул.

Нэмэлт Судрууд

Дуулал 51:10 (Дэвид өршөөл хүсэн залбирсан нь)

Исая 1:16–18 (бидэнд наманчил хэмээн тушаасан)

Лүк 15:7 (наманчилж буй хүмүүст тэнгэр талархан баярладаг)

2 Коринф 7:10 (Бурханлаг харуусал наманчлалд хүргэдэг)

Мосая 4:1–3 (Христийн цагаатгалаар нүгэл өршөөгдөнө)

Алма 7:15 (усан баталгаа бол наманчлалын билэгдэл)

Алма 12:14–15 (Итгэл ба наманчлал нь авралыг авчирдаг)

Алма 34:8–9 (Ертөнцийн нүглийг Христ цагаатгсан)

С ба Г 19:16–17 (Хэн наманчилна тэдний төлөө Христ зовсон юм)

С ба Г 76:40–42 (Ертөнцийн нүглийг цагаатгахын тулд Исүс үхсэн)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Repentance,” 19-р бүлгийг унш.
2. Ангийн гишүүдэд судраа хичээлд авчрахыг сануул.
3. Хэрэв хүсвэл Евангелийн Үндсүүд гарын авлага дахь 14-р бүлэгт тодорхойлсон наманчлалын долоон шатыг ярихыг хэд хэдэн ангийн гишүүдэд даалга.
4. Ангийн гишүүдэд хичээлд байгаа түүх, судруудыг танилцуулахыг даалга.
5. Чуулгын гишүүдийн хувийн асуудлуудыг ярилцлагад хөндөхгүй байх талаас нь анхаарч хичээлийг бэлтгэ.

Усан Баталгаа ба Үргэлжийн Гэрээ

Хичээл 29

Энэ хичээлийн зорилго бол биднийг усан баталгааныхаа үеэр хийсэн гэрээгээ үргэлжлүүлэн биелүүлэхэд дэмжих явдал юм.

Оршил

Усаар батлуулсан бидний хэн маань ч гэсэн амьдралаа өөрчилж, түүнийг өргөмжлөл тийш хөтлөх зарчмуудыг өөрийн хүслээрээ дуулгавартай дагана гэдгийн бэлгэдэл болгон усаар батлуулсан билээ. Гэвч зөвхөн усаар батлуулах нь хангалттай бус юм. Тэр үед бид шинэ амьдралыг эхэлдэг ба тэрхүү шинэ амьдралынхаа адислалуудыг хүртэхийн тулд өөрсдийгөө сайжруулж өсөж дэвшихээ үргэлжлүүлэх ёстой.

Бошиглогч Алма пристийн зэрэгтэн ахан дүүсийнхээ усан баталгааны дараа тэдний төлөө сэтгэл зовон тэднээс Бурханаас сүнсээрээ төрсөн эсэхийг нь асуусан билээ. Тэрээр мөн тэднээс Бурханы дүрийг зүс царайндаа хүлээн авч, мөн зүрх сэтгэлдээ хүчтэй өөрчлөлтийг мэдэрсэн эсэхийг нь асуув. (Алма 5:14). Энэ асуулт өнөөдөр ч гэсэн чухал хэвээрээ юм. Исүс Христийн Сүмд усаар батлуулан орсноосоо хойш бид бүгд зүрх сэтгэлдээ өөрчлөлтийг мэдэрч, сүнсээрээ дахин төрсөн үү?

Олон хүн усан баталгааныхаа үеэр сүнслэг мэдрэмжийг мэдрэн баярладаг. Нэгэн гишүүн үүнийг дараах байдлаар дүрсэлжээ: “Цэвэр байж, Бурханы хүүхдийн нэгэн адил шинээр эхлэх гэсэн миний зүрх сэтгэл доторх тэр сэтгэлийн хөдөлгөөнийг би хэзээ ч мартажгүй . . . Энэ бол маш онцгой сэтгэгдэл байсан юм!” (No More Strangers, 3 боть. х. 175.)

Бидний Усан Баталгааны Гэрээ

“Усан баталгааны үеэр бид Бурханы зарлигуудыг биелүүлнэ гэсэн гэрээ хийдэг.” 29-а үзүүлэнг таниул.

Гэрээ гэдэг нь хоёр буюу түүнээс дээш тооны хүмүүсийн хоорондох зөвшилцөл юм. Усан баталгааны үеэр бид Бурхантай маш чухал гэрээ байгуулдаг. Ерөнхийлөгч Спенсэр В. Кимболл: “Усаар батлуулах гэдэг нь хийхээс татгалзах бус, харин нүгэл хилэнцээс чадах чинээгээрээ зугтаж зөв шударгаар хөдөлмөрлөнө гэсэн

29-а. Усан баталгааны үеэр бид Бурхантай зарлигуудыг нь биелүүлнэ гэсэн гэрээ хийдэг.



гэрээг бид [Бурхантай] байгуулж буй юм” хэмээн хэлжээ. (The Miracle of Forgiveness х. 94).

Ангийн гишүүдээс С ба Г 20:37, Мосая 18:8–10-ыг уншиж тэмдэглэхийг хүс. Бид усаар батлуулахдаа Их Эзэнтэй онцгой ямар гэрээнүүдийг хийсэн бэ? (Гэрээнүүдийг самбарт жагсаан бич)

Бид—

- Исүс Христийн Сүмд орно
- Түүний нэрээр нэрлэгдэнэ
- Бурханд үйлчилж түүний зарлигуудыг биелүүлнэ
- Бие биендээ үйлчилж, нэг нэгнийхээ зовлонг хуваалцана
- Христ ба Түүний Сүмийн гэрч нь байна хэмээн амладаг.

Эдгээр судрууд мөн бидэнд усан баталгааны гэрээн дэх Бурханы хэсгийг хэлдэг.

Биднийг усаар батлуулахад Их Эзэн бидэнд юу амладаг вэ? (Хариултуудыг самбарт жагсаа)

Их Эзэн бидэнд —

- Нүглүүдийг маань өршөөх
- Ариун Сүнсний удирдамжийг өгөх
- Анхны дахин амилалтын боломжийг өгөх
- Мөнхийн амьдралыг бидэнд өгөхөөр амладаг.

Тэнгэр дэх Эцэг үрүүгээ буцаж очихын тулд бид бүгд мэдрэх ёстой” хүчтэй өөрчлөлтийн” эхлэл бол усан баталгаа юм. (Алма 5:13–14 ба Мосая 5:7–9-ыг үз). Бидний ихэнх маань усан баталгааныхаа дараахан нь өөрчлөгддөггүй ч, бид гэрээнийхээ дагуу амьдарснаар бидний хүсэл ба үйл хэрэг маань өөрчлөгдөж бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ улам улам адилхан болдог. Бидний усан баталгаа маань сүнсээрээ дахин төрөх шинэ эхлэлийг бидэнд өгдөг юм. “Бид Христтэй адил усан баталгаагаараа усанд “оршуулагдан”, дараа нь шинэ амьдралд эргэн босож ирдэг юм. (Ром 6:3–4-ийг үз). Энэ шинэ амьдрал маань Бурхантай хийсэн урт удаан хугацааны гэрээгээр эхэлдэг ба бид өөрсдийн хэсгийг биелүүлбэл, Тэр өөрийнхийгөө биелүүлэх болно. Бид Түүнийг дуулгавартай дагавал, Тэр бидэнд өөрчлөгдөхөд маань тусалж, биднийг Түүн рүү буцаж очиход хөтлөх болно.

Урьдчилан даалгасан хоёр ахан дүүсээр усаар батлуулахдаа ямар сэтгэгдэлтэй байсан мөн усан баталгаанаас нь хойш амьдрал нь хэрхэн өөрчлөгдсөн талаарх хувийн түүхээс нь яриул. Хичээлийн энэ хэсэгт өсвөр үеийнхнийг оролцуул.

Усан Баталгааны дараах Бидний Хөгжил Дэвшил

Хэдийгээр усан баталгаа нь зөвхөн эхлэл боловч зарим хүмүүс аврал зүгээр л усаар батлуулснаар ирдэг хэмээн боддог. Хэрэв бид

мөнхийн амьдралд хүрэхийг хүсэж байвал усан баталгааныхаа дараа бид зөв шударга ёсоор үргэлжлүүлэн өсөж хөгжих ёстой. Үүний тулд Их Эзэн бидэнд усан баталгааны дараа биелүүлэх ёстой тодорхой хэсэг зарлигуудыг өгсөн юм.

Ангийн гишүүдээр Моронай 6:4–9-ийг уншуул. Усан баталгааны дараа бидэнд ямар үүрэг хариуцлага ноогддог вэ? (Хариултуудыг самбарт жагсаа. Ариун Сүнсний удирдамжийг мөрдөх гэдэг нь нэг хариулт боловч үүний талаар 30-р хичээл дээр ярилцах болно.)

Усан баталгааны дараах бидний үүрэг хариуцлага бол—

- Үргэлж залбирах
- Онцгой шаардлагаар мацаг барих
- Сүмийн цуглаануудад оролцох
- Ариун ёслолыг тогтмол хүртэх
- Бие биенийхээ сайн сайхны төлөө санаа тавих
- Алдаа гаргавал нүглээ наманчлах
- Ариун Сүнсний удирдамжийг мөрдөх зэрэг юм.


Биднийг усаар батлуулж Ариун Сүнсний бэлэг хүртсэний дараа, бид амлалтаа хэдий хэр биелүүлнэ, төдий чинээ Бурхан бас биелүүлэх амлалтыг бидэнд өгсөн билээ. Гэвч бид хувийнхаа үүргүүд болон амьдралаа зохицуулан, сургуульдаа явж, шаардлагатай ажлаа гүйцэтгээд л байвал, бид ертөнцийн асуудлуудад уягдан өөрсдийн гэрээгээ мартах болно. Бид бүгд хэрхэн сүнслэг байдлаа хадгалж, шинэ амьдралдаа алхах вэ гэсэн асуудалтай тулгардаг. Моронайн дурьдсан бүх зүйлүүд нь, бид усан баталгааныхаа үеэр эхэлсэн шинэ амьдралаа үргэлжлүүлж, үнэхээр сүнсээрээ дахин төрөхөд туслахад чиглэгдсэн юм.

ЗАЛБИРАЛ

Хэрэв бид ариун сургаалын зарлигуудын дагуу амьдрахад маань хэрэгтэй хүч зориг шаардлагатай гэж үзвэл хувийн чин сэтгэлийн залбирал их чухал юм. Залбирал биднийг Тэнгэр дэх Эцэгт маань ойр байлгаж, бид Түүнтэй асуудлуудаа ярьдгийн нэгэн адил талархлаа ч мөн илэрхийлэх боломжийг бидэнд олгодог юм. Бид амьдралынхаа өдөр бүрийг залбирлаар нээж, хаадаг тул залбирлыг агуу адислал хэмээн тооцох хэрэгтэй.

МАЦАГ БАРИЛТ

Сард дор хаяж нэг удаа залбиралыг мацаг барилттай хамтатгах ёстой. Сүмийн хувьд мацгийн Ням гаригт хоёр хоолоор мацаг барьдаг. Хувь хүнийхээ хувьд бидэнд тайвшрах, сүнслэг нэмэлт хүч чадал шаардлагатай үедээ бид хэрэгцээтэй өдөр бүрдээ мацаг барьж болно. (Энэ гарын авлага дахь 31-р хичээлийг үз)



СҮМИЙН ЦУГЛААНУУДАД ОРОЛЦОХ НЬ

Бид бүгд ариун сургаалын талаар улам ихийг суралцаж, гэрчлэлээ бэхжүүлж чадах Сүмийн цуглаануудад тогтмол оролцсоноороо сүнслэг хүч чадлыг олж авдаг. Бид гэр бүлийн гишүүдээ Сүмийн бүх цуглаануудад оролц хэмээн уриалах хэрэгтэй. Бид эдгээр цуглаануудад оролцохдоо, дуулж, тунгаан бодож, яриа өгөн, бишрэнгүй байж оролцох хэрэгтэй.

АРИУН ЁСЛОЛООС ХҮРТЭХ НЬ

“Бид ариун ёслолоос хүртсэнээрээ усан баталгааныхаа гэрээг дахин сэргээдэг” 29-6 үзүүлэнг таниул.

Ариун ёслолын цуглаанд оролцох ёстой нэг шалтгаан бол ариун ёслолоос хүртэх явдал юм. Ариун ёслолыг хүртэхдээ бидний хийдэг гэрээ бол усан баталгааны үеэр хийсэн гэрээтэй маань адил юм. Ийм замаар, долоо хоног бүр ариун ёслолын турш бид усан баталгааныхаа гэрээнүүдийг санаж, тэдгээрийг биелүүлнэ хэмээн дахин амладаг.

БУСДАД ТУСЛАХ НЬ

Урьдчилан даалгасан гишүүнээс С ба Г 20:37-г С ба Г 20:77-той харьцуулахыг хүс.

Бид усаар батлуулахдаа Их Эзэнд бие биенийхээ зовлонг хамтран хуваалцаж, гашуудаж буй нэгэнтэй хамт гашуудан, тайвшрал хэрэгтэй хэн нэгнийг тайвшруулахад бэлэн байна хэмээн амласан билээ. (Мосая 18:8–9). Тусламж хэрэгтэй хүмүүст туслах, гэр бүлийнхэндээ заах, бүх хүмүүсийн сайн сайхны төлөө санаа тавих,— зэрэг найз нөхөддөө туслах үйлчилгээ бол— бидний Их Эзэнтэй хийсэн усан баталгааны гэрээний нэг хэсэг юм. Энэ нь усан баталгааны дараа бид өөрсдийнхөө төлөө хийх ёстой шинэ амьдралын чухал хэсэг юм.

НҮГЛЭЭ НАМАНЧЛАХ НЬ

Мэдээж хэрэг бид бүгд алдаа гаргадаг тул усан баталгааныхаа гэрээг биелүүлэхийн тулд наманчлах ёстой. Бид алдаагаа танин мэдэж зохих ёсны эрх мэдэлд мэдэгдэж буруугаа хүлээн зөвшөөрснөөр наманчилдаг. (Энэ гарын авлагын 28-р хичээлийг үз). Наманчлалаар дамжуулан бид нүглээсээ дахин цэвэрлэгдэж, ингэснээрээ Ариун Сүнсний удирдамжийг хүлээн авахад зохистой байж чадна.

Төгс Төгөлдөрт Хүрэх Зам

Усан баталгааны гэрээ бидэнд хэрэггүй болох цаг ирэх үү? Хариулт нь, мэдээж хэрэг үгүй— бид Бурханы нэгэн адил төгс төгөлдөр

29-6, “Бид ариун ёслолоос хүртсэнээрээ усан баталгааныхаа гэрээг дахин сэргээдэг”

болох хүртэл ирэхгүй. Тэр цаг хүртэл бид амьдралаа төгс төгөлдөржүүлэн, муу зуршлаа сайн зуршлаар сольж байх хэрэгтэй. Ерөнхийлөгч Спенсэр.Б.Кимболл: “Мэдээж хэрэг өөрийгөө хянах нь аяллын байнгын хөтөлбөр бөгөөд нэг хэсэг нь биш юм. Царсны боргоцой гэнэт царс болдоггүйн нэгэн адил хүмүүс тэр дороо зөв шударга болдоггүй. Хүн зорилго уруугаа шийдэмгийгээр алхсан ч төгс төгөлдөр тийшэх дэвшил хурдан байж чадахгүй” гэжээ. (The Miracle of Forgiveness, х .210.)

Бошиглогч Нефай сургахдаа усан баталгааны дараа “бид урагш давшин” “эцсээ хүртэл тэвчих” хэрэгтэй гэдэг билээ. Хэрэв бид дуулгавартай байснаар өөрсдийн хайраа Бурханд харуулбал, Тэр бидэнд мөнхийн амьдралыг өгнө хэмээн Нефай бидэнд амласан билээ. (2 Нефай 31:19–21-ийг үз). Бид Их Эзэнийг дуулгавартай даган усан баталгааныхаа үеэр Түүнтэй хийсэн гэрээгээ биелүүлбэл, энэ амьдралдаа аз жаргал, ирэх амьдралдаа мөнхийн баяр баясгаланг мэдрэх болно.

Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит гэрээгээ биелүүлэхдээ эцсээ хүртэл тэвчихийг ийм замаар тайлбарлажээ: “Үнэний сүмийн агуу зорилгуудын нэг бол усан баталгааныхаа дараа ариун сургаалын бүрэн адислалыг авахын тулд хүмүүс юу хийх ёстойг тэдэнд заах явдал юм. . . . Бид эцсээ хүртэл тэвчих ёстой; бид усан баталгааныхаа дараа зарлигуудыг биелүүлэх ёстой, бид авралынхаа төлөө хөдөлмөрлөх ёстой; . . . бид бурханлаг шинжтэй хамаатай шинжийг эзэмшихийн тулд мөн сэлэсчөл хаант улсын гайхамшгууд ба алдар хүндээр баясан цэнгэж чадах хүмүүс болон амьдрах ёстой.” (“The Plan of Salvation”, *Ensign* 11-р сар 1971, х. 5.)

Дүгнэлт

Урьд нь Католик гэлэнмаа байж байгаад Сүмд элсэн орсон эмэгтэй өөрийнх нь усан баталгаа өөрт нь ямар их үнэ цэнэтэй болохыг дараах байдлаар тайлбарласан юм:

“Сүм дээр үзэж сонссон бүх зүйл миний сэтгэлийг ихэд хөдөлгөсөн юм. Дулаан уур амьсгал, хайр энэрэл, гишүүн бүр бусад гишүүддээ чин сэтгэлээсээ санаа тавих байдал зэрэг нь, намайг энэ шашин ямар нэг онцгой зүйлтэй байх ёстой гэсэн бодолд хүргэв. . . .”

“Дараа нь би буруу сүмд явж байсан ба Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтэнүүдийн Сүм л үнэхээр энэ дэлхий дээрх цорын ганц үнэний сүм юм гэдгийг би мэдэв. Би үүнд нэгдэн орох ёстой гэдгээ бас мэдэж байлаа. . . .”

“Хуучин амьдралаасаа одоогийн энэ амьдрал уруу шилжих нь хялбар байгаагүй ч бүх л тохиолдлуудын минь турш— Аврагчийн нэрийг өөр дээрээ хүлээн авч, Түүнийг үргэлж дурсан санах, Түүний

сургаалуудыг биелүүлэх гэсэн миний гэрээ болон үүний хариу болох Их Эзэний гэрээ, хэрэв би эдгээр амлалтуудыг биелүүлбэл, Түүний Сүнс үргэлж надтай хамт байх болно хэмээн ариун ёслолын цуглаан дээр хийдэг усан баталгааны гэрээг шинэчлэх нь намайг дэмждэг байлаа.”

“Дараа нь би усан баталгаа ба усанд бүх л биеэрээ умбан дүрэгдсэнээ санаж байна. Энэ нь надад хувиа хичээх байдал, нүгэл хоёрын үхэл болон шинэ амьдралд Бурханы хүүхэд болон босож ирэхийн бэлэгдэл болсон юм. Усан баталгааны энэхүү ёслол нь мөн хувиа хичээх байдлыг даван туулж, уруу таталттай тэмцэн амьдраасай хэмээсэн Тэнгэрлэг Эцэгийн хүслийн бэлэг тэмдэг гэж би бодож байлаа. Ийм маягаар бид хувиа хичээх байдал болон нүглээ булшилж, Эцэг үрүү хүрэх зам дээр өдөр бүр өсөн хөгждөг.”

“Би Түүнийг, ариун сургаалын зарчмуудыг, Түүний сургаалуудыг, Сүмийг хүлээн зөвшөөрч, биднийг Бурханы нэрээр хөтлөн удирдахаар Тэнгэрлэг үүрэг авсан бошиглогчид болон Сүмийн бусад эрх мэдэлтнүүдийг дэмжих амлалтаа дахин сэргээж байна гэдгээ би Түүнд хэлэн, Исүс Христийн нэрийг өөр дээрээ авч байгаа гэрээгээ даруухнаар шинэчилж байна. Би өөрийн даруухан залбиралдаа ялангуяа уруу таталт, уруудан доройтох өдрүүдэд Түүнийг дуудаж байна хэмээн үргэлж Түүнийг дурсан санаж байна гэсэн гэрээндээ нэмэн хэлэх зэргээр гэрээгээ сэргээж байна. Би үүнийг итгэлтэйгээр хийвэл, Түүний Сүнс надтай хамт байх болно гэж мэддэгийнхээ хувьд би Түүний зарлигуудыг биелүүлнэ гэсэн гэрээгээ дахин шинэчилж байна.” (Мириан Спэйн Пэтэрсон, “The Lord Takes Care,” No More Strangers, 3 боть хх. 154–159.)

Уриалга

Усан баталгаанаасаа хойш амьдралдаа юу хийснээ шалга. Тэр цагаас хойш магадгүй танд зүрх сэтгэлийн өөрчлөлт гарч эхэлж буйг мэдэрсэн байх. Бошиглогч Алма биднээс одоо дээрх байдлыг мэдэрч чадаж байгаа эсэхээ авч үз гэж хүссэн. (Алма 5:26). Энэ сударт дурдсан, “амьдралын шинэчлэлтийг” та одоог хүртэл мэдэрч чадаж байна уу? Хэрэв ямар нэг зүйл дутагдаж байвал өнөөдрөөс эхлэн наманчилж буруугаа зас.

Нэмэлт Судрууд

Галат 3:27–29 (Бид усан баталгааныхаа үеэр Христийн нэрийг өөрсөд дээрээ авдаг)

1 Пэтэр 3:21 (усан баталгаа бол авралын угтвар нөхцөл юм)

С ба Г 27:2 (Христийг дурсан санахын тулд бид ариун ёслолоос хүртдэг)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Baptism,” 20-р бүлгийг унш.
2. Энэ гарын авлагын 28 ба 31-р хичээлийг унш.
3. Самбар, шохой бэлд, эсвэл усан баталгааны гэрээг мөн Моронай 6:4–9-д буй зөвлөгөөг бичсэн үзүүлэн хий.
4. Сонголтоор: Усан баталгаа ба ариун ёслолын гэрээг харьцуулахыг ангийн гишүүнд даалга.
5. Хичээл дэх судар ба түүхүүдийг ярихыг ангийн гишүүдэд даалга.

Энэ хичээлийн зорилго бол Ариун Сүнсний бэлгээр дамжин ирэх агуу адислалуудыг ойлгоход бидэнд туслах явдал юм.

Оршил

Сүмд нэгдэн орохоос өмнө Ариун Сүнс бидэн дээр ирж болох юм. Жишээлбэл, номлогч нарыг сонсож байх үед бидэнд төрөх сайхан мэдрэмж бол Ариун Сүнс бидэнд ойлгож, ариун сургаалыг хүлээн авахад маань тусалж буй явдал юм. Гэвч бид усан баталгаа хийлгэж, батлуулах хүртлээ Ариун Сүнсстэй тогтмол нөхөрлөх эрх байдаггүй. Тэр үед Мелкизэдэк Пристийн зэргийн хүч чадлаар бидэнд толгой дээр гар тавин Ариун Сүнсний бэлгийг өгдөг.

Ерөнхийлөгч Лорензо Снөү бидэнд зөвлөхдөө: “Бид энэхүү сүнсний мөн чанарыг суралцахыг хичээх хэрэгтэй, тэгвэл бид түүний санааг ойлгож чадах ба, ингэснээрээ үргэлж зөвийг хийх боломжтой болно. [Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан] тэр цагаас хойш бид буруу зүйл хийхээр өөрсдийгөө жолоодохгүй л юм бол найзтай байх болно. Тэр найз бол Ариун Сүнс юм” гэжээ. (Conference Report, 4-р сар 1899, х 52.)

“Ариун Сүнсний бэлэг бол Ариун Сүнсийг тогтмол хамтрагчаа болгох эрх юм.” 30-а үзүүлэнг таниул.

Ариун Сүнс юугаараа найз нөхөртэй адил вэ? Ангийн гишүүдээр Иохан 14:16, 17, 26 ба Жон 16:13-ыг уншуул.

Бид яагаад Ариун Сүнсийг хамтрагч ба найзаа болгох хэрэгтэй вэ? (Хариултуудыг самбарт жагсаа.)

Ариун Сүнс бидэнд тусалдаг зарим нэг арга зам бол:

- Тэр бидэнд үнэнийг илчилдэг.
- Тэр бидэнд ариун сургаалыг заахад маань тусалдаг.
- Тэр бидэнд ямар нэг зүйлийг санахад маань тусалдаг.
- Тэр уй гашуу тохиолдсон үед биднийг тайвшруулдаг.
- Тэр биднийг нүглээс хамгаалдаг.
- Бид яриа өгөхөд болон хичээл дээр ариун сургаалыг зааж байхад тэр биднийг урамшуулдаг.
- Бидэнд аюул тулгарахад тэр сэрэмжлүүлдэг.
- Тэр бидний хийх ёстой бүх зүйлийг хэлж өгдөг.

2 Нефай 32:5-ыг унш.



Ахлагч Лигранд Ричард дараах ишлэлийг хэлсэн юм: Би өөрийн хүүхдүүд, хүүхдүүдийнхээ хүүхдүүдийг ертөнцийн нөхөрлөлөөр баясан цэнгэхээсээ илүү Ариун Сүнсний нөхөрлөлөөр цэнгээсэй гэж хүсэж байна. Учир нь тэд тэрхүү Сүнсний шивнэхийг сонсвол тэр тэднийг бүх үнэнд хөтөлж мөн тэдний Тэнгэр дэх Эцэг үрүү нь буцаан амар мэнд үдэж өгөх болно. (Improvement Era, 6-р сар 1966, х 540).

Ариун Сүнс хамгийн их хүсэн хүлээж байдаг хамтрагч тул бид түүнийг өөрсдийн найз болгон хамтрагчтайгаа хамт байхын тулд хийж чадах бүхнээ хийх ёстой.

Ариун Сүнсийг Өөрсөдтэйгээ Хамт Байлгах нь

Ариун Сүнсийг өөрсөдтэйгээ байлгахын тулд бид олон зүйлийг хийж чадна. Үүний нэг зам бол ариун ёслолоос зохистойгоор хүртэх явдал юм. Ариун ёслолоос хүртэх бүрдээ бид Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагана хэмээн амладаг. Хэрэв бид амлалтаа биелүүлбэл бид үргэлж Түүний Сүнстэй хамт байх болно хэмээн Их Эзэн амладаг. (С ба Г 20:77-г үз.)

Ариун Сүнсийг өөрсөдтэйгээ байлгах өөр нэгэн арга бол бие махбодоо ёс суртахууны хувьд цэвэр байлгах явдал юм. Их Эзэн бидэнд хэлэхдээ: бидний бие махбод ариун сүмтэй адил учир тэдгээрээ бузартуулж болохгүй гэдэг билээ. (1 Коринф 3:16–17 үз). Ариун Сүнс цэвэр бус ариун сүмүүдэд амьдарч чадахгүй учраас бид бие махбодоо, бодол, яриа, хувцаслалт, үйл хэргээ цэвэр байлгаж нүгэл хилэнцийн ямар ч байдлаас зайлж ариун байлгах нь чухал юм. Ахлагч Мелвин.Ж.Баллард, “Ариун Сүнс миний мэдэх хамгийн мэдрэмтгий сүнс юм” гэж нэгэн удаа хэлсэн юм. (1967–68 Priesthood Study Course, Deacons Quorum, х. 70). Ариун сүнс их мэдрэмтгий учир бидний хэлэлцсэн чухал бус зүйлсээс болж гомдож болно.

Ариун Сүнсийг өөрсөдтэйгээ байлгахын тулд бид эргэн тойронд буй хүмүүстэйгээ таарамжтай амьдрах ёстой. Христ нефайчуудтай ярьж байхдаа маргааны сүнс муу ёрын сүнснээс ирдэг хэмээн хэлсэн билээ. (3 Нефай 11:29-ийг үз). Таарамжгүй эв нэгдэлгүй байдал оршин байгаа газар Ариун Сүнс амьдарч чадахгүй. Энэ шалтгааны улмаас эхнэртэйгээ маргах, ах эгч нартайгаа хэрэлдэх явдал нь Ариун Сүнсийг биднээс болон гэрээс маань холдуулах болно.

Жишээ нь, бошиглогч Жозеф Смит бусдын тухай зөв бодолтой байхгүй л юм бол Их Эзэнээс ямар ч урам хүлээн авч чадахгүй байсан. Нэг өглөө тэрээр эхнэрийнхээ хийсэн ямар нэгэн зүйлд сэтгэл нь дундуур байлаа. Дараа нь тэрээр Мормоны Номноос

зарим нэг хэсгийг орчуулах гэсэн боловч чадахгүй байв. Тэрээр бодлогоширон жимсний цэцэрлэгтээ очиж залбирчээ, ингээд гэртээ эргэн ирж Эммагаас өршөөл гуйв. Зөвхөн үүний дараа л тэр орчуулах боломжтой болжээ. (1882, 9-р сарын 15-нд өгсөн Дэвид Уитмерын ишлэлээс авав. *Comprehensive History of the Church*. 1 боть. х. 131.)

Бидний Ариун Сүнсний хэрэгцээ бошиглогчийн нэгэн адил асар их билээ. Үүрэг хариуцлагатаа, ялангуяа гэр бүлийнхэндээ зааварчлахад Ариун Сүнсээр удирдуулах нь бидэнд зайлшгүй хэрэгтэй билээ. Хүүхдүүд буруу зүйл хийвэл, бид түргэн зан гаргаж болохгүй харин тэдний алдааг засахад Ариун Сүнсээр зааварчилж өгөхийг хүсэх ёстой. (С ба Г 121:43-ыг үз).

Ариун Сүнсийг бидний хамтрагч байхад саад болох ямар зүйлсийг бид хийдэг вэ? Түүний нөхөрлөлийг байлгахын тулд бид юу хийж чадах вэ? (Хариултуудыг хоёр тусдаа эгнээ болгон самбарт жагсаан бич.)

Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит: Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаж биелүүлэхийг хүсдэггүй хүнтэй Ариун Сүнс амьдарч чадахгүй. . . . Иймэрхүү хүмүүст Ариун Сүнсний мэдрэмж ирж чадахгүй.

“Тэрхүү агуу бэлэг бидэнд зөвхөн хүнлэг чанар, итгэл ба дуулгавартай байдлаар дамжин ирдэг. . . . Бурхан тэргүүний нэг гишүүнтэй нөхөрлөлийн холбоотой байх нь ямар их аз завшаан болох талаар та бүхэн бодож байсан уу? Та энэ талаас бодож үзсэн үү? Бид Их Эзэний өгсөн зарлигуудыг биелүүлэх нь бидний аз завшаан,” хэмээн хэлжээ. (*Church News*, 11-р сар 4. 1961, х. 14.)

Ариун Сүнсний Бидэнд Тусалдаг Арга Замууд

Ариун Сүнсийг өөрсдийн хамтрагчаа байлгах хүслээ итгэлээрээ харуулбал тэр бидэнд улам аз жаргалтай сайхан амьдралаар амьдрахад маань дараах замаар тусална:

ТЭР БИДЭНД УЛАМ САЙН ХҮМҮҮС БАЙХАД ТУСАЛДАГ

Ариун Сүнс “ариун журам, эелдэг байдал, сайн чанар, нинжин сэтгэл, даруу байдал ба энэрлийг зоригжуулдаг.” (Парлей.П.Прэтт, *Key to the Science of Theology*. х. 101).

ТЭР БИДЭНД ЮУ ХИЙХИЙГ МААНЬ ХАРУУЛДАГ

Ариун Сүнс бидэнд чухал шийдвэр гаргахад тусалдаг.

С ба Г 6:15 ба С ба Г 8:2-ыг унш. Ариун Сүнс шийдвэр гаргахад бидэнд хэрхэн тусалдаг вэ?

ТЭР БИДЭНД СҮМД ӨСӨЖ ХӨГЖИХӨД ТУСАЛДАГ

Ахлагч Франклин.Д.Ричардс өөрийг нь Ариун Сүнс хэрхэн удирдсаныг дурссан билээ: “Ах Эгч дүү нар минь, би хүмүүст

пристийн зэргийг батлах; Сүмийн албанд эмэгтэй эрэгтэй хүмүүсийг онцгойлон адислах; өвчтөнд адислал өгөх; сүмийн гишүүд, гишүүн бус хүмүүстэй гэрчлэлээ хуваалцах, ёслол үйлдэх болон бусад олон үед Ариун Сүнсний намуухан дуу хоолой, шивнээг сонсоор л байна” (The Continuing Power of the Holy Ghost, *Ensign*, 7-р сар 1973, х. 117).

ТЭР БИДНИЙГ СЭРЭМЖЛҮҮЛДЭГ

Ариун Сүнс биднийг аюул болон уруу таталтаас сэргийлэх үеүүд байдаг. Ахлагч Франклин Д.Ричардс, босож доод давхар руу оч гэсэн дуу хоолойг нэгэн шөнө сонсоод сэрсэн залуу эцгийн тухай ярьсан юм. Тэр сэрэмжлүүлгийг сонсоод галын өрөөндөө ороход нэг хана нь шатаж буйг харжээ. Тэр сандран гэр бүлийнхнээ сэрээн, гал команд дуудан, гэр бүлийнхнийхээ тусламжтайгаар гал командынхныг ирж гал унтараатал галтай ноцолджээ.

“Энэ сэрэмжлүүлэг нь Сүнстэй зохицож амьдардаг тэдгээр хүмүүст Ариун Сүнсний өгч чадах хамгаалалтын илрэл байсан гэдэгт тэр ердөө ч эргэлзсэнгүй.” (*Ensign*, 7-р сар 1973, х. 117.)

Урьдчилан даалгасан гишүүнээс уруу таталт, аюулын үед Ариун Сүнс хэрхэн сэрэмжлүүлсэн тохиолдлоос нь хуваалцахыг хүс.

ТЭР БИДНИЙГ ТАЙВШРУУЛЖ ЧАДНА

Ариун Сүнсний үүргүүдийн нэг нь уй гашуу, өвчин зовлонгийн үед тайтгаруулагч байх явдал юм. Ийм цаг үед Ариун Сүнс бидэнд амар амгалан ба ойлголтыг олоход тусалдаг. Ахлагч Франклин Д.Ричардс дараах тохиолдлыг ярьсан юм: “Онгоцны эмгэнэлт ослоор нөхрүүдээ алдсан найз болох хоёр гайхамшигт эмэгтэйтэй уулзах завшаан надад тохиосон юм. Би тэдэнтэй уй гашуутай цөхөрсөн үед нь уулзсан уу? Ерөөсөө ч үгүй. Тийм асар их эр зориг, хүч чадлыг би урьд өмнө нь хэзээ ч үзээгүй. Хэрэв тэд Сүмд ойрхон амьдарч, Их Эзэний зарлигуудыг биелүүлбэл тэд болон тэдний гэр бүлийнхэн нь сайн сайхан байх болно гэсэн Ариун Сүнсний баталгааг үнэхээр мэдэрсэн гэсэн гэрчлэлийг тэд хуваалцсан юм.” (*Ensign*, 7-р сар 1973, х. 117.)

Урьдчилан даалгасан гишүүнээс дараах түүхийг ярихыг хүс.

Ерөнхийлөгч Хибэр.Ж.Грант, Ариун Сүнс түүний гэр бүлийн гишүүдэд мэдлэг болон тайвшралыг хэрхэн авчирсан тухай ярьжээ:

“Эхнэрээ нас барахаас цагийн өмнө би хүүхдүүдээ түүний өрөөнд дуудан, тэдэнд эх нь нас барах гэж байна, эхтэйгээ салах ёс гүйцэтгэ хэмээн хэлсэн билээ. Бага охидуудын нэг болох арван хоёр настай охин маань надад; “Аав аа, би ээжийгээ үхүүлэхийг хүсэхгүй байна. Би та хоёртой эмнэлэгт. . . . зургаан сарын турш байсан . . . ээжийн биеийг муудах . . . бүрт . . . та түүнийг адислаж, ээж маань

өвчнөөсөө ангижирч, тайван унтдаг байсан. Би таныг ээжийн толгой дээр гараа тавин эдгээгээсэй гэж хүсэж байна,” гэв.

Би бяцхан охиндоо бид бүгд хэзээ нэг өдөр үхнэ, мөн түүний эхийнх нь хугацаа болсон гэдэг баталгааг зүрх сэтгэлдээ авсан гэдгийг хэлэв. Тэр болон бусад бүх хүүхдүүд маань өрөөнөөс гарцгаав.

“Дараа нь би ухаан алдсан эхнэрийнхээ орны өмнө сөгдөн сууж Их Эзэнд амьдрал, үхэл, баяр баясгалан, уй гашуу, хөгжил, цэцэглэлт, саад тотгор тохиолдсон үед Түүний тусламжийг авсандаа талархлаа илэрхийлэв. Миний эхнэр надад мөнхөд харьяалагдах болно гэдэг мэдлэгийг надад өгсөнд нь би Түүнд талархав Гэвч би Их Эзэнд, эхнэрээ үхүүлэх нь миний бяцхан хүүхдүүдийн итгэлийг хөндөж байгааг дааж тэсвэрлэх хүч чадалгүй байгаагаа хэлэв ингээд би өөрт буй бүх хүч чадлаараа Их Эзэнээс миний бяцхан охинд түүний ээж үхэх ёстой нь Түүний хүсэл зориг, Түүний бодол юм гэдэг мэдлэгийг өгөхийг [гуйв].

“Цагийн дотор миний эхнэр нас барж, ингээд би хүүхдүүдээ өрөөнд дуудан оруулав. Тав орчим настай бяцхан хүү маань эхэр татан уйлахад, арван хоёр настай жижиг охин маань түүнийг тэврэн: “Битгий уйл, Хибэр; биднийг энэ өрөөнөөс гарахад Их Эзэний дуу хоолой тэнгэрээс надад, “Ээжийн чинь үхлээр Их Эзэний хүсэл зориг биелэгдэх болно” гэж хэлсэн гэв”. . . .

“Бурхан залбирлуудыг сонсон хариулдаг гэдгийг би мэднэ. Зовлон тохиолдсон үед Хожмын-үеийн Гэгээнтнүүд бусад хүмүүсээс онцгой тайтгарлыг аван адислагдаж, сэргээгддэг гэдгийг би мэднэ!” (Gospel Standarts, х. 361.)

ТЭР ҮНЭНИЙГ ГЭРЧИЛДЭГ

Ариун Сүнсээр дамжуулан бид ариун сургаалын гэрчлэлээ хүлээн авдаг. Үүний адил Ариун Сүнс бидэнд удирдагчид маань Ариун Сүнсний хүч чадлаар ярьж байгаа гэдгийг мэдэхэд тусалдаг. Ахлагч Хэнри.Д.Мойл: “Яриа өгч байгаа хүн Ариун Сүнсээр удирдуулж байгааг, бид өөрсдөө Ариун Сүнсээр удирдуулсан үедээ л мэдэж чадна. Иймээс Сүмийн гишүүд итгэлтэй удирдагчдынхаа нэгэн адил хичээнгүй байх хэрэгтэй” хэмээн сургажээ. (“Revelation; Yesterday and Today”, *Improvement Era*, 6-р сар 1962, х. 407.)

Ариун Сүнсний адислалууд бидэнд Сүмийн гишүүдийн маань хувьд, хэрэв бид өөрсдөө тэдгээрийг зөв шударгаар эрэлхийлэх юм бол бодитой бөгөөд боломжтой юм.

Урьдчилан даалгасан ангийн гишүүнээс Ариун Сүнсний нөхөрлөлийг мэдэрсэн үеэ дурсан ярихыг хүс.

Дүгнэлт

Ариун Сүнсний бэлэг нь Сүмийн батлагдсан гишүүдэд өгөгдсөн агуу адислал юм. Хэрэв бид нөхөрлөлдөө зохистойгоор амьдарвал тэр бидэнд дэлхий дээрх үүргээ амжилттайгаар гүйцэтгэхэд маань туслах болно. Тэр үүнийгээ биднийг удирдан, хамгаалан, тайтгаруулан мөн бидний амьдралын бүх л талбарт бидэнд тусалснаар хийх болно.

Уриалга

Өдөр тутмынхаа амьдралд Ариун Сүнсний нөхөрлөлийг эрэлхийл. Ариун Сүнсийг тогтмол хамтрагчаа болгох, сайжруулах ёстой талбараа мэдэхийн тулд өөртөө дараах асуултуудыг тавь:

- Би бүх зарлигуудыг биелүүлэхийг хичээж байна уу?
- Би тогтмол залбирдаг уу?
- Би Аврагчийг хайрлах хайраа хэрхэн үзүүлж байгаа вэ?
- Би бусдыг хайрлах хайраа хэрхэн үзүүлж байгаа вэ?
- Би үйл хэрэг ба бодол санаагаа цэвэр байлгадаг уу?
- Ариун Сүнсний бэлгийг оролцуулаад бүх адислалуудынхаа төлөө би Их Эзэнд талархдаг уу?

Нэмэлт Судрууд

Үйлс 5:32 (Дуулгавартай байгсдад Ариун Сүнс ирдэг)

1 Нефай 10:17–19 (Ариун Сүнснээс ирдэг хүч чадал ба мэдлэг нь Христэд итгэх итгэлээр дамжин ирдэг)

2 Нефай 31:13 (Итгэл, наманчлал ба усан баталгаагаар Ариун Сүнс ирдэг)

Мозес 6:61 (Ариун Сүнсний хүч чадал ба адислалууд)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагас “The Gift of the Holy Ghost,” 21-р бүлгийг унш.
2. Ангийн гишүүдэд судруудаа ангидаа авчрахыг сануул.
3. Хэрэв самбар, шохой олодох боломжгүй бол санал болгосон жагсаалтуудын үзүүлэн бэлд.
4. Ангийн гишүүдэд хичээл дэх түүх ба судруудыг ярихыг даалга.

Залбирал ба Мацаг Барилт

Хичээл 31

Энэ хичээлийн зорилго бол бид залбирал ба мацаг барилтаар дамжуулан гэр бүл ба чуулгуудаа хэрхэн бэхжүүлэхийг суралцахад маань туслах явдал юм.

Оршил

Евангелийн Үндсүүд гарын авлагад буй мацаг барилт, залбирлын зарчмуудын талаар бага зэрэг давтан ярихыг урьдчилан даалгасан ангийн гишүүнээс хүс.

Залбирч Мацаг Барих нь Биднийг болон Гэр Бүлийг маань Бэхжүүлдэг.

Залбирч мацаг барих нь бидэнд өөрсдийгөө болон гэр бүлийнхнээ бэхжүүлэхэд тусалж чадна. Мацаг барилт нь чин сэтгэлийн залбирлыг шаарддаг тул удирдамж авахын төлөөх бидний залбирал улам хүчирхэг болдог. Үүнээс гадна бид мацаг барьж залбирахдаа ертөнцийн зүйлсээс тусгаарлагдан, Их Эзэнээс шалтгаалдаг гэдгээ танин мэддэг. Ийм маягаар бид өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ төлөө Бурханы хүслийг суралцан, хүлээн зөвшөөрөхийн тулд зүрх сэтгэлээ нээдэг билээ.

Залбирал ба мацаг барилт нь пристийн зэргээ үр дүнтэй ашиглах боломжийг өргөтгөдөг. Пристийн зэргийн хүч чадлыг хэрхэн хянахыг суралцсанаар бид, бусад хүмүүс аль аль нь адислагддаг бөгөөд пристийн зэргийг бид зөв шударга ёсны зарчмуудыг хэрэглэсэн цагт л зөвхөн хянаж чадна. (С ба Г 121:34–36-г үз.)

“Мацаг барих ба залбирах нь пристийн зэргийг атгагчдад өвчтөнийг илүү үр дүнтэйгээр адислахад нь тусалж чадна.” 31-а үзүүлэнг таниул.

Доорх түүх нэгэн пристийн зэрэгтэнд мацаг барилт ба залбирлын хүч чадал пристийн зэргээ ашиглахад нь хэрхэн тусалсан тухай өгүүлж байна:

Жон, Бонни хоёрын бага хүү хүндээр өвчилсөн бөгөөд эмч нар уг өвчнийг нугасны менингит гэж оношлов. Тэд эцэг эхэд нь тэдний хүү нэг бол үхнэ, эсвэл оюун санаа ба бие махбодоороо тахир дутуу болно хэмээн хэлжээ. Мелкизэдэк Пристийн Зэрэгтнийхээ хувьд Жон хүүдээ адислал өгөхөөр шийдэв. Тэр тосолгооны баталгаа хийхээр бэлтгэхдээ, түүний хүүгийн талаарх Их Эзэний хүсэл

31-а. Мацаг барих ба залбирах нь пристийн зэрэгтэн өвчтөнд илүү үр дүнтэй адислал өгөхөд тусалж чадна.



зоригийг мэдэхгүй гэдгээ ухаарав. Ингээд тэрээр хүүгээ ая тухтай байгаасай хэмээн энгийнээр адислав.

Адислалын дараа Жон, Бонни нар Их Эзэний хүсэл зоригийг мэдэж, үүнийг хүлээн зөвшөөрөх боломжтой болохын тулд мацаг барив. Мацаг барилтынхаа төгсгөлд, Жон, Бонни нар Их Эзэний хүсэл зоригийг хүлээн авахад бэлэн болов. Жон хүүгээ дахин адислав. Энэ үед Сүнс түүнд, хүүгээ бүрэн гүйцэд эмчлэгдэнэ хэмээн адисал гэж шивнэв. Тэдний хүү эдгэрч, гурав хоногийн дараа тэд хүүгээ эмнэлгээс гарган гэртээ авчирчээ.

Хэрэв Жон, Бонни нарын залбирлын хариулууд өөр байсан бол мацаг барилт нь тэдэнд яаж туслах байсан бэ?

Залбирал ба Мацаг Барилтаар Гэр Бүлийнхэндээ Зааж Бэхжүүлэх нь

Эцэг эхийн хувьд бид хүүхдүүдийнхээ хэрэгцээг мэдэж, тэдгээр хэрэгцээг хэрхэн хянахын тулд үргэлж залбирч байх хэрэгтэй. Жишээ нь, хүүхдүүдийн маань хэн нэг нь хувийн асуудалтай тулгарсан бол бид түүнийх нь талаар гэр бүлийн залбиралдаа дурдаж болно. Бид үүнийг үргэлж зөв замаар хийхийн тулд хянуур байх хэрэгтэй. Нэгэн эцэг хүүгийнхээ төлөө дараах үгийг хэлж залбирсан юм: “. . . Тэнгэрлэг . . . Эцэг минь, Жон зан аашаа хянахын тулд үнэхээр чармайлт гаргаж байна гэдгийг бид мэдэж байна. Бид түүнийг таны дэмжлэг тусламжаар өсөж байгааг харж байгаадаа баяртай байна. Түүнийг үргэлжлүүлэн адислаж мөн бид түүнийг уурлуулахгүй харин, түүнд хайраа үзүүлэн, туслах хүсэлтэй байгаагаа илэрхийлэхэд маань биднийг адислан тусална уу.”

(*Ensign*, 5-р сар 1973, х 34.)

Иймэрхүү залбирал залуучуудад бэрхшээлээ даван туулахад нь хэрхэн тусалж чадах вэ?

Ахлагч М.Рассал Баллард, таван настай хүү нь бага. . . , сургуульд орохоос айж байсан тохиолдлыг ярьсан юм. Хүүгээ айж буйг мэдсэн тэрээр түүнд “Крэйг, үргэлж хамт байх найз чамд бий. Хоёулаа сөгдөн сууж Түүнээс чамд туслахыг гуйя” гэжээ. (*Ensign*, 10-р сар 1976, хх 87–88.)

Гэр бүлээрээ мацаг барин залбирах нь доорх түүхэнд дүрслэгдсэнтэй нэгэн адил гэр бүлд асар их хүч зориг ба нэгдлийг авчирч чадна:

Алан гэдэг нэгэн залуу Их Эзэнд үйлчлэхээр гадаадад номлолын дуудлага хүлээн авсан билээ. Тэр үйлчлэлдээ сэтгэл өндөр байсан боловч тухайн орны хэлийг суралцаж эхлэхдээ тэр уг хэлийг сурч чадахгүй байсан учраас санаа зовж эхэлжээ.

Аланы эцэг хүүгийнхээ бэрхшээлийг ойлгоод, гэр бүлийнхнээ цуглуулав. Тэрээр тэднээс, Алан бэрхшээлээ даван туулж,

номлолоо амжилттай дуусгаахын төлөө мацаг барин залбирья хэмээн хүсэв.

Иймэрхүү тохиолдол бидний үр хүүхдүүдийг хэрхэн зоригжуулж чадах вэ? Мацаг барилт ба залбирал гэр бүлийг хамтад нь хэрхэн нэгтгэж чадах вэ? 3 Нефай 18:21-ийг унш.

Залбирал ба Мацаг Барилтаар Их Эзэний Ажлыг Биелүүлэх нь

Нэг хүн Исүс дээр ирж сөгдөн суугаад:

“Их Эзэн минь, миний хүүд нигүүлсэлтэй хандаач; Хүү маань солиотой юм. Тэр их бие муутай. Гал усанд байнга унаж ойчиж байдаг юм. Түүнийг таны шавь нарт аваачихад тэд эдгээж чадсангүй” гэв.

Их Эзэн тэр дор нь муу ёрын сүнсийг хүүгээс зайлуулав. Шавь нар нь Исүс дээр ирж “Бид яагаад түүнийг хөөн зайлуулж чадсангүй вэ?” гэхэд, Исүс тэдэнд “Итгэл чинь бага байна” гээд “залбирал мацаг барилтгүйгээр үүнийг хийж чадахгүй” гэж хэлэв. (Матай 17:14–21-ийг үз).

Дараах түүхэнд ахлагч Матай Коулей мацаг барилт ба залбирлын ач холбогдлыг ойлгосон нэгэн бишопын тухай ярьсан юм.

“ . . . Хонолулу дахь нэгэн баян чинээлэг залуухан бишопыг Куин эмнэлгээс саа өвчин туссан хүүг адислуулахаар дууджээ. Нутгийнх нь эгч түүнийг дууджээ. Тэрээр түүний бишоп байсан тул эмэгтэй түүнд, “Бишоп оо, энд ирээч, миний хүү саа өвчнөөр өвчилсөн байна, би танаар энд ирж түүнд өвчтөнийг адислах адислал өгүүлэхийг хүсэж байна” гэв. Бүтэн өдөр тэр түүнийг хүлээхэд бишоп нь ер ирсэнгүй. Орой нь ч ирсэнгүй. Өглөө нь ч ирэхгүй байж байгаад үд дундын алдад тэрээр ирэв. Тэр түүнийг зэмлэн, санаандаа орсон бүх л зүйлээрээ түүнийг дуудав. “Та миний бишоп, би тань уруу утасдаж хүү маань саагаар өвчилсөн гэж хэлсэн. Гэтэл та өөрөө өөртөө дарга мөртлөө, мөн машинтай; гоёмсог дарвуулт онгоцтой, хүссэн бүх зүйл тань өөрт тань бий; цаг хугацаагаа ч өөрөө зохицуулах эрхтэй байж та ирсэнгүй. Та бүтэн өдрийн дараа ирлээ” хэмээн тэр дуусгаад үргэлжлүүлж хэлэх үгээ олохгүй зогсоход нь, тэр инээмсэглээд, “Өчигдөр би утсаа тавиад, мацаг барьж эхэлсэн. Би хорин дөрвөн цагийн турш мацаг барьсан. Одоо би хүүг чинь адислахад бэлэн байна гэв. Тэр оройн таван цаг гэхэд хүү саа өвчнөөсөө бүрэн гүйцэд эмчлэгдэн эмнэлгээс гарчээ. Үүнийг зөвхөн мацаг барилт ба залбирлаар л хийдэг юм.”

“Хэрэв тэр нэг өдрийн өмнө ирсэн бол дээрх зүйл тохиолдох байсан уу үгүй нуу гэдэгт би одоо маш их эргэлзэж байна. Мацаг барилт ба залбирал хэрэгтэй байсан гэж би бодож байна. Пристийн зэрэгтэн бид заримдаа үүнийг хийдэггүй гэж би бодож байна. Энэхүү пристийн зэргээ та бүхэн тордон, туршиж үзэх хэрэгтэй, тэгвэл бид пристийн

зэргийн албан тушаалынхаа албан үүргийг гүйцэтгэж адислал өгөхдөө бэлтгэгдсэн байх болно.” (Matthew Cowley Speaks, х. 150.)

Өвчтөнийг адислахдаа тийм удаан хүлээх шаардлагагүй боловч пристийн зэргийн ямар ч ёслол гүйцэтгэхийн өмнө бид Их Эзний урам, онгодыг ямагт эрэлхийлэх хэрэгтэй.

Пристийн зэргийн ёслолуудыг гүйцэтгэхдээ бид оюун санаагаараа бэлтгэгдсэн байх нь яагаад чухал вэ?

Пристийн зэрэгтнүүд ёслолуудыг гүйцэтгэхдээ бэлтгэх хэрэгтэйн адил адислал хүсэж буй хүмүүс өөрсдийгөө болон гэр бүлийнхнээ энэ ёслолуудыг хүлээн авахад нь бас бэлтгэх ёстой. Дараах түүх хүүхдийн эцэг эх өөрсдийгөө болон хүүхдүүдээ адислалд бэлтгэхийн тулд мацаг барилт ба залбирлыг хэрхэн ашигласан тухай өгүүлнэ.

“Жилийн өмнө нэгэн хос миний албан өрөөнд бяцхан хүүгээ тэврэн орж ирэв. Эцэг нь надад, “Миний эхнэр бид хоёр, хоёр өдрийн турш мацаг барьсан, ингээд бид бяцхан хүүгээ адислуулахаар авчирлаа. Бид таныг зорин ирлээ” гэв.

“Би, “Тэр яасан юм бэ?” хэмээн асуув?

“Тэд, хүү маань сохор, дүлий, хэлгүй, булчингийн зохицуулалтгүй төрсөн ба таван настай мөртлөө мөлхөж ч чаддаггүй” гэв. Би өөрөө өөртөө “Аврал нь мацаг барилт ба залбирлаар ирнэ” хэмээн хэлэв. Би тэдгээр эцэг эхийн мацаг барилт ба залбиралд гарцаагүй итгэв. Тэр хүүг би адислаад, хэдэн долоо хоногийн дараа захидал хүлээн авав: “Коули ах аа, бид таныг манай бяцхан хүүг одоо нэг хараасай гэж хүсэж байна. Тэр мөлхөж байгаа. Тэр газар уруу бөмбөг шидээд үүнийхээ дараа өвдөг, гар дээрээ тулан босдог. Тэр харж чадаж байна. Бид түүний толгой дээр алга ташихад тэр үсэрдэг. Тэр сонсож чадаж байна. Анагаахын шинжлэх ухаан энэ гэр бүлийн зовлонг эмчилж чадаагүй харин Бурхан эдгээжээ.” (Матай Коули, “Miracles”, Speeches of the Year, BYU. 1953 х. 8.)

Мацаг барилт, залбирал хоёр хосолсон үед ирдэг адислалуудыг олон номлогчид нээн илрүүлсэн юм. Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон номлогч байхдаа хамтрагчтайгаа хамт мацаг барин залбирсан тухай тохиолдлоо ярьсан юм:

Өөрийн хувийн туршлагаасаа залбирлын хүч чадал маш их үр дүнтэй гэдгийг би олж мэдсэн. 1922 онд Английн Хойд хэсэгт намайг залуу номлогч байхад Сүмийн сөрөг хүчнийхэн нилээд ширүүн болов. Сөрөг хүч маш хүчтэй болсон тул номлолын ерөнхийлөгч биднээс гудамжин дахь цуглаанаа зогсоохыг хүсэж, бас зарим тохиолдолд айлаар явахдаа зогсоож байв.

“Миний хамтрагч бид хоёр Өмнөд Шийлдс үрүү явж ариун ёслолын цуглаан дээр үг хэлэхээр уригдсан байв. Урилган дээрээ тэд, “Бид цуглааны бяцхан газраа дүүргэж чадна гэж бодож байна. Энд байгаа хүмүүсийн олонх нь бидний талаар бичсэн худал хэвлэлд итгэдэггүй. Хэрэв та нар ирвэл бид агуу цуглаан хийнэ гэдэгтээ итгэлтэй байна” гэсэн байв. Бид зөвшөөрөв.”

“Бид чин сэтгэлээсээ мацаг барин залбираад цуглаанд явав. Миний хамтрагч нэгдүгээр зарчмыг ярихаар төлөвлөсөн байлаа. Би урвалтын талаар ярихад бэлтгэн олон зүйлийг судлав. Цуглаан дээр гайхамшигтай сүнс байсан юм. Миний хамтрагч эхэлж ярихдаа урам өгөхүйц яриа өгөв. Би үүнд нь автагдан амьдралдаа хэзээ ч мэдэрч үзээгүй тийм их эрх чөлөөтэйгээр яриу. Би суухдаа, урвалтын талаар юу ч яриагүйгээ ухаарав. Би бошиглогч Жозеф Смитийн тухай ярьж, түүний тэнгэрлэг үүргийн талаар болон Мормоны Номын үнэний тухай гэрчлэлээ хуваалцсан билээ. Цуглаан дууссаны дараа зарим нь гишүүн бус хэдэн хүн бидэн дээр ирээд “Ахлагч нар аа, та нарын зааж буй ариун сургаал үнэн гэсэн гэрчлэлийг өнөө орой бид хүлээн авлаа. Бид одоо усаар батлуулахдаа бэлэн” гэж хэлсэн билээ. “

“Энэ бол бидний мацаг барилт ба залбирлын хариу байсан юм. Учир нь бид найз нөхөд, сонирхогчидын зүрх сэтгэлд хүрэх зүйлсийг л ярихыг хүсэн залбирсан юм.” (“Prayer”, *Ensign*, 5-р сар 1977, хх 33–34.)

Дүгнэлт

Их Эзэний ажлыг биелүүлэхэд мацаг барилт ба залбирал тусалж чадах өөр олон боломж байдаг. Жишээ нь, бид гэрийн багш хийдэг айл өрхийнхээ төлөө мацаг барин залбирч болно. Бид мөн чуулгаараа, чуулгынхаа хэн нэг гишүүн, түүний гэр бүлийнхний нь төлөө мацаг барин залбирч болно.

Залбирал ба мацаг барилтаар дамжуулан бид бие махбодоороо адислагдан, итгэл ба сүнслэг хүч чадлаа сайжруулж чадна. Бид хэрэв ажил хөдөлмөр ба өөрсдийгөө болон бусдыг зоригжуулах ажилдаа амжилттай байхыг хүсвэл иймэрхүү хүч чадал зайлшгүй хэрэгтэй билээ.

Уриалга

1. Өөрийн хувийн амьдрал ба гэр бүлийнхнийхээ талаар та мацаг барин залбирах хэрэгцээтэй байгаа зарим зүйлийг тогтоо.
2. Чуулгынхаа гишүүн найз нарынхаа хэрэгцээний талаар бод.
3. Эдгээр зорилгуудын аль нэгэнд зориулан мацаг барин залбирна хэмээн өөртөө амла.

Нэмэлт Судрууд

ЗАЛБИРАЛ

Матай 6:5–15 (Бид хэрхэн залбирах ёстойг Аврагч тайлбарласан)

Лүк 18:1–14 (бид цөхрөлтгүйгээр залбирах ёстой)

2 Нефай 32:8–9 (Бид Их Эзэний ажлыг хийхээсээ өмнө залбирах ёстой)

Алма 34:17–28 (хийж буй бүх зүйлийнхээ төлөө бид залбирах ёстой)

Моронай 10:3–5 (бид бүх зүйлийн үнэнийг залбирлаар мэдэж чадна)

С ба Г 19:28 (бид залбирал ба мацгийн газраа бий болгох ёстой)

С ба Г 88:119 (бид хувийн болон нийтийн залбирлыг аль алиныг нь хийх ёстой)

МАЦАГ БАРИЛТ

Дүрвэлт 34:27–28 (Мозес Бурханаас илчлэл авахынхаа өмнө мацаг барьсан)

Лүк 2:36–37 (Алма Бурханд мацаг ба залбирлаар үйлчилсэн)

Үйлс 13:2–3 (мацаг барилт Ариун Сүнсний илэрхийллийг авчирч чадна)

Мозая 27:33 (мацаг барилт ба залбирал Алмаад эдгэхэд нь тусалсан)

Алма 6:6 (Нефайчууд Бурханыг мэддэггүй хүмүүсийн төлөө залбиран мацаг барьсан)

Алма 17:9 (Номлогчид Сүнсний төлөө мацаг барин залбирсан)

Алма 45:1 (мацаг барилт ба залбирал нь Бурханд талархлаа илэрхийлэх нэг зам мөн)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Praying to Our Heavenly Father,” 8-р хичээлийг унш. Энэ хичээлийг гурван минут давтахыг ангийн гишүүнд даалга.
2. *Gospel Principles* гарын авлагаас “Fasting,” 25-р хичээлийг унш. Ангийн гишүүнд энэ хичээлийг гурван минут давтахыг даалга.

Энэ хичээлийн зорилго бол бид гэр бүлийнхэндээ бишрэлтэй байхыг хэрхэн заах мөн өөрсдийн бишрэлээ хэрхэн сайжруулан бэхжүүлэхийг сурахад туслах явдал юм.

Оршил

“Цуглааны газар дахь бишрэл нь Бурханыг хайрлах хайр хүндэтгэлийг илэрхийлдэг” 32-а үзүүлэнг таниул.

Самбарт дараах зүйлийг бич: Их Эзэн бидэнд хүндэтгэлийн өдрийг сахиж, сүмийг бишрэн хүндэтгэх хэрэгтэй гэж хэлсэн юм. Тэр бол Их Эзэн юм. (Ливитикус 19:30).

Доорх зүйлийг Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл бичсэн юм. Энэ нь 1976 онд “Бид Бишрэлтэй Хүмүүс Байх Ёстой” гэсэн гарчигтайгаар тусгай товхимол болон хэвлэгдсэн билээ.

Бид маш их адислагдсан хүмүүс билээ. Их Эзэн бидэнд Исүс Христийн ариун сургаал, пристийн зэргийн хүч чадал, усан баталгааны амлалтууд, ариун сүмийн гэрээнүүд, судруудын үнэнийг, бидний гэр бүл болон ертөнцийн эд баялгийг өгсөн билээ. Бид ертөнцийн хамгийн аз жаргалтай хүмүүс байх ёстой. Бид мөн хамгийн их бишрэлтэй хүмүүс байх ёстой. Бидэнд зарим үед бишрэлтэй байдлаа хадгалахад хэцүү байдаг. Үйл хэрэг маань гэр орон ба сүм дээр Бүтээгчид бишрэл үзүүлж буй эсэхийг бид өөрсдөөсөө асуух хэрэгтэй.

Бишрэл Гэж Юу Вэ?

Бишрэл гэдэг нь Бурханд үзүүлэх гүн хүндэтгэл, хайр ба сүсэг бишрэлийн мэдрэмж юм. Сүмийн олонх удирдагчид хэлэхдээ, бишрэл бол Бурханд итгэх жинхэнэ итгэл, дээд зэргийн соёл ба амьдралын гоё сайхан зүйлсийг хайрлах хайр учраас зүрх сэтгэлийн хамгийн дээд чанар юм.

Ариун Сургаалын бусад зарчмуудтай хамт байхад бишрэл нь улам их баяр баясгалан уруу хөтөлдөг юм. Энэ нь бид Ням гаригт харуулдаг уйтгартай түр зуурын байдал бус, харин ариун сургаалаар өдөр бүр амьдарсны үр дүн юм. Жинхэнэ бишрэл нь аз жаргал, хайр, хүндэтгэл ба талархлыг дэмждэг юм. Энэ нь бидний амьдралын нэг хэсэг байх ёстой сайн чанар юм.

Бурханыг Бишрэх нь

Шинэ үеийн илчлэлээр дамжуулан, Их Эзэн бидэнд бишрэлийн утга ба чухал байдлыг ойлгоход маань тусалсан юм. Жишээ нь, Сургаал



ба Гэрээнүүд судрын 76-р бүлэгт, Жозеф Смит, Сиднэй Ригдон нар бишрэл бол сэлэсчел хаант улсад орох хүмүүсийн чухал зан чанар юм гэдгийг тайлбарласан юм:

Жозеф Смит, Сиднэй Ригдон нар бүх зүйл сайн сайхан байх, Бурхан өөрийн хаан ширээндээ үүрд хаанчлах Сэлэсчелийн алдар сууг харжээ.

Хаан ширээний өмнө бүх зүйл даруухан бишрэлтэй бөхийж, түүнд алдар хүндийг үүрд өгч байлаа.

Түүнтэй цуг амьдарч буй хүмүүс бол Сүмийн Анхдагчид ба, Түүний алдар хүнд ба бүрэн дүүрэн байдлыг хүлээн авсан бөгөөд харагдсаныгаа харж, мэдсэнийгээ мэдэж байлаа.

Тэр тэдний хүч чадал, эрх мэдэл ба сүр хүчийг тэнцүү болгож байлаа. (С ба Г 76:92–95- ыг үз)

Шинэ үеийн өөр нэгэн илчлэл бидэнд Бурханы өөрийнх нь нэрийг хүртэл бишрэн хүндэтгэ хэмээн зааварчилдаг билээ; Бидэнд Эцэг ба Түүний нэрийг бузарлаж болохгүй ба тэр ч байтугай тэдгээрийн хэт олон удаа хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй хэмээн сургасан юм. (С ба Г 107:2–4-ийг үз). Арван зарлигийн нэгэнд бид Бурханы нэрийг дэмий хоосон дуудаж болохгүй бөгөөд Бурхан тэдгээр хүмүүсийг буруугүй мэт үзэхгүй гэж цохон тэмдэглэсэн байдаг. (Дүрвэлт 20:7).

Бурхан ба Түүний нэрийг хүндлэх нь бишрэлийн хамгийн чухал чанаруудын нэг юм. Үүнд мөн Түүний ариун гэрийг бишрэн хүндэтгэх явдал бас орно. Кэртлэндийн Ариун Сүмийг онцгойлон адислах залбирал хэмээн нэрлэгдсэн, Их Эзэний Жозеф Смитэд өгсөн чухал илчлэлд, Их Эзэн, Гэгээнтнүүдийн барьсан бусад бүх нандин ариун сүмүүд Түүнийг бишрэн хүндэтгэх газар байх ёстой гэж зааварчилжээ. (С ба Г 109:16–21-ийг үз).

Сүмийн нандин ариун сүмүүдийн талаар хэлсэн зүйлсийн жинхэнэ бодит утга бол Гэгээнтнүүд бишрэл хүндэтгэлээ үзүүлдэг газар, эсвэл Хожмын-Үеийн Гэгээнтний гэр ч бай, “Их Эзэний байшин” бүрт үнэн юм.

Бишрэл ба Гэр Орон

Бишрэл нь хаанаас хэрхэн эхэлдэг ба бид түүнийг хэрхэн хөгжүүлж чадах вэ? Тэнгэрлэг бусад чанаруудын адил гэр бол бишрэлийн түлхүүр юм. Хувийн болон гэр бүлийн залбирлуудаар дамжуулан бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярилцах үед үр хүүхдүүд маань толгойгоо бөхийлгөх, гараа нугалах, нүдээ аних зэргийг суралцдаг билээ. Залбирахыг гэртээ суралцсан хүүхэд, удалгүй сүмийн цуглаануудын залбиралд чимээгүй байх ёстойгоо ойлгодог.

32-а. Мөргөлийн газар дахь бишрэл нь Бурханыг хайрлах хайр хүндэтгэлийг үзүүлдэг.

Үүний нэгэн адил бид гэр бүлийн цуглааныг зохион байгуулахад хүүхдүүд маань хүн бүр сахилга баттай байх ёстой онцгой цаг мөч нь зөвхөн сүм дээр төдийгүй бас гэр оронд байдаг юм байна гэдгийг ойлгодог.

Бид мөн үр хүүхдүүддээ хөгжмөөр дамжуулан бишрэлийг суралцахад нь тусалж чадна. Хөгжим бол хүүхдүүдийн хувьд онцгой баяр жаргал юм. Хэрэв бид Сүмийн дууллауудыг гэртээ дуулбал, бидний үр хүүхэд тэдгээрийг сурч, улмаар *сүмийн цуглаануудад* дуулах болно. Жижиг хүүхдүүдэд бид ялангуяа гэрт нь хялбар дууллауудыг сурахад нь тусалбал энэ нь үр дүнд хүрэх болно. Ийм замаар, хүүхдүүд маань тэдгээрийг дуулах хүсэлтэй болно.

Сүм Дээрх Бишрэл

Бид мэдээж эцэг эхийнхээ хувьд Ням гаригийн цуглаануудад хүүхдүүдийнхээ хамт очих хэрэгтэй. Хүүхдүүдээ сүмд бэлтгэхдээ бид, эхнэртэйгээ хамтран, бэлтгэх нь нөхөрсөг гэр бүлийн туршлага юм гэдгийг батлахын тулд хөдөлмөрлөх хэрэгтэй. Сүүлийн хоромд хүүхдүүдээ цуглуулж, хувцаслан, цуглаандаа яаран ухасхийх нь бишрэлийг эвдэнэ. Бид бэлэн болох гэж яаран ухасхийвэл бид байнга сүмээсээ хожимдож, хүүхдүүдийг маань сүмийн үйл явцын туршид сэтгэл гонсгор, тайван бус байлгах, хэрүүлийн үг хэлж сэтгэлийг нь гомдоох явдал үе үе гардаг. Хэрэв бид цуглаандаа урьдчилан бэлтгэж, цуглаан эхлэхээс өмнө, бишрэлийн газраа ирж, дараа нь оршил хөгжмийг сонсон хамтдаа сууж, Аврагч ба Түүний ариун сургаалын талаар бодох цаг хугацаа гаргавал бид улам бишрэл хүндэтгэлтэй байх болно.

Бага насны хүүхдүүдтэй бидний зарим хүмүүст цуглаан дээр заримдаа хүүхдүүдээ чимээгүй суулгах их хэцүү байдаг. Гэсэн хэдий ч хэрэв бид гэртээ зөв сургалт хийвэл энэ нь асуудлыг шийдэхэд тусалдаг. Хэрэв бид хүүхдүүдээ сүм дээр чимээгүй суулгах аргаа олохгүй бол хүүхдүүдээ чимээгүй суулгах арга барилдаа амжилт олсон гишүүдээс зөвлөгөө авч болох юм.

Цуглаануудын өмнө, хойно бид бие биетэйгээ мэнд мэдэлцэхээр үе үе хэсэг бүлгээрээ цугларах дуртай байдаг. Зөвхөн Хүндэтгэлийн өдөр тааралддаг тэдгээр хүмүүстэйгээ, нөхөрлөлийн үүднээс бид дээрхийг хийдэг ч гэсэн энэ нь үймээнийг бий болгодог. Иймээс эцэг эхчүүд цуглааны өмнө, хойно бишрэлийн байрнаас гадагш гарч хүмүүстэй уулзаж учран гэр бүлийнхэндээ үлгэр дууриал болох хэрэгтэй. Цуглааны дараа бид бодол санаа, хөгжмийн үзүүлбэр, эсвэл цуглааны зарим нэг нааштай үзэл бодлын талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцсанаар, үйлчлэлийн сүнсийг гэртээ авчрахад туслах хэрэгтэй.

Бишрэлээ Бэхжүүлэх нь

Бид үр хүүхдүүддээ сүмийн цуглаануудад дуртай байж улам бишрэлтэй болоход нь хэрхэн тусалж чадах вэ? Ангийн гишүүдийг хариулсны дараа анги дахь гишүүнээр дараах саналуудыг уншуул:

Эцэг эхчүүд хүүхдүүдээ сүмийн цуглаануудад дуртай болоход нь дараах зүйлсээр тусалж чадна—

- Сайн жишээ үзүүлэх
- Цуглаануудад бэлтгэхдээ яаралгүй нөхөрсөг байх
- Цуглаан эхлэх цагийн хуваарийн цагаас таваас арван минутын өмнө ирэх
- Гэр бүлээрээ хамтдаа суух
- Цуглааны дараа яриа, мэдээ, хөгжмийн үзүүлбэр болон цуглааны бусад хэсгүүдийн талаар ярилцах

Бага насны хүүхдүүдэд бид бишрэлийг хэрхэн зааж чадах вэ? Ангийн гишүүдийг хариулсны дараа хэн нэгнээр дараах саналуудыг уншуул:

Бага насны хүүхдүүдтэй эцэг эхчүүд дараах зүйлийг хийхийг хичээх хэрэгтэй—

- Юу болж буйг хүүхдүүдэд ойлгоход нь туслах. Бага насны хүүхдүүд өөрсдийгөө зураг зурах, будах зэргээр саатуулж болох боловч тэдэнд боломжийнхоо хэрээр цуглааны талаар ойлгоход нь туслах нь чухал юм. Хэсгийн ажил хэрэг эсвэл ярьж буй хүний яриа зэргийг хааяа хааяа шивнэж тайлбарлаж өгөх нь, хүүхдүүдэд юу болж буй тухай ойлгоход нь тусалж чадна. Жишээлбэл, “Гордигийн аав нь одоо ярьж байна. Тэр анхдагчдын талаар ярьж байна” хэмээн эцэг нь шивнэж болно.
- Дууллуудыг гойд анхаарч дуулах нь хүүхдүүдийн хувьд цуглааны хамгийн дуртай хэсэг нь байж болно. Гэртээ хялбар дууллуудыг дуулж, тэдгээрийг хүүхдүүддээ зааж өгч дууллын талаарх сонирхлыг нь дэмж. Хэсгийн хөгжмийн удирдаач дараагийн цуглаануудад дуулах дуулалуудын жагсаалтыг гаргаж болно.
- Хүүхдийн Хэсэг ба Ням гаригийн хичээл болон гэртээ сурсан арга барилыг нь бэхжүүл. Залбирлын турш гараа нугалан, толгойгоо бөхийлгөж, ариун ёслолын турш чимээгүй суух ёстойг нь хүүхдүүддээ санахад нь тусал. Цуглаан болж буй үед эгнээнүүдийн хооронд явах, тоглох, цуглааны байрнаас гадагш гарч болохгүй гэдгийг хүүхдүүд ойлгох ёстой.
- Үлгэр жишээ үзүүл. Зөвхөн хэрэгтэй үед шивнэн ярьж, цуглаанд сонирхолтой байж, хүүхдүүдээ үүнийхээ нэгэн адил бай хэмээн уриалан үлгэр жишээ үзүүл.

-
- Хүүхдүүдээ цуглаанд бэлэн эсэхийг нь шалга. Цуглаан эхлэхийн өмнө бие засах газар орж, мөн амны цангааг нь тайлсан байх ёстой.

Бид өөрсдийн ангийн бишрэлийг бэхжүүлэн сайжруулахын тулд юу хийж чадах вэ?

Дүгнэлт

Орон нутгийн удирдагчид, гэр бүлүүд бишрэлийн талаарх асуудлаа даван туулах гэж хичээл зүтгэлээ хослуулсан цагт л бишрэл нь бэхжин сайжирна. Сүмийн удирдагчдаас гарч ирэх санал ба уриалгууд бишрэлийн талаарх асуудлаа хэрхэн шийдэхэд маань бидэнд тусалж чадах ч, орон нутгийн Сүмийн нэгдэл ба гэр оронд маань бодит ажил хийгдэх ёстой.

Тэнгэр дэх Эцэгтээ ойрхон байхад үнэн бишрэл бидэнд зайлшгүй чухал билээ. Гэвч нүгэл хилэнцийн хүч дэлхий ертөнцөд тархсан үед бишрэл нь устгагддаг юм. Хэрэв бид, Христийн үнэний Сүмийн гишүүд, бишрэлтэй байдлын үлгэр жишээгээр үйлчилбэл, бид хийж чадах сайн зүйлсээ урьдаас мэдэхгүй. Үлгэр жишээгээр бид олон хүний, ялангуяа өөрсдийн гэр бүлийн гишүүдийн амьдралыг өөрчилж чадна.

Уриалга

1. Танай гэр бүлийнхэн сүм дээрх бишрэлээ бэхжүүлэн сайжруулахын тулд юу хийж чадах талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилц.
2. Гаргасан саналуудын нэгийг дараагийн ням гаригт хэрэгжүүл.
3. Хэрэв та бага насны хүүхдүүдтэй бол тэдэнд сүм дээр болон гэртээ бишрэлтэй байх талаар заахаар төлөвлөн шийд.

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. Ангийн гишүүдэд судруудаа хичээлдээ авчрахыг сануул.
2. Самбар, шохой бэлд.

Энэ хичээлийн зорилго бол бусдад үзүүлэх хайр ба үйлчлэл нь пристийн зэргийн дуудлагад маань их чухал гэдгийг суралцахад туслах явдал болно.

Оршил

“Христ бол хайрын агуу жишээ юм” 33-а үзүүлэнг таниул.

Исүс Христ бүх хүнд хайртай. Түүний хайрлах чадвар төгс юм. Түүний хайр үнэхээр бүрэн төгс учир судрууд бидэнд Тэр бол хайр гэж хэлдэг юм. (1 Иохан 4:7–12). Христийн хайр нь, Түүний хүн төрөлхтөнд гүйцэтгэсэн үйлчлэлээр нь маш сайн илэрхийлэгдсэн юм.

Пристийн зэрэгтнүүдийн хувьд бид Христтэй адил болох үүрэг хариуцлага хүлээдэг. Гэвч үүнийг хийхийн тулд бид Түүний хайрладаг шиг хайрлаж, Түүний үйлчилдэг шиг үйлчилж сурах хэрэгтэй. Бишоп Х.Бурк Пэтэрсон бидэнд “Сатан хүн төрөлхтний хүүхдүүд рүү харгис аюултай дайралтуудаа өрнүүлж буй ертөнц, нийгэмд бидэнд цэвэр ариун, хувиа боддоггүй Христийн хайраас өөр зэвсэг үгүй,” хэмээн сургасан билээ. (“The Daily Portion of love”, *Ensign*, 5-р сар 1977, х 69).

Бидэнд Хайрлахыг Тушаасан

Нэгэн өдөр Христийг сургаал айлдаж байхад, бичээч нарын нэг нь түүнээс ямар зарлиг нь бүх зарлигуудын эхэнд байхыг асуув. Исүс хариулахдаа бид Бурханыг бүх зүрх, сэтгэл, хүч, оюун ухаанаараа хайрлах ёстой гэжээ. Энэ бол эхний зарлиг.

“Өөрийн хөршөө өөрсөд шигээ хайрла, гэдэг нь хоёр дахь нь юм. Эдгээрээс илүү чухал зарлиг гэж байхгүй, хэмээн хариулжээ” (Марк 12:28–31).

Эдгээр хоёр нь бусад зарлигуудаасаа яагаад илүү чухал вэ? (Бид Бурхан ба найз нөхдөө хайрлавал бид тэдгээрийг аз жаргалтай байлгахын тулд хийж чадах бүгдийг хийх болно, ингэснээрээ бусад бүх зарлигуудыг биелүүлэх болно.)

Аврагч ихэнх амьдралаа хайрын тухай заахад зарцуулсан юм. Зарим үед түүний ариун сургаалыг “хайрын ариун сургаал” хэмээн нэрлэдэг. Тэрээр бидэнд заахдаа бид бусдыг хайрласан цагт л Түүний шавь нар байх болно гэсэн билээ. (Иохан 13:35-ыг үз). Тэрээр бид дайснаа ч хүртэл хайрлах ёстой хэмээн тайлбарласан билээ. (Матай 5:43–44-ийг үз). Цовдлогдохоосоо хэдхэн цагийн

өмнө Исүс “Та нарт шинэ зарлиг өгч байна. Бие биенээ хайрлагтун. Би та нарыг хайрласны адил бие биенээ хайрлагтун” гэсэн билээ (Иохан 13:34).

Ерөнхийлөгч Элдон Таннэр хайрлах зарлигийн ач холбогдлыг цохон тэмдэглэхдээ, “Бид аз жаргалтай байхад маань хэрэгтэй уриа лоозон бол . . . Бие биенээ Хайрла гэсэн— гуравхан энгийн үг юм” гэжээ. (The Great Commandment, *Improvement Era*, 1967, х 29).

Христийн Цэвэр Хайр бол Энэрэл Мөн

Ангийн гишүүдээр Моронай 7:45–47-г уншуул. Энэрэл гэж юу вэ?

Ахлагч Марк.И.Пэтэрсэн энэрлийг тайлбарлахдаа, “Бидэнд Бурхан ба бусдыг хайрлахад маань тусалдаг зүйл бол Христийн цэвэр ариун хайр юм” гэжээ. (“Вщ Гтеш Щеруки”, *Ensign*, 5-р сар 1977, х 75). Ахлагч Мариан Д.Хэнксийн ярьсан дараах түүх эцэг нь өөрийн охиндоо, энэрлийг хэрхэн хөгжүүлж бусдад үзүүлэхийг заасан тухай өгүүлдэг.

Тажир дутуу биетэй төрсөн сонгогдсон бүсгүйн талаар би бодож байлаа. . . [Тэр] өөрийн хүүхэд насны тохиолдлоосоо ярьсан юм. Хамт тоглодог байсан хүүхдүүд нь түүнийг гомдоож уйлуулах тийм нэрээр түүнийг дууддаг байжээ. Түүнийг гэртээ ирэхэд эцэг нь том хүчирхэг гараараа тэврэн авч уйлах зуур. . . . тэр [энэ тохиолдол] нь түүний амьдралыг аз жаргалтай, үр өгөөжтэй болгож чадах л байсан хэмээн тайлбарлажээ. Тэрээр охиндоо “Хонгор минь, чиний нуруу бөгтөр ба бусад олон согог бий. Гэвч энэ бол чиний буруу биш. Энэ нь чиний эцэг эх эсвэл Тэнгэрлэг Эцэгийн буруу биш. . . . Охид, хөвгүүдийн хэлсэн зүйл үнэн боловч, энэ нь шударга бус ба эелдэг бус байна. Хэрэв чи бүх л амьдралынхаа туршид бусдад улам шударга, улам эелдэг байхыг хичээвэл, зарим нь чамд эргэн ирж аз жаргалтай болж, амьдрал чинь бүрэн гүйцэд, үр өгөөжтэй байх болно” гэжээ. (“More Joy and Rejoicing”, *Ensign*, 11-р сар 1976, х 32.)

Энэ түүх хүн бүр энэрэнгүй байхын тулд яах ёстой хэмээн санал болгосон бэ? Ангийн гишүүнээр 1 Коринф 13:1-ийг уншуул.

Ахлагч Теодор М.Бюртон тайлбарлахдаа “Энэрэл бол. . . бид өөрсдийнхөө нэг хэсгийг бусдад өгөхдөө баяртай байх агуу их хайр юм. Би чамд хайртай гэж хэлэх нь амархан боловч хайрыг зөвхөн тунхаглах ёсгүй, түүнийг үйл хэргээрээ батлах хэрэгтэй. Үүнийг батлан харуулахгүй юм бол хайр нь “чих дүлийрүүлэм жингэнэх цан, нүргэлэх хэнгэрэг болж, зүрх сэтгэлийг тайвшруулж чадахгүй” гэжээ. (“If I Have Not Love—”, *The Instructor*, 6-р сар 1970, х 201.)

Энэрэнгүй байх нь биднийг аз жаргалтай, үр өгөөжтэй амьдралаар амьдрахад маань туслах болно. Хэрэв бид энэрлээ хөгжүүлэхгүй бол үнэгүй болон хаягдаж, хүмүүсийн хөлд гишгэгдэн үрэгдэх хэрэггүй материал болон хувирна (Алма 34:29) .

Христийн Адил Үйлчлэл

“Христ бол хайрын агуу жишээ юм” 33-а үзүүлэнг таниул.

Тэнгэрлэг Эцэг ба Түүний хүүхдүүдийг хайрлах бидний хайр найз нөхөддөө үзүүлэх үйлчлэлээр маань илэрхийлэгддэг. Ерөнхийлөгч Хэролд Б.Ли нэг шөнө үзэгдэл үзэж тэр нь түүнд ингэж хэлжээ. “Хэрэв чи Бурханыг хайрлахыг хүсэж байвал хүмүүсийг хайрлаж тэдэнд үйлчлэхийг суралцах хэрэгтэй. Ийм замаар чи Бурханыг хайрлах хайраа үзүүлнэ.” (Stand Ye In Holy Places, x 189.)

“Христийн адил” үйлчлэл гэдэг нь тусламж хэрэгтэй хүнд ямар нэг шан харамжгүйгээр үе үе чин сэтгэлээсээ үйлчлэхийг хэлнэ. Энэ нь бидний хүсээгүй, эсвэл тааламжгүй зүйл байж болох учраас биднээс маш их хичээл зүтгэл шаардаж болох юм. Энэ нь магадгүй бидэнд тусламж үзүүлэхэд хэцүү байгаа цаг мөчид шаардагдаж болох юм. Гэвч энэ нь яаж үйлчилснээс хамаарахгүй, тэр үйлчлэлийг бид Тэнгэрлэг Эцгийнхээ хүүхдүүдэд хайртай учраас хийсэн энгийн үйлчлэл юм.

Бид яагаад үйлчлэл үзүүлэх ёстой вэ? Бид хэнд үйлчилж болох вэ?

Бид бүх хүмүүст хэрэгцээнийх нь хэрээр, чадахынхаа хэмжээгээр туслах ёстой. Гэхдээ ахлагч Томас Монсон бидэнд, зарим хүмүүст бидний тусламж бусдынхаас илүү хэрэгтэй байдаг гэдгийг сануулахдаа: “Өвчтэй, ядарсан, өлсгөлөн, даарсан, гэмтсэн, ганцаардсан, өндөр настай болсон, тэнэмэл—эд бүгд бидний тусламжийг гуйдаг юм” гэсэн билээ. (“Your Jerico Road” *Ensign*, 5-р сар 1977, х 73). Дараах түүх нэгэн залуу үйлчлэлийн чухлыг хэрхэн ойлгосон тухай өгүүлнэ.

Урьдчилан даалгасан гишүүнээр дараах түүхийг яриул.

Бишоп ариун ёслолын цуглааны дараа Стийвтэй уулзахаар албан өрөөндөө дуудав. “За боллоо доо” “Намайг багш нарын шинэ чуулгын ерөнхийлөгч болгох гэж байна. Хэсгийн бүх гишүүд миний гарыг атган баяр хүргэхийг хүснэ дээ” хэмээн Стийв бодов.

“Стийв, бидэнд чамд даалгах нэгэн даалгавар байна” хэмээн бишоп нь хэлээд “Энэ нь сайн хөрш хэмээх онцгой даалгавар юм. Бид Хэсти Макферлэндийн талаар санаа зовж байна. Түүнд ямар нэгэн найз хэрэгтэй байгаа юм. Тэр Сүмийн гишүүн биш боловч Бурханы хайр бүх хүмүүст хүрдэг болохоор бидэнд тэрхүү хайрыг үзүүлэх боломж байгаа юм” гэв.

Стийв мэгдэн сандрав. Хоёр долоо хоногийн өмнө тэр ба түүний нөхөд нэгэн настай эрийг шоолон түүний тухай шүлэглэн дуу зохион дуулж байсан үе түүний ухаан санаанд орж ирэв. Сэтгэл нь гонсойж буруутайгаа мэдрэн зогсох тэр “Би чамайг явж түүнийг долоо хоногт хоёроос гурав дахин эргээсэй гэж хүсэж байна. Хэрэв энэ



даалгавар чамд хийхэд дэндүү хэцүү санагдвал, үүнийгээ хэлэх гэж бүү санаа зовоорой” гэж бишопынхоо хэлэхийг сонсов.

Стийв зөвшөөрөн, бишопдоо уг даалгаврыг хийнэ гэдгээ хэлэв. Бишоп нь түүнд уг даалгаврын талаар нэмэлт зааварчилгаа өгөхдөө, “Чи гал түлэх модыг нь хагалж өгч, хоол хүнс, хөгжим гэх мэт түүнд хэрэгтэй бүх зүйлээр нь тусалж өөрт нь нөхөрсөг байгаагаар мэдүүл. Найз нь бай. Эцэг чинь энэ даалгаврын талаар мэдэж байгаа, тэр чамд тусална гэдгийг надад хэлсэн. Мөн Тэнгэрлэг Эцэг чамд туслах болно” гэв.

Арван таван настай Стийв— хөл бөмбөг тоглон, ан хийх, загасчлах, эсвэл найз нөхөдтэйгээ тоглох зэрэг илүү дээр хийж чадах зүйлсээ л бодов. Гэвч тэр уг даалгаврыг зөвшөөрснөө мэдэж байв.

Хэсти хотын захын нэгэн бяцхан модон байшинд даяанч амьдралаар амьдардаг байлаа. Жилд нэг удаа тэр цагдаагаар төлүүлэн, зочид буудалд үнэгүй усанд ордог байв. Тэр хар нүдний даруулга зүүдэг байсан бөгөөд толгойныхоо хажууд хавдартай байлаа. Ихэнх хүүхдүүд, тэр ч байтугай том хүмүүсийн зарим нь түүний талаар зохисгүй зүйл ярьдаг байлаа.

Стийв, Хэстигийн гэрт ирэхдээ маш их айж байлаа. Тэр хаалгыг нь тогшсон боловч хариу алга байв. Эцэст нь тэрээр, настай эрийг дуудсанахаа дараа, хаалгыг нь түлхэн онгойлгохоор шийдэв. Хэстигийн гэр хүйтэн, харанхуй байв. Хэсти хир буртаг болон хөгзөрсөн хөнжилтэй орон дээрээ сууж байлаа.

Хэсти, би таны төлөө ямар нэгэн зүйл хийж болох уу? хэмээн Стийв бувтнав. ХҮГ-ийн Сүмийн бишоп түүнийг явуулсан, гэж хэлээд тэр нэрээ хэлэв. Настай эр юу ч хэлэлгүй, шал ширтсээр л байв. Стийв түлээ хагалахаар байшингаас гарав. Тэр яагаад энд байгаагаар модоо сүхээр цавчих болгондоо гайхан бодож байв. “Бухимдахаа боль, настай эр даарч байна, түүнд тусламж хэрэгтэй” хэмээн түүний дотроос нэгэн дуу хоолой түүнд хэлэв.

Стийв гал түлэн, юу ч хариулахгүй байгаа Хэститэй ярихыг оролдож байв. Хэсти сонсохгүй байна хэмээн тэр бодоод, түүнд маргааш цэвэр, дулаахан хөнжилтэй ирнэ гэдгээ хэлэв. Тэр маргааш нь амласныхаа дагуу шинэ хөнжилтэй ирэв. Дараагийн дөрвөн долоо хоногийн турш тэр өнжөөд Хэстигийн ирж байлаа. Эцэст нь, настай эр түүнтэй ярьж эхлэв. Нэг өдөр тэр “Хүү минь чи яагаад ирдэг юм бэ? Чиний насны хүүхэд нэгэн өвчтэй муухай ааштай хүнийг эргэж тойрохоос илүү дээр юм олж хийж чадна гэдэгт би итгэлтэй байна” гээд тэр инээмсэглэв.

Талархалын өдөр Стийв түүнийг оройн хоолонд урив. Тэр ирээгүй боловч Стийвийн гэр бүлийнхэн оройн хоолноосоо хоол аваачиж өгөв. Хэсти тэдэнд талархлаа илэрхийлэх гэж хичээхэд нүд нь нулимстай байлаа.

Стийв удалгүй Хэстигийн амьдралыг хоньчин мэт мэддэг боллоо. Түүний эхнэр хүүхдүүд нь аймшигтай халуурлаас болон нас барж, уг өвчин Хэстиг нүднээс нь салгасан гэдгийг нь тэр мэдэж авав. Хөгшин даяанч яагаад ч юм муухай юм шиг харагдахаа больж, Стийв хичээлээ тараад түүнд тусалж, мөн түүхүүдийг нь сонсох гэж яардаг болов.

Зул сарын баяр болоход Стийвийн гэр бүл Хэстиг оройн хоолондоо дахин урив. Энэ удаад тэр ирэхдээ—цэвэрхэн, костюм өмссөн, сайхан харагдаж байв. Оройн хоолны дараа настай эр Стийв болон түүний гэрийнхэнд талархлаа илэрхийлэв. Түүний амьдрал эмх цэгцгүй байсан боловч тэдний түүнд үзүүлсэн хайр түүнийг өөр хүн болгон өөрчилж байгааг тэр хэллээ.

Стийв Хэстиг хараад тэр хичнээн их аз жаргалтай, мөн түүний зүрх сэтгэл дулаан болж буйг тэр дотроо мэдэрлээ. (“Hasty”, *New Era*, 11-р сар, хх 48–49-ийг үз.)

Хэстид үзүүлсэн үйлчлэл Христийн адил үйлчлэл байсан уу? Үзүүлсэн үйлчлэлээрээ залуу хүү хэрхэн адислагдсан бэ? Хэн хамгийн их адислагдсан бэ?

Бид усаар батлуулахдаа бие биенийхээ зовлонг хуваалцаж, гашуудаж буй нэгэнтэй хамт гашуудан, тайвшрал хэрэгтэй нэгнийг тайвшруулна хэмээн Их Эзэнд амласан билээ. (Мозая 18:8–9). Бид тусламж хэрэгтэй нэгнийг хайж олох үүрэг хариуцлагатай билээ. Дараа нь бид шаардуулахгүйгээр эсвэл тушаалгахгүйгээр хайр ба эелдэг байдлаар тэдэнд туслах үүрэг хариуцлагатай билээ (С ба Г 58:26–29-ийг үз).

Дүгнэлт

Бишоп Х.Бүрк Пэтэрсон бидэнд: “Эзэн—нэг газар нутаг дахь цөөн тооны хүмүүст бус, өөр газар нутгийн хэсэг хүмүүст бус, энд тэнд байгаа гэр бүлд бус, газар сайгүй буй өөрийн бүх хүүхдүүдэд зарлиг өгсөн юм. Хайраа одоо л илэрхийл! Үүнийгээ одоо л үзүүл” хэмээн сануулсан юм. (*Ensign*, 5-р сар 1977, х 69.)

Иймэрхүү хайр бидний үйлчилсэн зөвхөн тэдгээр хүмүүст бус, бас бидэнд үр ашгаа өгдөг юм. Ерөнхийлөгч В.Кимболл нэгэн удаа: “Үйлчилснээрээ бид хэрхэн үйлчлэхийг сурдаг. Бид найз нөхөддөө үйлчлэхэд, тэдэнд туслах ажлаа хийгээд зогсохгүй, өөрсдийн хувийн асуудлуудаа хойш тавьдаг ба. . . өөрсдийнхөө талаар бодох цаг тун бага байдаг . . . Бид бусдад тусалснаараа улам чухал ач холбогдолтой хүмүүс болно” хэмээн сануулсан билээ. (“Small Acts of Service”, *Ensign*, 12-р сар 1974, х.2.)

“Гэр орноо хөршүүдийнхээ зохицол, хайр, нийгмийн үүргүүд, үнэнч шударга занд нийцүүлэхээс гадна асар том үүрэг хариуцлагууд бидэнд бий. Хөршүүддээ үүнийг харах, сонсох боломж олгоцгооё пристийн зэрэгтэн, Сүмийн гишүүдийн хувьд Бурхан минь бидэнд Хайр, Энэрэл, . . . ба Үйлчлэлийг гаргахад туслаач!” (Дэвид О. МакКэй, “Radiation of the Individual”, *Instructor*, 10-р сар 1964, х.374.)

Уриалга

1. Христийн адил хайрлах чадварын төлөө даруухнаар чин сэтгэлээсээ залбир.
2. Гэр бүлийн гишүүн бүрдээ эелдэг үйл хийж гэр бүлийнхэндээ хайраа харуул.
3. Тусламж хэрэгтэй хэн нэгэнд эелдэг зүйл хийж хайраа харуул.
4. Пристийн зэргийн чуулгадаа хэн нэгэнд үйлчлэх үйл ажиллагаа хийх төлөвлөгөө гаргахад нь тусал.

Нэмэлт Судрууд

Матай 25:31–46 (бид найз нөхөддөө үйлчилснээрээ Бурханд үйлчилдэг)

1 Коринф 13 (энэрэл бол Бурханлаг шинжийн хамгийн агуу шинж чанар юм)

Моронай 7:45–48 (энэрэл бол Христийн цэвэр хайр ба Бурханаас өгсөн бэлэг юм)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “Service,” 28-р бүлэг ба “Charity,” 30-р бүлгийг унш.
2. Хичээл дэх түүх ба судруудыг ангийн гишүүдэд ярихыг даалга.

Энэ хичээлийн зорилго бол бидэнд ёс суртахуунаараа цэвэр байхыг ойлгоход маань туслах явдал болно.

Оршил

Өнөөдрийн ертөнцөд төлөв зан чанарын олон янзын жишиг байгаа билээ. Эдгээр жишгүүд нь цаг хугацаа ба нөхцөл байдлаас шалтгаалан үе үе өөрчлөгддөг. Бурханы жишиг хэзээ ч өөрчлөгддөггүйгээрээ эрс ялгаатай юм. Учир нь Тэр өчигдөр, өнөөдөр, үүрд хэвээрээ байдаг. Ёс суртахууны цэвэр байдлаар амьдрах нь Бурханы биднээс үргэлж хүлээж байдаг нэг жишиг юм.

Судрууд бидэнд хэлэхдээ ямар ч бохир зүйл Бурхантай цуг байж чадахгүй гэдэг билээ. (1 Нефай 10:21-ийг үз). Төлөөлөгч Паул сургахдаа та нар Бурханы ариун сүм бөгөөд та нарын дотор Бурханы Сүнс амьдарч буй. Хэрэв хэн нэгэн хүн Бурханы ариун сүмийг бузарлавал Бурхан түүнийг устгах болно, учир нь та нар ариун сүм бөгөөд Бурханы ариун сүм бол ариун юм” гэсэн билээ. (1 Коринф 3:16–17-г үз). Бидний бие махбод нандин билээ. Их Эзэн бидэнд бие махбодыг тэнгэрлэг зорилгын үүднээс өгсөн бөгөөд тэр биднээс, бие махбоддоо Сүнсийг нь хүлээн авахын тулд түүнийгээ цэвэр, зохистой байлгаасай хэмээн хүсдэг.

Бие Махбод Маань Нандин Юм

Пристийн зэрэгтнүүдийн хувьд бид өөрсдийгөө ёс суртахуунаараа цэвэр байлгах нь чухал юм. Учир нь бидэнд хамгийн чухал байдаг адислалууд нь бидний ёс суртахууны цэвэр байдалтай холбоотой байдаг. Ахлагч Бойд.К.Пакэр ийнхүү хэлжээ: “Бурханы олон хүч чадлуудын нэг нь, түүний хамгийн өндөр үнэлдэг нь, амьдралыг өгөх, авах хүч чадал юм. Тэрээр амьдралыг зогсоохыг бидэнд хориглосон боловч хүүхдүүдийг дэлхийд авчрах зөвшөөрөл олгосноор амьдралыг бүтээх хүч чадлаа бидэнтэй хуваалцсан юм. Энэ нь тэнгэрлэг хүч чадал учраас тэр өөрийн бүх хүүхдүүдэд уг хүч чадлаа зөвөөр ашиглаж, зөвхөн гэрлэлтэнд зориулан нөөцөл хэмээн тушаасан билээ. Энэхүү агуу хүч чадлын хүслийг хангаж, Түүний тогтоосон хязгаарын дотор байлгах ёстой ба хувиа бодсон дур хүсэл эсвэл зугаа цэнгэлд ашиглаж болохгүй хэмээн Тэр бидэнд мөн хэлсэн билээ. . . Энэ амьдралд [бидэнд] ирэх аз жаргалын ихэнх нь [бид] энэхүү бүтээх хүч чадлыг хэрхэн ашигласнаас шалтгаалах болно.”

“Энэ бүтээх хүч чадал нь өөртөө хүчтэй хүсэл ба шаардлагыг зайлшгүй агуулдаг. Хүмүүст гэр орон ба гэр бүлийнх нь хариуцлагыг хүлээн зөвшөөрөхийг ухуулан ойлгуулахын тулд хүчтэй байдаг юм. Энэ хүсэл нь хүчтэй байдаг учраас биднийг үе үе энэхүү бүтээх хүч чадлыг буруугаар ашиглуулахаар уруу татдаг юм. Энэхүү хүч чадлыг буруугаар ашигласны улмаас гэр бүл салж сарнин, аз жаргалаа алддаг юм. Энэ шалтгааны улмаас, [бид] [эхнэрүүдээсээ] өөр хэнтэй ч тэр хүч чадлаа ашиглахгүй байх ёстой Иймээс бүтээх хүч чадлын нэгэн адил бидний бие махбод мөн нандин билээ. Бид өөрсдийн [бие махбодоор] сорилт эсвэл зүй бусаар харьцах байдлыг өөрсөддөө эсвэл бусдад олгохгүй байх хэрэгтэй. Энэ хүч чадлыг зөв шударга ашиглах ганц зам бол гэрлэлтийн хүрээн дотор байдаг юм.” (Why Stay Morally Clean? *The New Era*, 7-р сар 1972, хх 4–6.)

Сайн чанар бол бүх зүйлийн хамгийн эрхэм үнэтэй нь юм хэмээн Моронай бидэнд хэлсэн билээ. (Моронай 9:9). Бид өөрсдийгөө ёс суртахуунаар цэвэр байлгаж өөрсдийн гэр бүлээ зөв шударга ёсонд нийцүүлэн байгуулж, амар амгалан, таарамжтай амьдрах болно.

Цэвэр Байдлын Тухай Бурханы Хууль

Хүн бэлгийн харьцааны нүглийн талаарх хуулийг өөрийн тааламжиндаа нийцүүлэн өөрчлөхийг хичээсэн ч Бурхан үүний талаарх өөрийн хууль зарлигуудыг хэзээ ч өөрчлөөгүй юм. Ариун явдлын хуулинд хүн эхнэрээсээ өөр хэнтэй ч бэлгийн дотны харьцаанд орж болохгүй гэж заадаг билээ. Их Эзэн, садар самуун явдал бүү хий хэмээн бидэнд тушаасан билээ. (Дүрвэлт 20:14). Ариун явдлын хууль нь завхайрахыг хязгаарлаад зогсохгүй, мөн тэнгэрлэг хүч чадлыг буруугаар ашиглах бүх хэлбэрүүдийг багтаадаг билээ.

Энэ хүч чадлыг хүмүүс өөр ямар буруу замаар ашигладаг вэ? (Хариултуудыг самбарт жагсаа.)

Хүмүүс энэ нандин хүч чадлыг буруугаар ашигладаг хэлбэрүүдэд дараах зүйлс орно.

- Садар самуун явдал ба нууцаар амраглах (гэрлэхгүйгээр хамт амьдрах нь мөн үүнд орно).
- Ижил хүйстэнтэйгээ явалдах
- Үр хөндөлт
- Өөрөө өөрийнхөө дурыг хангах

Ариун явдалд цэвэр бодол ба хувцаслалтын даруу байдал багтдаг. Судрууд бидэнд, бидний үйлдэл бол бодол санааны маань үр дүнд бий болдог юм хэмээн сургадаг. (Сургаал үгс 23:7-г үз); Иймээс бид өөрсдийгөө ёс суртахуунаараа цэвэр байлгахыг хүсвэл бодол

санаагаа ариун байлгах хэрэгтэй. Бодол санаа маань амьдрал дээр илэрдэг нэг зам бол бидний хувцаслалт юм. Даруу байдалтай хувцасладаг тэдгээр хүмүүс, бие махбодынхоо нандин байдлыг хадгалж буйгаа харуулж байгаа юм.

Урьдчилан даалгасан ангийн гишүүнээр Ерөнхийлөгч Кимболлын ярьсан дараах түүхийг яриул.

“Нүгэл нь аялал мэт анхны алхмаас эхэлдэг; иймээс анхны уруу таталтаас татгалзах нь гэрийн хэв маяг өсөж ирэх дараа дараачийн уруу таталтаас татгалзахаас хялбар байдаг хэмээн мэргэн ухаан ба туршлага нь заадаг юм. Энэ нь болжморын түүхэнд дүрслэгдсэн байдаг. Болжмор аюулаас болгоомжлон өндөр мөчир дээр сууж байхдаа, нэгэн жуулчин ой дундуур жижиг сонин янзын хар хайрцаг барьж явахыг харжээ. Болжмор доош нисэж буугаад жуулчны мөрөн дээр суув.” Таны жижигхэн хар хайрцганд юу байгаа юм бэ?” хэмээн тэр асуув.

“Өтнүүд,” гэж жуулчин хариулав.

“Та тэдгээрийг зарж байгаа юм уу?”

“Тийм ээ, тэгээд бас маш хямдхан гээч. Нэг өтний үнэ ердөө л нэг ширхэг өд”

“Болжмор хормын төдий бодов. “Надад сая гаруй өд байх ёстой. Мэдээж хэрэг би тэдгээрийн нэгээр нь дутахгүй. Огт ажил хийлгүйгээр сайн хоол олоод идчих аятайхан боломж гарлаа.” Ингээд тэрээр уг хүнд нэгийг худалдан авъя гэдгээ хэлэв. Тэр далавчныхаа доогуур жижигхэн өд хайв. Тэр өдөө зулгаахдаа ялимгүй ярвайсан боловч өтний хэмжээ ба чанар нь түүнийг өвчнөө хурдан мартахад хүргэв. Модны орой дээр дахин гарч тэр урьдынхаасаа илүү сайхан жиргэж эхлэв.”

“Дараагийн өдөр нь тэр нөгөө хүнтэй дахин тааралдан нэг өтийг нэг өдөөрөө солив. Хоол олж идэх гэж хичээл чармайлт гаргах шаардлагагүй ямар сайхан арга вэ?”

Үүнээс хойш болжмор өдөр бүр өднөөсөө нэгийг зулгааж, зулгааж бүрд нь өвдөх нь улам багасаж байлаа. Эхэндээ тэрээр олон өдтэй байсан боловч өдөр өнгөрөх тусам нисэхэд нь улам хэцүү болж буйг тэр мэдэж байлаа. Эцэст нь, тэр үндсэн гол өднүүдийнхээ нэгнээсээ л салахад, модны оройд дахин хүрч чадахгүй болж, дээш тэнгэр үрүү ч нисч чадахаа болив. Үнэн хэрэгтээ тэр агаарт далавчаа хэдэн метр хий дэвэхээс өөр юу ч чадахгүй болж, үсчимтгий хэрүүлч богширго нартай хоолоо олж идэхээс өөр аргагүйд хүрэв.

“Өт зардаг эр дахин ирсэнгүй, учир нь хоолонд төлөх өд дууссан байлаа. Болжмор доройтон муудсан байдлаасаа ихэд ичиж байсан учраас дахин дуулсангүй.”

“Эхэндээ өвчтэй, дараа нь арай хялбар гэх мэтээр, эцэст нь биднийг агаарт халин нисэх, дуулж хуурдах юу ч үгүй болтол маань зохисгүй зуршлууд эзэмдэн авдаг юм. Ийм байдлаар эрх чөлөө гээгддэг юм. Ийм маягаар бид нүгэлд ороогддог юм.” (The Miracle of Forgiveness, хх 214–15.)

Бодол санаагаа хянаж, даруухан хувцаслан, мөн Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг сонсон, тэдгээрийг дуулгавартай дагавал, бид зохисгүй зуршлаа хөгжүүлж, ариун явдлаа гээх байдлыг хөгжүүлэхгүй байх баталгаатай болно.

Алмагийн хүү садар самуун явдал үйлдэхэд Алма түүнд эдгээр зүйл нь Их Эзэний жигшил дургүйцлийг хүргэдэг ба гэмгүй хүний цусыг урсгах, эсвэл Ариун Сүнснийг үгүйсгэх нүглүүдийн дараа орох хамгийн жигшүүртэй нь юм хэмээн хэлжээ (Алма 39:5-ыг үз).

Ёс суртахуунгүй байдлын ноцтой байдлыг бид сайтар мэдэж ойлгох хэрэгтэй. Бид өөрсдөө нүгэлгүй амьдралаар амьдраад зогсохгүй бусдад ялангуяа үр хүүхдүүддээ ёс суртахуун цэвэр байдлыг зааж өгч түүгээр амьдрахыг уриалах хэрэгтэй.

Бид үр хүүхдүүддээ даруу хувцаслаж, ёс суртахуунаараа цэвэр байхыг хэрхэн уриалж чадах вэ?

Ёс Суртахууны Цэвэр Байдал Дах Пристийн Зэргийн Хүч Чадал

Ариун явдлын хуулийг зөрчсөн ямар ч хүн, уг нүглээ чин сэтгэлээсээ наманчлахгүй л юм бол амар амгаланг олж авч чадахгүй. Мормоны Ном бидэнд Ариун Сүнс бохир сүмд амьдарч чадахгүй хэмээн хэлдэг билээ. (Хиламан 4:24-ийг үз). Хэрэв бид Ариун Сүнсний хүч чадлыг гээвэл бид өөрсдийн шагнал болон пристийн зэргийн эрх мэдлээ ашиглах боломжгүй болно. Их Эзэн бидэнд, түүний өмнө бүх зүйлүүдийг цэвэр ариунаар хийх ёстой, хэмээн хэлсэн билээ. (С ба Г 42:41-ийг үз). Бид ёс суртахуунаараа цэвэр байвал Ариун Сүнс бидэнд Пристийн зэргийн хүч чадлаа зөвөөр ашиглахад маань туслахын тулд биднээр дамжуулан ажиллах болно. Ийм замаар, пристийн зэрэг нь нүглийн эсрэг агуу хамгаалалт болдог. Бид үүнийг зөв шударгаар ашигласнаараа бусдад үр дүнтэй үйлчлээд зогсохгүй, уруу таталтаас зайлах хүч чадлыг олж авах болно. Ахлагч Теодор Таттл, шударга бус байдал пристийн зэргийн эрх мэдлээ ашиглахад маань хэрхэн саад болдог тухай жишээг ярьсан юм.

“Нэг тэнэг залуу номлолд явахаар ярилцлагад оржээ. Ингээд түүнээс зарим нэг асуултыг шууд асуухад, тэр худлаа хариулжээ. . . . Дараа нь тэр номлолд явж, ариун сургаалыг заахыг оролджээ. Тэр нь мэдээж хэрэг түүний унасан эцсийн шалгалт байлаа. Их Эзэний Сүнсгүйгээр тэр номлогчийн ажил хийж чадахгүй гэдгийг тэр номлогч олж мэджээ. . . . Ингээд Их Эзэний Сүнснийг өөртэйгээ хамт

байлгахын тулд уг номлогч ярилцлага өгсөн тэдгээр хүмүүст худлаа хэлснээ хүлээн нүглээ наманчлах хэрэгтэй болжээ,” хэмээн ахлагч Таттл бичжээ (“Men With a Messages”, BYU-гийн Семинар Институтын факультетад хандаж хэлсэн үг. 1958, х. 2.)

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл дээрх түүхэнд гарсантай адил номлогч нарт тус болох зөвлөгөө өгсөн юм. “16 эсвэл түүнээс дээш насанд хүртлээ үерхэл ба найз нөхөдтэй болохоо азнах буюу маш анхааралтайгаар сонгон хянах ёстой. Залуу хөвгүүд арван есөн нас хүрээд номлолд явах учир тэд ойр дотны харьцаа холбоонд орох асуудлыг хязгаарлах хэрэгтэй.” (The Marriage Decision, *Ensign*, 2-р сар 1975, х 4.)

Ерөнхийлөгч Кимболл “залуучуудын маань үйлддэг бэлгийн харьцааны хамгийн нийтлэг нүглүүдийн дунд тэврэлдэх, бие биенээ илэх зэрэг ордог. Эдгээр зүй бус харьцаанууд нь үе үе нууцаар амраглах. . . . үр хөндөлт зэрэг үрүү хөтөлдөг ч —бүх муухай нүглүүд— өөрсдийн гэсэн хор хөнөөлтэй нүгэл хилэнцээр зогсохгүй, мөн энэ нь залуучуудад үе үе нэг нь хаана төгсөж, нөгөө нь хаанаас эхэлж буйг ялгахад хэцүү байдаг юм” хэмээн тайлбарлажээ. (The Miracle of Forgiveness, х 65.)

Ерөнхийлөгч Кимболлын зөвлөгөө залуу номлогчид хэрхэн туслах вэ?

Өөрсдийгөө ариун явдалтай, үнэнч шударга байлгах нь Их Эзэн биднийг сүнслэг хүч чадлаар адислах боломжийг олгодог. Гэсэн хэдий ч заримдаа бид алдаа гаргадаг. Хэрэв бид алдаа гаргавал салбарын ерөнхийлөгч, бишоп, эсвэл номлолын ерөнхийлөгчтэйгээ түүнийхээ талаар ярих хэрэгтэй. Тэр бидэнд зөвлөж, өршөөл авахад маань туслах болно.

Бид Их Эзэнд нүглээ хүлээхэд Тэрээр биднийг ёс суртахуунаараа цэвэр үлдэхэд маань туслахынхаа хэрээр биднийг өршөөхийг ихэд хүсдэг билээ. Тэр бидний сул дорой талыг мэддэг бөгөөд уруу таталтыг эсэргүүцэх арга замаар биднийг хангаж өгөх болно. (1 Коринф 10:13-ыг үз). Түүний өгсөн хэм хэмжээгээр хэрхэн амьдрахыг бидэнд заахын тулд, мөн биднийг удирдахын тулд нэмэлт тусламж болгон Тэр бошиглогчдыг илгээсэн юм.

Их Эзэний өмнө ёс суртахуунаараа цэвэр байхын тулд шаардлагатай бүгдийг хийвэл бид Бурханы өмнө өөртөө итгэлтэй, айж эмээхгүй, ичиж зовохгүй зогсох болно. Энэ нь зөв шударга бүх эрэгтэй эмэгтэй хүмүүст өгсөн амлалт юм. (Гордон.Б.Хинкли, “From My Generation to Yours, With love”, *Improvement Era*, 12-р сар 1970, х. 73.)

Бидний ёс суртахууны цэвэр байдал үр хүүхдүүдийн маань байдалд хэрхэн нөлөөлдөг вэ? Зөв жишээ үзүүлэхийн тулд бид юу хийж чадах вэ?

Пристийн зэрэгтний хувьд бид ёс суртахуунаараа цэвэр л байхгүй бол сүнслэг үүргээ биелүүлж чадахгүй. Үүнийг биелүүлэх хамгийн сайн арга бол ёс суртахууны ямар ч бохир байдлыг амьдралдаа оруулахгүй байх явдал юм. Хэрэв бид ёс суртахууны хуулиудад дуулгавартай байдлын жишээг үзүүлбэл, үр хүүхдүүд маань ёс суртахууны цэвэр байдлын чухлыг мэдэн авч, өөрсдөө ёс суртахуунаараа цэвэр байхыг эрмэлзэх болно.

Дүгнэлт

Их Эзэн биднийг аз жаргалтай болгохын тулд зарлигуудыг өгсөн. Бурханы хуулиудыг дуулгавартай дагах бүрдээ бид адислал хүлээн авах болно. Гэвч хуулиудыг зөрчих бүрдээ бид үйлдлийнхээ үр дүнгийн зовлонг амсах болно. Ёс суртахуунаараа цэвэр амьдрах нь бидэнд олон талаар үр ашгаа өгөх болно. Ёс суртахууны цэвэр амьдрал нь аз жаргалтай гэр ба гэрлэлтүүдийг бий болгодог. Энэ нь биднийг уймраа байдал, гэмшил харууслаас хол байлгах болно. Энэ нь биднийг Их Эзэнд үйлчлэхэд зохистой байлгадаг. Энэ нь бидэнд ариун сүм үрүү явах боломжийг олгодог. Энэ нь пристийн зэрэгтний хувьд бидэнд пристийн зэргээ бусдын ашиг тусын тулд үр дүнтэйгээр ашиглах боломжийг олгодог. Хамгийн чухал нь, энэ нь бидэнд амьдрахад маань тусалдаг ба ингэснээрээ бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт мөнхөд амьдарч чадна.

Уриалга

1. Ёс суртахуунаараа цэвэр байхын тулд шаардлагатай алхмуудыг хий.
2. Ёс суртахуунаараа цэвэр байхын чухлыг, мөн ёс суртахуунаараа хэрхэн цэвэр байх талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилц.

Нэмэлт Судрууд

Матай 5:27–28 (бид зүрх сэтгэлдээ садарлаж болохгүй)

1 Тимот 2:9–10 (даруу төлөв байдлын ач холбогдол)

2 Нефай 9:36,39 (ёс суртахууны цэвэр байдлын шагналууд, ёс суртахуунгүй байдлын шийтгэлүүд)

Якоб 2:27–28 (Их Эзэн ариун явдалд баярладаг)

С ба Г 42:22–24, 80–81 (ёс суртахуунгүй байдлын шийтгэлүүд)

С ба Г 88:86 (ёс суртахууны цэвэр байдал хувийн эрх чөлөөг олгодог)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “The Law of Chastity,” 39-р бүлгийг унш.
2. Самбар, шохой бэлд.
3. Ангийн гишүүдэд хичээл дэх түүх ба судруудыг ярихыг даалга.

Энэ хичээлийн зорилго бол мөнхийн гэр бүлийг байгуулах үүрэг хариуцлагаа ойгоход маань туслах явдал болно.

Оршил

Мөнхийн гэрлэлт нь Исүс Христийн Сүмийн үндсэн сургаал бөгөөд Их Эзэний бидэнд зориулсан төлөвлөгөөний хамгийн чухал хэсэг юм. Үүнгүйгээр бид энэ амьдралдаа үнэхээрийн аз жаргалтай байж чадахгүй бөгөөд мөнхөд сэлэсчел хаант улсад өргөмжлөгдөж чадахгүй. Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит: . . . Гэрлэлт нь Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн ойлголтоор бол . . . [мөнхийн] . . . гэрээ юм . . . Энэ нь мөнхийн өргөмжлөлийн үндэс бөгөөд үүнгүйгээр Бурханы хаант улсад мөнхийн дэвшил хөгжил байж чадахгүй. (Doctrine of Salvation, 2:58.)

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимболл “Тэнгэрлэг Эцэгт маань хүн төрөлхтний нялх нярай өсөлтөөс эхлээд тэнгэрлэг зан чанарт хүрэхэд зориулсан төлөвлөгөө бий . . . Тэр бүх хүмүүс цаг үе болон мөнхөд гэрлэхэд зохистой байх ёстой хэмээн төлөвлөсөн юм. (“The Lord’s Plan for Men and Women”, *Ensign*, 10-р сар 1975, хх 2,4). Ариун Сүмийн гэрлэлт нь мөнхийн гэр бүлийн нэгдлийн эхлэл нь юм. Ариун Сүмд гэрлэсэн хос хүүхдүүдтэй болж зарлигуудыг биелүүлбэл, тэд үүрд аз жаргал ба баяр баясгаланг тэдэнд авчрах мөнхийн гэр бүлийг бүтээнэ.”

Мөнхийн Гэр Бүл Болоход Бэлтгэх нь

“Мөнхийн гэр бүл Ариун Сүмд эхэлдэг” 35-а үзүүлэнг таниул.

Хожмын-үеийн Гэгээнтнүүдийн хувьд, ариун сүм бол дэлхий дээрх хамгийн чухал газруудын нэг юм. Ариун сүмд гэр бүлүүдийг Бурхантай мөнхөд хамт амьдрах боломжийг олгодог ёслолуудыг гүйцэтгэдэг юм. Гэр бүлийн тэргүүний хувьд, мөн пристийн зэрэгтнүүдийнхээ хувьд бид гэр бүлийнхнээ өргөмжлөл тийш хөтлөн удирдах үүрэг хариуцлагатай байдаг. Энэ нь бид гэр бүлийнхнээ ариун сүмд ороход нь бэлтгэх үүрэг хариуцлагатай гэсэн үг юм. Бид пристийн зэргээ хүндлэх мөн цэвэр ариун амьдралаар амьдрахыг эрмэлзэх зэргээс иймэрхүү бэлтгэл нь эхэлдэг юм.

35-а. Мөнхийн гэр бүл Ариун сүмд эхэлдэг.



35-a

TEMPLE
ARCHITECTURE
AND DESIGN

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс ариун сүмд гэрлэхэд, тэд энэ амьдралынхаа туршид гэрлэж, мөн үүрд хамт байхаар батлагддаг юм. Үүнээс гадна тэднээс гарах бүх хүүхдүүд тэдэнтэй шууд холбогдож гэрээнд төрдөг юм. Хосууд хууль ёсоор гэрлэж ариун сүмийн мөнхийн холболт хийлгэхээр явж байгаа бол эхнэр, нөхөр хоёр эхэлж холболтоо хийлгэж дараа нь хүүхдүүд нь эцэг, эхтэйгээ холбогддог. Тэднийг холболт хийлгэсний дараа төрөх хүүхдүүд нь тэдний мөнхийн гэр бүлийн нэгэн хэсэг болон тэдэнд шууд холбогддог юм.

Бид ариун сүмд гэрлэхээр бэлтгэгдэж ч бай, ариун сүмд гэр бүлийнхэнтэйгээ холбогдохоор бэлтгэгдсэн ч бай, бид адилхан бэлтгэгдэх ёстой. Бидний эхний алхам бол ариун сүм үрүү явах зорилго тавих. Бид эхнэр хүүхдүүдтэйгээ бэлэн болоход хийх ёстой зүйлсийг ярилцан, явах өдрөө хамтдаа товлох хэрэгтэй. Энэхүү өдрөө бид бичиж тэмдэглэн, энэ өдрийн төлөө Их Эзэнээс тусламж гүйн залбирч, бэлтгэхэд зориулан чадах бүхнээ хийх хэрэгтэй. Үүнээс гадна ариун сүм маш нандин газар тул бид тийш орохдоо өөрсдийгөө сүнслэг байдлаар бэлтгэх хэрэгтэй. Ариун Сүмд бид сүнслэг чухал байдлын агуу гэрээг хийдэг бөгөөд бид Их Эзэнд түүний бүх зарлигуудыг биелүүлж, бүх зүйлээрээ түүнийг дуулгавартай дагахаа амладаг юм. Иймээс бид эдгээр гэрээнүүдийг хийхэд бэлтгэхийг хүсэж байвал зөв шударгаар амьдарч Сүнснийг өөртэйгээ хамт байлгахыг эрэлхийлэх хэрэгтэй.

Бид өөрсдийгөө сүнслэг байдлаар илүү сайн бэлтгэхийн тулд юу хийж чадах вэ? (Хариултуудыг самбарт бич.)

Бид өөрсдийгөө бэлтгэж чадах зарим нэг арга замууд нь—

- Байнга чин сэтгэлээсээ залбир
- Судруудаас тогтмол унш
- Ёс суртахуунаараа цэвэр ариун бай
- Даруу байж наманчилж бай
- Гэр бүлийн цуглаан ба гэр бүлийн залбирлыг итгэлтэйгээр хий.

Хэрэв бид сүнслэг байдлаараа бэлтгэгдэхэд өөрсдийн чадах бүхнийг хийвэл Ариун Сүнснээс тусламж авах болно.

Дараах түүхээс ярихыг урьдчилан даалгасан ангийн гишүүнээс хүс.

Нэгэн эмэгтэй, түүний гэр бүл ариун сүмд хамтдаа холбогдоход бэлтгэгдсэнээр өөрсдийн аз жаргалыг хамтдаа хэрхэн бий болгосон тухай ярьсан юм:

“Хүүхэд байхдаа ч би эцэг эхийгээ хоорондоо хэрэлдэхэд нь хорсол, харуусал, уурыг мэдэрч чаддаг байлаа. Орчин байдал маань байх ёстойгоороо байхгүй байгааг би мэддэг байсан учраас унтахдаа би байн байн ганцаараа уйлдаг байлаа.”

“Гэр бүл нь ариун сургаалаар нэгдсэн найз нөхдийнхөө гэр орны ялгааг би мэдэрч чаддаг байлаа . . . [байдал маань өөрчлөгдөж эхэлж байна. Бишоп ба гэрийн багш нартаа баярлалаа]. Ариун сургаал аажмаар амьдралын маань нэг хэсэг болж байна. . . . Маргаанууд цөөрч—холдож байна . . . Манай гэр бүлийнхэн заалгасан зүйлсийнхээ дагуу амьдрах хариуцлагын төлөө ялангуяа ариун сүмд явах зорилгын төлөө ажиллаж байгаа үед ойлгож байна. Хурц хатуу үгийг хэлсэн үед, бид хайрын үгийг тайван ба чин сэтгэлээсээ эргүүлэн хэлдэг болсон. Бид бие биедээ туслахдаа баяр баясгаланг мэдэрдэг боллоо. Ээж, аав хоёр маань хоёр, гурван удаа гуйх хэрэггүй; бид үүрэг даалгавруудыг хурдан шуурхай чимээгүйхэн хийчихдэг болсон. Хайр болон туслах хүсэл нь бидний дундах хуучин хорсол, бардамнал, байнгын хэрүүл маргааныг ялан дийлсэн юм.”

“Өөрчлөлтийг юу бий болгосон бэ? Маш олон зүйл. Магадгүй энэ нь удаан хүлээсэн мөрөөдлийн бодит биелэл байж болох юм. Гэр бүлийн залбирал ба гэр бүлийн цуглаан нь бидний амьдралын нэг хэсэг болсноор бид бие биенээ танин мэдэж хайрлаж сурсан. Бидний амьдарч буй байдал маань гэр бүлийн залбирлын гэрчлэл, судар унших, гэр бүлийн цуглаан, сүмийн цуглаануудад оролцох зэрэг гэрчлэлүүдтэй болох боломж олгосон юм. Бидний бодит гэрчлэл нь наманчлалын зарчим байсан билээ. Бид Бурхан амьдардаг гэдгийг мэдэж байсан. Хэсэг хугацааны дараа энэ гэрчлэлийн хамт мөн бид зохистой байсны баталгаагаар, гэр бүлээрээ цаг үе болон мөнхөд холбогдохоор ариун сүм үрүү явахад бэлэн болсон байлаа. . . .”

“Бид ариун сүмийн хаалганы өмнө зогсоход, хоолой дээр минь бөөн юм тээглэх шиг болов. Эргэлзээ төрсөн хэдэн хормын дараа бид орцгоов. . . . Үйлчлэгч биднийг холболтын өрөөнд оруулахаар хүрч ирэв. Ээж, аав хоёр маань тэнд ариун сүмийн хувцастай царай нь гэрэлтэн зогсож байлаа. Бид гар гараасаа барилцан өргөлийн тавцанг хүрээлэн сөхрөн сууцгаалаа. Үйлчлэгч бас нялх хүүхдийг гэр бүлийн хүрээний нэг хэсэг болгохоор тэвэрсэн байлаа.”

“Дараа нь биднийг цаг үе болон мөнхийн гэр бүлд нэгтгэсэн үгийг хэллээ.”

“Тэд намайг өөрсөдтэйгөө цаг үе болон мөнхөд холбосон учраас миний эцэг, эх надад хайртай гэдгийг би мэднэ.” (Брэнда Блоксхэн, “My Parents Took Us to the Temple”, *Ensign*, 8-р сар 1974, хх 61–62.)

Ариун сүмд явахаар бэлтгэхэд санхүүгийн бэлтгэл бас чухал билээ. Зарим үед үүнийг төлөвлөх, хадгалах, хамтдаа хөдөлмөрлөхөд хэдэн жил зарцуулдаг. Олон гэр бүлүүд ариун сүмд явахын тулд байсан бүхнээ золиосолдог. Гэр бүлийнхэн маань бидэнд хичнээн

үнэтэй болохыг хэдэн минут ярилц. Гэр бүлийнхэнтэй маань тэнцэх хэмжээний хөрөнгө байдаг гэж үү?

Ариун сүм үрүү явах зардлаа төлөхийн тулд бид хоол хүнс, зочид буудал зэргийг оролцуулаад ариун сүм үрүү явж тэндээс буцаж ирэхэд хичнээн хэмжээний зардал гарахыг тооцон үзэх хэрэгтэй. Бид энэ тооцоогоо гаргасны дараа сар бүр хичнээн хэмжээний мөнгө хадгалж чадахыгаа тооцох хэрэгтэй. Хэрэв бид үүнийг хийвэл, эцэст нь ариун сүм үрүү явах болно. (Ваха Танга Ахын гэрчлэлийг 21-р хичээлээс үз). Өөрсдийгөө болон гэр бүлийнхнээ ариун сүм үрүү явахад бэлтгэх хэрэгтэй зүйл бүрийг бид одооноос эхэлж хийх хэрэгтэй. Шагнал нь зарцуулсан ямар ч цаг хугацаа ба зардлаас хавьгүй их байх болно.

Гэр бүлээрээ ариун сүмд орсон чуулгын гишүүнээр бэлтгэл ба туршлагынх нь талаар яриул.

Гэрлэж амжаагүй байгаа залуу хүмүүсийг ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэ хэмээн бошиглогчид байнга зөвлөдөг билээ. Ерөнхийлөгч Кимболл: “Залуу хүмүүсийн ихэнх нь энэ цаг үед ариун сүмгүй газар нутагт амьдарч байгаа хэдий ч, очиход боломжийн зайд орших ариун сүмүүд бий билээ. . . Зөв бэлтгэлээ хийсэн үед эдгээр ойролцоох ариун сүмүүдийн аль нэг рүү нь, үр хүүхдүүдээ үүрд өөрсдийн болгох, мөн өөрсдөө тэдний мөнхийн эцэг, эх болж үүнийгээ мөнхийн гэрлэлт болгох, цаг үе болон мөнхөд холбогдохоор явна гэдэгт бид найдаж байна” хэмээн хэлсэн юм. (“The Marriage Decision”, *Ensign*, 2-р сар 1975, х. 4.)

Мөнхийн Гэр Бүлийг Бий Болгох нь

“Ариун сүмд гэр бүлээрээ холбогдсон гэр бүлүүдэд, хэрэв тэд итгэлтэй хэвээр байвал мөнхөд хамт байх болно хэмээн амладаг,” 32-б үзүүлэнг таниул.

Ариун Сүмийн гэрлэлт бол мөнхийн гэр бүлийн эхлэл юм. Гэвч энэ нь зөвхөн эхлэл билээ. Үүрд үргэлжлэх гэр бүлийн харилцааг бий болгохын тулд бид ариун сүмд хийсэн амлалтдаа итгэлтэй үнэнч байх хэрэгтэй. Бид мөнхөд гэр бүлээрээ хамтдаа байхыг хүсэж байвал бие биетэйгээ эелдэг харьцах хэрэгтэй. Бид өөрсдийнхөө гэрийг тэнгэрийн нэг хэсэг болгохыг эрмэлзэх ёстой.

Эцэг хүний хувьд бид мөнхийн гэр бүл байгуулахын тулд олон зүйлийг хийж чадна. Бид хөрөнгөтэй эсвэл боловсролтой байх албагүй ч пристийн зэргээ хүндэтгэх ёстой. Хэрэв бид үүнийг хийвэл, пристийн зэргээр дамжуулан өөрчлөгдөн хүчирхэгжиж, бидэнд мөнхийн гэр бүлийн нэгдлийг байгуулахад туслах Ариун Сүнсний дотоод удирдлагыг хүлээн авах болно. Мөнхийн гэр бүлийг байгуулахын тулд бидний хийх ёстой зарим нэг зүйл бол;—

35-б. Ариун сүмд холбогдсон гэр бүлүүдэд, хэрэв тэд итгэлтэй хэвээр байвал мөнхөд хамт байх болно хэмээн амладаг.



台灣台榭聖殿

耶穌基督

末世聖徒

- Гэр бүлийн залбирал хамтдаа хийхээр гэр бүлийнхнээ цулуулах
- Хоол адислуулахыг нэгэндээ даалгах
- Гэр бүлийнхнээ сүмд аваачих
- Аравны нэг ба бусад өргөлүүдээ төлөх
- Хийж буй бүх зүйлсдээ шударга байх
- Үр хүүхдүүд ба эхнэртээ заахдаа мөн тэднийг хайрлахдаа Их Эзэнээс тусламж гуйхын тулд байнга ганцаараа сөгдөн залбирал хий.
- Гэр бүлийнхэндээ, ялангуяа гэр бүлийн цуглаан дээр ариун сургаалыг заах бүх боломжийг ашигла.

Бид өөрсдийн гэр бүлийнхнийг ийм замаар адисласнаараа мөнхийн гэр бүлийн нэгэн хэсэг байгаадаа баясах болно.

Гэрлээгүй пристийн зэрэгтнүүд гэр бүлийнхэндээ аз жаргалтай байж мөнхийн гэр бүл мэт амьдрахад нь тусалж чадна. Бид Их Эзэний гэр бүлд маань зориулсан төлөвлөгөөг ойлгоод, гэр бүлийн гишүүд маань амьдралын маань хамгийн чухал хүмүүс юм гэдгийг харж чадна. Бид тэдэнтэй хайр, эелдэг байдлаар харьцаж тэднийг урамшуулан зоригжуулж чадах бүхнээ хийх хэрэгтэй.

Ангид тань гэрлээгүй залуу пристийн зэрэгтнүүд байвал, тэдэнтэй ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэх арга замуудын талаар ярилц. Мөнхийн гэрлэлт тэдэнд яагаад чухал вэ гэдгийг тэднээс асуу. Тэд яг одоо гэр бүлийнхнээ аз жаргалтай болгохын тулд хийж чадах зүйлсийнх нь талаар ярилц.

Дүгнэлт

Урьдчилан даалгасан ангийн гишүүнээр дараах түүхийг яриул.

Нэгэн Мексик залуу өөрийн нагац ах эгчийнхээ тухай дараах түүхийг ярьсан юм. Ариун сүмийн гэрлэлт дээр тулгуурласан гэр бүлийн амьдралын баяр баясгаланг энэхүү түүх өгүүлдэг юм:

“Миний Нагац ах Дэвид болон нагац эгч Гуадалун хоёр . . . үргэлж хэрэлддэг байлаа. Тэдний гэр нь замбараагүй байсан ба хүүхдүүд нь өдөр бүрийн хэрүүл зодооны гэрч нь болж байгаадаа зовж шаналдаг байлаа. Эцэст нь Нагац эгч Гуадалун хүүхдүүдээ авч эцэг, эхтэйгээ амьдрахаар явлаа.”

“Энэ тусгаарласан амьдралын хугацаанд Нагац Ах Дэвид номлогч нартай уулзаж хэдэн өдрийн дараа усаар батлуулжээ. Ариун сургаалын талаарх түүний шинэ ойлголт нь, гэр бүл бол мөнхийн нэгдэл юм гэдгийг ухамсарлуулжээ. Тэр номлогчдыг эхнэр хүүхдүүд үрүүгээ явуулсан боловч тэд сонсохоос татгалзав. [Эцэст нь] тэд ариун сургаалыг хүлээн зөвшөөрч сүмд нэгдэн, хамтдаа дахин амьдарч эхлэв. Гэсэн хэдий ч хэрүүл зодоон урьдын адил үргэлжилсээр л байлаа.”

“Тэд ариун сүмийн гэрлэлтийн чухлын талаар ярилцсан боловч санхүүгийн асуудал ба тогтмол хэрүүл нь тэднийг зорилгоос нь холдуулж байлаа. [Гэвч эцэст нь ихээхэн золиослолын үр дүнд тэд ариун сүм үрүү явах боломжтой боллоо]. Миний нагац ах, эгч хоёр зарим хүүхдүүдтэйгээ хамтдаа холбогдон батлуулж, Мексикт ердөө 15 песотой ирсэн бөгөөд, . . . нагац ах маань ажилгүй болов.”

“Ариун сүмд гэрлэсэн явдал нь эдгээр асуудлуудыг арилгаагүй ч, нагац ах, эгч хоёрт маань энэ нь мөнгөгүй ч урагшлан явж, аз жаргалтай байх хүч чадлыг өгсөн юм.”

“Бага багаар тэд идэх хангалттай хоолтой болж, нагац ах маань ажил олох боломжтой болов.”

“Би тэдний нүүр царай ба амьдралд нь бий болсон асар том өөрчлөлтийг харах боломжтой байлаа. Тэд урьдынхаасаа улам аз жаргалтай болсон ба дахин ямар ч хэрүүл сонсоогүйдээ би гайхаж байсан юм. Тэдний гэрт би хайрын үгийг сонсдог болсон юм. . . .”

“Саяхан нагац ах маань надад, “Жорж 24 жилийн турш амьдраад ингэж их зовсныхоо дараа, бид өөрсдийн аз жаргалыг оллоо. Энэ нь бид дөнгөж анх удаа гэрлээд, яг одоо мөнхийн бал сараа эдэлж буй цэвэр залуу хүмүүс мэт санагдуулж байна” гэсэн билээ.” (Жорж Карлос Тежада Перада, “Eternal Honeymoon”, *Ensign*, 8-р сар 1974, хх 62–63.)

Мөнхийн гэр бүлийн харилцаанаас шалтгаалан бид агуу их баяр баясгаланг хүлээн авч чадна. Сорилт, зовлон бэрхшээлийг бид гэр бүлийнхэнтэйгээ хуваалцсанаар тэдгээр нь хялбар болдог. Хуваалцаж буй хайраас маань үүдэн бидний амьдрал улам элбэг дэлбэг аз жаргалтай болно. Бид үүрд хамтдаа байна гэсэн баталгааныхаа үр дүнд асар их амар амгаланг ба тайтгарлыг мэдрэх болно.

Уриалга

1. Ариун сүмд гэрлээгүй байгаа бол төлөвлөгөө боловсруулж, ариун сүмд гэр бүлийнхэнтэйгээ холбогдох бэлтгэлээ эхэл. Хэрэв боломжтой бол ариун сүмийн зураг олж авч харагдахуйц газарт байрлуул. Дараа нь ариун сүмийнхээ зургийн доор гэр бүлийнхээ зорилго болгон сонгосон он сар өдрөө бич.
2. Хэрэв та ариун сүмд гэрлэсэн бол гэр бүлийнхэнтэйгээ мөнхөд хамт амьдрахын тулд хийх ёстой зүйлсийн талаар ярилц. Гэр бүл тань бэхжихэд хэрэгтэй нэг арга замыг сонгон түүн дээрээ энэ долоо хоногоос эхлэн ажилла.

Нэмэлт Судрууд

С ба Г 131:1–4 (сэлэсчел хаант улсын хамгийн дээд хэсэгт орохын тулд бид гэрлэлтээр холбогдох ёстой)

С ба Г 132:19,55 (мөнхийн гэр бүл болон хамтдаа холбогдсон хүмүүст адислалууд амлагдсан)

Багшийн Бэлтгэл

Энэ хичээлийг заахын өмнө:

1. *Gospel Principles* гарын авлагаас “The Family Can Be Eternal,” 36-р бүлгийг унш.
2. Хичээл дэх түүх ба судруудыг танилцуулахыг ангийн гишүүдэд даалга.
3. Ариун сүмд гэр бүлийнхэнтэйгээ орсон чуулгын гишүүнд бэлтгэл ба туршлагынх нь талаар ярихыг даалга.

Ашигласан Материал

- Cowley, Matthew. *Matthew Cowley Speaks*. Salt Lake City: Deseret Book Company, 1943.
- Durrant, George D. *Love at Home, Starring Father*. Salt Lake City: Bookcraft, 1973.
- Gospel Principles*. Salt Lake City: The Church of Jesus Christ of Latter-day Saints, 1978.
- Grant, Heber J. *Gospel Standards*. Compiled by G. Homer Durham. Salt Lake City: Improvement Era, 1941.
- Jensen, Margie Calhoun. *When Faith Writes the Story*. Salt Lake City: Bookcraft, 1973.
- Kimball, Spencer W. *Faith Precedes the Miracle*. Salt Lake City: Deseret Book Company, 1972.
- _____. *Marriage and Divorce*. Salt Lake City: Deseret Book Company, 1976.
- _____. *The Miracle of Forgiveness*. Salt Lake City: Bookcraft, 1969.
- Lee, Harold B. *Stand Ye in Holy Places*. Salt Lake City: Deseret Book Company, 1974.
- McKay, David O. *Gospel Ideals*. 2nd printing. Salt Lake City: Improvement Era, 1954.
- _____. *Treasures of Life*. Compiled by Clare Middlemiss. Salt Lake City: Deseret Book Company, 1962.
- Maeser, Reinhard. *Karl G. Maeser*. Provo: Brigham Young University, 1928.
- Packer, Boyd K. *Teach Ye Diligently*. Salt Lake City: Deseret Book Company, 1975.
- Pratt, Parley P. *Autobiography of Parley Parker Pratt*. Edited by Parley P. Pratt, Jr. 11th printing. Salt Lake City: Deseret Book Company, 1975.
- _____. *Key to the Science of Theology*. 9th ed. Salt Lake City: Deseret Book Company, 1966.
- Rector, Hartman, and Connie Rector. *No More Strangers*. Vol. 3. Salt Lake City: Bookcraft, 1976.
- Roberts, B. H. *A Comprehensive History of The Church of Jesus Christ of Latter-day Saints, Century One*. 6 vols. Salt Lake City: The Church of Jesus Christ of Latter-day Saints, 1930.
- Smith, Joseph. *Teachings of the Prophet Joseph Smith*. Selected by Joseph Fielding Smith. Salt Lake City: Deseret Book Company, 1938.
- Smith, Joseph F. *Gospel Doctrine*. 5th ed. Salt Lake City: Deseret Book Company, 1939.
- Smith, Joseph Fielding. *Doctrines of Salvation*. 3 vols. Compiled by Bruce R. McConkie. Salt Lake City: Bookcraft, 1954–56.
- Widtsoe, John A. *Evidences and Reconciliations*. 3 vols. in 1. Arranged by G. Homer Durham. Salt Lake City: Bookcraft, 1946.
- Woodruff, Wilford. *The Discourses of Wilford Woodruff*. Compiled by G. Homer Durham. Salt Lake City: Bookcraft, 1946.
- Young, Brigham. *Discourses of Brigham Young*. Selected by John A. Widtsoe. Salt Lake City: Deseret Book Company, 1941.

Индекс

A

- Аарон, Мосесын ах, 11
Аароны Пристийн Зэрэгт томилох, пристийн үүрэг, 48
- Адам
усаар батлуулсан, 8
. . . ийн хүүхдүүд, хэрэгжүүлсэн сонголт, 10
Эдэний цэцэрлэгээс хөөгдсөн нь, 8
Сүм байгуулсан, 8
пристийн зэргийг хүлээн авсан, 8
үр хүүхдүүддээ ариун сургаалыг заасан, 10
- Адислал, патриархын. Патриархын адислал-ыг үз.
- Ажил алба
ур чадвараа хөгжүүлэн сайжруулах, 167–75
Хибэр. Ж. Грантын туршлага, 174
чуулга ажилтай болоход, 173 тусална.
Ховард. В. Хантерын тунхаглал. шилж сонгох нь, 167–73
- Ажил
зарлиг ба адислал, 154, 167, 179 зуршлууд, 173
- Амар амгаланг олгогч, байх нь, Аароны Пристийн Зэргийн багшийн үүрэг, 46
- Амралт эрүүл мэндэд чухал, 122
Амралт эрүүл мэндэд чухал, 182 Бригхэм Янгийн тунхаглал.
- Аравны нэг ба мөнгө зохицуулалт, 153
- Ариун ёслол
ба усан баталгааны гэрээ, 220
прист гүйцэтгэх үүрэгтэй, 49
ба Ариун Сүнсний бэлэг бэлтгэл, 224
Аароны Пристийн Зэргийн багшийн үүрэг, 40
нандин байдал, Виктор. Л. Брауны тунхаглал, 34
- Ариун Сүмийн ажил, Мелкизэдэк Пристийн зэрэгтнүүдийн үүрэг хариуцлага, 165
- Ариун Сүнс
Бурхан. . .-ээр дамжуулан ажилладаг, 3
тусламж, 225–27
Франклин. Д. Ричардсын тунхаглал, 228
Хибэр. Ж. Грантын тунхаглал, 228
Хэнри. Д. Майлын тунхаглал, 229
удирдамжийг хүлээн авах, 133
Марион. Г. Ромнэй-ийн тунхаглал, 133–35
хүч чадлаар заах нь, 132–37
А. Теодор Таттлын тунхаглал, 132
Дэвид. О. Маккэй-ийн тунхаглал, 132
- Ариун Сүнс, бэлэг, 224–30
байлгах, 225–27
Жозеф Смитийн тунхаглал, 225
Жозеф Филдинг Смитийн, 227 тунхаглал,
Мелвин. Ж. Баллардын тунхаглал, 225
Ли Гранд Ричардсын тунхаглал, 225
Лоренцо Снөүгийн тунхаглал, 225
- Ариун Сүнс, заах нь. “Ариун Сүнс”-ийг мөн үз.
- Ариун Сургаал
заахад бэлтгэх, 114–23
Дэвид. О. Маккэй-ийн, 114
жагсаасан алхмууд, 116
Адам хүүхдүүддээ заасан, 10
- Ариун Сургаалын гэрчлэл, тодорхойлогдсон, 192–93
Хэролд. Б. Лигийн тунхаглал, 192–93
заах хүч чадлыг өгдөг, 135–37
Алвин. Р. Дайрын түүхэнд өгүүлэгдсэн, 135

эцэг эх, хүүхдүүддээ гэрчлэх ёстой, 112
 хүлээн авах, 193–94
 Жозеф Смитийн тунхаглал, 194
 Лорэн Данни тунхаглал, 193
 Парли Прэттийн тунхаглал, 193
 бэхжүүлдэг, 195
 Хэролд, Б. Лигийн тунхаглал, 195
 Ариун явдал. Ёс суртахууны цэвэр байдал-ыг хар.
 Ахлагч, үүргүүд, 63–68

Б

Багш, Аароны Пристийн Зэргийн үүргүүд, 40–47
 Бие даасан байдал. Спэнсэр В. Кимболлын тунхаглал, 159
 Бие даах чадвар, Спэнсэр. В. Кимболлын тунхаглал, 159
 Бие, махбод, Бригхэм Янгийн тунхаглал, 176
 Бишоп
 томилолт, 57
 үүргүүд, 57–59
 цаг зуурын, Томас. С. Монсоны өгүүлсэн, 58–59
 Бишрэл, Спэнсэр. В. Кимболлын тунхаглал, 238–43
 Бурхан
 Адамд пристийн зэргийг өгсөн, 8
 пристийн зэргийн хүч чадлын эх сурвалж, 1
 хүч бол пристийн зэрэг мөн, 1
 хүсэл, залбирлаар мэдэгддэг, 5
 хүсэл, судрыг судалснаар мэдэгддэг, 5
 Ариун Сүнсээр дамжуулан ажилладаг, 3
 Бусдад туслах ба усан баталгааны гэрээ, 220

Г

Гишүүдийнхээр айлчлах, пристийн үүрэг, 49
 Гэр
 ариун сургаалаас сурах төв, 106–13
 Марион. Г. Ромнэйгийн тунхаглал, 107

зөрчилдөөн, эх сурвалжууд, 145–47
 нийцэл, 12
 Дэвид. О. Маккэй-ийн тунхаглал, 97
 туслах
 Аароны Пристийн Зэргийн багшийн үүрэг, 40–47
 өв тэгш, Жозеф. Ф. Смитийн тунхаглал, 145
 пристийн зэрэгтнүүд удирддаг, 92
 Меллизэдэк Пристийн зэрэгтний үүрэг хариуцлага, 63

Гэр Бүл

адислал, 40
 зөвлөгөө ба мөнгө зохицуулалт, 154–156
 мөнхийн, 258–65
 байгуулал, 262
 болоход бэлтгэл, 258–62
 Спэнсэр. В. Кимболлын тунхаглал, 258
 эцэг гишүүдтэй зөвлөлдөх, 92–99
 Элрэй. Л. Крисченсэний тунхаглал, 97
 Ричард. Л. Эвансын тунхаглал, эцэг хүн хэрэгцээнүүдэд үүрэг хариуцлага хүлээдэг, 97
 санхүү, 152–58
 гэрийн цуглаан, 110
 залбирал.
 адислал, 103, 107–08
 эцэг удирдах ёстой, 100–05
 уруу таталтаас татгалзах тусламж, 100
 гэр орондоо ажил хөдөлмөр эрхлэх нь, 102–03
 Хибэр. Ж. Грантын тунхаглал, Спэнсэр. В. Кимболлын тунхаглал, 100, 103
 асуудлууд, эв найрамдалтайгаар зохицуулах, 145–51
 Бойд. К. Пакерын тунхаглал, 147
 Спэнсэр. В. Кимболлын тунхаглал, 147; 148–49
 хамаарлууд, Мелкизэдэк Пристийн Зэрэгтэнүүдийн үүрэг хариуцлагууд, 63
 залбирал ба мацаг барилтаар хүчирхэгжин, 232

М. Рассел. Баллард (Бага)-ын
өгүүлсэн түүх, 232
зөв шударга пристийн зэрэгтний
харьцаа, 6
Гэрийн багшлалт
Мелкизэдэк Пристийн зэрэгтний
үүрэг, 63
Аароны Пристийн Зэргийн
багшийн үүрэг, 40–43
хүч чадал, Х. Бүрк Питерсоны
тунхаглал, 41–43
Гэрийн үйлдвэрлэл ба хадгалалт
Спэнсэр. В. Кимболлын
тунхаглал, 159, 161, 163
Ван. Ж. Фийвэрстоуны
тунхаглал, 161
Гэрлэлт, мөнхийн,258–65
Гэр бүл, мөнхийн.
Жозеф Филдинг Смитийн
тунхаглал зэргийг мөн хар, 258
Гэрчлэл олж авахын төлөөх мацаг, 193

Д

Дал
Чуулгууд, 79
Даниэл, 11
Даруу байдал.
гэртээ заах нь, 138–44
А. Теодор Таттлын тунхаглал, 143
Бойд. К. Пакерын тунхаглал,
138, 141
Спэнсэр. В. Кимболлын
тунхаглал, 138
Ван. Ж. Фийвэрстоуны
тунхаглал, 139
Дасгал эрүүл мэндэд чухал, 180
Дикон
үүргүүд, 31–38
Виктор. Л. Брауны тунхаглал, 31,
34
Диконы чуулга хэрхэн тусалдаг,
36–38
Дуулгавартай байдал дээр
тулгуурлагдсан адислалууд, 68
Жозеф Филдинг Смитийн
тунхаглал, 68
Дэмжлэг
пристийн зэргийн чуулганы
асуудал тулгарсан үйл
ажиллагаанд, 25

Хэролд Б. Лигийн тунхаглал, 25
Ж. Рүбэн Кларкийн (залуу), 26
Ван, Ж. Фийвэрстоуны өгүүлсэн
түүх, 27–29

Дээд прист, үүргүүд, 63–68

Е

Ева Эдений Цэцэрлэгээс хөөгдсөн нь, 8
Ерөнхий Эрх Мэдэл
хэрэгцээ, 77–84
Дэвид. О. Маккэй-ийн өгүүлсэн
түүхэнд дүрслэгдсэн, 80–82
үүрэг хариуцлагууд, 79
Хэролд. Б. Лигийн тунхаглал
дэмжих, 81
Ерөнхийлөн удирдах бишопын зөвлөл,
79

Ё

Ёс суртахууны цэвэр байдал, 251–57
пристийн зэргийн хүч чадал,
254–56
А. Теодор Таттлын тунхаглал,
254–55
Бойд. К. Пакерын тунхаглал, 251
Гордон. Б. Хинклигийн
тунхаглал, 255
Спэнсэр. В. Кимболлын
тунхаглал, 255
Спэнсэр. В. Кимболлын
өгүүлсэн гарз хохирлыг
өгүүлсэн түүх, 253–54

Ж

Жишээ
жишээний ач холбогдол, 39–41
пристийн зэрэгтнүүд үзүүлэх
ёстой, 3–5, 39–40
Жэкоб

З

Заах
пристийн үүрэг, 48
хүмүүст хайртай байх, 116–17
Бойд. К. Пакерын тунхаглал,
116–17
ариун сургаалд, бэлтгэх, 114–23
алхмууд, Дэвид. О. Маккэй
жагсаасан, 121
гэрчлэл хүч чадлыг өгдөг, 135–37

- Элвин. Р. Дайрын түүхэнд өгүүлэгдсэн, 135
- Заах**
Сүм дээр, 114–23
Бойд. К. Пакерын тунхаглал, 116–17
Ач холбогдол, 122
Дэвид. О. Маккэйн тунхаглал, 122
Ван. Ж. Фийвэрстоуны тунхаглал, 122
Ариун Сүнсний хүч чадлаар, 132–38
А. Теодор Таттлын тунхаглал, 132
Бригхэм Янгийн тунхаглал, 117
Дэвид. О. Маккэйн тунхаглал, 122
- Заин.**
Инохын, тэнгэрт гарсан нь, 10
Инохоор үндэслэн байгуулагдсан, 10
- Залбирах**
пристийн зэргийг зөвөөр ашиглах удирдамжийн төлөө, 5
Бурханы хүсэл зоригийг мэдэхийн төлөө, 5
гэрчлэлийг олж авахын төлөө, 195
- Залбирал, 231–37**
ба усан баталгааны гэрээ, 220
гэр бүл, Гэр бүл, залбирал-ыг үз.
- Зөв шударга ёс**
пристийн зэргийн чуулгыг бэхжүүлэхэд зайлшгүй шаардлагатай, 24
пристийн зэргийн хүч чадлыг олж авахад зайлшгүй шаардлагатай, 3-4
- И**
- Ижил хүйстэнтэйгээ бэлгийн харьцаанд орох явдал, 252
- Израил.**
Жэкобын үр удам Израилын хүүхдүүд хэмээн нэрлэгддэг, 11
Жэкобын нэрийг сольсон, 11
Мелкизэдэк Пристийн Зэргийг хүүхдүүдээс нь авсан, 11
- Исүс Христ**
пристийн зэргийн түлхүүрүүдийг барьдаг, 12
- Төлөөлөгчдийг томилсон, 12
Сүмийг зохион байгуулсан, 12
ариун сургаалын бүрдлийг сэргээсэн, 12
- Исүс Христэд, итгэх итгэл, 198–206**
хүмүүст золиослох боломжийг олгодог, 198
ариун сургаалын анхны зарчим, 198
Бригхэм Янгийн тунхаглал, 169
Марион. Г. Ромингийн өгүүлсэн түүх, 133–35
бэхжүүлдэг, 200–05
- Исүс Христийн Сүм**
Исүсийн зохион байгуулсан, 12
пристийн зэргийн үндэс суурь, 12
- Илайжа, 11
Инох Зайныг байгуулсан нь, 10
Итгэл, Исүс Христэд итгэх итгэл-ийг үз.
- К**
- Каин.**
- М**
- Мацаг барилт, 231–37**
ба усан баталгааны гэрээ, 220
хүч чадлын талаар өгүүлсэн түүх, Эзра Тафт Бэнсон, 235–36
хүч чадлын талаар өгүүлсэн түүх, Матай Казан, 234
- Мацгийн өргөл, 34**
Мелкизэдэк, 11
Мелкизэдэк Пристийн Зэрэг. Пристийн Зэрэг, Мелкизэдэк-ийг хар.
- Мэргэн Ухааны Үг**
дуулгавартай байсны адислалууд, 177–80
тодорхой зүйлсийн хорио, 178
- Мозес**
Израилын хүүхдүүдийг Египтээс гаргасан, 11
хуулиуд ба ёслолуудыг хүлээн авсан, 11
- Мозесийн цаг үе ба Исүс Христийн цаг үеийн хоорондох бошиглогчид, 11**
- Мөнгө зарцуулалт ба зохицуулалт, 154–55**
- Мөнгө**
зохицуулалт, 152–58

Бригхэм Янгийн тунхаглал, 156
Спэнсэр. В. Кимболлын
тунхаглал, 152

Н

Наманчлал, 207–14
ба усан баталгааны гэрээ, 220
баяр баясгалан, 208–13
хэрэгцээ, 207–08
Жозеф Филдинг Смитийн
тунхаглал, 207
Хэролд. Б. Лигийн тунхаглал, 213
Жозеф Смитийн тунхаглал, 207
Наманчлах, хэрхэн, 208
А. Теодор Таттлын тунхаглал, 208
Нөхөрлөл
пристийн зэргийн чуулгын үйл
ажиллагаа, 25–26
Стефэн. Л. Ричардсын
тунхаглал, 25
Бойд. К. Пакерын тунхаглал, 25
Номлогч
пристийн үүрэг. . . болон, 51–53
үр дүнтэй, пристийн үүрэг
номлогч болоход бэлтгэх, 54
Спэнсэр. В. Кимболлын
тунхаглал, 56
Номлогчийн ажил, Мелкизэдэк
Пристийн Зэрэгтний үүрэг
хариуцлага, 63
Нэгдлийн үйлчлэл, 184–90
Мелкизэдэк Пристийн
Зэрэгтнүүдийн үүрэг, 65
хувь хүний үүрэг, 184–90
Дэвид. О. Маккей-ийн
тунхаглал, 184

Ө

Өр ба мөнгөө зохицуулах нь, 153
Эзра Тафт Бэнсоны тунхаглал,
153
Өөрөө өөрийнхөө дурыг хангах, 252
Өөрчлөлт, Мелкизэдэк пристийн
зэрэгтнүүдийн хариуцлага, 65

П

Патриархын адислал, 69–76
Элдрэд. Г. Смитийн тунхаглал, 70
Жон. А. Видсоугийн тунхаглал, 71
Жозеф Смитийн тунхаглал, 69

Жозеф. Ф. Смитийн тунхаглал, 69
Патриарх, пристийн зэргийн албан
тушаал, 69–76

Жозеф Смитийн тунхаглал, 70
Патриархын эрин үеийн патриархууд
Пристийн зэргийн дуудлагаа
хөгжүүлэх, 51–53
пристийн талаарх тунхаглал.
Виктор. Л. Брауны, 53
Вилфор Уодраффын, 51
Пристийн зэргийн ерөнхийлөгчийн
зөвлөл, түлхүүрүүд, Сүмийн бүх
ерөнхийлөгч нар атгадаг, 8
Прист, үүргүүд, 48–56
Пристийн зэрэг

Адам хүлээн авсан, 8
эрх мэдэл ба хүч чадал, 2–4
зэрэгтэн гэр бүлээ удирддаг, 92
зэрэгтэн эхнэрээ хайрлан
түүнтэй зөвлөлдөх ёстой,
92–95

Мормоны Номын үед, 11
Исүсийн өдрүүдэд, 12
Ж. Рүбэн Кларк. Бага-ын
тунхаглал, 93
үерийн дараа, 11
түүх, 8–14
зэрэгтэн, гэр орноо өөрчилж
чадна, 5
Дэвид. О. Маккэй-ийн тунхаглал,
6
зэрэгтэн, жишээ үзүүлэх ёстой,
4–7

Бурханы хүч чадал, 1
Хэролд. Б. Лигийн тунхаглал, 1
Жозеф Филдинг Смитийн
тунхаглал, 2

Түлхүүрүүд.
Зөвхөн сүмийн Ерөнхийлөгч
бүгдийг атгадаг, 8
Адам атгаж байсан, 8
эрх мэдлийн шугам.
агуу их урвалтын үед Сүмээс
гээгдсэн, 10
хөгжүүлэх.

Жозеф Филдинг Смитийн
тунхаглал, 29
Вилфорд Уодраффын
тунхаглал, 51
хүч чадал Бурханаас ирдэг, 2–3

- хүч чадал зөв шударга амьдралаас ирдэг, 2–3
 хөгжүүлэх хүч чадал, 3–5
 А. Теодор Таттлын тунхаглал, 255
 хайран дээр үндэслэгдсэн хүч чадал, 5
 Х. Бүрк Питэрсоны тунхаглал, 2
 хүч чадал, ба ёс суртахууны цэвэр байдал, 254–56
 хүч чадал, Н. Элдон Таннэрийн тунхаглал, 6
 зорилгууд, Х. Бүрк Питэрсоны тунхаглал, 3
 сэргээлт, 15–22
 Жозеф Смитээр дамжуулсан, 17–21
 Жозеф Филдинг Смитийн тунхаглал, 79
 зэрэгтэн байх зохистой байдал, Н. Элдон Таннэрын тунхаглал, 6
- Пристийн зэрэг, Аароны Жозеф Смит ба Оливэр Каудэри нарыг баталсан, 18
 Мозесын ах Аароны нэрээр нэрлэгдсэн, 20
 хүч чадал ба үүргүүд, 20–22
- Пристийн зэргийн удирдагчид дэмжихийн чухал байдал, 61
 Бойд, К. Пакерын тунхаглал, 61
 дагаж мөрдөх хүсэл, пристийн зэргийн хүч чадлыг олж авахад зайлшгүй хэрэгтэй, 5
- Пристийн зэрэг, Мелкизэдэк, 11
 Жозеф Смит ба Оливэр Каудэри нарыг баталсан, 18
 Абрахам Исаакт өгсөн, 11
 Исаак Жэкобт өгсөн, 11
 бошиглогч Мозесоос Исүс Христ хүртэл цаашаа дамжсан, 12
 Мелкизэдэк гэдэг хүний нэрээр нэрлэгдсэн, 11, 20
 хүч чадал ба үүргүүд, 21–23
 Израилын хүүхдүүдээс буцаан авсан, 11
- Пристийн зэргийн чуулга, гишүүдийн хувьд өөрсдийн хэсгээ гүйцэтгэх, 26–29
- Ж. Рүбэн Кларк (Бага)-ын тунхаглал, 25
 Ван. Ж. Фийвэрстоуны өгүүлсэн түүх, хэрхэн, үйл ажиллагаанууд, 24–26
 Бойд К. Пакерын тунхаглал, 26
 Дэвид О. Маккэйн тунхаглал, 25
 Хэролд. Б. Лигийн тунхаглал, 25
 Стэфи. Л. Ричардсын тунхаглал, 25
 зорилгууд, 23–29
- Пристийн зэргийн дахин сэргээлт, 15–22
 Пристийн зэргийн чуулгын үйл ажиллагаанд нэгдэл зайлшгүй хэрэгтэй, 24–25
 эхнэрүүдээ дарлах, пристийн зэргийг буруугаар ашиглах, 93
 Дэвид, О. Маккэйн тунхаглал, 25

С

- Садар самуун явдал, 254
 Салбарын ерөнхийлөгч, томилолт, Бишоп, томилолт-ыг үз.
 Салбарын ерөнхийлөгч, үүргүүд, Бишопын үүргүүд-ийг үз.
 Санхүү, гэр бүлийн, 152–58
 Сайн чанар, гэртээ заах нь, 138–44
 А. Теодор Таттлын тунхаглал, 141–43
 Бойд, К. Пакерын тунхаглал, 138, 141
 Спэнсэр. В. Кимболлын тунхаглал, 138–39
 Ван. Ж. Фийвэрстоуны тунхаглал, 139
- Смит, Жозеф
 Жон Баптистаар томилогдсон, 18
 Петр, Иакоов, Иохан нараар томилогдсон, 18
 пристийн зэрэг дахин сэргээгдсэн, 17–18
- Сонголт, 10
 Адамын хүүхдүүдийн хэрэгжүүлсэн, 10
- Судрууд
 Брюс. Р. Макконкигийн тунхаглал, 112

суралцах
гэртээ, 108–10
Бурханы хүсэл зоригийг,
5мэдэхэд зайлшгүй хэрэгтэй,
гэрчлэл хүлээн авахад
зайлшгүй хэрэгтэй, 193
Х. Бүрк Питэрсоны тунхаглал,
110
Жозеф Смитийн тунхаглал,
194
заах нь, 124–31
Спэнсэр. В. Кимболлын жишээ,
127–29
Хэролд. Б. Лигийн тунхаглал,
130
Ж. Рүбэн Кларкийн тунхаглал,
124
Марион. Г. Ромнигийн
тунхаглал, 130
Сүнсний хамтаар,
дэлхийд.
Суралцах, бүтээх уур амьсгал, гэрт, 107
Дэвид. О. Маккэйн тунхаглал,
107
Суралцах
гэр бол ариун сургаалын төв,
106–12
Марион. Г. Ромнигийн
тунхаглал, 107
пристийн зэргийн гарын
авлагууд нь пристийн зэргийн
үүргүүдийг мэдэхэд зайлшгүй
чухал, 5
судрууд Бурханы хүсэл зоригийг
мэдэхэд зайлшгүй хэрэгтэй, 5
Сүм дээр угтаж аван мэндчилэх нь
Аароны Пристийн Зэргийн багшийн
үүрэг, 44
Сүмийн үйлчлэл бол Мелкизэдэк
Пристийн Зэрэгтэнүүдийн үүрэг, 67

Т

Төгс Төгөлдөржилт үрүү хүрэх зам, 221
Спэнсэр. В. Кимболлын
тунхаглал, 221
Төлөөлөгчид
Исүсээр томилогдсон, 12
Арван хоёрын Чуулга, 79
Төсвийн маягт, 157

Түлхүүрүүд
пристийн зэргийн
ерөнхийлөгчийн зөвлөлийн
Сүмийн бүх ерөнхийлөгч нар
атгадаг, 8
Адам хүлээн авсан, 8
Мелкизэдэк Пристийн Зэргийн
атгадаг сүнслэг адислалууд
ба хүч чадлуудын, 67–68
Тэргүүн Зөвлөл, 77–79
Тэтгэлгийн үйлчлэл. Мелкизэдэк
Пристийн зэрэгтнүүдийн үүрэг
хариуцлага, 65

У

Усаар батлах
пристийн үүрэг, 49–51
Усан баталгаа
гэрээ, 217–24
Спэнсэр. В. Кимболлын
тунхаглал, 221
дараах хөгжил дэвшил,
220–24
Улс
үүрэг хариуцлагууд, 188–89
Хэролд. Б. Ли-гийн тунхаглал
үйлчлэл, 186–89
Дэвид. О. Маккэй-ийн тунхаглал,
184–85
Урвалт, 10
анхны агуу, 10
агуу, 10–12, 15–17
Ургийн бичиг, Мелкизэдэк Пристийн
зэрэгтний үүрэг хариуцлага, 65
Учрал, Болзооны, заавар удирдамж.
Спэнсэр. В. Кимболл, 255

Ү

Үйлчлэл, Христийн адил.
Дэвид. О. Маккэй-ийн тунхаглал,
247–49
Хэролд. Б. Лигийн тунхаглал,
247
Томас. С. Монсоны тунхаглал,
247
Үндэстэн, үйлчлэл, 184–91
Дэвид. О. Маккэйн тунхаглал,
184–85
Үр хөндөлт, 255

Х

Хадгаламж, ба мөнгөний зохицуулалт, 154

Хайр

зарлиг, 247–49

Х. Бүрк. Питэрсэний тунхаглал, 244–49

Н. Элдон Таннэрын тунхаглал, 245

Спэнсэр. В. Кимболлын тунхаглал, 249

пристийн зэргийн хүч чадал үндэслэгдсэн, бусдын. . . .6

ба үйлчлэл. . . ., 247–49

Дэвид. О. Маккэйн тунхаглал, 250

Марк. И. Питэрсэний тунхаглал, 249

Теодор. М. Бюртоны тунхаглал, 245

эхнэр хүүхдүүдийн, 6

Хоолны дэглэм эрүүл мэндэд чухал, 180

Христ. Исүс Христ-ийг үз.

Хууль

Мелкизэдэк Пристийн Зэргийн удирдагчид хүндэлж,

дуулгавартай

дагаж, дэмжих ёстой, 67

Хүнлэг чанар, пристийн зэргийн хүч

чадлыг олж авахад зайлшгүй

хэрэгтэй, 64

Хүсэл тэмүүлэл нь пристийн зэргийн

хүч чадлыг олж авахад зайлшгүй

хэрэгтэй, 3

Хүүхдүүд

эцэг эхчүүд гэрчлэлээ хуваалцах ёстой, 112

эцэг эхчүүд зөвлөлдөх ёстой, 93, 96–98

Элрэй. Л. Крисчинсэний тунхаглал, 98

Ричард. Л. Эвансийн тунхаглал, 98

Ц

Цуглаанууд, Сүмд ирэх, 220

Цэвэр байдал нь, бие махбодын

эрүүл чийрэг байдлын чухал

болох, 176–83

Ч

Чуулгын үйлчлэл бол Мелкизэдэк

Пристийн зэрэгтнүүдийн үүрэг, 67

Ш

Шүдээ арчлах нь эрүүл мэндэд чухал,

180

Э

Эдэний Цэцэрлэг, Адам, Ева хоёр хөөгдсөн нь, 8

Эмнэлгийн асаргаа сувилгаа нь эрүүл мэндэд чухал, 180

Энэрэл, Хайр-ыг үз

Эрин үе

цаг хугацааны бүрдлийн эрин

үе. Жозеф Смитэд өгсөн, 14

патриархын

Эрүүл мэнд, бие махбодын.

ашиг тусууд, 176–77

тордох, 177–82

Бригхэм Янгийн тунхаглал, 182

Дэвид. О. Маккэй-ийн тунхаглал, 176

Эхнэрүүд

пристийн зэрэгтнүүдийг хайрлан зөвлөхийн тулд, 93–95

Ж. Рүбэн. Кларк (Бага)-ын тунхаглал, 93

зөв шударга бус ноёрхол,

пристийн зэргийг буруугаар

ашиглах, 93

Эцэг

адислалууд, 90

гэр бүлийнхэнтэйгээ зөвлөлдөх, 92–99

Элрэй. Л. Крисченсэний тунхаглал, 97

Ричард. Л. Ивансын тунхаглал, 97

гэр бүлийнхээ сайн сайхны

төлөө хүлээх үүрэг

хариуцлага, 85–91

Эцэг эх

хүүхдүүдтэйгээ зөвлөлдөх ёстой, 93, 96–99

Элрэй. Л. Крисчэнсэний тунхаглал, 97

Ричард. Л. Эвансын тунхаглал, 97

Ариун Сүмүүд

1. Солт Лэйкийн Ариун Сүм
2. Провогийн Ариун Сүм
3. Жордан Ривэрийн Ариун Сүм
4. Вашингтоны Ариун Сүм
5. Аризонагийн Ариун Сүм
6. Огдены Ариун Сүм
7. Логаны Ариун Сүм
8. Сао Паулогийн Ариун Сүм
9. Гавайн Ариун Сүм
10. Токиогийн Ариун Сүм
11. Шведийн Ариун Сүм
12. Лос Анжелесийн Ариун Сүм
13. Сэнт Жоржийн Ариун Сүм
14. Айдахо Фолсын Ариун Сүм
15. Оклэндын Ариун Сүм
16. Лондоны Ариун Сүм
17. Албэртын Ариун Сүм
18. Шинэ Зеландын Ариун Сүм
19. Сиэтлын Ариун Сүм
20. Мантийн Ариун Сүм
21. Самоагийн Ариун Сүм
22. Оклэндын Ариун Сүмийн усан баталгааны сан
23. Провогийн Ариун Сүмийн сэлэсчел өрөө
24. Аризонагийн Ариун Сүмийн баталгааны өрөө
25. Солт Лэйкийн Ариун Сүмийн холболтын өрөө
26. Солт Лэйкийн Ариун Сүмийн сэлэсчел өрөө
27. Эртний Ирусалим дахь Хэродын ариун сүм (загвар хот)
28. Солт Лэйк Сити дахь Сүмийн Албаны Байр
29. Солт Лэйк Сити дахь Сүмийн Захиргааны Байр
30. Солт Лэйк Ситийн ойролцоох Грэнайт Маунтэний бүртгэлийн бунхан
31. ХҮГ-ийн дэлхий даяар байдаг уулзалтын байрууд



1



2



3



4



5



6



7



8



9



10



11



12

14




15



13





16



17



18

20




19



21










24



25











31



32



33



ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

